

ПОЛИТОЛОГИ V

Эрдэм шинжилгээний бичиг

№ 325 (51)

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:	Ц.Ганболд доктор, профессор
Нарийн бичгийн дарга:	Ё.Довчин доктор, профессор
Гишүүд:	Д.Содномгомбо доктор, профессор А.Юндэндорж доктор, профессор С.Базарпүрэв доктор, профессор Ж.Төртогтох доктор, дэд профессор Д.Болд-Эрдэнэ доктор, ФСЭХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ц.Мөнхцэцэг доктор, МУБИС-ийн Улс төр, социологийн тэнхмийн багш
Дугаарыг эрхэлсэн:	Ё.Довчин
Техник редактор:	Ц.Өлзийжаргал
Хаяг:	Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө МУИС-ийн хичээлийн II байр Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Улс төр судлалын тэнхим, Орчин үеийн улс төрийн судалгааны төв

Утас: 312659, 318641

Факс: 976-11-328890

ПОЛИТОЛОГИ V

Эрдэм шинжилгээний бичиг

№ 325 (51)

АГУУЛГА

Өмнөх үг

Улс төрийн шинжлэх ухааны түүх, онол, арга зүй

Орчин үеийн улс төрийн онолын хөгжлийн тойм

Ё.Довчин

Улс төр, түүний өөрчлөлтийн тухайд

А.Жамбал

Улс төрийн сэтгэлгээний түүхэнд бүтээгдсэн бослогын үзэл суртал

С.Базарпүрэв

Жон Роулзын зүй ёсны онол

Ж.Жаргал

Харьцуулсан улс төрийн арга

С.Зүльфикар

Нийгмийн хамгаалалт төрийн судалгааны онол арга зүйн зарим асуудал

Г.Түмэннаст

“Цагаан түүх” зохиол дахь хоёр ёсны үзэл

М.Саранцэцэг

Улс төрийн институт, үйл явц

Улс төрийн намын нийгмийн хариуцлага

С.Мөнхбат, С.Зүльфикар

Улс төрийн шинжлэх ухаан дахь нам судлалын өнөөгийн хандлага

Ж.Төртогтох

Улс төрийн үзэл суртал ба намуудын үзэл баримтлал

Ё.Довчин, Г.Цэнд-Аюуш

Парламент дахь улс төрийн намын үүрэг хариуцлага

Д.Болд-Эрдэнэ

Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал: улс төр – эрх зүйн шинжилгээ

Ж.Төртогтох, Б.Эрдэнэдалай

Ардчиллын үйл явц: улс төрийн хошуучлал

Ч.Өлзийсайхан, Д.Оюунчимэг

Засаглал дахь патримониаль, неопатримон хэлбэрийн ноёрхол

Ц.Батболд

Номын орчуулга, судалгааны танилцуулга

Улс төрийн ухамсарын социологи

Г.Цэнд-Аюуш

Оюутны сургалтын тэтгэлэг: хэрэгцээ, шаардлага

Ц.Ганболд

Нийтлэлийн шаардлага стандарт

Өмнөх үг

МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхим, Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн гаргадаг Политологи эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлийн ээлжит дугаар уншигчдын гар дээр очиж байна. Өмнө хэвлэгдэн гарсан цуврал сэтгүүлийн үргэлжлэл болон гарч буй энэхүү дугаар нь өмнөх сэтгүүлүүдийн ололт, туршлагад тулгуурласан болно. Монголд шинээр үүсэн бүрэлдэж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэд, судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдагийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн энэ дугаарт улс төрийн түүх, онол арга зүй, сургалт судалгааны орчин үеийн хөгжлийн хандлагын үүднээс өнөөгийн Монголын улс төрийн үйл явцын нэг чухал хэсэг болох улс төрийн намуудын төлөвшил, хөгжлийн асуудлаар эрдэмтэд, судлаачдын бичсэн өгүүллүүдийг бие даасан сэдэв болгож оруулснаас гадна улс төрийн онол, философийн асуудлыг хөндсөн өгүүллүүдийг нийтэллээ.

Энэхүү сэтгүүлийг гаргахад сэтгүүлийн зөвлөл чамгүй хүчин чармайлт гаргасан. Гэвч зарим нэг техникийн шалтгаан хийгээд өгүүллийн стандарт, шаардлагын дутагдалтай байдлаас үүдэн сэтгүүл гарах гэж нэлээдгүй хугацаа өнгөрсөнд эрхэм уншигч танаас хүлцэл өчиж байна. Сэтгүүлийн зөвлөл энэхүү дугаарыг эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигддаг стандарт, шаардлагыг бүрэн хангасан өө сэвгүй сэтгүүл болсон гэж үзэхгүй байна. Тиймээс уг сэтгүүлийн талаар санал, хүсэлтээ МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн хаягаар ирүүлж бидний ажилд гүн туслалцаа үзүүлэхийг эрхэм хүндэт уншигч Танаас хүсч байна.

Сэтгүүлийн зөвлөл. 2009.12. 28

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН ОНОЛЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ

Ё. Довчин

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Эл өгүүлэлд улстөрийн онолын өнөөгийн үндсэн чиглэлүүд, чиг хандлага, орчин үеийн улстөрийн үйл явдлууд ба улстөрийн онолын харилцан нөлөөлөл зэргийг тоймлон авч үзэж судлаачдын анхаарлыг хандуулахыг зорьсон болно.

XX зууны хоёрдугаар хагасаас улстөрийн онол мэдлэг ухааны бие даасан салбар болж хөгжихдөө улстөрийн философийн уламжлалаас ихээхэн хамааралтай байв. 1950-1960–аад онд улстөрийн норматив онол хөгжлийн хувьд зогсонги байдалд орсон гэж шуугидаг.

Гэвч "Улстөрийн философи өнөөдөр устаж алга болоогүй ч гэсэн задрал, сарнилын байдалтай байгаа нь үнэн юм. Тэрээр ямар нэг хэлбэрээр оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болоод байна" (Штраус, 1954, 16) гэж бичиж байсан чухам тэр үед улстөрийн онолын "ургац" тийм ч тарчиг байгаагүй нь ажиглагддаг. М.Оакешотт "Улстөр дэх рационализм" (1962) бүтээлдээ улстөрийн философийн мөн чанарыг шинээр авч үзэж, тухайн үеийн эмгэнэлт үйл явдлуудын хариуцлагыг нэлээд хэмжээгээр үүрэлцэх учиртай өрнөдийн сэтгэлгээнд ноёрхогч рационализмыг шүүмжилжээ. "Хүний тавилан", "Өнгөрсөн ба ирээдүйн дунд" (1961), "Хувьсгал"(1963) зэрэг Х. Арентдын гол зохиолууд гарч, тэрбээр хүний уг чанарын ойлголтыг сөхөн тавьж, уламжлалт философийн улстөрийн бус шинж чанарыг шүүмжилж, тоталитаризмтай холбогдуулан энэ салбарын таамаглалууд, ойлголтуудыг эрс өөрчилж шинэчлэх шаардлагатай байгааг нотолжээ.

И.Берлины "Эрх чөлөөний хоёр ойлголт" (1958), "Улстөрийн онол оршин байна уу?" (1962) шүүмжлэлт өгүүллүүд нийтлэгдэж, либерализм болон уламжлалт улстөрийн философийн ихэнхэд буй ёс суртхууны монизмыг хурц шүүмжилж, либерализмын бусдаас тодрох орчин үеийн, хүч нөлөөтэй хэлбэрийг тоймлон гаргажээ. Түүнчлэн Поппер, Штраус, Хайек зэрэг тэр үеийн нэрд гарсан олон улстөрийн философчдыг нэрлэж болно. Мөн үед Сартри, Хабермас, Маркузе нар марксын улстөрийн философийг сэргээн бүтээх системтэй оролдлого хийж байв.

1950-1960-аад оны улстөрийн философчид, онолчид хоорондоо харилцаа холбоо сул, мөр мөрөө хөөж, бие даасан шавь сургуулийн хэлбэрээр ажиллаж байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг (Parekh, 1996, 505). Тэд хэдийгээр асуудалд өөр өөр байр сууринаас хандаж байсан боловч улстөрийн философи, улстөрийн онолыг судалгааны боломжтой бөгөөд хэрэгцээ шаардлагатай хэлбэрүүд гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч байсан нь тэр үеийн нэг онцлог байв. Тэд бараг бүгдээр улстөрийн философийн үүрэг нь зааж зааварлахаас илүү ойлгоход л оршино гэж үзэж байсан. Энэ нь практик дээр аливаа нэг институт, бодлогыг санал болгож зөвлөхгүй гэсэн үг. Мөн үеийн улстөрийн онолчид дайны аймшиг, нацизм, тоталитаризмыг биеэр үзэж туулсан учраас тэдгээрийн үндэс язгуурыг рационализм (Оакешотт), историцизм (Поппер), ёс суртхууны монизм (Берлин), релятивизм (Штраус), капитализмаас (Маркузе) тус тус эрж хайж байлаа. Улстөрийн онолчид орчин үеийн коммунизмд төдийгүй либерал ардчилал, зарим либерал үнэт зүйлст шүүмжлэлтэй хандаж байв. Тэд фашизмын дайчилгаанд олон түмнийг татан оруулсан хэмээн ардчиллыг бас шүүмжилсэн. Тухайн үеийн улстөрийн онолчид чөлөөт нийгмийг эрхэмлэж байсан хэдий ч либерал ардчилалтай дүйцүүлэхээс цааргалж байлаа. Иймд тэд нийгмийг нээлттэй, чөлөөт, либертар, рационал, иргэний гэх зэргээр янз бүрээр нэрийдэж байжээ.

1970-1980-аад онд улстөрийн философийн сэргэлтэд судлаачдын тэмдэглэснээр Вьетнамын дайн, АНУ дахь Иргэний эрхийн хөдөлгөөн, дайны дараахь зөвшилцлийн задрал зэрэг нь дэм болсон байна.

Түүнээс гадна 1971 онд америкийн улстөрийн онолч Ж.Роулсын “Шударга ёсны онол” бүтээл нийтлэгдсэн нь улстөрийн онолын сэтгэлгээнд шинэ үе эхэлсний дохио болжээ. Үүний дараахан Р. Нозикын “Анархи ёс, төр ба утопи үзэл” ном гарсан. Роулсын дурдсан суурь бүтээлийн үзэл санааг шүүмжлэхийн хамт Нозик “Роулсын шударга ёсны онол бол улстөрийн болон ёс зүйн философийн чиглэлийн хүчтэй, гүн гүнзгий, түгээмэл өргөн агуулга бүхий системтэй бүтээл бөгөөд хэрэв харьцуулж болдогсон бол Жон Стюарт Миллээс хойш түүнтэй дүйцэх зохиол гараагүй билээ. ... Улстөрийн философчид одоо нэг бол Роулсын онолын хүрээнд ажиллах, эс тэгвээс яагаад үгүй гэдгээ тайлбарлах хэрэгтэй боллоо” гэж үнэлжээ. (Нозик, 2006, 212)

Роулсын онолд “шударга ёс”, “тэгш байдал” гэсэн ойлголтууд төв байр эзэлж нийгмийн улстөрийн зохион байгуулалтын гол зарчим болсон. Түүний байр суурь өмнөх онолчдоос нэлээд ялгаатай байв. Тэд давын өмнө улстөрийн философи улстөрийн амьдралыг *ойлгох* учиртай гэж үзэж байсан бол Роулсын хувьд тэр нь юуны урьд норматив бөгөөд практик философийн хэлбэртэй байх ёстой аж. Мөн тэд улстөрийн философи хүний амьдралын суурь шинжүүдийг тайлбарлах үүрэгтэй гэж үзсэн бол Роулсын үзснээр зөвхөн хүний тухай онол төдийгүй шаардлагатай институтүүд, бодлого, практикийн бүтцийг бий болгож болно. Өөрөөр хэлбэл, нийтээр хүлээн авч болох наад захын

зарчмуудын үндсэн дээр хэн ч бүхэл нийгмийн бүтцийг зохиох чадвартай гэж үзэж байв. Тэрбээр улстөрийн онолыг логик, илтгэх урлаг, онтологи болон өрнөдийн соёл иргэншлийн түүхээс салгаж эдийн засаг, сэтгэл зүй, улстөрийн институци судлал, нийгмийн бодлоготой нэг эгнээнд тавьснаараа бас урьд үеэс ялгардаг.

Роулс шударга ёсыг улстөрийн эх ойлголт болгож түүнийг ихээхэн өргөн утгаар хэрэглэсэн. Тэрбээр өөрийн онолдоо тэгш эрх чөлөөний тухай нэгдэх зарчимдаа (Вольф, 2002,206 дахь талд үз.) тэргүүн зэргийн ач холбогдол өгсөн байдаг. Гэтэл түүний онол дэвшигдснээс хойшхи олон жилийн судалгаанд тэгш байдал олгох хоёрдахь зарчимд буюу нийгэм эдийн засгийн тэгш бус байдал хамгийн бага аз завшаан бүхий хүмүүст ашигтай байх сайхь зарчимд илүүтэй анхаарчээ. Түүний онолыг тайлбарлагчдынхаар бол шударга ёсны онол зөвхөн эрх чөлөөг хамгаалах төдийгүй нийгэм-эдийн засгийн илүү тэгш байдлыг бий болгохын тулд засгийн газрын идэвхтэй оролцоог санал болгосон гэж үздэг. Эл онол нийгэм-эдийн засгийн тэгш байдлын хэм хэмжээг либерал уламжлалын хүрээнд гаргаж тавьсан. Либерал ардчилсан төр нийгмийн асуудлууд ба эдийн засгийн гачигдлыг төрийн бодлогоор дамжуулан шийдэхийг зорьж ирсэн. Хэрэв Роулс хамгийн бага аз завшаант хүмүүст хуваарилалтыг сайжруулахад чиглэсэн бодлогыг хамгаалагчдад онолын хүрээ татаж өгсөн бол Нозик бусад хэсэгт зориулж хүрээ гаргажээ. Нозик шударга ёсны “загварт” зарчмуудыг ашиглахын эсрэг байдаг. Уг зарчим ёсоор бол нийт оролцогчдоос хуваарилалтын тодорхой загваруудыг баримтлахыг шаарддаг. Үүний оронд тэрбээр эд баялагийг легитим байдлаар олж авах горимуудыг тодорхойлсон загварт бус зарчмыг хамгаалдаг (Нозик 2006,181-183).

Нозикын онол нь хуваарилалтын тэгш бус байдлыг залруулахын тулд эрх чөлөөг хамгийн түрүүнд тавьсан бол Роулс эрх чөлөө ба тэгш байдлын аль алинд нь үнэнч байх нь зохистойг үндэс болгож онолоо бүтээжээ. Эрх чөлөө гагцхүү нийгмийн илүү тэгш байдалд нийцэлтэй төдийгүй түүнийг шаардаж байдаг гэсэн Роулсын санааг улстөрийн онолчид (А.Гутманн, Б.Акерман, К.Нилсен, М.Фиск гэх мэт) хөгжүүлсний дотор Ч.Бейтз “Улстөрийн онол ба Олон улсын харилцаа” (1979) бүтээлдээ Роулсын шударга ёсны зарчмуудыг хөгжингүй болон буурай хөгжилтэй орнууд хоорондын хуваарилалтын тэгш бус байдлыг судлахад үндэс болгох боломжтойг нотолсон байна. Ийнхүү Роулсын онол 1970-1980-аад оны улстөрийн онолын хөгжлийн дүр төрхийг тодорхойлж байсан нь энэ үеийн нэг онцлог гэж болно.

1970-аад оны сүүлчээс “позитивистүүд” ба “марксистууд”-ын хоорондын мэтгэлцээн намдаж, түүний оронд бодлогын шинжилгээ шинэ онол бүтээх дунд төвшин болж гарч иржээ. Энэ үед улстөрийн шинжлэх ухааны гол чиглэл 1960-аад оны сүүлээр нэг үе сэргэсэн улстөрийн үзэл сурталжсан “том” онолоос улстөрийн эмпирик судалгаа тийш хандсан онцлогтой. Энэ үеийн онол бүтээх оролдлого нийгмийн хамтын ажиллагаагаар дамжуулж удирдах хувилбарууд дээр төвлөрч байжээ. Лейпхартын (1977)

консоциативизм, Шмиттерын(1981) неокорпоратизм, Виллкын (1983) социетал хамтын ажиллагаа зэргийг энд дурдаж болох юм.

Ийнхүү улстөрийн онол багагүй зөрчил бэрхшээлийг давж хөгжсөн нь илэрхий байна. Жишээ нь, 1950-1960-аад онд шударга ёс, үүрэг, эрх чөлөө зэрэг цөм ойлголтуудын үнэ цэнийг няцаасан позитивизмын, эмпирик судалгааг дөвийлгөж нормативыг үл хайхарсан бихевиорализмын довтолгоонуудыг улстөрийн онол гэтэлж гарч чаджээ.

Гэвч өнөөдөр ч улстөрийн онол хөгжлийн жам ёсоор шинэ сорилтуудтай тулгарсаар байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Тухайлбал, улстөрийн онолуудыг нэгтгэгч суурь болсон улстөрийн сэтгэлгээний сонгодог бүтээлүүдийг судлах нь улстөрийн онолд хамаатай эсэх талаар маргаж байна. Улстөрийн онолыг судлахад уламжлал ёсоор багтдаг эдгээр зохиолуудыг ердөө орчин үеийн онолчид зохиосон “домог” гэх, эсвэл улстөрийн онол олон мэдлэг ухааны салбаруудын огтлолцол дээр орших өөрийн гэсэн өнгө төрхгүй зүйл гэж шүүмжлэх нь ч байна.

Гэвч улстөрийн олонхи эрдэмтэд түүх, философи, социологи, хэл шинжлэлээс зээлдсэн олон мэдлэг ухааны салбарын нийлмэл улстөрийн онолыг улстөрийн шинжлэх ухааны дэд салбар гэж үздэг. Олон улсын Улстөрийн шинжлэх ухааны холбооноос 25 жилд нэг удаа эрхлэн гаргадаг 1996 оны “Улстөрийн шинжлэх ухааны лавлах толь бичиг”-т улстөрийн онолыг улстөрийн шинжлэх ухааны нэг дэд салбар хэмээн оруулсан байдаг. Улстөрийн онол хэрэв улстөрийн шинжлэх ухааны ерөнхий урсгалаас тасарвал тэр нь наад зах нь өөрийн олон салаа салбарууд дунд тарж алга болж болзошгүй гэж улстөрийн онолчид сануулсан байдаг.

1980-1990-ээд онд улстөрийн онолын үндэс гэггдэг талаасаа дайралтад өртсөн сонгодог зохиолууд улстөрийн шинжлэх ухааны мэдлэгийн салбарын чухал хэсэг хэвээр үлдсэн нь улстөрийн онолчид өнгөрсөн үеийн бүтээлүүдийн үнэ цэнийг хамгаалах талаар зөвхөн хориглох байр суурь баримтлалгүй харин олон жинтэй ном зохиолоороо өргөжүүлэн баяжуулж байсанд оршдог байна. Улстөрийн амьдралын “мөнхийн” суурь асуудлуудын тухай сонгодог сэтгэгчдийн бясалгал эрэгцүүлэл нь орчин үеийн үйл явдлуудаас урган гарсан эдүгээ цагийн асуудлуудыг шүүн тунгаах бололцоо олгоно. Улстөрийн онол улстөрийн шинжлэх ухааны өөрийн утга учрыг олж авч, тулгуурлаж байдаг норматив суурь хэвээр үлдсэн.

Улстөр ба улстөрийн онол өвөр зуураа нарийн уялдаатай. Улстөрийн амьдралд үүссэн зөрчил, асуудлууд онолын боловсруулалт, шинэ дүгнэлтүүдийг шаарддаг. 1980-1990-ээд онд марксизмын улстөрийн нөлөө буурсан нь консерватив улстөр сэргэж харин олон уламжлалт либералууд, социал-демократуудыг баримжаагаа алдахад хүргэжээ. Сонгодог социалист үзэл санааг тээгчид зах зээлийн эдийн засаг, ардчилсан улстөр давуутайг мэдэрсэн. Сүүлийн 20 гаруй жилд либерал нийгмүүдэд иргэний хөдөлгөөн хүч

авч тэдгээрийн шаардлага эрх, эрх чөлөө, аж байдлын явцуу хүрээнээс хальж, байгаль орчин, энх тайван, эмэгтэйчүүдийн эрх, соёлын олон янз байдал гэх мэт асуудлуудыг хөндөж, хурц шаардлага тавих болсон нь шинэ зүйл байв. Улстөрийн онолчид ийм “нийгмийн шинэ хөдөлгөөн”-үүдийн улстөрийн арга барил, үр дагаврын талаар өөрсдийн онол баримтлалаа дэвшүүлсэн. Уул хөдөлгөөнүүдийг “шинэ” гэдгийн учир нь нэгдүгээрт, тэдгээр нь иргэний үндсэн эрх, эдийн засгийн эрхийн төлөө гэхээсээ илүү нийгмийн шинжтэй асуудлуудыг нэн онцгойлон авч үзсэн; хоёрдугаарт, эдгээр хөдөлгөөнүүдийн зохион байгуулалтын хэлбэр нь улстөрийн нам, үйлдвэрчний эвлэлийн олон түмнийг хамарсан хэлбэрийг хуулбарлаагүй, өөр өөрийн зарчим, арга барил бүхий голдуу орон нутгийн бүлгүүдийн сүлжээ байдаг.

Улстөрийн онол зарим хөдөлгөөнд биеллээ олсон норматив улстөрийн зарчмуудыг системтэй тусгасан байна. Жишээ нь, байгал хамгаалах хөдөлгөөн норматив үнэт зүйлс, нийгмийн рациональ шинж чанар, ардчилсан оролцооны тусгал болж байдаг. Даяаршлын нөхцөл дэх үндэсний төр улсын хил хязгаар, бүрэн эрхт байдал, мөн орчин үеийн үндэсний төр улсуудын нийтийн институтууд улстөрийн онолын чухал сэдэв болсон. Хүйсийн тэгш байдлын үүднээс феминист онол нийтийн ба хувийн хүрээний ялгаварлыг няцаадаг. Үндэстэн угсаатны адилсал сэргэснээр онолчдыг үндэсний төр улс доторхи жижиг нийтлэгүүдийн ёс зүйн шаардлагуудыг судлахад хүргэжээ. НҮБ, Дэлхийн Банк, Европын холбоо зэрэг үндэстэн хоорондын институтууд идэвхжсэн нь онолын судалгааны шинэ орон зайг бэлдэж өгч байна.

Өөрийнх нь хөгжлийн дотоод логик, мэтгэлцээн улстөрийн онолын өмнө цөөнгүй асуудлыг дэвшүүлж тавьсан. Тухайлбал, дээр дурдсан “хөдөлгөөний” жишээ нь 1980-аад оны сүүлээр олон либералууд хувь хүн, төрийг холбодог “иргэний нийгэм” тийш эргэснийг баталдаг. Энэ нь либералуудыг хувь хүний эрх, эрх чөлөөг хадгалахын хамт нийтийн үйлдлийн сэтгэл хөдлөл, ёс зүйн боломжийг хүлээн зөвшөөрөхөд хүргэжээ. Либерал автономи нь жижиг нийтлэгүүдийг хамгаалах төрийн үйлдэлтэй нийцэх төдийгүй түүнийг шаарддаг гэж зарим либерал үзэлтнүүд нотлох болжээ (Kymlicka, 1992, 140-46). Ийнхүү иргэний нийгмийг “дахин нээх”-ийн хамт “төр”-ийг басхүү “эгүүлэн авчирсан” нь улстөрийн онолын нэг ололт болсон. Онолчид плюрализм, бүтэц-үүргийн онол, сонгодог марксизмын эсрэг дайралт хийж, тэдгээр нь төрийг нийгмийн үйл явцын хамааралт хэмжигдхүүн болтол “жижгэрүүлсэн” арга хэлбэрүүд гэж үзжээ. Ийм хялбарчлалыг шүүмжилж, төрийн онолчид төрийн институтүүдийн автономийн тухай ойлголтыг сэргээх, үүгээр олон эмпирик асуудлуудыг хэрхэн тайлбарлаж болохыг хуруулахыг зорьсон байна. Нэрт онолчид төр бол улстөрийн онол, судалгаанаас хэзээ ч шахагдаагүй (Almond, 1988, 854-74) гэдгийг нотолж, бас энэхүү сэргэлт нь улстөрийн шинжилгээ ойлголт маргааны намаг балчигаас дахин сугарч гарсныг тэмдэглэж байв (Easton, 1981, 303-25).

Өнөөгийн улстөрийн онолд феминизм шинэ зам мөр гаргасныг судлаачид хүлээн зөвшөөрдөг. Феминист онолчид уламжлалт болон орчин үеийн улстөрийн сэтгэлгээ дэх улстөрийн тухай ойлголтыг эцгийн эрхт ёсны цогцлол гэж үзэж улстөрийг үндсээр нь дахин авч үзэх хэрэгтэй гэдэг. Феминист улстөрийн онолын гол нь улстөрийг төр, засгийн газар, шударга хуваарилалтын төв гэдгээс илүү өргөн утгатай үзэгдэл гэж үздэгт орших ажээ. Уг онол ёсоор нийгмийг нийтийн ба хувийн гэж ялгаж хуваахыг зогсоох ёстой, учир нь гэр бүлийн харилцаа, бэлгийн хандлага, гудамж, сургууль, ажлын байр дахь хүйсийн харилцаа үнэндээ улстөрийн харилцаа байдаг ажээ. Өнөөдөр феминист онолын судалгаа улстөр, нийгэм, хувь хүнийг тал бүрээс нь хамарч байгаа төдийгүй либерал, ардчилсан, марксист, постструктурал, психоаналитик зэрэг нийгмийн сэтгэлгээний олон хэлбэрүүдээр салбарлан хөгжиж байна.

Постмодернизм гарч ирсэн нь улстөрийн онолд өвөрмөц санаа авчирч, өөрийн орон зайг бий болгосон. Энэ онол рационализмд суурилсан баруун европын улстөрийн сэтгэлгээний уламжлалд сөрөг байр сууринаас ханддаг. Постмодерн үүссэн нь орчин үеийн улстөр, засаглалын бүхнийг эзэлж дийлсэн, бүхэнд нэвтэрч орсон, бүхнийг хавчиж шахсан шинж чанарт шүүмжлэлтэй хандахаас эхлэлтэй гэж болно. Орчин үеийн либерализмын хямрал нь Соён гэгээрлийн зарчмууд дээр үүссэн нийгмийн хямрал гэж үздэг. Өөрөөр хэлбэл, модернийн легитим хямралд орсон гэсэн үг. Постмодернийн нэрт төлөөлөгч Жан-Франсуа Лиотар орчин үеийн засаглалын легитимийг улстөр, шинжлэх ухаан, философийн дээр үеэс боловсорч бий болсон хэл, тухайлбал онцлог хүүрнэлтэй (“метанарраци”) –тай холбож шүүмжлэлтэй авч үзсэн байна. Орчин үеийн нийгэмд шинжлэх ухаанч шалгуурыг тогтоож буй этгээд хууль тогтоогчын нэг адил үйл ажиллагаа явуулж байна. Шинжлэх ухаанд ч, улстөрд ч легитимчлэлийн ижил механизм үйлчилдэг бөгөөд тэр нь “хууль тогтоогч” дискурсын тодорхой дүрэм журмыг тулган хүлэлгэдэг явдал юм. Өнөөгийн постмодерн нийгэм шинжлэх ухаан ба улстөр дэх легитимчлэлийн механизмыг эвдэж өөрчилж байна гэж Лиотар үздэг жишээтэй. Постмодернизмыг либерал ардчиллын эсрэг марксист биш зүүнийхний шүүмжтэй адилтгаж байхад Хабермас XIX зууны аристократ антилиберал үзлээс улбаатай консерватизмын далд хэлбэр гэж дүгнэжээ. Модернист ба постмодернистуудын хоорондын маргаан 1980-аад оны улстөрийн онолын ээдрээтэй асуудлуудын нэг байв.

Үүний зэрэгцээ М.Санделын “Либерализм ба шударга ёсны хязгаарууд” (1982) ном хэвлэгдэн гарснаар “коммунитаризм” гэгдэх орчин үеийн улстөрийн онол эхлэлээ тавьсан. Энэ онолын гол үндэслэл нь шударга ёс, эрх эрх чөлөө зэрэг улстөрийн үнэт зүйлсийг нийгэм, соёлын тодорхой контекстэд бэхэлж өгсөнд оршино. Энэ онолын төлөөлөгчид (Сандел, Валзер, Тейлор) нийгмээс ангид онол гэж үгүй. Улстөрийн ба ёс зүйн үнэт зүйлс хийсвэр оюун дүгнэлтээр тодорхойлогдох учиргүй гэж үздэг. Ийм үнэт зүйлс нь тухайн түүхэн нийтлэгүүдээс үүсч гардаг. Бодгалиудаас бүтсэн тодорхой нийтлэгийн барилдлагыг хүлээн зөвшөөрснөөр шударга ёс улам хүчтэй байх болно. Мөр

мөрөө хөөж, бие биеэ сонжихоос хэтэрдэггүй зожиг бодгалиудын ертөнцийн гэм согог гагцхүү тодорхой үнэлэмж, үнэт зүйлсийг хуваалцсан нийтлэгүүдээр дамжиж эмчлэгдэх жамтай ажгуу. Энэ онолын тулгуур үзэл санаа 1980-аад оны дундаас эрчтэй өрнөсөн либерализм ба коммунитаризмын мэтгэлцээний сэдэл болсон нь лавтай. Мөн судлаачид онолын эдийн засаг, тоглоомын онол, рациональ сонголтын онолд тулгуурласан улстөрийн онолын “загвар байгуулах” хэлбэрийн ач холбогдлыг үнэлж тэмдэглэдэг. Тухайлбал, улстөрийн рациональ сонголтын онол орчин үеийн эдийн засгийн аналитик арга техникийг улстөрийн үйл явцыг судлахад хэрэглэсэн. Эл онол хувь хүний зорилго ба нийтийн сонголтын холбоо, харилцан хамаарлыг нээж илрүүлэх талаар өөрийн норматив үнэлгээгээ санал болгодог гэж үздэг.

Ийнхүү улстөрийн онолын орчин үеийн хөгжил XX зуунд улстөрийн шинжлэх ухааны мэдлэгийн салбар мэргэжлийн өндөр төвшинд хүрсэнтэй давхцсан онцлогтой. Улстөрийн онолын хөгжилд улстөрийн дискурс, түүний дотоод асуудлууд шийдвэрлэх түлхэц өгч байсны зэрэгцээ дэлхийн улстөрийн амьдрал ч нөлөөлсөн нь мэдээж. Жишээлбэл, коммунизмын задрал эмпирик улстөрийн онолууд коммунист орнуудын хөгжлийг тайлбарлаж байсан онолын үндэслэлүүдээ хянан засварлах хэрэгтэй болсон төдийгүй ардчилал хэдийнээ ялсан улсууд ч өөрийнхөө улстөрийн системийн тухай ойлголт, дүгнэлтүүдээ эргэж харах шаардлага гарсан. Модернизацийн болон ардчилсан шилжилтийн онолууд нь 1970-аад оны Өмнөд Европ, Өмнөд Америкийн хөгжлийн загварт тулгуурласан байв. Тэдгээрээс цөөнгүй зүйл 1980-аад оны сүүл 1990-ээд оны эхэн үеийн тайван хувьсгал, их өөрчлөлт шинэчлэлтэй тохирч таарахгүй байлаа. Олон орон ардчиллын зам дээр гарч ирсэн хэдий ч ойрын ирээдүйд тогтвортой ардчилалд хүрч чадах эсэх нь тодорхойгүй. Либералчлал, ардчиллах үйл явц, бэхжилт гэсэн шилжилтийн нийгмийн ерөнхий дэс дарааллыг Зүүн Европт тэр чигээр нь буулгахад бэрхшээлтэй байв. Энэ бүхэн ардчиллын онолыг бүх талаар шинээр хөгжүүлэхийг шаардсан нь ойлгомжтой. Иймээс ардчилсан шилжилт, бэхжилтийн онол-практикийн асуудлууд өнөөгийн улстөрийн онолын үндсэн чиглэл болж байна.

Эцэст нь тэмдэглэхэд эдүгээ олон улстөрийн онолчид орчин үеийн улстөрийн онолоос улстөрийг шахан гаргаж байна гэж шүүмжилдэгийг анзаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, улстөрийг зөвхөн хууль эрх, засаг захиргаа, эсвэл зохицуулах зорилгоор хязгаарлаж байна гэсэн үг юм. Үүнээс үүдэн улстөрийн онолчид улстөрийн ертөнцийн хөл үймээнээс зай барьж, улстөрийн хурц зөрчилтэй “халуун” асуудлуудыг барьж авахаас халгах болсныг бас сануулсан байдаг.

Ийнхүү улстөр зарим үед системтэй онолтой огтлолцож, заримдаа түүнээс хазайх замаар үзэл санааны шугам дагуу шилжиж байна (Vincent,1997,9). Улстөр бол судалгааны объект төдийгүй улстөрийн онолуудын өрсөлдөх талбар болжээ гэж дүгнэх бүрэн үндэстэй юм.

Ашигласан ном зохиол

Ж.Вольф. Улстөрийн философийн удиртгал. УБ., 2002.

Р.Нозик. Анархи ёс, төр, утопи үзэл. УБ., 2006.

Л.Штраус. Введение в политическую философию. М., 2002.

Almond,G. 1988. "The Return to the State". American Political Science Review 82.

Easton,D. 1981. "The Political System Beseiged by the State". Political Theory 9.

Kymlicka,W. 1992, "The Rights of Minority Cultures". Political Theory 20.

Parekh,B. 1996. "Political Theory: Traditions in Political Philosophy". A New Handbook of Political Science. IPSA.

Vincent, A. 1997. Political Theory. Tradition and Diversity. Cambridge.

УЛС ТӨР, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙД

А.Жамбал

ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний дэд ажилтан

1. **Түлхүүр үг:** Улс төр, улс төрийн бодлого, улс төрийн амьдрал, улс төрийн хүрээ, улс төрийн ахуй, улс төрийн ертөнц, өөрчлөлт, шинэтгэл, шинэчлэлт, трансформаци, хувьсал, шилжилт, улс төрийн систем, улс төрийн байгууллага, улс төрийн хэм хэмжээ, улс төрийн ухамсар, соёл.
2. **Өгүүллийн зорилго:** Энэхүү өгүүллийн зорилго бол улс төр, түүний өөрчлөлт нь олон талтай, нарийн нийлмэл бүтэц, агуулгатай болохыг гаргаж тавих, түүний талаархи онол, арга зүйн үндэслэл, үзэл санааг постсоциалист нөхцөл дэх улс төрийн өөрчлөлтийн зорилтуудыг судлах, практик амьдралд хэрэгжүүлэхэд анхаарч тусгах шаардлагатай болохыг авч үзэхэд оршино.

Улс төрийн өөрчлөлт бол нийгмийн өөрчлөлтийн салшгүй чухал хэсэг юм. Түүнийг авч үзэхдээ гүн далдын мөн чанар, багтаамж, агуулгыг нь юуны өмнө нягтлан тодорзуулах хэрэгтэй болно. Энэ нь улс төрийн өөрчлөлтийн практик зорилтуудыг судлахдаа түүнд онол, арга зүйн үндэслэлтэй хандах, тухайлбал улс төрийн өөрчлөлт чухам юуг хамрах вэ, түүний явцад ямар үзэгдэл хэрхэн яаж өөрчлөгдөх вэ, нийгмийн улс төрийн системийн өөрчлөлт нь улс төрийн өөрчлөлтийг бүрэн төлөөлөн илэрхийлэх үү, улс төр, улс төрийн бодлого, улс төрийн амьдрал, улс төрийн хүрээ, улс төрийн ахуй, улс төрийн зүйл, улс төрийн ертөнц гэсэн ойлголт, нэр томъёонуудын утга агуулга, танин мэдэхүйн боломж, үүрэг, хоорондын харьцаа ямар байна вэ гэх зэрэг асуудлыг авч үзэж тодруулан тогтоох шаардлагаас урган гарч байгаа юм.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан нь нийгмийн ба улс төрийн философи, социологийн ерөнхий онол, улс төрийн эдийн засгийн ухаан, улс төрийн түүх зэрэг шинжлэх ухаан, мэдлэгийн салбаруудын ололт, үр дүнд тулгуурлаж улс төрийн шилжилт ба хөгжлийг чухалчлан анхаарч, бие даасан судлагдахуун болгож, дэлхийн янз бүрийн орнуудын туршлага, амьдралын жишээн дээр судлан боловсруулж, онол, арга зүйн ач холбогдолтой дүгнэлт, ололттой үр дүнд хүрч, сонирхолтой үзэл баримтлалуудыг дэвшүүлэн тавьж байна. Энэ нь нийгмийн улс төрийн амьдралын одоогийн динамик өөрчлөлт, язгуур шинэтгэлийн мөн чанар, онцлог, хандлага, бусад практик асуудлуудын талаар онолын ерөнхий ойлголт, шинэлэг мэдлэгтэй болох шимтэй хөрс суурь болж байгаа юм.

Холбогдох утга зохиолд улс төр, улс төрийн бодлого, улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн ертөнц, улс төрийн зүйл, улс төрийн ахуй, улс төрийн амьдрал, улс төрийн хүрээ, салбар гэсэн ойлголт, нэр томъёог хэрэглэж байна. Гэтэл эдгээрийн аль нь суурь, цөм

бүхий ойлголт, аль нь түүнээс ургаж гарсан үүсмэл, салаа ойлголт вэ, тэдгээрийн тус бүрийн цаана нь үнэхээр бие даасан, мөн чанарлаг өөр өөр бодит байдал оршиж байна уу, эсвэл тэдгээр нь нэгдмэл нэг үзэгдэлийг өөр өөр талаас нь тусгаж илэрхийлсэн, нэрлэж тэмдэглэсэн зөвхөн нэр томъёоны асуудал уу гэдгийн хариу тайлбар төдийлөн хангалттай биш байна.

Холбогдох ном бүтээлээс үзэхэд эл асуудалд улс төр судлагчидтай харьцуулахад нийгмийн болон улс төрийн философчид илүү нарийн анхаарал хандуулж, сонирхолтой санаа бодлуудыг гарган тавьжээ (1). Энэ нь дээрхи асуултад хариу тайлбар эрж эрэгцүүлэн бодох чиг баримжаа болж байна.

Улс төр бол (polity) хүмүүсийн хамтын амьдрал, нийгмийн оршин тогтнол, хөгжлийн амин гол хэрэгцээгээр зайлашгүй нөхцөлдсөн жам ёсны үзэгдэл юм. Хүмүүс амьдралынхаа материаллаг хэрэгсэл, нөхцөлийг хамтран бүтээж үйлдвэрлэхдээ нийгмийн эдийн засгийн амьдрал бүрэлдэж болдог, хоорондоо харилцаж хамтран амьдрахын зэрэгцээ нийгмийн амьдралын зэрэг дэв, шатлалд зохих байр суурь эзлэж зиндаагаараа, бүлгээрээ аж төрөх явцад нийгмийн социаль хүрээ үүсэж бүрэлддэг байна. Харин эдгээр хүрээн дэх нийгмийн субъектуудын эрх ашиг, байр суурь, харилцааны угийн болон үүсмэл ялгаа, зөрчил, тэмцэлдээнийг хүмүүс өөрснөө болон тэднийг төлөөлсөн байгууллагууд зохион байгуулалттайгаар, удирдлага, дэг журам, захирах захирагдах харилцаа, албадлага, хүчирхийлэл ба бусад арга хэрэгсэлүүдээр зохицуулж шийдвэрлэх явцад нийгмийн амьдралын өөр нэг үндсэн хүрээ болж улс төрийн амьдрал, хүрээ үүсчээ. Өөрөөр хэлбэл улс төрийн амьдрал хэмээх ойлголт, түүнийг тэмдэглэсэн нэр томъёо бол хүмүүсийн нийгмийн амьдрал, оршин тогтнолын нэгэн өвөрмөц хэлбэр, төлөв байдлыг илэрхийлсэн, танин мэдэхүйн чухал үүрэг, ачаалалтай бие даасан ойлголт юм.

Эдийн засаг, нийгэм (социаль), улс төр, оюун санааны амьдрал нь хоорондоо органик нэгдэлтэй байж нийгмийн бүхэл, нэгдмэл амьдралыг бүрдүүлэхийн зэрэгцээ тус бүртээ өөр өөрийн мөн чанар, гүйцэтгэх үүрэг, бие биеэсээ ялгагдах өвөрмөц онцлог, бие даасан чанартай болно. Тэдгээр нь үүний эрхээр нийгмийн амьдралын нэгдмэл, ерөнхий хүрээ хязгаарын дотор тус бүртээ нийцэж тохирсон өөр өөрийн хүрээ, салбар бүхий хил хязгаартай ажээ. Чухамдаа тэрхүү тодорхой хүрээн дотор нийгмийн амьдралын тэдгээр хэлбэрүүдийн мөн чанар, нийгмийн чиг үүрэг, онцлог нь тодорч харагддаг байна.

Улс төрийн амьдрал нь хэдийгээр нийгмийн амьдралын бусад хүрээнд төрийн үйл ажиллагаа, хууль, эрх зүй, улс төрийн бодлогоор дамжиж идэвхтэй нөлөөлдөг, нэвтэрдэг боловч эцсийн дүндээ өөрийн тогтсон хүрээ хязгаартай болно. Улс төрийн амьдралын оршихуй, үйлчилэл, илэрлийн чухам тэрхүү хүрээ хязгаарыг тодруулж тогтоох, түүнийг нийгмийн амьдралын бусад хүрээ, орон зайгаас зааглан ялгаж танин мэдэхийн тулд улс төрийн хүрээ (нийгмийн амьдралын улс төрийн хүрээ) хэмээх ойлголтыг хэрэглэдэг байна.

Улс төрийн ертөнц гэсэн нэр томъёо нь улс төрийн шинжлэх ухаанд төдийлөн тогтож хэвшсэн, бие даасан ойлголт харахан биш боловч танин мэдэхүйн зохих үүрэг, ачаалалтай байгааг үгүйсгэж болохгүй. Түүнийг эрдэмтэд ном бүтээлд улс төр, улс төрийн амьдрал нь өөрийн мөн чанар, зүй тогтол, орон зай, цаг хугацаатай, нийгмийн бодит байдлын бие даасан хэсэг бүхий субстанцлаг, нэг ёсондоо бүхэл бүтэн ертөнц болохыг илэрхийлж тэмдэглэхэд илүү оновчтой, зохимжтойн хувьд нь хэрэглэдэг тал ажиглагдаж байна.

Улс төрийг нийгмийн болон улс төрийн философи авч үзэхдээ улс төрийн ахуй гэдэг ойлголтыг голцуу хэрэглэж байна. Марксист чиглэлийн философи биет, материаллаг бодит байдлын оршихуйг ахуй хэмээх ойлголтоор илэрхийлдэг бол бусад чиглэлийн нийгмийн философи юмс үзэгдэл биет материаллаг ч бай, материаллаг бус, оюун санааны байдалтай ч бай, тодорхой хэлбэрээр оршин буй байдлыг ахуй хэмээх ойлголтоор илэрхийлэн тэмдэглэдэг. Марксист философи улс төрийн ахуйлаг мөн чанар, шинжийг үгүйсгэж, түүнийг эдийн засгаас үүсэж гардаг, зөвхөн давхаргын чанартай хэмээн өрөөсгөл ойлгож ирснийг засаж залруулах, улс төрийн ахуйн “эрхийг” ёсоор нь сэргээж “цагаатгах” ёстой гэж оросын эрдэмтэн А.С.Панарин бичжээ (2,19; 3,12). Тэгэхлээр “улс төрийн ахуй” хэмээх ойлголт нь улс төр, улс төрийн амьдрал нь нийгмийн практикийн бие даасан нэг төрөл болохыг, улс төрийн үзэгдэлүүд тодорхой арга хэлбэрээр бодитойгоор (биет, материаллаг байдлаар биш ч гэсэн) оршдог болохыг тусган илэрхийлж байгаа юм.

Улс төр, улс төрийн бодлого хоёр хоорондоо ялгаатай уу, эсвэл хоёр өөр үгээр илэрхийлсэн нэг зүйл үү гэсэн асуулт тавигдаж, түүнд өөр өөр хариулт өгдөг тохиолдол гардаг. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан эдгээр ойлголт хоорондоо нягт холбоотой боловч мөн чанараараа хоёр өөр үзэгдэлийг тус тусд нь илэрхийлнэ хэмээн үздэг. Улс төр нь (polity-полития) нөгөөгөөсөө өргөн утга агуулгатай бөгөөд нийгэм нь улс төрлөг шинжтэй, улс төрийн зохион байгуулалттай, төр засагтай байгааг илэрхийлсэн ойлголт юм.

Хэл зүйн хувьд монгол хэлний улс, төр гэсэн хоёр үг нийлж аль нэг улс нь бие даасан улс орон байхын тулд заавал төртэй байх, төр нь төр байхын тулд заавал улс оронтой байх, улс орныг төр нь засаглан захирч, төлөөлдөг тухай гүнзгий утга санааг илэрхийлж байгаа нь улс төрийг үзэж ойлгох өрнөдийн болон бусад чиглэлийн үзэл баримтлал, ойлголттой утга агуулга үндсэндээ нийцэж байна. Харин улс төрийн бодлого нь (politics) үйл ажиллагааны шинж чанартай бөгөөд тэрээр нийгмийн томоохон анги, давхраа, бүлгүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн язгуур эрх ашиг, хүсэл, зорилгыг улс төрийн засаглал, бүр тодруулж хэлбэл төрийн засаглалаар дамжуулж хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа мөн гэж ойлгож болно.

Улс төрийн уг шинж, зорилгыг танин мэдэх, тэрээр эдийн засаг хийгээд нийгмийн анги бүлгүүдийн хоорондын харилцаатай нягт холбоотой болохыг ухаарч ойлгоход марксизм чухал үүрэг гүйцэтгэжээ. Гэвч марксист, ялангуяа ленинист үзэл нь улс төр бол эдийн

засгийн төвлөрсөн илэрхийлэл, нийгмийн ангиудын хоорондын эдийн засаг, нийгмийн зөрчил тэмцлийн илэрхийлэл, эдийн засгийн бааз суурин дээр боссон давхарга мөн бөгөөд үүнээс өөрөөр бодож сэтгэх аргагүй хэмээн хатуу ойлгосноороо өрөөсгөл шинжтэй, эдийн засгийн детерминист үзэл байсан гэж судлаачид шүүмжилдэгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Марксизм улс төрийг, ер улс төрийн амьдралыг эдийн засгийн үүднээс үзэж ойлгосноороо тэдгээрийн олон талтай агуулгыг зохиомолоор хумьж, явцуу болгосон гэдэг нь түүнийг бусад үзэл баримтлалуудтай харьцуулахад тодорхой харагддаг.

Өрнөдийн эрдэмтэд улс төрийг эдийн засаг, нийгэм, эрх зүй, ёс зүй, субстанциал, институционал, антропологи, мөргөлдөөн, зөвшилцөл, үйл ажиллагаа, зорилго, системийн арга хандлагаар олон талаас нь авч үзэж янз бүрээр тодорхойлж байгаа юм. Энэ нь улс төрийн агуулгыг олон талаас нь илэрхийлэн гаргах, мөн чанарыг нь гүнзгийрүүлж танин мэдэхэд чухал ач холбогдолтой болох нь тодорхой. Гэвч үүнд сөрөг тал бас байдаг ажээ. Учир нь тэдгээр олон янзын үзэл, хандлага бүхэн улс төрийн мөн чанар, чухал шинжүүдийг тэр бүр тусгаж илэрхийлээгүй тохиолдол цөөнгүй гардагийн дээр тэдгээр нь улс төрийн тухай ерөнхий, интеграл ойлголт бүрэлдэхэд бэрхшээл учруулдаг тал байна.

Ер нь бодит амьдрал дахь улс төрийн олон янзын эмпирик шинж, түүхэн тодорхой илэрэл, хэлбэр, төлөв байдлыг нэгбүрчилэн түүж гаргах, тоочих аргагүй. Асуудалд тийнхүү хандах нь ялангуяа онолын танин мэдэхүйн хувьд үр дүн муутай болохыг эрдэмтэд хэдийнээ ухааран ойлгожээ. Улс төрийг судлахдаа түүний түгээмэл, мөн чанарлаг шинжүүдийг нь хийсвэрлэн нэгтгэх үндсэн дээр түүний идеалчилагдсан, санаалаг загварыг бий болгож тэр дагуу онолын түвшинд судлаж танин мэдэх эхлэлийг германы эрдэмтэн К.Шмитт ба түүнийг дагасан бусад судлагчид санаачилж тавьжээ (4,43). Улс төрийн асуудлын судалгаа орчин үед энэхүү чиглэл бүхий арга зүйд тулгуурлан хийгдэж, онол-танин мэдэхүйн ахиц ололттой үр дүнд хүрч байна. Тэдгээр нь нийгмийн улс төрийн амьдралын үндсэн бүрдэл хэсэгүүд, гол үзэгдэлүүдийг тодруулж гаргах, түүний үндсэн дээр улс төрийн өөрчлөлт, шинэчлэлтийн мөн чанар, хамрах хүрээ, зорилго, тодорхой зорилтууд ба хэрэглэх арга хэрэгсэлүүдийг онолын судалгааны түвшинд илүү үндэслэлтэй танин мэдэх бололцоог өгч байгаа юм.

Улс төр нь: 1) улс төрийн байгууллага (төр, улс төрийн нам, улс төрийн шинжтэй олон нийтийн байгууллага, хөдөлгөөн, фронт, эвсэл, холбоод), 2) улс төрийн хэм хэмжээ (үндсэн хууль, төрийн хууль, эрх зүйн акт, баримт бичгүүд, дүрэм, журам, нам, олон нийтийн байгууллагын мөрийн хөтөлбөр, дүрэм), 3) улс төрийн харилцаа, тухайлбал засаглалын харилцаа (ноёрхол, захирах захирагдах харилцаа, удирдлага, зохион байгуулалт, улс төрийн тэмцэл, өрсөлдөөн, сөргөлдөөн, мөргөлдөөн, зөвшилцөл, хамтын ажиллагаа гэх зэрэг), 4) улс төрийн үхамсар (улс төрийн онол, номлол, үзэл суртал, үзэл санаа, улс төрийн сэтгэл зүй, менталитет, улс төрийн үнэлэмж гэх мэт), 5) улс төрийн соёл (нийгэм, ард түмэн, анги, бүлгүүдийн) гэсэн үндсэн бүрдэл хэсэгтэй. Тэдгээр нь

хоорондоо нягт уялдаа, харилцан нөлөөлөлтэй байж улс төрийн ахуйн оршин тогтнол, хэвийн хөгжлийг хангадаг байна.

Орчин үеийн синергетикийн ухааны дүгнэлт ёсоор нарийн нийлмэл бүтэц, зохион байгуулалттай, өөрөө хөгжих нээлттэй системийн өөрчлөлт нь мөн адил нарийн нийлмэл, цогцолбор чанартай байдаг ажээ. Энэ чанар улс төрийн өөрчлөлтөд ч хамаарч холбогдоно.

Улс төрийн өөрчлөлтийн уг сурвалж, шалтгаан, шинж чанар, илэрэх хэлбэрийн асуудлыг нийгмийн философи, улс төрийн социологи, улс төрийн түүх, улс төр судлал өөр өөрийн аспект, онолоор судлаж ирсний үр дүнд олон янзын үзэл баримтлал, онолын төсөөлөлүүд боловсрогдсон байна. Улс төрийн өөрчлөлт нь улс төрийн амьдралын үзэгдэлүүдийн хамгийн ерөнхий суурь шинж чанар юм. Улс төрийн шинжлэх ухаанд түүнийг улс төрийн үзэгдэлүүдийн бүтэц, үүрэг, хэлбэр, агуулга, шинж чанарууд улс төрийн орон зай, цаг хугацааны тодорхой хэмжээс дотор хувьсаж, модификаци буюу дүрсийн хувиралд орж буй төлөв байдал хэмээн ойлгох нь голлож байна. Улс төрийн өөрчлөлт нь улс төрийн үйл явцтай органик холбоотой, түүний цөм, суурь үндэс нь болдог, гэхдээ танин мэдэхүйд тэдгээрийг хооронд нь адилтгаж болохгүй гэдэг нь улс төр судлалд нэгэнт тогтсон зүйл юм.

Эрдэмтэд улс төрийн өөрчлөлт нь уг сурвалж, шалтгааныхаа олон янз байдлаас хамаарч оршин тогтнол, хөгжил, доройтол гэсэн үндсэн гурван янзын арга, төлөв байдлаар оршдог хэмээн үзэж байна (5,289). Улс төрийн оршин тогтнол (функционирование) бол хэвшин тогтсон төлөв байдалтай хүрээн доторхи хэвийн ажиллагаа ажээ. Улс төрийн хөгжлийн талаар олон янзын санал, шалгуур, үзүүлэлт байдаг. Эрдэмтэдийн зарим нь улс төрийн хөгжлийг зөвхөн улс төрийн системийн хөгжлөөр хэмжиж тайлбарласан бол ихэнх нь түүнийг явцуу хандлага хэмээн шүүмжилж, улс төрийн амьдрал, улс төрийн ахуйг бүрдүүлж буй бусад үндсэн бүрдэл хэсэгүүдийн хөгжлийг ч тооцон анхаарч, цогцолбороор хандах хэрэгтэйг заажээ. Энэ дагуу улс төрийн хөгжил бол улс төрийн систем нь нийгмийн өөрчлөгдөн буй орчин ахуйд уян хатан зохицож дасах, үүргээ амжилттай биелүүлэх бодит чадварын өсөлт, түүнчлэн улс төрийн субъектуудын үйл байдал, ухамсар, соёл, улс төрийн хэм хэмжээнүүдийн цаашдын эерэг шинжийн өсөлт юм гэсэн үзэл санаа товойн гарч байна (6,453-455). Улс төрийн доройтол нь улс төрийн хөгжлийн эсрэг өөрчлөлт төдийгүй улс төрийн хэвийн оршин тогтнол, ажиллагааны алдагдал ажээ.

Улс төрийн өөрчлөлт нь илэрч хэрэгжих, нийгмийн субъектуудын зүгээс зохион байгуулагдах тодорхой хэлбэрүүдтэй юм. Тэдгээр нь нийгмийн өөрчлөлтийн үндсэн хэлбэрүүдийн улс төрийн хүрээн дэх өвөрмөц илэрэл, тухайлбал улс төрийн хувьсгал, шилжилт, шинэтгэл (реформа), шинэчлэлт (модернизация), трансформаци, хувьсал мөн болно. Тэдгээр тус бүрийн мөн чанар, агуулга, хоорондын холбоо хамаарал ба ялгааг эрдэмтэд онолын үүднээс ерөнхийдөө сайтар судлан боловсруулжээ. Гэхдээ тэдгээрийн тухай асуудал, түүний дотор улс төрийн шилжилт, трансформацийн асуудал өнөөгийн

постсоциалист орнуудын улс төрийн амьдралын жишээ баримтын үндсэн дээр багагүй хэмжээгээр шинээр тавигдаж судалгаа, боловсруулалтаа хүлээж байна.

Нийгмийн улс төрийн амьдралын өөрчлөлтийн уг сурвалж, шалтгаан дэлхийн орнуудад нэг талаар олон зүйлээр нийтлэг, ойр төстэй, нөгөөтэйгүүр янз бүрийн орны нийгмийн байгуулал, эдийн засаг, улс төрийн дэглэм, ардчилал, хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын ялгаа, онцлогоос шалтгаалж хоорондоо багагүй ялгаатай байдгийг улс төрийн практик харуулж байгаа билээ. Тийм ялгаа, онцлог нь улс төрийн өөрчлөлтийн уг сурвалж, шалтгааныг үзэх олон янзын үзэл баримтлал, ойлголт боловсрогдож гарсны нэг үндэслэл болсон байна. Тэдгээрийн дотроос орчин үед нөлөөтэй хэвээр байгаа дараах үзэл баримтлалуудыг дурьдах нь зүйтэй.

Марксист-ленинист сургаал улс төр, улс төрийн бодлого нь эдийн засгийн төвлөрсөн илэрхийлэл, эдийн засгийн бааз суурин дээр сүндэрлэж боссон давхарга байдаг учираас тэдгээрийн өөрчлөлт, тодруулж хэлбэл хувьсгалын уг сурвалж, шалтгаан бол эдийн засагт оршдог, тухайлбал үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцааны хоорондын зөрчил мөн гэж үздэг. Үүний улмаас марксист – ленинист онол улс төрийн өөрчлөлтийн өөрийнх нь дотоод эх сурвалж, сэдэл, шалтгааныг бага анхаарчээ. Гэхдээ эл онолын хүрээнд улс төрийн өөрчлөлтийн хамгийн хурц, оргил хэлбэр болох нийгмийн хувьсгал, тэр дотор улс төрийн хувьсгалын нөхцөл, хүчин зүйл, хэрэгжих механизм, хөдөлгөгч хүч, хэлбэр, зүй тогтолын асуудал чухлаар тавигдаж чамгүй боловсрогдсныг дурьдвал зохино.

Элитийн онол, тухайлбал Паретогийн үзэл ёсоор нийгэмд улс төрийн элитүүд ба тэдний ноёрхогч байр суурь битүү тойргоор байнга ээлжлэн солигдож, нэг нь нөгөөгөөр халагдаж байдаг явдал улс төрийн өөрчлөлтийн эх сурвалж, шалтгаан болдог ажээ. Улс төрийн өөрчлөлтийн шалтгааныг М.Вебер харизматик удирдагч, хошуучлагчийн үйл ажиллагаатай, Т.Парсонс нийгэм-улс төрийн янз бүрийн субъектууд харилцан ялгаатай үүрэг гүйцэтгэдэгтэй, “массын нийгэм”-ийн онол (“теория массового общества”) олон түмэн улс төрийн тавцанд түрэн гарч ирдэгтэй холбон тайлбарладаг бол зөрчил, мөргөлдөөний онол чухамдаа нийгэм, улс төрийн зөрчил, мөргөлдөөн бол улс төрийн өөрчлөлтийн гол эх үүсвэр мөн гэж үздэг. Улс төр судлал дахь сэтгэл зүйн чиглэл ба бихевиорист хандлага улс төрийн өөрчлөлтийн шалтгааныг олон нийтийн улс төрийн сэтгэл зүй ба улс төрийн зан байдлын (үйл байдлын) өөрчлөлт, дотоод сэдэлтэй түлхүү холбож ойлгодог.

Дээрхи үзэл баримтлалуудын алинд нь ч үнэний багагүй хувьтай үзэл санаа, сонирхолтой дүгнэлт, өөр өөрийн давуу тал, бас өрөөсгөл хандлага, дутагдал бий. Тиймээс улс төрийн өөрчлөлтийн эх сурвалж, шалтгааныг тэдгээрийн аль нэгээр дангаар нь авч үзэж ойлгохоос болгоомжлох, олон талаас нь хандаж судлах хэрэгтэй гэсэн санааг эрдэмтэд гаргаж байна.

Улс төрийн өөрчлөлт нь өөрийн зөнгөөрөө явагдах урсгал шинжтэй үйл явц биш юм. Түүний шинж чанар, чиглэл, илэрч хэрэгжих хэлбэрт улс төрийн субъектуудын хүсэл

зориг, эрх ашиг, зорилго чиглэлтэй үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэй. Түүгээр ч үл барам улс төрийн шинэтгэл, шинэчлэлт бол угтаа улс төрийн субъектуудын, ялангуяа төрийн тодорхой зорилго чиглэлтэй бодлого, үйл ажиллагааны илэрэл мөн болно.

Улс төрийн өөрчлөлт, шинэтгэл хийх хэрэгцээ шаардлага, түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэрэгсэл, загварууд дэлхийн орнуудад багагүй хэмжээгээр нийтлэг шинжтэйн зэрэгцээ олон янзын хүчин зүйл, нөхцөл байдлаас шалтгаалж орон тус бүрт өвөрмөц онцлогтой, өөр хоорондоо ихээхэн ялгаатай байдгийг эрдэмтэдийн хийсэн харьцуулсан улс төр судлалын шинжилгээ харуулж байна (7). Энд улс төрийн шинэтгэл, шинэчлэлтийн тэдгээр олон янзын хувилбар, загвар, үй олон эмпирик шинжүүдийн талаар тоочиж өгүүлэх аргагүй. Тиймээс тэдгээрийг түгээмэл, нийтлэг шинжүүдээр нь бүлэг болгож ангилах, одоо дэлхийн улс төрийн практикт зонхилж буй үндсэн хэв маягуудыг илэрүүлж гаргахыг хичээх нь илүү зүй зохистой болно.

Улс төрийн өөрчлөлт, шинэтгэлийн хувилбар, загвар, хэв маягуудыг илэрүүлж ангилах нь тодорхой судалгаа шаардах хялбаргүй ажил юм. Тэдгээр хувилбар нь судлагч юуг шалгуур, үзүүлэлт болгож, сонгож баримталсан байна вэ гэдгээс шалтгаалж тоо хэмжээ нь өсөж багасадаг, дотроо задардаг, бас хоорондоо нийлж анги бүлэг болдог байна. Улс төрийн шинэтгэл, шинэчлэлтийг хэрэгжиж ирсэн түүхэн үе шатаар нь, дангаараа юм уу эсвэл эдийн засаг, оюун санааны амьдралын шинэтгэлтэй давхцаж, зэрэг хийгдсэн эсэхээр нь, тавьсан зорилго, чиг баримжаа болгосон загвараар нь, түүнчлэн нийгмийн нэг байгуулал, улс төрийн нэг дэглэмийн хүрээнд хийгдсэн байна уу, эсвэл тэдгээрийн нэгээс нөгөөд нь шилжих явцад хийгдсэн байна уу гэх зэрэг олон янзын шалгуур, үзүүлэлтээр хандаж судалсан, ангилаж хуваасан туршлага байгаа юм.

Бид энд нийгэм, улс төрийн нэг байгууллын хүрээнд жамаараа аажмаар, хувьсалын аргаар явж буй улс төрийн өөрчлөлт ба нөгөөтэйгүүр нийгмийн нэг байгууллаас, тухайлбал социализмаас капитализмд, улс төрийн ардчилсан бус дэглэмээс ардчилсан дэглэмд шилжин орж буй постсоциалист орнуудад хийгдэж буй улс төрийн хувьсгалт шинэтгэл, трансформаци буюу өөрчлөлт бүхий үндсэн хоёр том хэв загвар орчин үеийн улс төрийн практикт хэрэгжиж байна хэмээн төсөөлж байгаа болно. Эхний хэв маягт багтах улс төрийн өөрчлөлт, шинэтгэл нь өрнөдийн өндөр хөгжилтэй орнууд, Ази, Латин Америкийн хөгжиж буй орнууд ба дэлхийн ядуу буурай орнуудад дотроо харилцан ялгаатай өөр өөр загвар, хувилбар, өвөрмөц онцлогтой арга замуудаар явагдаж байна. Тухайлбал өнөөгийн өрнөдийн хөгжилтэй орнуудад явагдаж буй улс төрийн өөрчлөлтүүд нь хөгжиж буй, хоцрогдсон орнууд дахь өөрчлөлтүүдээс ихээхэн ялгаатай болохыг харьцуулсан улс төр судлалын шинжилгээний үр дүн харуулж байгаа ажээ (8). Өрнөдийн орнууд дахь улс төрийн өөрчлөлтүүдийг шинэтгэл, эсвэл язгуур шинжтэй трансформаци гэхээсээ илүү улс төрийн системийг боловсронгуй болгоход чиглэгдсэн аажим, хэвийн хувьсалын өөрчлөлт гэж нэрлэвэл үнэнд илүү нийцэх талтай хэмээн зарим эрдэмтэн үзжээ (9,9).

Хоёр дахь хэв загварын буюу өнөөгийн постсоциалист орнууд дахь улс төрийн өөрчлөлт нь язгуур шинжтэй шинэтгэл, дутуугаа нөхөх шинэчлэлт, шилжилтийн шинж агуулгатай трансформаци хослосон, хамрах хүрээ, зорилгоороо нийгмийн улс төрийн амьдралыг бүхэлд нь, юуны өмнө улс төрийн хуучин дэглэм ба системийг өрнөдийн либерал ардчиллын зарчим, үнэт зүйлсийн дагуу хувьсгалт ёсоор өөрчилж шинэтгэх цогцолбор үйл явц байгаа болно. Энэхүү өөрчлөлт дэлхийн орнуудын нийгэм, улс төрийн түүхэнд гарч байсан өөрчлөлт, шинэтгэлүүдээс олон зүйлээр ялгаатай байгаа бөгөөд тэдгээрийг улс төрийн өөрчлөлтийн талаархи уламжлалт онол, үзэл баримтлалуудаар нэг мөр тайлбарлаж ойлгоход багагүй бэрхшээлтэй байна. Тэдгээр нь энэ чанараараа ул суурьтай, бие даасан судалгаа шаардаж буй танин мэдэхүйн шинэ бөгөөд сонирхолтой объект болж байгаа юм.

Улс төрийн шинэтгэл хийх арга зам, технологийн асуудлыг судлан боловсруулах явдал өнөөгийн практик зорилтуудтай уялдаж чухлаар тавигдаж байна. Холбогдох зарим ном бүтээлд, ихэвчлэн улс төрийн практикт улс төрийн шинэтгэл, шинэчлэлт хийх нь зөвхөн улс төрийн систем, түүний байгууллагууд ба хууль, эрх зүйн шинэтгэлээр хязгаарлагддаг мэтээр үзэж ойлгох явдал багагүй гардаг. Энэ бол ташаа ойлголт, явцуу хандлага юм. Практикт улс төрийн шинэтгэл нь хэлбэрийн хувьд голцуу улс төрийн систем, түүний албан ёсоор үйлчилж буй хууль, эрх зүйн тогтолцоог шинэтгэхээс эхэлдэг нь бодит баримт билээ. Түүнчлэн энэ зорилтыг хэлбэрийн талаас нь харьцангуй богино хугацаанд хэрэгжүүлж болдогийг амьдрал харуулж байна.

Гэтэл нийгмийн улс төрийн амьдралын хөгжил, шинэтгэлийн үр дүн, түвшинг зөвхөн улс төрийн системийн байгууллагуудын хэлбэрийн талын шинэтгэлээр хэмжиж үнэлэх, хүсэж хүлээсэн үр дүнд хүрлээ хэмээн үзэх аргагүй. Учир нь нийгмийн субъектуудын улс төрийн ухамсар, улс төрийн соёл, хэвшин тогтсон зан байдал, үнэлэмж нь улс төрийн амьдралд дутуу үнэлэх, тооцож анхаарахгүй байхын аргагүй жин дардаг чухал үзэгдэлүүд бөгөөд гэтэл тэдгээрийг тусгайлсан бодлого, зохицуулалт, зохион байгуулалтаар, албан ёсоор, тэр тусмаа богино хугацаанд өөрчилж шинэтгэх аргагүй. Тэдгээр нь нийгэм, эдийн засаг, улс төрийн тааламжтай объектив нөхцөл бүрэлдэхийн хэр хэмжээгээр, шаардлагатай объектив хүчин зүйлийн идэвхтэй, зорилго чиглэлтэй нөлөө оролцоогоор харьцангуй удаан хугацаанд аажим өөрчлөгдөж шинэчлэгддэг байна.

Улс төрийн систем нь нийгмийн улс төрийн ахуйд бие даасан байр суурь эзэлдэг, улс төрийн амьдралыг эмхлэж журамлах идэвхтэй хүч бүхий харьцангуй тусгаар байгууламж байдаг. Гэвч түүний өөрчлөлт, шинэтгэлийг дан өөрийнх нь тэрхүү бие даасан хүрээн дотор, өөрийг нь өөрөөр нь хэмжиж хандвал дутагдал, өрөөсгөл байдал гарна. Учир нь улс төрийн системийн гүн гүнзгий, жинхэнэ агуулгын шинэчлэлт, үүргээ гүйцэтгэх чадварын дээшлэлт, үйл ажиллагааны эерэг бодит үр дүн нь иргэд, нийгмийн томоохон бүлгүүдийн улс төрийн соёл, ухамсар, үйл байдлын өөрчлөлт, шинэчлэлтээс, нэг үгээр хэлбэл хүний улс төрийн шинж чанаруудын шинэчлэлтээс мэдэгдэхүйц хэмжээгээр шалтгаалдагийг практик харуулж байгаа билээ. Улс төрийн систем үндсэн бүрдэл

хэсэгүүдээрээ жигд тэнцүү, мөн хүний орчинтойгоо нягт холбоотойгоор шинэчлэгдэж байж улс төрийн амьдралын шинэтгэл ба нийт нийгмийн өөрчлөлт, шинэтгэлд түлхэц, эрч хүч өгөх оньсон хөшүүрэг болж чадах ажээ.

Улс төрийн өөрчлөлт, шинэтгэлийг өөрийн нь зайлашгүй шаардлагаар нь, тодорхой зорилго чиглэлтэйгээр жолоодож, нийгэмд үр өгөөжтэй, доргио донсолго, “бэртэл” багатай, гэхдээ бүрэн, тууштай хэрэгжүүлэх зорилт дэлхийн олон оронд, ялангуяа постсоциалист орнуудад, түүний дотор Монгол Улсад тулгаран тавигдаж байна. Түүнийг хэрэгжүүлэх явдал харьцангуй урт хугацаа, нийгэм-улс төрийн идэвх, хүч энерги, улс төрийн ухаан, урлаг, чадвар шаарддаг, асар их хариуцлагатай түүхэн том зорилт болно. Тиймээс хэрэв тэр талаар алдаа гаргавал нийгэм, ард түмний амьдрал, хувь заяанд ихээхэн “бэртэл”, хохирол учруулдгийг постсоциалист хэд хэдэн орны сүүлийн хориод жилийн улс төрийн туршлага харуулж, сургамжлан сануулж байна.

Ишлэл, зүүлт

1. Марксистско–ленинская теория исторического процесса. Исторический процесс: целостность, единство и многообразие, формационные ступени. М.,1983
 - Материалистическая диалектика. В пяти томах. Том 4. Диалектика общественного развития. М., 1984
 - Материалистическая диалектика как общая теория развития. В 4-х томах. Том 4. Диалектика общественного развития. М., 1987
 - Панарин А.С. Философия политики.М.,1996
 - Гаджиев К.С. Политическая философия. М.,1999
 - Штраус Л. Введение в политическую философию. М.,2000
 - Вольф Ж. Улс төрийн философийн удиртгал. Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун. УБ., 2002
2. Панарин А.С. Философия политики.М.,1996
3. Панарин А.С. Политология.Учебник. 2-ое изд. М.,2001
4. Шмитт К. Понятие политического. –Вопросы социологии. М.,1993. Т.1
5. Соловьев А.И. Политология: политическая теория, политические технологии. Учебник для вузов. М.,2001
6. Политология. Учебник для вузов. Под ред. М.А.Василика. М.,1999
7. Чарльз Ф.Эндрейн. Сравнительный анализ политических систем. Эффективность осуществления политического курса и социальные преобразования. Пер. с англ. М., 2000
 - Довчин Ё.Харьцуулсан улс төр. Уб.,2006
 - Мартин Сланн. Улс төрийн удиртгал. Хүйтэн дайны дараах эрин үеийн засгийн газрууд ба үндэстнүүд. (Англи хэлнээс хөрвүүлсэн Ё.Довчин). УБ.,2005
8. Мөн 7-д дурдсан зохиолууд
9. Данилов А.Н. Переходное общество: Проблемы системной трансформации. Минск, 1998

УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХЭНД БҮТЭЭГДСЭН БОСЛОГЫН ҮЗЭЛ СУРТАЛ

С.Базарпүрэв

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Анги бүлгийн зохион байгуулалттай аль ч улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тогтож буй төр, улс төрийн дэглэм, хууль тогтоомж мөн ард түмний эрх ашгийг хамгаалж байгаа дүр эсгэн, шударга нийгмийг шуурхай байгуулах санал дэвшүүлсэн үзэл сурталд сэтгэл дундуур байдаг иргэд байсан одоо ч багагүй байна.

Эдүүгээ ноёрхон буй улс төрийн эрх баригч ард түмнийг дарангуйлж байгаа хэмээн үзэгсэд ирээдүйн нийгмийн дэвшил, өөрчлөлт, шинэчлэлт хийгдэх нөхцөл бүрдүүлэхийн тулд оршин байгаа засаглал, засаглагчийг хүчээр албадан үгүй хийх санаа, санаархал ч байнга орших ажээ.

Ийм радикал үзлийг тээгчид өөрсдийн талынхныг төрийн эргэлт хийх, хувьсгалыг хэрэгжүүлэн, ард түмнийг бослогот уриалан турхирч байдаг. Бослогын үзэл сурталчдийн дэвшүүлсэн бодол санаа их амь бөхтэй, улс төрийн сургаал бүтээгчдийн ярьж бичих “дуртай” сэдвийн нэг юм. Үүнтэй төстэй аядуу үзэл нийгмийн ухамсарт цөөнгүй төлөвшсөн байдаг.

Хувьсгал, улс төрийн эргэлт, бослого зэрэг ойлголт нь эрэгцүүллийн нэг сэдэвт багтах боломжтой ч тодорхой ялгаа байх учиртай гэж үздэг улс төрийн сургаал ч бий.

Хувьсгалыг нийгмийн бүтцэнд эсвэл түүний нэг чухал хэсэгт агшин зуур өөрчлөлт хийхтэй ижилсүүлэн адилтгасан байна / Theda Skocpol "States and Social Revolutions: a Comparative Analysis of France, Russia, and China" Harvard University Press., 1979/. Хувьсгал нь хүчирхийллийн замаар эсвэл харьцангуй тайван хэрэгжиж, төрийн засаглал шинэ ангийн гарт шилждэг гэсэн байр суурь нилээд түгээмэл юм.

Улс төрийн эргэлт гэдэг нь үндсэн хуулинд харшилсан, ихэнхдээ хүчирхийллийн аргаар засгийн эрх нэг ангиас нөгөө ангид, нэг улс төрийн элит, фракц бүлгээс нөгөөд шилждэг үйл явц гэж үзээд цэргийн, төрийн, ордны гэдгээс үл хамааран улс төрийн эргэлт нь төрийн төрөл ангийг сольж өөрчилдөггүй гэсэн дүгнэлт хийж болох талтай. Төрийн механизм түүний үйл ажиллагаанд хэсэгчилсэн, өнгөц өөрчлөлтийг хийдэг байна.

Тухайн төрийн байгуулал, хэлбэрийг үндсээр нь халж, шинээр солих эсвэл тухайн төрийн байгууллын үндсийг хэвээр орхин төрийн дээд эрх мэдлийг авах эсвэл тухайн төрийн байгууллыг улам бататган бэхжүүлэх эсвэл ганхуулах мөн тухайн төрийн байгууллыг

бүхэлд нь хэвээр үлдээн хэсэгчилсэн шинэчлэл, өөрчлөлт, татан буулгах ажил хийх нь төрийн эргэлтийн зорилго хэмээн Аристотель тодорхойлсон байдаг.

Төрийн тодорхой төрөл ангийг зайлшгүй хүч хэрэглэн солих гэсэн санааг үндэслэн нийгмийн тодорхой анги, бүлгийн сонирхлыг илэрхийлсэн улс төр, ёс суртахуун, шашин, философийн үзэл санааны системийг бослогын үзэл суртал хэмээн тодорхойлж болно. Бослого гаргах эрхийн талаарх онолын тайлбар нь тухайн үзэл суртлын үндэс суурь болдог билээ.

Улс төрийн сургаалын түүхэнд бослогын үзэл суртал чухал байр суурь эзэлж нийгмийн “хөгжилд” дэвшил авчирсан гавьяатай.

Дундад зуунд бослогын үзэл суртал реформацийн радикал мөрийн хөтөлбөрт /Т.Мюнцер, Ж.Кальвин, 1419-1437 оны гусийн хувьсгалт хөдөлгөөн/ багтан сүм хийдийг “ардчилан” хөрөнгөтний ертөнцийг үзэх үзлийн төлөвшилтөнд хүчтэй нөлөөлсөн байна.

Хөрөнгөтний хувьсгалын үед яг бослогын үзэл суртал нийгмийн харилцааг ардчилах, хөгжил дэвшлийг тодорхойлсон байдаг. АНУ дахь тусгаар тогтнолын төлөө дайныг нөхцөлдүүлсэн гол хүчин зүйл нь бослого гаргах эрх байв.

XX зуунд тухайн үзэл суртал нь дэлхийн олон оронд тогтож байсан колонийн тогтолцоог үгүй хийхэд их үүрэг гүйцэтгэсэн гэдгийг ази, африк, америкийн олон орны түүх гэрчилж байна.

Нийгмийн байгуулалтыг өөрчлөн байгуулах зорилго агуулсан улс төр, шашны болон бусад философийн үзэлтэй өрсөлдөн тэмцэлдэх явцад бослогын үзэл суртал “бойжин” төлөвшсөн аж.

Улс төрийн сургаал боловсрох явцад ямар ч нөхцөлд засаглалд үг дуугуй захирагдах ёстой гэх номлол байхад нөхцөл шаардлагаас болж бослого гаргах эрх байх учиртай гэсэн сөрөг байр суурь идэвхтэй яригдаж байжээ.

Философи, улс төрийн сэтгэлгээний томоохон төлөөлөгч болох И.Кант ард түмний бослого гаргахын эсрэг тууштай зогсон тэдэнд тийм эрх байхгүй гээд гарал үүслээс нь үл хамааран өнөөдөр оршин тогтнож байгаа засаглалд захирагдах болно гэжээ. Хууль тогтоогч төрийн тэргүүний эсрэг ард түмэн эсэргүүцэх эрхгүй. Тэднийг бүх нийтийг зохицуулах хуульд захируулснаар эрх зүйт тогтолцоо боломжтой болно. Тиймээс төрд дургүйцэх ямар ч эрхгүй, тэх тусмаа бослого гаргах. Эрх мэдлээ хортойгоор ашиглалаа гэх шалтгаанаар хааны эрх мэдэл, амь насанд халдах эрх олон түмэнд байхгүй. Харин эх орноо хөнөөх оролдлого хэмээн үзэн төрөөс уравсан гэмтэнг цаазлах хэрэгтэй гэж И.Кант үзэж байв /Кант И. Метафизика нравов., Соч. В 6 томах/.

Консерваторууд, либералуудын ихэнх нь хувьсгал хийж нийгмийн хөгжлийг хангана гэсэн үзлийг үгүйсгэж байдаг. Социал-демократууд ч хувьсгалт хүчирхийллийг шүүмжлэн эсэргүүцдэг билээ.

Радикал хувьсгалт үзэлд сөрөн гарч ирж XX зууны туршаад идэвхтэй сурталчилагдаж байсан хүчирхийллийн бус эсэргүүцлийн концепцийг Л.Н.Толстой, М.Ганди, М.Кинг нар дэвшүүлсэн байдаг.

Оросын зохиолч Толстой христийн сургаалд тулгуурлан хүчирхийлэлд эсэргүүцэхгүй байх үзлийг санал болгож байжээ. Хүлцэнгүй байдлаар харгис хүчийг ялна. “Бүү уурал, тэвч, дайснаа хайрла...Хэрвээ бүгд ингэж амьдарваас хувьсгал хийх хэрэггүй билээ”. Хортонтой тэмцэх цорын ганц арга нь засаглалын буруу үйл ажиллагааг нийтэд уудлан илчлэх, идэвхгүй байж, эс захирагдах явдал гэжээ /Толстой Л.Н. Божеское и человеческое., Собр.соч. в 12 томах/.

Нийгмийг хувьсгалт үйл ажиллагаагаар өөрчлөх боломжийг үгүйсгэн хүчирхийллийн бус аргаар үндэсний эрх чөлөөний тэмцлийг Энэтхэгт хэрэгжүүлэх бодлого барьж байсан ажээ. Төрийн эрх мэдэлтэнтэй хамтран ажиллахгүй байх, үл захирагдах иргэний байр суурь баримтлахыг нийгэм-улс төр, шашин-философийн сургаал номлогч Ганди санал болгож байв.

АНУ-д негр иргэдийн эрхийн төлөө тэмцлийг зохион байгуулж байсан Кинг хүчирхийллийн бус тэмцлийг сурталчилж байв.

Засаглалд хүчирхийллийн бус эсэргүүцэл үзүүлэхийг номолсон дээрх байр суурь нь бослогын үзэл сурталд альтернатив үзэл болон өрсөлдөж, олон оронд нийгмийн янз бүрийн анги давхраанд дэмжлэг авч хүчирхийллийн уур амьсгалыг нийгмээс зайлуулан радикал-хувьсгалт үзлийг нийгмийн ухамсраас ангижруулахад их хувь нэмэр оруулсан хэмээн үлэмж үнэлэгдсэн тал бий.

Нийгмийн хөгжилд нөлөөлөх хүчин чадал нь суларсан ч бослогын үзэл суртал улс төр нийгмийн үйл явцад тодорхой байр суурь эзэлж, өөрийн гэсэн тодорхой нийгмийн дэмжигч бүлэг давхраатай байдаг. Мөн уг үзэл суртлыг үе үе өдөөн идэвхжүүлж байдаг улс төрийн хүч, лидерүүд байна.

Бослогын үзэл суртал амь бөхтэй байдаг нь нэгд, тухайн үзэл энгийн, ойлгомжтой байдагт, хоёрт улс төрийн сэтгэлгээний түүхэнд онолын хувьд гүнзгий боловсрогдсон, гуравт, нийгэм-эдийн засаг, улс төрийн хүндрэл бэрхшээл, зөрчил мөргөлдөөн нь засаглалыг үзэн ядах санаа бодлыг тэжээн тэтгэж байдагтай холбоотой билээ.

Засаг төр баригчийн зан үйл, үзэл суртал, улс төрийн бодлого, шийдвэр, захирамжаас бослого гарах үзэл санаа, үзэл суртал үүсэн бүрэлдэх шууд хамааралтай юм.

Бослого гаргах эрхийн асуудал төр, засаг баригч субъектын хувь заяатай холбогдон тавигдаж байсан онцлогийг улс төрийн сургаал, номлол бүрт ямар нэгэн байдлаар ажиглаж болно. Эрт эдүүгээ бүтээгдсэн улс төрийн сургаал, номлол, үзэл суртал нь улс төрийн болон төрийн засаглалын эрх мэдлийг барьж буй субъектийн улс төр-эдийн засгийн эрх ашиг, сонирхлыг хамгаалж байдаг нь улс төрийн зүй тогтол болжээ. Тиймээс ч улс төрийн сургаал ихэвчлэн засаглагч субъектын захиалгаар бүтээгдэж байв. Мөн засаг, төрийн тэргүүн нийгмийн нийтлэг эрх ашгийг харгалзан үзэж байхыг сануулан захирагч түшмэл, олигарх ноётонд зохистой хэм хэмжээнд бие сэтгэл үйлдлээ дэглэн зөв зүйтэй авч явах зөвөлгөө өгсөн сургаал түгээмэл байв. Энэ нь бас л засаглагчийн эрх ашигт нийцсэн байдаг гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Бослого гаргах эрхийн үзэл суртлын философийн үндэслэл их эртнээс шашны, иргэний, шинжлэх ухааны гэх мэт олон төрөл янзаар хийгдсэн түүхтэй.

Бослогын зорилгыг тодорхойлох байр суурь янз бүр байв. Төрийн засгийн эрхийг өөр нэг анги булаан авах, нийгмийн харилцааг өөрчлөн шинэчлэх, хуучин тогтолцоог сэргээн тогтоох зэрэг асуудал их яригдаж байдаг. Бослого гаргах эрх эдлэгчийн тоонд төлөөний байгуулга, сүм хийд, ард түмэн гээд олон субъектийг багтаасан байна. Улс төрийн сургаалд бослогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэлийг сурталчилсан олон төрлийн байр суурь бий. Засгийн эрхийг хүчээр булаан авах үзэл давамгайлж байхад төрийн эрх мэдлийг хязгаарлах санаа бүхий номлол бас байх жишээтэй. Бослогыг нарийн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан сургаал ч байна. Гэвч дийлэнх сургаалд бослого гаргах эрхийг зөвхөн тунхаг төдий хязгаарлсан байдаг. Эртний Египетийн улс төрийн сэтгэлгээний түүхэнд бүтээгдсэн улс төрийн сургаалд уг сэдэв тодорхой тусгагдсан байна.

“Төр нийгмийг удирдаж дэг журмыг тогтоохдоо энгийн номхон ард олонд хэтэрхий хатуу харгис хандахгүй байх, зовж зүдэрсэн, өнчирч бэлэвсэрсэн зэрэг доодсыг хамгаалж халамжлах, үнэнийг эрхэмлэх талаар...заажээ. Дээдэс, захирагчид ард олныг хэрээс хэтэрч дарлаж зовоох нь нийгэм төрийг тогтворгүй болгож үймүүлэхэд хүргэнэ” хэмээн дүгнэж бослого гарах шалтгааныг тодорхойлсон байна. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001./

“Гэвч энэ нь тууштай эрхэм зорилго биш, төр, нийгмийг удирдаж засаглах арга хэрэгсэл байжээ. Эзэн хаан, засагт дургүйцэл илэрхийлбэл хэнийг ч алж устгахыг зөвлөсөн байна. Хааны эсрэг босож тэмцэгчид ба өмч хөрөнгөнд халдагсдыг хайр найргүй хяргаж нух” гэжээ. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001./

“Хүн бүхэн нийгэмд эзэлсэн өөр өөрийн байр суурь, хэр хэмжээгээрээ байх ёстой...удирдагч, захирагчдад онцгой хүндэтгэл, бишрэлтэйгээр хандвал зохино...захирагчийн дэргэд нуруугаа нугалтал бөхий, тэгвэл орон гэр чинь ая тухтай байж, өргөдөл гомдол чинь барагдана. Захирагчийг эсэргүүцсэн хэн боловч муугаа үзнэ” гэж сургаалд заасан нь шагнал шийтгэлийг хослуулан байж бослогыг гаргуулахгүй байж болох талаар улс төрийн номлол боловсруулсан байна. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001./

Эртний Египетийн улс төрийн сэтгэлгээний чухал сурвалж бичгийн нэг бол “Ипусерийн сургаал” юм. “Үймсэн харц олны бослого тэмцлийн улмаас аж ахуй уналтанд орж, улс орон эмх замбараагүй байдалтай болсон” хэмээн бослогын үр дагавар, сөрөг талыг тэмдэглэсэн байна. Мөн Ипусер сургаалдаа бослогын “гол шалтгаан бол төр, төрийн аппарат сулран эвдэрсэн, эзэн хааны засаглалыг түлхэн унагаасан, нийгэмд дээдэс доодос гэхгүйгээр бүх хүн эрх тэгш болж хувирсан явдал юм” гэж үзжээ. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001./

Эртний Вавилоны нэгэн бичигт “хэрэв эзэн хаан хууль цааз, эрх зүйг баримталж хүндэтгэхгүй юм бол хүмүүс түүнийг жигшин зэвүүцэх ба улс орон ч уналт доройтолд

орно” гэж бослого гарах эх үүсвэрийг оновчтой тодорхойлсон байна. Хаммурап хааны хуулийн оршил хэсэгт “улс оронд шударга ёсыг мандуулан тогтоох, хууль ёсыг зөрчигчид, нүгэлтэй муу явдалтнуудыг хөнөөж устгах, хүчтэн нь дорой буурайгаа шахан дарангуйлахгүй болгох” явдлыг тогтоосонор “нийгэм тайван тогтвортой, нэгдмэл, бүрэн бүтэн байх, эзэн хааны түшиг тулгуур өргөжиж бэхжихэд ач тустай болно” гэж бослого гаргуулахгүй байх үндсэн нөхцлийг зааж өгчээ. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001./

Эртний Энэтхэгийн улс төрийн сэтгэлгээний брахманизмын үзэлд, нүгэл буянаар дэнслэн хүлцэнгүй тэвчээртэй байлгах гэсэн байр суурийг засаг баригчид баримталж байжээ. Бурхан тэнгэрээс тогтоосон хууль, ариун үүрэг, шаардлага заалтыг үнэнч шударгаар сахиж биелүүлэх ёстой. Түүнийг зөрчих нь гэм нүгэл болох ба түүний төлөө хойт насандаа шийтгэл, цээрлэл хүлээнэ. Хүн энэ насандаа ядуу дорой, зовж зүдэрч аж төрж байгаа бол тэр нь урьд насандаа хийсэн нүгэл, дхармаг зөрчсөний хариу шийтгэл, цээрлэлт болно. Брахманизм тийнхүү нийгмийн оршин буй дэг журам, зохион байгуулалт, улс төрийн дарангуйлалыг дхармагийн тухай шашны үзлээр зөвтгөж бататгахыг хичээжээ. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001/

Эртний Хятадын түүхэнд Күнзийн нийгэм, улс төрийн сургаал томоохон байр суурь эзэлдэг. Нийгмийн дэг журам, удирдлага, хэвийн тогтвортой байх талаар сургаал айлдсан байна. Юуны өмнө “эд баялгийг тэгш хуваарилсан цагт ядуу байдал үгүй болно. Улс оронд тэгш байдал, зохицол, тогтож ноёрхсон байхад хүн ард гачигдаж зовохгүй дээдэс доодсын хооронд эе эв, энх тайван тогтож ноёрхсон цагт эзэн хааныг түлхэж унагаах аюул осол гарахгүй” гэж сургжээ. Күнз нийгмийн амгалан тайван байдал, иргэдийн хоорондын эвтэй найрсаг харилцааг эрхэмлэн үзэж иргэний дайн, бослого, засгийн эрхийн төлөө тэмцлийг жигшин эсэргүүцэж байв. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001/

Төр баригч эрхэмсэг агуу ч дээрэнгүй бус, хатуу ч харгис бус байх ёстойг Күнз сануулж байв. /История китайской философии. М., 1989/. Хүчирхийллийн аргаар нийгмийг удирдахыг эсэргүүцэж, төрийн хар хүний ёс суртахуун, зан үйл зөв байвал бүх зүйл аяндаа зохицуулагдан эс тэгвээс ард түмэн захирагчийн тушаал албадлагыг үл ойшоон дуулгаваргүй загнах болно гэжээ. /Гусейнов А.А. Великие моралисты. М.,1995., Малявин В.В. Конфуций. М., 1992/ Ийнхүү Күнз нь Платоны нэгэн адил төрийн тэргүүн нь улс орны нөхцөл байдалд санаа тавьсан ухаантай цэцэн мэргэд байх ёстой гэж үзэж байжээ. /Древнекитайская философия. М., 1972. Т.1./ Шударга бус, гэм зэмтнээр шударга олныг удирдуулбал ард олон задарч захирагдахгүй болно. Сайн үйлийн үлгэр жишээгээр удирдан нөлөөгөө тогтоовол хүн ард ичих зовохыг мэддэг болохоор барахгүй засарч үнэнч шударга болно, дуулгавартайгаар захирагдана хэмээн Күнз номлсон байна. Ард түмний дургүйцэл, бослого гарах үндсэн шалтгааныг төрийн тэргүүний мэдлэг чадвар, хувийн жишээ, ёс суртахуунтай холбон үзсэн байна.

Аристотель “Улс төр” зохиолдоо төрийн бослого түүний шалтгаан, илрэх хэлбэр, тэдгээрээс сэрэмжлэх талаар тодорхой дурьдсан байна. Бослого гарах үндсэн шалтгаан нь тэгш байдал алдагдах явдал хэмээн тодорхойлсон байна. Тэгш байдал алдагдснаар төрийг бүрдүүлж буй хүн амын хэсэг бүлгийн хооронд хэрүүл маргаан, тэмцэл үүсэж өрнөнө. /А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх (эртний үе) УБ., 2001/

Үүний нэгэн адил Халкедоны Фалей нийгэмд үүсэж гарах аливаа замбараагүй байдал, зөрчил тэмцлийн эх үндэс нь өмч хөрөнгийн тэгш бус байдал гэжээ.

Бослого, үймээний шалтгааныг тогтоохын тулд бослого гаргаж буй хүмүүсийн санаа сэтгэлийг, юуны төлөө босон тэмцэж байгааг мөн тэмцэл юунаас эхэлдэгийг илрүүлэх хэрэгтэй. Баян ядуусын туйлыг багасган, дунд зэргийн хөрөнгө чинээтэй иргэдийн тоог өсгөх, албан тушаалтанд хялбар ашиг олох, хөрөнгө завших бололцоо олгохгүй байх, нийгмийн баялгийг чанд хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй ингэснээр бослого гарах нөхцөл үгүй болно гэсэн дүгнэлтийг Фалей хийсэн байна.

Мөн үүний зэрэгцээ хэрцгий төр ч бослого гаргуулахгүй хэмээн арга зам сүвэгчилдэг байна. Уг засаглал олон түмнийг бослого гаргах тэнхэлгүй болгох олон зүйлийн арга хэрэгслийг ашигладаг талаар Аристотель дурьдсан байна. Засаглагч овжин заль хэрэглэж хууран мэхлэхээс гадна ард олныг хооронд нь сөргөлдүүлж дарангуйлагчийн эсрэг хамтран тэмцэх боломжгүй болгон, иргэдийг айлган сүрдүүлж, эрүүл саруул уур амьсгалыг дарж, хүмүүсийн нэгдэл нягтралыг үгүй болгон, сэтгэн бодох үйлдэлд хатуу хяналт тавьж, зав чөлөөгүй ажиллуулж, аян дайн байнга хийдэг гэжээ. Хэрцгий засаг төрийн гаж буруу хэлбэрийн дотроос адгийн муу нь хүний мөн чанарт харш гэж Аристотель шүүмжилсэн байна.

Бослого төрийн тогтвортой байдлыг алдагдуулдаг их аюултай улс төрийн үйл явдал хэмээн Аристотель үзэж түүнийг гаргуулахгүй байх талаар санаа тавих хэрэгтэйг эрх баригчид зөвлөжээ.

Сайн санаатай, эрэлхэг зоригтой, дарангуйлагчийн хэрцгийллийг үл тэвчих хүмүүс бослого тэмцэл хийх санаа гарган ард түмний дэмжлэг тусламжтайгаар харгис хэрцгий төрийг түлхэн унагааж язгууртны төрийг тогтооно гэж Полиби үзсэн байна.

Бослого гарах эрхийн талаар шашны сургаал бүтээгчдийн номлолд бишгүй бий. Засаглагчийн үйл ажиллагаа бурханы сургаалаас хазайсан тохиолдолд сүм хийдийн сонирхолд харшилдаг. Тиймээс албат иргэд тухайн үйлдэлд эсэргүүцэл үзүүлэх эрхтэй гэж Аквины Фома үзжээ. Бурханы номлолд тохирохгүй зүйл хийхийг тулгах эсвэл засаглагч хүрэх ёсгүй хүний оюун санааг эзэмдэх гэж оролдсон тохиолдолд төрийн эрх баригчид захирагдахгүй байж болно гэжээ. Ард түмэн тэмцэлд босч засаглагчийг эрх мэдлийн сэнтийгээс түлхэн унагаах бүрэн эрхтэй хэмээн Фома үзээд энэ нь тийм ч их нүгэл биш. Нийгмийн шийдвэрээр дарангуйлагчийг цаазалж болно.

Гэвч гол нь бослого ашиг авчрах ёстой гэж онцлон үзэж байв. Бурханы сургаал, сүм хийдийн ашиг сонирхолд босогчдын зорилго нийцэх учиртай гэсэн Фомагийн дэвшүүлсэн теологийн тайлбар нь явцуу номлол шиг боловч тэр үеийн бодит байдлыг

илэрхийлэн илчилж байв. Босогчид өөрийн тодорхой хэрэгцээг хангах гэсэн бодолтой байдаг ч түүний үйл явц, ажиллагаанд тухайн үеийн эрх баригч улс төрийн хүч, ялангуяа түүний сөрөг тал идэвхтэй оролцдог байна. Дундад зууны үед сүм хийд төрийн засаглалын төлөө шургуй тэмцэл өрнүүлж амжилтанд хүрч байсан түүхтэй. Шашны үзэл суртал, сүм хийдийн эрх ашиг, сонирхолд таарж тохирсон ард түмний бослогыг дэмжиж оролцдог байжээ.

Реформацын эрин үед ч бослогын үзэл сурталыг идэвхтэй боловсруулж байв. Кальвины сүм хийдийг үндэслэгч Жан Кальвин хууль бус үйлдэлтэй, дур зоргоороо аашилж хүчирхийлэгч засгийг бурхан гэсгээнэ гэж үзжээ.

Нийгмийн хэрэгцээг хангах нэрийдлээр ард түмнийг татвараар дарамтлахгүй байх мөн иргэдийг хавчиж гадуурхагчийг хамгаалж хаацайлахгүй байх нь эзэн хааны үүрэг гэжээ. Эс тэгвээс нийгмийн тогтворгүй байдал үүсч шударга байхыг хүсэмжлэх болно. Ард түмэн дарангуйлагчийг эсэргүүцэх онц бүрэн эрхтэй хэмээн Кальвин үзэж байв. Үүнээс гадна бослого гаргах эрхийг засаглалын байгууллага, сүм хийд, төлөөний байгууллага эдлэнэ гэж номлоод дургүйцлээ илэрхийлэх хууль ёсны арга хэрэгсэл шавхагдсан тохиолдолд зэвсэгт бослого гарган дарангуйлагчийг түлхэн унагаана гэсэн үзэл санааг дэвшүүлжээ.

Варфоломын шөнийн дараа францын кальвинист-гугенотууд монархомах И.Жантйе, Ла Боэси нарын бүтээлийг идэвхтэй сурталчилах болов. Эдгээр зохиолд эзэн хаан ба дарангуйлагчийн тухай мөн тирантай тэмцэх боломжийн талаар бичсэн байна.

И.Жантйе “Anti-Machiavel” шастиртаа дарангуйлагчтай тэмцэх нь иргэний үүрэг гэжээ. Харгислал дээр тогтсон төр дарангуйллыг төрүүлдэг гэсэн дүгнэлт хийсэн байна. Харгислалын талаар ёс суртахууны тэмдэглэл хийхийн зэрэгцээ түүнд улс төрийн өнгө аяс байгааг олж тодорхойлсон байдаг. Хүн ба өмчинд хууль бус хандахыг харгислал гэнэ. Ийм төр удаан оршин тогтнож чадахгүй гэдэгт Жантйе хатуу итгэлтэй байв.

Аливаа дарангуйлал хүчирхийллийг агуулдаг. Тиймээс түүнийг нэг их удаалгүй иррационал хүч болох бурхан зогсоодог. Ёс суртахууны уналт дарангуйллыг үүсэх нөхцөл болдог. Нийгмийн задрал, хямрал дарангуйлагчаас бусдад ямарч ашиг өгдөггүй. Харин дарангуйлагч өөрийн засаглалаа бэхжүүлэхийн тулд түүнийг ашиглаж байдаг билээ.

Фомагийн санааг үндэслэн тиранд тодорхойлт өгсөн байдаг. Тиран гэдэг нь харгислалыг хэрэгжүүлдэг тэгснээр хүн алж, цус урсгаж болохгүй гэсэн бурханы тогтоосон эрхийг доромжилдог. Өөртэйгээ адил байгалийн бүтээл болох хүнийг үгүй хийж байгаагаараа дарангуйлагч жам ёсны эрхийг гутааж байдаг. Амь эрсдэх айдас доор ч хүн алж болохгүй гэж хориглосон иргэний эрхийг зөрчиж байна гэж үзээд тираныг хуулийн гадна үлдээсэн ажээ.

Хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн жам ёсны эрхийг зөрчин уландаа гишгэснээр эзэн захирагч дарангуйлагч болох эхний алхамаа хийдэг гээд дарангуйлагчийг дүгнэхдээ Жантйе, Бартолотой санал нийлж байв.

Дарангуйлагч өөрийн үйл ажиллагаандаа тодорхой тооны зарчим баримталдаг гэж Бартоло үзжээ.

- Ганцаар дарангуйлагчын эсрэг хөдөлгөөнийг удирдах чадвартай иргэдийг алж устгах
- Эрдэм боловсролтой ухаалаг хүмүүсийг алга хийх
- Мэдлэг, ном бүтээлийг үгүй хийх
- Аливаа нийгэмлэгтэй тэмцэл явуулах
- Тагнуул туршуулыг ашиглах
- “Хуваан, захиран засаглах” зарчмыг баримтлах
- Хүн ардыг тонон дээрэмдэх
- Иргэдийг туйлдуулах зорилгоор үргэлжилсэн дайн хийх
- Гадныханд итгэж, иргэдээ үл ойшоох
- Нэг бүлэглэлийг дэмжин нөгөө рүү нь турхирах

Дээрх зөвлөмжийг дагаж хэрэгжүүлэгч хэн боловч засрашгүй дарангуйлагч гэж Жантийе дүгнэсэн байна.

“Сайн дурын боолчлолын тухай эрэгцүүлэл” бүтээлдээ Этьен де Ла Боэси хууль ёс, хүний эрхийн баталгаа үгүй абсолют дэглэмийн засаглалыг шүүмжлэн тираны эсрэг тэмцэх хэрэгтэй гэж үзэж байв. Гэрээ хэлцэл, үе удам дамжиж эсвэл хүчээр тогтсон тиран ард түмний боолчлогдох “дур сонирхол зуршлаас” шалтгаалан оршин тогтнож байдаг. Дарангуйлагчийн доромжлолыг ард олон энгийн зуршил төөрөгдлөөр хүлээн зөвшөөрч сайн дураар тэвчиж байдаг гэжээ.

Нидерланд, Англид ялсан феодалын эсрэг хувьсгал нь жам ёсны эрхийн онол дээр суурилсан улс төрийн шинэ үзэл суртал төлөвшихөд түлхэц болжээ. Бослогын эрхийн талаарх үндэслэл ч өөрчлөгдсөн байна.

Голландын хуульч Гуго Гроц ард түмэн удирдлагын ямарч хэлбэрийг сонгох эрхтэй байхыг тэмдэглээд гол нь олон түмний эрх ашигт нийцэх нь чухал гэж үзжээ. Удирдлагын хэлбэрийг сонгосны дараа гэрээний дагуу ард түмэн төр засагт захирагдах учиртайг сануулсан байна. Гэсэн ч Гроц ард түмэн ямар нөхцөлд бослого гаргах эрхтэйг тодруулсан байдаг.

- Нийгмийн гэрээний онолд бослого гаргах эрхийг ил, далд тусгасан.
- Нийгмийн гэрээг төрийн тэргүүн зөрчсөн эсвэл хүчингүй болгосон тохиолдолд.
- Ард түмнийг бүхэлд нь хөнөөх хорон санаа агуулсан.
- Дайн түрэмгийлэл хийж хууль бусаар засгийн эрх авсан.

Засаглалд хүч хэрэглэн эсэргүүцэх эрхтэйгээс гадна засаглагчийг хороох ч эрхтэй хэмээн Гроц бослого гаргах эрхийн талаар өөрийн боловсруулсан онолдоо тусгажээ.

Жам ёсны эрхийн онолч Бенедикт Спиноз бослого гаргах эрхийг төрийн эрхийг хязгаарлах замаар хангана гэж үзэж байв.

- Хуульд шингэсэн эрүүл ухаанаар тэр хязгаарыг тогтооно.

- Төрийн үйл ажиллагааг хязгаарлах асуудал хүний мөн чанартай холбоотой гэж үзэв. Шийтгэл, урамшлаар ч өдөөн идэвхжүүлж, нөлөөлж чадахгүй зүйл төрд байдаг. Хүний жам ёсны эрх болох сэтгэн бодох, сүсэглэн шүтэх, амиа хайрлан хамгаалах, бурханд итгэх чадварт нөлөөлөх боломжгүй юм.
- Олны дургуйцлыг хязгаарлах эрх төр эдэлж чадахгүй юм. Цөөнгүй хүнд хуйвалдах шалтаг бүрдүүлсэнээр төрийн хүч, эрх мэдэл багасдаг. Төрийн засаглал өөрийн нэр хүндэнд сэв суулган албат иргэдийн дургуйцлыг өдөөсөн үйл ажиллагаа хэрхэвч үйлдэж болохгүйг сануулсан байна. Бослого гаргах ард түмний эрхийг засаглалын легитимт байдалтай холбон авч үзжээ.

Засаглагч хууль зөрчсөнөөр олон түмэнд айдас төрүүлдэг тэр нь улмаар засаглалын эсрэг дургуйцал болон хувирч төр улс эвдэрч гэрээ хэлцэл цуцлагдан хүчин төгөлдөр бус болдог байна. Нийгмийн гэрээний нөхцлийг төрийн засаглагч зөрчсөн тохиолдолд бослого гаргах жам ёсны эрхтэй гэж Спиноз үзсэн ажээ /Соколов В.В. Спиноза. М., 1977/ .

Хууль үгүй болсноор дарангуйлал эхэлдэг. Тиймээс тиран засаглалыг хэрэгжүүлэх эрхгүй хэмээн Жон Локк үзээд удирдлагын систем гадны нөлөө, дотоод шалтгаанаар задарч унадаг гэсэн дүгнэлт хийсэн байна.

Хууль тогтоох байгууллага иргэдийн өмчинд халдсанаар эсвэл ард түмнийг боолын хүнд амьдрал руу түлхэн оруулах оролдлого хийснээр ард түмэн дарангуйлагч засагтай дайсагнан түүнд захирагдах шаардлагагүй болно гэж Локк үзжээ.

Хэрэв ерөнхий сайд, эзэн хаан хариуцлагаа үл ойшоож, үүргээ биелүүлэхгүй, парламентад өөрийн сонирхлоо тулган түүнд ажиллах боломжийг олгохгүй, сонгуульд саад болж, гадаад гүрэнд улс орноо барьж тушаах зэрэг тохиолдолд ард түмэн амиа аврах зорилгоор шинээр хууль тогтоох засаглал байгуулж, өөрийн үзэмжээр засаглагчдыг, засаглалын хэлбэрийг эсвэл аль алийг нь сольж болох талаар Локк сануулсан байна.

Үл захирагдах онол нь бослогод турхирч байна хэмээн Локкыг шүүмжилж байсан ч түүнд тэрээр үндэслэлтэй хариу барьсан байдаг.

- Хэрэв хүмүүсийг дарангуйлаад байвал тэд ямар ч удирдлагын эсрэг босдог
- Хувьсгал ялихгүй зүйлээс болж гардаггүй
- Бослого гаргах эрхээр хангаснаар бослого гарахгүй байх баталгаа бий болдог гэж дүгнэжээ.
- Эрх чөлөө хэр их байна төдий чинээ хувьсгал гарах шаардлага багасна.

Ард түмний жам ёсны эрх, эрх чөлөөнд халдсан дарангуйлагч засаглалын эсрэг чиглэсэн олон түмний бослогыг зүй ёсны зайлшгүй үйл явц гэжээ. /С.Базарпүрэв. Шинэ үеийн өрнөдийн улс төрийн сургаалын түүхийн товчоо (ХҮII-ХҮIII зуун). Уб., 2008/ XVIII зуунд Францад социалист, коммунист нийгмийн онол үүсэж, эрч хүчээ аван хөгжиж байсан билээ. Эдгээр онолыг бүтээгчдийн нэг нь Жан Мелье юм. Санваартан ламтан байсан ч атеист, материалист, хувьсгалч үзэлтэн байв. Дарангуйлагч тиран, шашны

эсрэг хувьсгалт тэмцэлийг хийхийн тулд нууц бүлгэм байгуулж, ард түмнийг нэгдэхийг уриалж байв. Мелье “Гэрээс” (Testament) бүтээлдээ дээрх онолыг боловсруулжээ.

“Ард олныг тэвчишгүй дарамтанд оруулж түүнд их гай зовлон авчирч буй хүмүүст түүнийг улам дарангуйлж байх боломж олгох нь эрүүл ухаан, шударга ёсонд нийцэхгүй гээд нэг нь амьдралын хүнд бэрхийг нуруундаа үүрч, нөгөө нь санаа зовох юмгүй тансаг баялагт умбах нь зүйд таарахгүй” гэжээ. Ард түмэн зүдэрч байгаад баячууд шууд буруутай.

Засгийн эрх мэдлээ зүгээр тавиад өгдөггүй баячуудтай хувьсгал хийх замаар асуудлыг шийднэ гэжээ.

Хувийн өмч шунахай сэтгэл, сэдлийг төрүүлдэг. Үүний үр дагавар гэвэл нэг талаас хүчтэй, зальтай, овжин, хэрцгий, ёс журамгүй нь баяжиж нөгөө талаас ард түмэн ядуурдаг гэсэн дүгнэлт хийжээ.

Феодализм, хувийн өмч түүний эрх ашиг, сонирхлыг хамгаалж буй засаглалыг шүүмжлэхийн зэрэгцээ Мелье ардын хувьсгал хийх мөрийн хөтөлбөр боловсруулсан байна. Хэний эсрэг хувьсгал өрнүүлэх талаар тодорхой төлөвлөгөөтэй байжээ. Тэдгээрийн тоонд “таныг дарангуйлж буй та нарын дунд амьдарч байгаа их зантай сурвалжит эрх мэдэлтэн, хаад ноёдын гар хөл болсон бардам зантай түшмэл, хот хөдөөгийн сайрхуу амбан, мужийн захирагч, түрэмгий татварын байцаагч, сагсуу түрээслэгч, бичиг хэргийн алба, хамба ламтан, хаан, ашиг орлоготой газрыг эзлэн түрэмгийлэгч, баячууд, зугаа цэнгэл хөөж, цагаа таатай өнгөрүүлэгч хатагтай” нар багтана гэжээ. /С.Базарпүрэв. Шинэ үеийн өрнөдийн улс төрийн сургаалын түүхийн товчоо (ХҮII-ХҮIII зуун). Уб., 2008/

Жан-Жак Руссогийн улс төрийн сургаал бослогын үзэл санааг баяжуулж нийгмийн ухамсарт нөлөө үзүүлсэн номлол юм. Францын соён гэгээрүүлэгчдийн төлөөлөгч, философич Жан-Жак Руссогийн нийгэм-улс төрийн үзэл санаа нийгмийн сэтгэлгээний шинэ чиглэл болох улс төрийн ардчилсан-радикализмийн эхлэлийг тавьсан байна. Нийгмийг үндсээр нь өөрчлөх мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн нь тариачид, эрс өөрчлөлт хийхээр шийдсэн ядуусын сонирхол, шаардлагад нийцэж байв.

Дарангуйлагчийг авч хаяахад тэрээр хүч хэрэглэлээ гэж гомдлох хэрэггүй юм. Жам ёсны нөхцөлд бүгд л хүч хэрэглэж, хүчтэний тогтоосон хуулиар л амьдардаг. Дарангуйлагчийн эсрэг бослого гарах нь зүй ёсны үйлдэл юм. “Дарангуйлагч хүчирхийлэл дээр тогтож, тэр нь түүнийг авч хаядаг бүх юм жам ёсны замаар л явж байна”. “Ард түмэн захирагдахаас өөр аргагүй, захирагдаж байгаа цагт сайн, боломж гарахад дарангуйлагчийг авч хаявал бүүр сайн” гэжээ. Хувьсгал хийж абсолютизмийг хүчээр албадан засгаас татан буулгахыг Руссо цагаатган зөвтгөж байв.

Дарангуйлагчийн эсрэг боссоноор дарангуйлагчийн хуулийн дагуу л хийгдэх зөв алхам ч хууль ёсны засаглал авчирдаггүй гэж тэрээр сануулсан байдаг. /С.Базарпүрэв. Шинэ үеийн өрнөдийн улс төрийн сургаалын түүхийн товчоо (ХҮII-ХҮIII зуун). Уб., 2008/

1793 оны таван сарын 31-ээс зургаан сарын 2 хүртэл Францад якобинчууд хувьсгалт диктатур тогтоон Конвент Ж.Ж.Руссогийн дарангуйлалыг эсэргүүцэх эрхийн үзэл санааг тусгасан Үндсэн хуулийг баталсан байдаг.

Якобинчууд, бабефчууд Руссогийн дэвшүүлсэн үзэл суртлыг амьдралд хэрэгжүүлэн, онолын хувьд дахин боловсруулсан байна.

Якобинчууд бослого, хувьсгалт диктатурын талаар сургаал боловсруулж байв. Түүний удирдагч Жан Поль Марат “Боолчлолын гинж” бүтээлдээ дарангуйлагч абсолютизмыг хүлээн зөвшөөрөлгүй харгис улс төрийн дэглэм тогтоох эх сурвалж, хэрэгсэл, дарангуйллын сөрөг талыг судлан бослогыг түүнтэй тэмцэх үр бүтээлтэй арга хэмээн үзсэн байна.

Хувьсгалын дайсан, хуйвалдагч нарыг устгах зорилготой диктатур тогтоох хэрэгтэйг сануулж тэдний эсрэг террор хийх нь зохистой гээд 1793 онд Конвент түүнийг хэрэгжүүлэн их цус урсгасан байдаг. Европын соён гэгээрүүлэгчдийн радикал үзэл зөвхөн европт түгэн дэлгэрээд зогсохгүй мөн далай тэнгэс дамнан америк тивд хүрчээ. АНУ-ыг английн колончлолоос чөлөөлж тусгаар тогтнолын тунхаглах үйл явцад дээрх үзэл санаа мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн гэж үздэг тал бий. Франклин, Пейн, Жефферсон нар эрх чөлөөний хөдөлгөөний үндсэн санааг дэвшүүлэн 1776 онд батлагдсан тусгаар тогтнолын тунхаг бичигт бататгасан байна. Ард түмэн хувьсгал хийх эрхтэйг тэд санал нэгтэй дэмжиж байв.

Нийгмийн ухамсрын нэг хэсэг, америк дахь ардчиллын нэг үнэт зүйл хэмээн бослогын тухай радикал дүгнэлтийг Жефферсон хийсэн байдаг. Засаглагч цаг тутам ард түмэн эсэргүүцэн босох чадвартай гэдгийг ойлгож мэдэрч байх хэрэгтэй гэжээ. Эрх чөлөөний модыг цаг цагт тиран ба эх орончдын цусаар усалж байх шаардлагатай. Тэр нь жам ёсны бордоо гэсэн байна.

1848-1849 онуудад Европт өрнөсөн хөрөнгөтний хувьсгалаас үүдэн бий болсон туршлага дээр тулгуурлан марксист үзэл суртал үүсэж, социалист хувьсгалын тухай сургаал боловсрогдсон байна. Маркс К, Энгельс Ф нарын эртний бүтээлд бослогын үзэл суртал тусгагдсан байдаг /Минц И. Маркс о вооруженном восстании //Историк-марксист. 1933. №2/.

Пролетар ангийн хөгжлийн ерөнхий үе шатыг авч үзэх явцад нийгмийн гүнд их бага хэмжээгээр далдлагдсан иргэний дайныг ажиглаж болно гэжээ. Уг дайн яваандаа нээлттэй хувьсгал болон хувирч хүчирхийллийн аргаар хөрөнгөтнийг түлхэн унагааж өөрийн ноёрхлоо тогтооно гэжээ /Маркс К. и Энгельс Ф. Манифест коммунистической партии // Маркс К. Избранные произведения в 2-х т. Т.1. Изд-во ЦК ВКП (б), 1934/.

Зэвсэгт бослогыг хийх эрхтэй хэмээн тунхагласан ч марксистууд нийгмийн хөгжлийн хямралыг тайван замаар шийдвэрлэх нь илүү ач холбогдолтой гэж үзэж байв /Энгельс Ф. Эльберфельдские речи. 15 февраля 1845 г. // Маркс К., Энгельс Ф. Соч. 2-е изд. Т.2/.

XVIII зууны сүүлчээр хөрөнгөтний нийгмийн нийгэм-эдийн засгийн зөрчил мөргөлдөөнийг төр зохицуулах чадваргүй хэмээн үзэн анархизмийн үзэл суртал үүсэн гарсан түүхтэй.

Анархист хувьсгалчид төр түүний улс төр, эрхийн байгууллагыг устгах хэрэгтэй гэж үзээд түүний оронд янз бүрийн чөлөөт үйлдвэрлэгчдийн нийгэмлэгийн зөвшилцөл дээр тулгуурлан өмч тэгш байх зарчим ноёрхсон нийгмийн төгс төгөлдөр байгуулалтыг бүтээн бий болгох зорилго агуулж байв /Бакунин М.А. Революционный катехизис /Избранные философские сочинения и письма.М., Мысль, 1987. Бердяев Н. Русская идея // Вопросы философии. 1990. №2//.

В.И.Ленин бослогын онолыг чанарын шинэ түвшинд боловсруулсан байна.

Түүний үзэж байгаагаар зэвсэгт бослого нь ажилчин анги засгийн эрхийг авах хамгийн шалгарсан арга гэжээ. “Доодос” хуучнаараа амьдрах хүсэлгүй болж, “дээдэс” нь хуучнаар удирдах чадваргүй болсон цагт хувьсгал ялна гэсэн дүгнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл, нийт үндэстний хямралгүйгээр хувьсгал хийх боломжгүй юм гэжээ /Ленин В.И. ПСС. Т. 41/.

Бослого гаргах эрхийн талаар дэвшүүлсэн дээрх болон бусад улс төр, эрхийн, шашин, философийн үзэл санааг шинжлэх явцад улс төрийн амьдралд хэрэгжиж батлагдсан онолын хэд хэдэн баримтлалыг тодруулж болох юм.

Нэгд: нийгмийн зөрчил мөргөлдөөнийг ил тод, хуулиар баталгаажуулсан аргаар шийдвэрлэх нь илүү ач холбогдолтой юм.

Хоёрт: улс төрийн дэглэм, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, ноёрхож буй үзэл сурталд олон түмэн илт дургуйцан хүн амын ихэнх нь хувьсгалт хөдөлгөөнд эвсэн оролцсон тохиолдолд бослогын үзэл суртал “амь” орж идэвхжин түүний бодит хэрэгцээ үүсэн бий болдог ажээ.

Гуравт, нийгмийн шинэ байгуулалт төлөвших урьдчилсан нөхцөл бүрэлдсэн нийгэмд бослогын үзэл суртал ноёрхож эхэлдэг.

Бослогын үзэл сурталыг бүрдүүлж буй үзэл санаа, сургаал, номлолын хувьслын түүх нэн баялаг арвин гэдгийг дурьдахын зэрэгцээ орчин үед бослогын үзэл суртал өөртөө олон янзын онцлог зүйл агуулж байгааг олж харж болно.

Нэгд, иргэд бүх нийтээрээ сонгуулийн эрх эдэлж, хүн амын амьжиргааны төвшин дээшилж, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, иргэний хөдөлгөөн идэвхжин тэдгээрийн шахалтаар төр хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн нийгэм журам байгуулах гэж хичээн зүтгэсэний үр дүнд орчин цагт бослого гаргах эрхийн асуудал тодорхой хэмжээнд өөрийн ач холбогдлоо алдаад байна.

Нийгмийн зөрчил, үндэстэн ястан, анги бүлгийн мөргөлдөөнийг эрхийн арга зүйгээр зохицуулах үйл ажиллагаа улам өгөөжтэй, эерэг үр дүн авчирч байгаа нь нийгмийг тайвшруулан тогтворжуулж байна. Хүч үл хэрэглэн “төртэй тэрслэх” арга зам арвижин олон янз болсонтой холбоотойгоор бослого, хувьсгалын үзэл санаа уналтанд

орсон гэж болно. Мөн бослогыг дарах хангалттай хүч орчин үеийн төр засаглалд хуримтлагдах болсон нь үүнд бас нөлөөлсөн байна.

Хоёрт, эдүүгээ цагт улс төр, хууль эрхийн баримт бичигт бослого гаргах эрхийн тухай заалт үгүй болсон байна. Дарангуйлагчийг эсэргүүцсэн бослого гаргаж болох талаар эрх зүйт төрийн үндсэн хуульд энэ талаар дурьдсан зүйл огт алга.

Гуравт, орчин үед ихэнх орны үйлчилж буй хуульд бослого гаргах хориотой байдаг. Тухайн байр суурь нь төр улсын тогтвортой байдлыг хангах, хууль зөрчих хүмүүсийн амь насыг сахин хамгаалах зорилго агуулсан байна.

Улс төрийн сөрөг хүч олон түмний дэмжлэгтэйгээр тайван замаар эрх мэдлээ шилжүүлэхийг шаардаж төр засагт шахалт үзүүлэн нэг бол огцруулж чаддаг, эсвэл засаглагч олон түмний эрх ашигт нийцсэн улс төрийн бодлого явуулж эхэлдэг байна.

Бослого гаргах эрхийг хуульчлах нь их оновчтой шийдвэр биш юм. Учир нь гадаадын улс гүрэн өөрийн улс төрийн зорилго, эдийн засгийн ашиг сонирхолдоо бусад орны эрхийн баримт бичигт тусгагдсан зүйл ангийг ашиглах бодит боломж байдаг. Тухайлбал, их гүрэн бусад улсын иргэд сонгуулийн эрхийг (намын нэр дэвшигч, олон нийтийн байгууллагын улс төрийн үйл ажиллагааг чиглүүлж, олон улсын ажиглагчид дарамт үзүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нөлөөлөх үйл ажиллагааг санхүүжүүлэх) эдлэх явцад идэвхтэй оролцож, гадаад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс “хошуу дүрж”, өөрийн хүнийг, сонгуулиар тавигддаг албан тушаалд “томилж” чаддаг жишээ гарч байсан түүхтэй. Ийм жишгээр хуулиар бэхжүүлсэн бослого гаргах ард түмний эрхийг ашиглах тохиолдолд ямар хор хөнөөлтэй үр дүн гарах нь төсөөлөх ч аргагүй юм. Үүний жишээ болгон бид дундад ази, кавказын посткоммунист улс оронд өрнөсөн “өнгөт” хувьсгалыг дурьдаж болно. Үүнтэй уялдан үндсэн хуулинд оруулах зүйл анги, засвар өөрчлөлтийг нягт бодон тунгааж, судалгаа шинжилгээн дээр тулгуурлан хийх ёстойг сануулахад илүүдэхгүй биз.

Бослого гаргах нь туйлын арга хэрэгсэл юм. Тайван замаар хурцадсан асуудлыг шийдвэрлэх боломж шавхагдсан тохиолдолд ард түмэн, улс орноо аврахын тулд хийдэг ажил. Хэдийгээр бослого гаргах үйл ажиллагаа улс төрийн амьдралд хэрэгжих боломж хэт багассан ч дараах нийгэм улс төрийн нөхцөл бүрэлдсэн тохиолдолд гарахгүй гэх газаргүй. Улс төрийн тодорхой хүчний эрх ашигт хөтлөгдсөн төр албан тушаалтан иргэдийг харгислах (улс төр-эдийн засаг, сэтгэл санааны хэлмэгдүүлэлт) хүн амыг үй олноор нь хомроглон устгах эсвэл бусад орон тухайн улсын газар нутгийг хэсэгчлэн болон бүхлээр нь эзлэн түрэмгийлэх нөхцөл бүрэлдэх буюу тохиолдвол бослого гаргах шаардлага зайлшгүй гарна.

Улс төрийн харгислал гэдэг нь тэрс үзэлтэн, улс төрийн сөрөг хүчнээ дарж устгах зорилго бүхий улс төрийн алан хядах үйлдэл юм. Иргэдээ залхаан цээрлүүлэх үйл ажиллагаа явуулсан төрийн дарангуйлагчийн эсрэг ард түмэн бослого гаргах бүрэн эрхтэйг улс төрийн сэтгэлгээний түүх бичилцэж байсан олон сэтгэгчид зориуд сануулан сургаал номлолдоо бичиж байжээ. Ард түмний өмнө амлалт өгөн төрийн сэнтийд

заларсан түшмэл ч хариуцлагагүй үйлдэл хийж, журамт үүргээ биелүүлэхгүй байх нь ард түмнийг бослогод турхирч буй алхам гэдгийг ч улс төрийн сэтгэгчид олонтаа тэмдэглэсэн байдаг.

Угсаа үндэстэн, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж, хүчээр нутаг заан хөөн зайлуулах, нийгэм-эдийн засгийн тэвчишгүй нөхцөлд оруулдаг нь аймаглан устгах үйлдэл мөн. Үүний эсрэг ард түмэн босох нь жам ёсны үзэгдэл юм.

Олон улсын гэрээ хэлэлцээрийг зөрчин олон улсын байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдын газар нутагт халдан, эзлэн түрэмгийлэх нь илт тус нутгийн төр улсын дотоод хэрэгт хүч түрэн бүдүүлгээр оролцож байгаа явдал. Үүнийг эсэргүүцэн түрэмгийлэгчдийн тогтоосон удирдлагын хэлбэр улс төрийн дэглэм, үндсэн хуулийг үгүй хийх үйл ажиллагаа (бослого гаргах) нь тухайн улсын ард түмний бүрэн эрх юм.

Хүний эрхийг хамгаалах, тоталитар дэглэмийг устгах нэрийдлээр ямар ч улс орны төр засаг бусдын хэрэгт оролцон ямар нэгэн “тоглоомын” дэглэм /ардчилсан ч бай/ тогтоох эрхгүй билээ. Ямар дэглэм тогтоохыг тухайн орны ард түмэн шийдэн сонгох эрх мэдэлтэй байдаг болов уу.

Тиймээс улс үндэстний төлөө хийх иргэдийн хөдөлгөөн эерэг бослогын тоонд багтаана. Бослогын эрхийг эдлүүлэхгүй байх гол баталгаа нь төрийн эрх мэдэл баригч. Түүний улс төрийн үйлдэл, гаргасан шийдвэр, явуулж буй улс төрийн бодлого хуулийн хүрээнд хариуцлага үүрч хэрэгжиж буй тохиолдолд өргөн түмний хөдөлгөөн шаардлагагүй юм.

Бослого гаргах эрх нь ард түмэнд зөвхөн үзэл суртлын баталгаа болж л үлдэх учиртай. Төр, засгийн тэргүүн, түшмэл, албан хаагч бюрократууд төрийн шийдвэр ард түмний язгуур эрх ашиг, сонирхолд нийцэхгүй тохиолдолд гарцаагүй эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй гэдгээ гүнээ ухамсарлаж ойлгох нь нэн чухал бөлгөө.

ЖОН РОУЛЗЫН ЗҮЙ ЁСНЫ ОНОЛ

Ж.Жаргал

МУБИС, Улс төр социологийн тэнхим

Түлхүүр үг: улс төрийн философи, ёс зүйн философи, шударга ёс, зүй ёс, уг байдал, үл мэдэхийн хөшиг, нийгмийн гэрээ, зарчим, тэгш эрх, гарааны тэгш байдал, хуваарилалт, эрх ашиг, иргэний дуулгаваргүй байдал, нийгмийн тогтвортой байдал.

Өгүүллийн зорилго: Энэхүү өгүүллийн зорилго бол ХХ зууны Америкийн сэтгэгч, улс төрийн болон ёс зүйн философийн гол төлөөлөгч Жон Роулзын нийгэм дэх зүй ёс, шударга ёсны тухай онолын агуулгыг түүний “Зүй ёсны онол” зохиолын дагуу тоймлон гаргах явдал болно.

Амьдрал, бүтээл туурвилын тойм

ХХ зууны өрнөдийн нийгмийн сэтгэлгээ, түүний дотор улс төрийн болон нийгмийн философийн онол, үзэл баримтлалууд манай оронд 1990 он хүртэл “хөрөнгөтний номлол” гэсэн хаяг дор хаагдмал, судлаж болохгүй сэдэв байв. 1990 оноос хойш тэдгээрийг хожимдсон ч гэсэн судлаж танилцах, монголын нийгмийн амьдралыг танин мэдэж ойлгох, үнэлж цэгнэхэд хэрэглэх, их дээд сургуулийн мэргэжлийн анги, салбаруудад хичээл болгож заах бололцоо бий болов. Тийм чухал бөгөөд сонирхолтой сэдвийн нэг бол Жон Роулзын улс төрийн философи дахь нийгмийн шударга ёс, зүй ёсны тухай онол юм. Эл асуудлаар философч эрдэмтэн Б.Батчулуун ганц нэг өгүүлэл нийтлүүлсэн, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлснээс (1) өөр судалгаа хийгдээгүй, тоймтой зүйл нийтлэгдээгүй байна. Роулзын улс төрийн философи, зүй ёсны онолыг судлан шинжлэх, манай нийгмийн сэтгэлгээ болон их, дээд сургуулийн сургалтын эргэлтэд оруулах шаардлагатай бөгөөд тэр нь онол-танин мэдэхүй ба сургалт боловсролд ач холбогдолтой байх болно.

Бид эл өгүүлэлд Ж.Роулзын зүй ёсны онолыг түүний гол бүтээл болох “Theory of justice” (“Зүй ёсны онол”) бүтээлийн үндсэн дээр улс төрийн философийн үүднээс тоймлон авч үзэх зорилт тавьсан болно.

Жон Роулз бол ХХ зууны улс төрийн философийн хамгийн том төлөөлөгч гэж зүй ёсоор үнэлэгддэг. Тэрбээр 1930–иад оноос хойш зогсонги байдалд ороод байсан улс төрийн философийг сэргээх, дахин эрчимтэй судлаж эхлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна.

Жон (Бордлей) Роулз АНУ – ын Мариленд мужын Балтимор хотод 1921 оны 2 дугаар сарын 21 нд төржээ. Тэрбээр Уилиам Лее Роулз болон Анна Абел Стампын таван хүүгийн хоёр дахь нь болж мэндэлсэн байна. Түүнийг бага байхад хоёр дүү нь халдварт өвчнөөр нас барж, энэ нь түүнд сэтгэлийн хүнд цохилт болжээ. Роулз протестант шашны бэлтгэл сургуулийг төгсөөд Принстоны их сургуульд элсэн орсон байна. Түүний ах нь Принстонд суралцаж байсан нь түүнийг энд суралцахад нөлөөлжээ.

Роулз дэлхийн II дайн ид өрнөж байсан 1943 онд сургуулиа төгсч 1944 онд цэрэгт татагдан Номхон далайд Японтой хийсэн дайн, Шинэ Гвиней, Филиппинд болсон тулалдаанд оролцсон байна. Хиросимад атомын бөмбөг хаясны дараах ул мөрийг нүдээрээ үзжээ. Дайн дууссаны дараа түүнд армид үлдэн офицер болох санал тавьсан ч түүнээс татгалзаж, Принстоны их сургуульд ёс зүйн философийн чиглэлээр докторын зэрэг хамгаалахаар 1946 онд эргэн ирж түүнийгээ 1950 онд амжилттай хамгаалжээ. Үүний дараа Маргерет Фокстой гэрлэсэн байна. Роулз Принстоны их сургууль (1950 - 1952), Корнеллийн их сургууль (1953 - 1959), Массечутесийн технологийн институт (1960 - 1962), 1964 оноос насан өөд болтлоо Харвардын их сургуульд бараг 40 шахам жил багшилжээ. 1952 – 1953 онд Оксфордод байх үед нь түүний үзэл бодолд либерал улс төрийн онолч, түүхч Исаак Берлин ялангуяа эрх зүйн онолч Х.Л.А. Харт нар хүчтэй нөлөө үзүүлжээ. Ж.Роулз 1995 онд саа өвчин тусч ажиллах чадвараа алдсан боловч “Ард түмнүүдийн эрх зүй” хэмээх бүтээлээ дуусгаж чадсан ба 2002 оны 11 дүгээр сарын 24 нд нас баржээ.

Ж.Роулз “Зүй ёсны онол”(Theory of Justice, 1971), “Улс төрийн либерализм”(Political Liberalism, 1993), “Ард түмнүүдийн эрх зүй” (Law of Peoples, 1999) гэсэн гурван том зохиол бичжээ. Тэрбээр эдгээр бүтээлдээ зүй ёсны асуудлыг өргөн хүрээтэйгээр авч үзсэн байна.

Ж. Роулз “Зүй ёсны онол” зохиолоо хэвлүүлэхээс өмнө 1958 – 1969 оны хооронд “Зүй ёс шударга байх нь”(Justice as Fairness, 1958), “Үндсэн хуулиар баталгаажсан эрх чөлөө”(Constitutional Liberty, 1963), “Иргэний дуулгаваргүй байдал” (Civil disobedience, 1966), “Хувиарлалтын зүй ёс” (Distributive Justice, 1967), “Хувиарлалтын зүй ёс: зарим хавсралтууд” (Distributive Justice: Some Addenda, 1968) зэрэг өгүүллүүд бичсэн бөгөөд тэдгээрийн агуулга сүүлд “Зүй ёсны онол” номонд нь тусгалаа олсон байна.

Ж. Роулзын гол бүтээл болох “Зүй ёсны онол” нь 3 хэсэг, 9 бүлэг, 87 зүйлтэй том хэмжээний бүтээл юм. 1975, 1999 онд нэмж засварлан дахин хэвлүүлж байсан ба дэлхийн 27 хэлээр орчуулагдан гарчээ. Тэрбээр уг бүтээлдээ нийгэмд шударга ёсыг хэрхэн, яаж тогтоох вэ гэсэн асуудлыг ул суурьтай авч үзсэн байна. Ж. Роулз бүтээлийнхээ эхний хэсэгт зүй ёсыг уг байдал (original position) хэмээх нөхцөл байдлаас ургуулан гаргахыг зорьж, түүн дэх хүмүүсийн байдал, зүй ёсны зарчмуудын талаар авч

үзжээ. Номныхоо хоёрдугаар хэсэгт зүй ёсны зарчмуудын хоорондын зохилдолго болон иргэдийн үүрэг, хариуцлагыг шинжилсэн бол төгсгөлийн хэсэгт нь зүй ёсны дагуу зохион байгуулагдсан нийгмийн тогтвортой байдал, тийм нийгэм дэх хүмүүсийн зүй ёсны талаархи үзэл болон тэд чухам юуг үнэлдэг тухай асуудлыг авч үзсэн байна.

Ж.Роулзын хоёр дахь том бүтээл бол “Улс төрийн Либерализм” юм. Роулз эл бүтээлдээ тогтвортой байдлын асуудалд гол анхаарлаа хандуулсан бөгөөд зүй ёсны хоёр зарчмын дагуу зохион байгуулагдсан нийгэм цаашид оршин тогтнож чадах уу гэсэн асуулт тавьсан байна. Энэхүү асуултад өгсөн түүний хариултууд нь улс төрийн либерализмын тухай лекцүүдэд нь багтжээ. Роулз мөн зүй ёсны зарчимуудыг авч үзэхдээ хэрэглэсэн зарим нэр томъёо, үг хэллэгээ өөрчилсөн байна. Гэхдээ энэ нь түүний томъёолсон зүй ёсны зарчимуудын анхны утгыг ноцтой өөрчлөөгүй ажээ.

Роулзын сүүлчийн бүтээл болох “Ард түмнүүдийн эрх зүй” нь “Зүй ёсны онол” номонд нь дурьдалгүй өнгөрсөн олон улсын зүй ёсны асуудлыг хөндсөн байна. Роулз улс хоорондын харилцааг зохицуулах боломжтой зүй ёсны зарчмыг томъёолон гаргахыг оролджээ. Либерал төрийн гадаад бодлого зүй ёсны ямар зарчимууд дээр үндэслэх ёстой вэ ? гэсэн асуулт тавьжээ. Роулз хөндлөнгөөс үл оролцох, хүний эрхийг хүндэтгэх, зүй ёсны дэглэм гарч ирэх нөхцөл бололцоогоор дутагдаж байгаа улс орнуудад туслах явдлыг үндсэн зарчим болгон хөгжүүлсэн байна. Эдгээр зарчимууд нь нэг улсаас бусад улстай харилцах харилцааг зохицуулна.

Тэрбээр зохиолдоо олон улсын хувиарлалтын зүй ёсны тухай товч авч үзсэн бөгөөд түүний зүй ёсны онолын үзэл санаан дээр тулгуурлан хувиарлалтын зүй ёсны зарчмуудыг хөгжүүлсэн Ч. Бейтцийн үзлийг шүүмжилжээ.

Роулз дэлхийн II дайны үед Америк улс Герман, Японы хотуудыг бөмбөгдөж гэмгүй олон хүнийг хөнөөсөн явдалыг, мөн цагаачлал, цөмийн зэвсгийн асуудлыг уг бүтээлдээ судалсан байна.

Зүй ёсны онолын агуулга

Роулзын боловсруулсан зүй ёсны онолын агуулгыг авч үзэхийн өмнө энд түүний хэрэглэсэн Justice, fairness гэсэн ойлголт, тэдгээрийг тэмдэглэн илэрхийлсэн нэр томъёоны талаар тайлбар хэлэх шаардлага гарч байгаа юм.

Роулзын эл бүтээлийг англи эхээр нь уншиж ойлгох, агуулгад нь шинжилгээ хийхэд ихээхэн бэрхшээлтэй байгаа бөгөөд энэ нь уг зохиолд хэрэглэсэн гол ойлголт, нэр томъёо, зохиолын үзэл санаа, логик, бичлэгийн онцлогтой багагүй холбоотой юм. Сэтгэгч зохиолдоо justice, fairness гэсэн үгсийг улс төрийн философийн гол ойлголтыг тэмдэглэсэн шинжлэх ухааны чухал нэр томъёо болгож ялгаатай хэрэглэжээ. Энэ нь тэрбээр зохиолынхоо нэгдүгээр бүлгийг “Justice as fairness” буюу “Зүй ёс нь шударга

болох нь” гэж томъёолсон байдлаас мэдэгдэж байгаа юм. Эдгээр нэр томъёог монгол, орос хэлээр адилхан шударга ёс, шударга байдал гэж орчуулах нь давамгайл байгаагийн зэрэгцээ justice – г ёс зүй, зүй ёс гэж орчуулсан тал бас байна. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д шударга гэсэн үгийг шулуун, чигч, үнэнч, төлөв төвшин, зүй гэсэн үгийг аливаа юмны тогтоол, жам ёс, зөв гэсэн утгатай гэж тайлбарлажээ. Шударга ёс, зүй ёс хоёр хоорондоо утга агуулгын хувьд нягт холбоотойн хамт бас нарийн ялгаатай, зүй ёс нь жамаараа, зүй зохистой, ёс журмаараа байгаа байдлыг илүү илэрхийлдэг, тиймээс угтаа шударга байдаг гэсэн үзэл санаа Роулзын зохиолд агуулагджээ. Философч эрдэмтэн Б.Батчулуун тийм санал хэлсэнийг бид дэмжин баримтлаж байна.

Ж. Роулз зүй ёсны асуудлыг утилитар үзлийг шүүмжлэх явдлаас эхэлж тавьжээ. Утилитаризм нь хангалттай хэмжээний зүй ёсыг бий болгодоггүй бөгөөд учир нь уг номлол олонхийн сайн сайхан амьдралыг цөөнхийн хүсэл зориг, эрхийг үгүйсгэх замаар бий болгодог хэмээн тэрбээр шүүмжилсэн байна. Улмаар Ж.Роулз сайн зохион байгуулагдсан нийгэм нь зүй ёсны тодорхой зарчимуудын дагуу зохицуулагдах ёстой гэж үзжээ.

Тэрбээр өөрийн гаргаж боловсруулсан онолын зорилгыг тайлбарлахдаа “Миний зорилго бол Локк, Руссо, Кант нарын нийгмийн гэрээний онолыг хийсвэрлэлийн илүү өндөр түвшинд гаргаж нэгтгэн дүгнэсэн зүй ёсны үзэл баримтлалыг гаргаж ирэх явдал юм. Үүнийг хийхийн тулд бид хэн нэгэн хүн тодорхой нийгэмд нэгдэн ордог, эсвэл төрийн тодорхой хэлбэрийг бий болгодог уг гэрээний тухай бодох ёсгүй. Харин биднийг чиглүүлэх үзэл бол нийгмийн үндсэн бүтцэд тохирсон уг гэрээний зорилго бол зүй ёсны зарчимууд юм гэсэн үзэл юм. Эдгээр зарчмууд нь бидний цаашид үүсэх бүх гэрээг зохицуулна. . . Би зүй ёсны зарчмуудыг ийм замаар авч үзэн зүй ёсыг шударга байх явдал гэж нэрлэнэ” гэж бичжээ (9,11). Justice as Fairness буюу зүй ёс шударга байх гэсэн Роулзын нэр томъёо нь анхнаасаа шударга нөхцөлд хүлээн зөвшөөрөгдсөн зүй ёсны зарчимууд гэсэн санааг илэрхийлдэг (9,12).

Ж. Роулзыг Гоббс, Локк, Руссогийн нэгэн адил нийгмийн гэрээний онолын төлөөлөгч хэмээн эрдэмтэд үздэг. Гэхдээ Ж.Роулзын нийгмийн гэрээний үзэл нь өмнөх үеийн сэтгэгчидийнхээс өөр юм. Тэрбээр зүй ёсны асуудлыг таамаг гэрээний тусламжтайгаар шийдэх боломжтой гэж үзжээ. Энэхүү таамаг гэрээг хийхэд тодорхой нөхцөл байдал шаардлагатай. Роулзын хувьд энэ нөхцөл нь уг байдал (original position) юм. Хүмүүс аливаа асуудалд хандахдаа үргэлж өөрсдийн эрх ашгаа бодож, хувиа хичээдэг. Тэд шударга байхыг хичээсэн ч түүнд нь тэдний нийгмийн байр суурь, хувийн ашиг сонирхол нь саад болдог. Роулз, хүмүүс өөрсдийн эрх ашгаа, тэд ер нь өөрсдөө хэн болохоо мэдээгүй байх үедээ шударга байж чаддаг гэж үзсэн байна. Энд яригдаж буй уг байдал гэдэг нь жинхэнэ бодит байдал биш, харин асуудлыг шинжилж тайлбарлахын

тулд Роулзын гаргаж тавьсан нэг ёсны санаалаг туршилт (мысленный эксперимент) юм гэсэн чухал санааг Г.Скирбекк, Н.Гилье нар хэлжээ (6, 746)

Уг байдалд байгаа хувийн ашиг сонирхолтой тэдгээр хүмүүс “үл мэдэхийн хөшигний” (veil of ignorance) ард зогсож байдаг бөгөөд тэрхүү хөшиг нь хүмүүсийн өөрсдийнх нь тухай бүхий л баримт мэдээллийг хааж байдаг тусгай хэрэгсэл болж өгдөг ажээ. “Хэн ч нийгэм дэх өөрийнхөө байр суурь, ангийн байдал, эсвэл нийгмийн статусаа, бүр өөрт нь байгаа төрөлхийн үнэт зүйлс, ур чадвар оюуны чадамж, хүч чадлаа мэддэггүй. Би ер нь оролцогчидыг өөрсдийн сайн зүйлийн талаархи ойлголт, эсвэл өөрсдийн сэтгэл зүйн онцгой дур сонирхолоо ч мэддэггүй байх гэж таамаглаж байна” гэж Роулз бичжээ (9,137). Хүмүүс нэгэнт өөрсдийн тухай мэдэхгүй учир аль нэг тал руу хэвийж болохгүй. Учир нь тэдний гаргасан шийдвэр өөрсдөд нь хор хохирол учруулж болно. Тиймээс хүмүүс аль болох шударга байхыг хичээдэг. Үл мэдэхийн хөшигний ард байгаа хүмүүс тодорхой зарчимуудыг сонгох хэрэгтэй болдог. Тэдний хувьд өөрсдөө шинэ зарчим бий болгох чадваргүй тул тэдний өмнө сонгох зарчимуудын цэс ирдэг. Роулз тэдэнд өөрийнхөө зарчимуудыг санал болгосон байна. Эдгээр зарчимууд нь бодит амьдралыг зохицуулах үүрэгтэй юм.

Уг байдалд байгаа хүмүүс юунд дуртай, дургүйгээ, сонгож байгаа нийгмээ ямар болохыг мэддэггүй. Тэгвэл хүмүүс юун дээр үндэслэж сонголтоо хийх вэ гэсэн асуулт зайлашгүй гарч ирнэ. Роулз үүнд хариулт өгөхдөө “анхдагч сайн зүйлс” (primary goods) бол уг байдал дахь хүмүүсийн цорын ганц сэдэл болдог гэжээ. Түүнд эрх, эрх чөлөө, бололцоо, орлого, баялаг, өөрийгөө хүндэтгэх нийгмийн үндэс гэсэн зүйлс ордог.

Анхдагч сайн зүйлсийг эрмэлзэж байдаг хүмүүс харилцан бие биеэ сонирхдоггүй бөгөөд бүгд аль болох их хэмжээний анхдагч сайн зүйлсийг олж авахын төлөө байдаг ба бусад нь түүнд хүрсэн эсэх нь огтхон ч хамаагүй. Уг байдалд байгаа хүмүүс нинжин сэтгэл, атаа жетөө, өш хонзон гэдгийн алийг нь ч мэддэггүй.

Роулз уг байдалд байгаа хүмүүс үл мэдэхийн хаалт бүхий хөшигний араас дараахь хоёр зарчмыг сонгодог гэжээ.

Нэгдүгээр зарчим. Хүн бүр бусдад адил байдаг эрх чөлөөний системд тохирох эрх чөлөөний ижил сууринаас хандах тэгш эрхтэй байх ёстой.

Хоёрдугаар зарчим. Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь: а) хамгийн бага аз завшаан бүхий хүмүүс хамгийн ашигтай байхаар; б) албан тушаал, байр суурь нь бололцооны хувьд тэгш, шударга байдлаар бүх хүнд нээлттэй байхаар зохион байгуулагдсан байх ёстой (9,302).

Нэгдүгээр зарчим нь эрх чөлөөний зарчим бөгөөд хүн бүрт тэгш эрх чөлөөг өгч байгаа учир эгалитар зарчим юм. Нэгдүгээр зарчимд томъёологдсон эрх чөлөөний тоонд

үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, сонгох, сонгогдох, хувийн өмчтэй байх, хуулиар хамгаалуулах эрх орно. Эдгээр эрх нь ямар ч тохиолдолд, тухайлбал, төрийн халамжыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, ядуусын орлогыг нэмэх зорилготой байсан ч зөрчигдөх ёсгүй.

Хоёрын Б зарчим бол хүн болгон төрийн болон хувийн албан тушаал, байр сууринд хүрэх тэгш, шударга бололцоогоор хангагдсан байх ёстой гэсэн үг юм. Энэхүү зарчмыг шударга бололцооны зарчим гэдэг.

Хоёрын А зарчмыг “ялгааны зарчим” (the difference principle) гэж нэрлэдэг. Ялгаатай байх зарчим нь нийгэмд эрх мэдэл, орлого, байр суурь зэрэг зүйлсээрээ бусад хүмүүсээс илүү байдаг тийм албан тушаал, байр суурь зайлашгүй байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн зарчим юм. Бусдаас илүү ухаантай, авьяас чадвартай хүмүүс илүү сайхан амьдрах нь зүй ёсны асуудал билээ. Хэрэв удирдах албан тушаалтан доороо ажилладаг хүнтэйгээ адил цалин авч, нийгэмд адил статустайгаар амьдардаг бол энэ нь шударга бус юм. Роулз эд хөрөнгө, орлогын хувьд тэгш бус байх явдал нь үйлдвэрлэлийн өндөр түвшинг хангахад зайлашгүй хэрэгтэй зүйл гэж үзэж байв. Мэдээж хэрэг, тийм албан тушаал, байр сууринд хүрэх зам хүн бүхэнд нээлттэй байх ёстой. Аж амьдрал нь сайн байгаа хүмүүсийн амьдралыг илүү сайхан болгосон ч тэр нь дор байгаа хүмүүсийн амьдралд ямар ч нөлөө үзүүлээгүй, бүр дордуулсан бол түүнийг хүлээн зөвшөөрч болохгүй.

Роулз өөрөө эдгээр зарчимууд нь хоорондоо зөрчилдөх тохиолдолууд гарч болохыг хүлээн зөвшөөрч байлаа. Зүй ёсны зарчмууд нь хоорондоо эрэмбэлэгддэг ба эрх чөлөөг зөвхөн эрх чөлөөний тусын тулд хязгаарлаж болно. Тухайлбал эрх чөлөөний зарчим нь эрэмбээрээ нөгөө хоёр зарчимаас давуу юм. Шударга бололцооны зарчим нь мөн эрэмбийн хувьд ялгаатай байх зарчимаас илүү байна.

Уг байдалд байгаа хүмүүс яагаад заавал Роулзын зүй ёсны зарчимуудыг сонгох хэрэгтэй болдог вэ гэсэн асуулт гарч ирдэг. Та нэгэнт өөрийнхөө тухай юу ч мэдэхгүй учир өөртөө хор учруулахгүйн тулд зөв сонголт хийх хэрэгтэй болно. Сонголт хийх тодорхой зарчимууд байдаг. Уг байдалд байгаа хүн утилитар онолын дагуу сонголт хийж болох юм. Утилитар онолоор бол хүн өөрт нь хүлээгдэж буй ашиг тусыг аль болох ихэсгэх, тухайлбал дундаж үнэт чанарыг ихэсгэхийг хичээнэ. Үүнийг максимизын (maximize) зарчим гэдэг. Гэхдээ бид уг байдал дахь хүн өөрийнхөө тухай болон түүний хүлээж буй нийгэм нь ямар болохыг мэддэггүй гэдгийг байнга санаж байх хэрэгтэй. Хүн максимизын зарчмыг баримтлах нь түүнийг эрсдэлд оруулах магадлал өндөр байдаг.

Тиймээс Роулз хүмүүс “максимины” (maximin) зарчмыг баримтлах хэрэгтэй гэжээ. Энэхүү зарчим бол нөхцөл байдал нь тодорхойгүй байгаа үед шийдвэр гаргахад хэрэглэгддэг гол зарчим юм. Тэр нь хамгийн муу үр дүнг хамгийн боломжын зүйл болгож

хувиргахад сургадаг, хамгийн бага зүйлийг хамгийн их болгох зарчим болно (2, 212). Энэ бол сонголт хийх хамгийн аюулгүй арга зам бөгөөд ийм зарчмыг баримтлагчид Роулзын зүй ёсны зарчмыг сонгодог.

Роулз нийгмийн институтуудын тогтвортой байдал нь зүй ёсны зарчимуудтай шууд холбоотой гэж үзжээ. Тогтворгүй институтууд нь иргэдийн эрх, эрх чөлөө, бололцоог хамгаалж чадахгүй. Хэрэв институтууд дагаж буй зарчимууд нь тогтвортой биш гэдгийг ухаарвал тэдгээр зарчимуудыг өөрчлөх хэрэгтэй ажээ. Роулз энэ тухай бүтээлийнхээ гуравдугаар хэсэгт авч үзсэн бөгөөд зүй ёсны зарчмын дагуу байгаа институтууд утилитар зарчмыг баримталж буй институтуудаас хавьгүй илүү тогтвортой байдаг гэж үзсэн байна.

Роулз хууль болон нийгмийн институтууд үр ашигтай, сайн зохион байгуулагдсан байлаа ч гэсэн хэрэв шударга бус байвал шинэчлэгдэх, солигдох ёстой хэмээн үзжээ. Тэрбээр иргэдийн дуулгаваргүй байдлыг (civil disobedience) дараахь нөхцөлд зөвтгөж болно гэжээ. Үүнд:

1. Хэрэв зүй бус явдал бодитойгоор биелэлээ олж, ялангуяа өөр бусад зүй бус явдлыг арилгахад хэн нэгэн этгээд саад болж байгаа болон, эрх чөлөөний зарчим зөрчигдөж, шударга бололцооны зарчим илэрхий үгүйсгэгдсэн үед зөвтгөж болно.
2. Хэрэв олонход тавьсан санал сайн санааны үүднээс тавигдсан, гэхдээ тэр нь бүтэлгүйтсэн бол иргэдийн дуулгаваргүй байдал сүүлчийн найдлага байх болно.
3. Цөөнхийн олон янзын бүлгүүд хууль ёсны шаардлагаа дуулгаваргүй байдлыг сонгох замаар тавих юм бол шударга үндсэн хууль элэгдэж мууддаг. Ийм байдлыг шийдвэрлэх арга зам бол цөөнхийн олон бүлгүүд олонхтой эвсэж улс төрийн эвсэл байгуулах явдал юм гэж үзжээ.

Ж.Роулзын үзлээр зөвлөлт маягийн коммунизм нь шударга бус бөгөөд учир нь үндсэн эрх чөлөөнүүдтэй харшилдсан үйл ажиллагаа явуулдаг. Цэвэр *Laissez – Faire* (төр үл оролцох) капитализм нь мөн адил шударга бус, учир нь энд эд баялаг, орлого шударга хувиарлагддаггүй гэжээ. Роулзын хувьд шударга нийгэм бол хувийн өмчийг дээдлэсэн ардчилсан нийгэм юм. Ийм нийгэмд үйлдвэрлэлийн арга хэрэгсэлийн эзэмшил нь өргөнөөр хувиарлагдсан байдаг ба ядуу буурай хэсэг нь эдийн засгийн хувьд бие дааж хөгжих боломжтой байх ёстой.

Роулзын зүй ёсны онол нь эл асуудлаархи бусад үзэл баримтлалд идэвхтэй нөлөөлж, дэлхийн олон орны эрдэмтэдийн анхаарлыг татсан бөгөөд тэдний нэг хэсэг нь уг онолыг сайшаан дэмжиж байсан бол өөр нэг хэсэг нь шүүмжилж байв. Тухайлбал америкийн улс төрийн философийн томоохон төлөөлөгч Роберт Нозик “Роулзын шударга ёсны онол бол улс төрийн болон ёс зүйн философийн чиглэлийн хүчтэй, гүн гүнзгий, түгээмэл, өргөн агуулга бүхий системтэй бүтээл бөгөөд хэрэв харьцуулж болдогсон бол

Жон Стюарт Миллээс хойш түүнтэй дүйцэх зохиол гараагүй билээ. ...Улс төрийн философчид одоо нэг бол Роулзын онолын хүрээнд ажиллах, эс тэгвээс яагаад үгүй гэдгээ тайлбарлах хэрэгтэй боллоо” гэж Роулзын онолыг өндөр үнэлэхийн хамт эл онол түүхэн нөхцөл байдлаас тасархай, хийсвэр шинжтэй юм хэмээн шүүмжилсэн байна (10,212). Роулзын онолыг судлан шинжилж нэгэн сэдэвт бүтээл туурвисан оросын эрдэмтэн Т.А.Алексеева мөн адил эл онолын гол дутагдал бол нийгэм-улс төрийн түүхэн тодорхой нөхцөл байдлаас тасархай, хийсвэр загвартай байгаа явдал юм гэж шүүмжилжээ (4,82).

Роулз ийм талархал, дэмжлэг ба шүүмжлэлийн аль алины нөлөөг тусган авч өөрийн онолоо эргэн харж засварлан боловсронгуй болгож байв. Түүний онолдоо хийсэн засвар, өөрчлөлт нь нэгдүгээрт, бие хүний тухай үзэл баримтлалаа нягтлаж улам тодруулах, хоёрт, онолоо улам бүр улс төрийн утга агуулгатай болгох, гуравт, эл онол нь дэлхийн аль ч оронд тохирох түгээмэл шинжтэй биш, харин америк маягийн баян чинээлэг, ардчилсан, зах зээлийн эдийн засагтай хөгжингүй орнуудын нийгмийн амьдралд илүү нийцэж тохирох чиглэлтэй болсон байна.

Роулзын онол нийгмийн амьдралын түүхэн тодорхой нөхцөл байдлыг тусгаагүй, хийсвэр шинжтэй байна гэсэн шүүмжлэлд үнэний хувь байгааг үгүйсгэх аргагүй боловч нөгөөтэйгүүр түүнийг бүрэн зөвтгөн зөвшөөрөх үндэслэл бас хомс юм. Роулзын зохиол аль нэг орны нийгэм, улс төрийн амьдралыг тодорхой авч үзэж шинжилсэн улс төр судлалын бүтээл биш, харин нийгэм дэх зүй ёс, нийгмийн амьдралын улс төрийн шударга зохион байгуулалтын асуудлыг онолын түвшинд, ёс зүйн болон улс төрийн философийн аспектыг хослуулан авч үзэж нэгтгэн дүгнэх зорилго тавьсан философийн бүтээл билээ. Эдийн засгийн хувьд зах зээлийн харилцаанд үндэслэсэн, улс төрийн хувьд ардчилсан, оюун санааны амьдралд олон эшт үзэл, байр суурь тогтсон орчин үеийн нийгэмд зүй ёс, нийгмийн шударга ёсны тухай нэгдмэл ойлголт, байр суурь бий болох аргагүй юм. Тийм учраас Роулз зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх иргэд, нийгмийн бүлэг, давхраануудын ялгаатай эрх ашиг, байр суурь ба нөгөө талаас нийгэм дэх тэдний хамтын амьдралын хэрэгцээ шаардлагаар зайлашгүй нөхцөлдсөн нийгэм-улс төрийн шударга ёс, зүй ёсны зарчмын хоорондын зүй зохистой харьцаа, тохирооны тухай онолын ерөнхий үзэл санаа, төсөөллийг ёс зүйн болон улс төрийн философийн зааг уулзвар, огтолцол дээр бүтээж боловсруулах, томъёолон тавих зорилго тавьжээ. Чухам үүнтэй Роулзын зохиолын агуулга, бүтэц, ерөнхий логик хийгээд тодорхой үзэл санаа, онцлог нягт холбоотой бөгөөд сэтгэгчийн боловсруулсан зүй ёсны онолыг үзэж ойлгох, үнэлж цэгнэхдээ эл байдлыг анхаарч тооцох хэрэгтэй ажээ.

Роулзын боловсруулсан зүй ёсны онолын үнэ цэнэ, ач холбогдол нь бүхэлдээ ХХ зууны дэлхийн хөгжингүй орнуудын нийгмийн амьдралын улс төрийн зохион байгуулалт, нийгэм дэх зүй ёс, шударга ёс, хуваарилалт, ардчилал, тэгш эрх, иргэд амжилтад хүрэх

гарааны тэгш байдлыг авч үзэж ойлгох, тэдгээрийг цаашид ямар арга зарчимаар боловсронгуй, зүй зохистой, шударга болгох вэ гэсэн тулгуур асуудлыг улс төрийн философийн аспектээр шинэ байдлаар дэвшүүлэн тавьж түүнд онолын үүднээс нэгэн сонирхолтой хувилбараар хариу өгсөнд оршино гэж дүгнэж болно.

Abstract

In Mongolia since 1990 The history of twentieth - century western social thought, including political philosophy have been researched. The Author considers in his article the main ideas of Rawls's theory of justice by examining his magnum opus "A Theory of Justice".

Ашигласан ном зохиол

1. Батчулуун Б. Зүй ёсны тухай Ж. Раулсын онол. - Философи, шашин судлал III. МУИС - ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2005. 1244 (27)
2. Вольф Ж. Улс төрийн философийн удиртгал. Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун. УБ., 2002
3. Жамбал А. Улс төрийн философийн судлах асуудлын тухайд. - Философи, эрх зүйн судлал. XXII боть. УБ., 2007
4. Алексеева Т.А. Справедливость как договор (Критический анализ теории Джона Роулса). - Проблемы политической философии. М., 1991. с. 69 – 85.
5. Реале Д, Антисери Д. Западная философия от истоков до наших дней. Том 4. От романтизма до наших дней. Санкт – Петербург., 1997
6. Скирбекк Г, Гилье Н. История философии. Пер. с англ. В.И. Кузнецова. М., 2000
7. John Rawls. Internet encyclopedia of Philosophy
8. John Rawls. Encyclopaedia Britannica 2007 Ultimate Reference Suite DVD
9. Rawls J. A Theory of Justice. Harvard University Press. 2005
10. Роберт Нозик. Анархи ёс, төр, утопи үзэл. Орчуулсан С.Наран. УБ., 2006

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨРИЙН АРГА

С.Зульфикар

доктор

Удирдлагын Академи, Нийгмийн Удирдлагын тэнхмийн эрхлэгч

Хүний нийгмийн үндсэн шинжүүдийн нэг аливаа юмс үзэгдлийг харьцуулах, түүгээр дамжуулан тухайлсан ойлголт, төсөөлөл, үзэл бодолтой болох явдал байдаг. Хүмүүс өөрийгөө, өөрсдийгөө өрөөл бусадтай харьцуулах, гишүүн нь болж байгаа гэр бүл, нийтлэг бүлэг, харьяалагдаж байгаа улс үндэстэн, улс төрийн тогтолцоогоо бусдынхтай харьцуулж, жишсээр ирсэн. Миний хүүхэд байхад капиталист ертөнц гэж ялзарч завхарсан, хүний эрх чөлөө, эрх ашгийг цөөн тооны эрхтэн дархтнуудын тусын тулд уландаа гишгэсэн нийгмийн харилцаа байдаг тухай хэн хүнгүй ярьдаг байв. Улс төр-нийгэм- эдийн засгийн үзэл сурталжсан харьцуулалт буюу анхдагч төсөөлөл маань ингэж бүрэлдэж байсан бөгөөд энэ бүгдийг ухаан санаандаа ургуулан бодох гэж хэрэндээ л зүдэрдэг байж билээ. Өөрөөр хэлбэл харьцуулалт хийх нь хүний төрөлхийн буюу түүнд байгаль эхээс олгосон өгөгдөл гэлтэй. Аливааг харьцуулах нь юмс, үзэгдэл, зүй тогтлын сайн-муу, давуу-сул, хэрэгтэй-хэрэггүй талыг олж илрүүлэх, шаардлагатай гэж үзвэл шинэчлэх, боловсронгуй болгох шийдэлд хүрэх анхдагч арга зам байдаг.

Иймд харьцуулах, жиших оюун санааны үйлдлийг хүний тухайлбал хүний нийгмийн үүсэлтэй холбож ойлгож болохоор байна. Зарим харьцуулалт иргэдийн амьдрал ахуйг баримжаалж, түүнд нөлөөлөх улс төрийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлох нь ч бий. Тухайлбал, улс төрийн сонгууль нь сонгогчдын хувьд улс төрийн сонгуульд өрсөлдөгч талуудаас сонголт хийх ухамсартай, эрх зүйгээр зохицуулагдсан албан ёсны үйлдэл байдаг. Таны сонголт ялж болно ялагдаж болно. Эхний тохиолдолд таны сонголт ялсан бол цаашид бусад улс төрийн хүчинтэй өөрийн сонголтыг харьцуулах бус улс төрийн эрх мэдэлд хүрсэн улс төрийн хүчний хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаатай сонгуулийн өмнөх итгэл үнэмшил, хүлээлтээ харьцуулан өөрийн сонголтоо үнэлж, дүгнэнэ.

Ийнхүү энгийн харьцуулалт нь харьцуулсан улс төр судлалтай ижил үү эсвэл өөр үү гэсэн асуулт тавигдаж байна. Хариулт нь тийм бас үгүй. Тийм гэсний учир нь харьцуулсан улс төр судлалд бидний өдөр тутмын амьдралд хэрэглэдэг харьцуулалт хийх ердийн аргыг хэрэглэдэг. Бодит хариулт нь үгүй. Үгүй гэсний учир нь харьцуулсан улс төр судлалд нийгмийн шинжлэх ухаан түүн дотроо улс төр судлалд түгээмэл хэрэглэж байгаа туршигдсан, батлагдсан судалгааны аргуудыг тулгуур болгодог

оршино. Хэдийгээр ердийн ажиглалтын арга ашиглаж болох ч харьцуулж байгаа зүйлээ бодит нөхцөл байдалд ойртуулан судлах үүднээс шинжлэх ухаанд түгээмэл ашиглагдаж байгаа аргуудаар харьцуулан судлах зайлшгүй шаардлага урган гарна.

Нөгөөтэйгүүр харьцуулсан улс төр судлал чухам юуг хэрхэн судалдаг вэ? гэсэн асуулт тавигдах нь гарцаагүй. Улс төрийн тогтолцоо, түүнийг бүрдүүлж байгаа институцууд, үнэт зүйл, манлайлагчидыг харьцуулах нь онолын болоод практик ач холбогдолтой байж болно. Ямартай ч харьцуулна гэдэг нь хоёр болон түүнээс олон тооны юмс, үзэгдлийн ижил төстэй хийгээд ялгаатай байдлыг олж тогтоох үйл ажиллагаа байдаг¹ учраас дээрх зүйлсийг цаг хугацааны өөрчлөлтөөр нь мөн түүнчлэн өөр өөр орчинд (улс орон, газар нутаг, бүс, хязгаарт) хэрхэн бүрэлдэж, үйлчилж байгааг олж илрүүлэх, тэдгээрийн зүй тогтол, учир шалтгаан, бодит нөхцөлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийх ёстой болж байна.

Харьцуулсан улс төр судлалын түүхэн хөгжил багагүй цаг хугацаа туулж, янз бүрийн үндэстэний нийгэм - улс төр - төр ёсны хөгжилтэй холбогдсон байдаг. Анхны системтэй харьцуулсан судалгаа эртний Грек, Ромын үеэс буюу 2500 жилийн өмнөөс магадгүй түүнээс урьд ч эхэлсэн байж болох талтай.² Эртний Грек, Ромд хот улсуудыг хооронд нь харьцуулах, иргэдийн шууд оролцоотой боловсруулж, хэрэгжүүлсэн бодлогыг тухайлан харьцуулж, үнэлж, дүгнэсэн, шаардлагатай гэж үзвэл шинэ шийдэл хайх арга дэлгэрсэн байжээ.³ Эртний хүмүүс, овог, аймаг, гэр бүл өөрсдийн байр байдлыг тэдэнтэй харилцаанд ордог бусад овог аймагтай харьцуулан зохих ойлголттой болдог байв. Христийн шашны ариун судар Библи харьцуулсан судалгааны анхны бичмэл эх сурвалжуудын нэг байж болох юм. Тухайлбал, Библи сударт өгүүлснээр бурхны элч гэгдэх зөнчид эртний Израильчуудыг Мисир, Перстэй харьцуулсан байх нь цөөнгүй тохиолддог.⁴

Эртний Грекийн суут сэтгэгчид Платон, Аристотель улс төр судлал, харьцуулан судлах арга зүйг үндэслэгчид байсан гэгддэг. Тэдний судалгаа нь улс төрийн хүрээний бүхий л асуудал: төр, төрийн бодлого, институт, манлайлал зэрэгт чиглэгдэж байсны зэрэгцээ үнэ цэнээ алдаагүй хэвээр байна. Платоны “Бүгд найрамдах улс”, Аристотелийн “Төр” зэрэг сонгодог бүтээлүүд өнөө цагийн харьцуулсан улс төр судлалд онцгой байр сууриа хадгалсаар байна. Аристотел судалгаандаа улс төрийн тогтолцоо, харилцааг

¹ Grofman, Bernard, and Lijphart, Arend (eds.). *Electoral Laws & Their Political Consequences*. New York: Agathon Press, 1986. x-23

² http://en.wikipedia.org/wiki/Comparative_politics

³ Morton R. Davies & Vaughan A. Lewis. *Models of Political System*. The Pithman Press. 1971 page 113.

⁴ Rod Hague & Martin Harrop *Comparative Government and Politics*. 5th edition. Palgrave 2001. x-36

харьцуулан судлах арга зүйг түлхүү хэрэглэсэн. Тэрээр эртний Грекийн хот-улс болон ойр тойрныхоо бусад улсын 150 гаран үндсэн хуулийг цуглуулж ангилах, бүлэглэх, нэгтгэн дүгнэх аргаар судалжээ. Түүний судалгааны зорилго нь бусад хот улсын улс төрийн тогтолцоо, харилцааг судлах замаар засаглалын хамгийн оновчтой хувилбар санал болгох явдал байв. Платон, Аристотель нар улс төрийн системийн анхны цэгцтэй ангиллыг санал болгосон. Тэдний боловсруулсан ангиллыг өнөөдөр ч улс төр судлалын арга зүй болгон хэрэглэсээр байна.

18-р зууны Францын их сэтгэгчдийн нэг Монтескье улс төр, түүн дотроо харьцуулсан улс төр судлалд онцгой байр суурьтай сэтгэгчдийн нэг байв. Тухайн цаг үеийн Английн философичид Томас Гобесс, Жон Лок нар улс төрийн харьцуулсан судалгаа хийсэн боловч энэ нь дан ганц улсаар хязгаарлагдаж байсан төдийгүй тэд үүнийгээ бусад улсад мөн адил түгээмэл байх хууль гэж үзэж байжээ. Харин Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлээрээ улс орнуудын эрх зүйн харилцааны мөн чанар, зарчмыг судлаад зогсохгүй түүний бий болох, бүрэлдэх, хэрэгжих нийгэм-соёлын орчинд давхар дүн шинжилгээ хийсэн байдаг. Үүгээр нь түүнийг жинхэнэ харьцуулсан судлаач байжээ гэж үнэлдэг.

Америкийн их сургуулиуд 1890-ээд оноос гадаад орны улс төр сэдэвт хичээл үздэг байсан бөгөөд XX зууны эхнийг хүртэл харьцуулсан улс төр судлал судлаачдын анхаарлыг төдий л татаж чадахгүй байв. Харьцуулсан судалгаа нь гол төлөв Их Британи, Франц, Герман зэрэг улсуудаар хязгаарлагдаж байжээ.⁵ Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш харьцуулсан улс төр судлал судлаачдын анхаарлыг татаж, эрчимтэй хэрэглэгдэх болсон. Энэ нь нэг талаар нацистуудын аюул заналаас эмээн баруун Европоос дүрвэсэн эрдэмтэд, судлаачид Америкийн их, дээд сургуулиудад судалгаа, шинжилгээний ажил хийж, тэндхийн академик орчинд оюун санааны шинэ хүч болсон, нөгөө талаар олон улсын харилцаанд олон талт, хоёр туйлт харилцаа төлөвшсөн нь түүнийг зайлшгүй судлах хөрс, түлхэх хүчин зүйл болсонтой шууд холбоотой. Үүнийг дагалдсан даяарчлал түүний үр дүнд бий болсон олон улсын харилцаа нь улс орнууд бие биенийхээ улс төрийн тогтолцоо, харилцааг танин мэдэх, угтаа бол практик хэрэгцээ аяндаа үүсгэсэн.

Ер нь харьцуулсан судалгаа хийх зарчмын ямар шаардлага байгаа юм бэ? гэсэн асуулт дахин тавьж болох юм. Үүнд дараах байдлаар хариулт хүргүүлж болох болов уу.

- Юуны өмнө өөр улс орон, үндэстэн, бүс нутгийн талаар мэдээлэлтэй болох нь сонирхолтой байх нь эргэлзээгүй.

⁵ Morton R.Davies & Vaughan A.Lewis. Models of Political System. The Pithman Press. 1971 x-111.

- Бусад улс орны талаар судалгаа явуулах нь судлаачид угсаатан-үндэстэн төвтэй (ethnocentric)⁶ үзлээ давж гарах боломж нээдэг.
- Судлаачдад өөрийн оюун ухааны боломж, мэдлэг туршлагаа сорих боломж нээнэ. Тухайлбал, Яагаад зарим улс орон өндөр хөгжилтэй байхад зарим нь хөгжлөөр хоцорсоор байн вэ? Яагаад зарим нь ардчилсан дэглэмтэй байхад зарим нь цэргийн эсвэл авторитар дэглэмтэй байна вэ? гэх мэт.
- Харьцуулсан судалгааны арга зүй, аргачлал нь байнга шинэчлэгдэж, боловсронгуй болж байдаг нь судлаачдад шинэ арга барилаар судалгаа хийж өөрийгөө сорих, үйл явдал, үйл явцыг тухайлан танин мэдэх, ойлгох боломж нээнэ.
- Ижил төстэй болон ялгаатай улс орнуудыг судалснаар тэдний туулж өнгөрүүлсэн алдаа, ололт туршлагаас суралцах таатай нөхцөл бүрдэнэ.

Харьцуулалт хийсний ач холбогдол, үр дүн нь юу байж болох талаар хэлэлцсэн бол түүний шалтгааныг мөн адил томъёолж болох юм. Үүнийг дараах үндсэн учир шалтгаантай холбож тайлбарлах нь зүйтэй болов уу. Эдгээр нь нэг талаар харьцуулалт хийх шалтгаан нөгөө талаар харьцуулах арга замыг тодорхойлно. Үүнд: агуулгын шинжилгээ (тайлбар), ангилах буюу бүлэглэх (төрөл зүйл, хамрах хүрээгээр нь), дэвшүүлсэн таамаглалаа турших (сорих), онол дэвшүүлэх, урьдчилан хэлэх зэрэг нь болно.⁷

Агуулгын шинжилгээ нь ялгаатай тогтолцоо, бусад улс орны талаар тодорхой, гүн гүнзгий ойлголттой болох арга зам юм. Тухайлбал, Хятад яагаад улс төрийн хувьд коммунист чиг баримжаатай, эдийн засаг нь зах зээлийн харилцаанд суурилсан либерал шинжтэй байна вэ? Дэн Сяопины бодлогыг гарамгай залгамжлагчид чадварлаг аргаар улс орноо социалист аж ахуйн системээс зах зээлийн харилцаа руу чиглүүлж, нийгмийн өмнө тулгараад байгаа асуудалд бүрт бодитой хандаж улс төрч хүний чадамжийг харуулан, шаардлагагүй зүйлээ ард түмэндээ хэлэхгүй байж, шаардлага гарвал коммунизмыг ч хоёр өөр янзаар ойлгогдохоор тайлбарлан эцсийн бүлэгт улс орноо өөд татаж чадсан.⁸

Хятадын тухайд улмаар гүнзгийрүүлэн судалж, улс төрийн тогтолцоо, коммунист нам, түүний хэрэгжүүлж байгаа нийгэм-эдийн засгийн бодлогыг нарийвчлан ойлгох мэдээлэл бүрдүүлж, агуулгын шинжилгээ, тайлбар хийснээр энэ улсын талаар тодорхой ойлголттой болоод зогсохгүй улс төрийн дэглэмийн бусад хэлбэрээс (ардчилсан) ямар

⁶ Аливаа юмс үзэгдэл, хөгжлийн төвд өөрсдийгөө буюу өөрийн бүрэлдэж бий болсон угсаатныг тавих үзэл. Өөрөөр хэлбэл хөгжлийн төвд бид буюу манай үндэстэн, угсаатан байдаг, бидний оюун санаа, материаллаг хөгжил анхдагч нь, мөн тэргүүлэгч байсан гэж номлоно.

⁷ Todd Landman. Issues and Methods in Comparative Politics in Introduction. Routledge 2002. х-4.

⁸ Конрад Зайц, Хятад: Дэлхийн их гүрэн эргэн иж байна. Орчуулга Д.Моононцагаан. Монсудар. УБ., 2006. х-11

ялгаатай, юугаараа ижил төстэй байж болох тухайд дүгнэлт өгнө. Үүнийг нэг улсын хувьд хэрэглэж болохын дээр хэсэг бүлэг улсын хувьд нэвтрүүлж болно. Тухайлсан агуулгын шинжилгээ хийснээр судлаач угсаатан төвтэй (дан ганц өөрийн улс орон, үндэстэнг судлах) судалгааны арга зүйгээс зайлсхийж, судлагдахууны хувьд субъектив биш хандлагад тулгуурласан үнэлэлт дүгнэлт өгөх таатай нөхцөл болдог байна. Америкийн улс төр судлаач Макевилли 1967 онд бичсэн “Сандиногийн асуудал” сэдэвт номонд Никарагуад ерөнхийлөгчийн сонгуулийн дараа Августо Сандиногийн шууд удирдлага доор өрнөсөн партизаны хөдөлгөөн, түүний шалтгаан, АНУ-ын оролцоо ямар байсан тухайд агуулгын шинжилгээ хийх зорилго тавьсан байдаг.

Улс орон, улс төрийн тогтолцоо, институцуудын харилцааг бүлэглэх, ангилал нь харьцуулан судлах бас нэг үндэслэл юм. Улс төрийн дэглэмийг авторитар, тоталитар, коммунист гэх мэтчилэн ангилж болохын зэрэгцээ засаглалын хэлбэрээр нь ерөнхийлөгчийн, хагас ерөнхийлөгчийн, парламентын засаглалтай гэх мэтчилэн ангилдаг. Ангилал хийхдээ урьдчилан боловсруулсан төгс загварын хүрээнд хийж болохын зэрэгцээ систем бүрийн шинж чанарыг тухайлан илрүүлж, хоорондын нь ижил төстэй болоод ялгаатай талыг олж тогтоох хэлбэрээр хийж. Нэг ангилалд багтах нөхцөл нь яах аргагүй ижил, төстэй шинж чанар байх ёстойн дээр түүнд тохирсон шалгуурыг мөн адил олж тогтоосон байна. Аристотел шинжлэх ухааны үндэслэлтэй хамгийн анхны улс төрийн системийн ангилал боловсруулсан байдаг. Түүний ангиллын зорилго нь улс төрийн системүүдийн давуу хийгээд сул тал, ашигтай болон хор хөнөөлтэй шинж чанарыг олж илрүүлэх, дэлгэн тавихад оршиж байв. Уг ангилал нь нэг талаар хот-улсууд (city states)-д хэрэглэж байгаа үндсэн хуулийн ангилал байжээ.

Хүснэгт 1 1

Аристотелийн улс төрийн дэглэмийн ангилал

Эрх мэдэл хэрэгжүүлэгч

Дэглэмийн хэлбэр	Сайн	Дангаар	Цөөнх	Олонх
			Монархи	Аристократ
	Муу	Тирани (дарангуйлал)	Олигархи	Ардчилал

Эх сурвалж: Rod Hague & Martin Harrop *Comparative Government and Politics*. 5th edition. Palgrave 2001. p-24


Аристотель улс төрийн сайн тогтолцоонд монархи, аристократ, полити дэглэмийг; муу тогтолцоонд тирани, олигархи, ардчилсан дэглэмийг багтаажээ. Засаглалын сайн хэлбэр нь иргэдийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бол засаглалын муу хэлбэр нь цөөнх болон эрх мэдэлтний эрх ашгийн төлөө үйлчилж байгаагаараа ялгарна. Монархи хэлбэр нь эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх, ард түмний төлөөх систем байдаг бол аристократ хэлбэрт цөөнх ард түмний төлөө үйлчилж, полити засаглалд ард түмний сайн сайхны төлөө тэдний өөрсдийн засаглал оршин тогтнодог. Энэ гурван засаглалын хэлбэр нь эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байгаагаас үл хамааран ард түмний төлөө үйлчилсэн, тэдний эрх ашгийг дээдэлсэн улс төрийн систем юм. Тирани засаглалд хаан дангаараа эрх мэдэл хэрэгжүүлж, түүнийг өөрийн эрх ашигт нийцүүлэн нэвтрүүлдэг бол олигархийн дэглэмд цөөнх дан ганц тухайн цөөнхийн эрх ашигт үйлчилдэг. Ардчилсан дэглэмд олонх нь олонхын эрх ашгийн төлөө үйлчилсэн засаглал хүлээн зөвшөөрөгдсөн байдаг хэдий ч энэ нь нэг талаар ард түмний төлөөлөл болсон зарим нийтлэг бүлгийн эрх ашгийг орхигдуулсан байж болох талтай. Энд тэрээр олонх зарим тохиолдолд цөөнхийн эрх ашгийг зөрчиж болзошгүй нөхцөл байдлыг тооцсон бололтой.⁹

Улс төр судлаачид улс төрийн аливаа харилцааны талаар онолын үндэслэлтэй таамаглал дэвшүүлж, үүнийгээ сорих оролдлого хийдэг. Байгалийн шинжлэх ухаантай харьцуулахад нийгмийн шинжлэх ухаанд туршилт хийх боломж хязгаарлагдмал байдаг ч тодорхой онол, загвар, парадигмын батлагдах, эс батлагдах нөхцөлийг таамаглал дэвшүүлэх хэлбэрээр сорих боломжтой. 1982 онд судлаач Бринхам Повел ардчилсан дэглэмтэй 29 улсад сонгогчдын сонгуульд оролцох оролцоо идэвхийг хэд хэдэн хүчин зүйлээр таамаглал дэвшүүлж сорил хийсэн байна. Тэрээр дотоодын нийт бүтээгдэхүүн өндөр, улс төрийн намууд нь төлөвшсөн, сонгуулийн оновчтой хууль үйлчилдэг, иргэд нь төлөөллийн ардчиллын зарчмын үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлдэг улсад иргэд нь сонгуульд идэвхтэй оролцож, тэр хэрээр сонгуульд санал өгөгсдийн хувь өндөр байдаг гэсэн таамаглал дэвшүүлжээ. Судлаач эл таамаглалаа сорих зорилгоор дээрх шинж чанарыг илэрхийлж чадах ангилалд багтсан 29 улсад сонгуулийн оролцоо, үр дүнд дүн шинжилгээ хийжээ. Түүний дэвшүүлсэн таамаглал нь төлөөллийн ардчиллын үнэт зүйл хэвшин тогтсон эдгээр улсуудад хийсэн судалгааны явцад батлагдсан байна.¹⁰ /зураг 1-ийг үзнэ үү/.

Бүдүүвч Сонгогчдын сонгуулийн идэвхи

⁹ Өгүүлэл бичигчийн өөрийн дүгнэлт бөгөөд онолын судалгааны баримт бичигт тулгуурлан дэвшүүлсэн санал болно. Иймд улс төр судлалын бусад ном, сурах бичгийн тайлбар, дүгнэлтийг давхар үзэхийг санал болгож байна.

¹⁰ Powel G. Brinham (1982) *Contemporary Democracies: Participation, Stability and Violence*. Cambridge, MA: Harvard University Press




Эх сурвалж: Patterns of Democracy: Government Forms & Performance in Thirty-six Countries. New Heaven: Yale University Press, 1999. дам ишлэв.

Улс төрийн харьцуулсан судалгаа хийх өөр нэг үндэслэл нь аливаа улс төрийн үйл явц, үзэгдлийг урьдчилан таамаглах явдал юм. Нэгэнтээ бэлэн байгаа онол, загвар, хэд хэдэн удаа давтагдсан үйл явц, эмпирик туршлагад тулгуурлан одоо байгаа болон цаашид илэрч болох үзэгдэл, үйл явц, түүнээс гарч болох үр дүн, үр дагаварыг урьдчилан хэлэх нь харьцуулсан судалгааны бас нэг хэлбэр юм. Энэ нь нэг талаар онол, загвар, олон дахин давтагдсан эмпирик туршлагад тулгуурласан мэдлэг ашиглаж байгаа хэлбэр боловч нөгөө талаар тэдгээр онол, загвартай одоо бий болж байгаа улс төрийн үйл явцыг харьцуулж байгаа хэлбэр юм.

Тухайлбал, парламентад хэд хэдэн удаа улиран сонгогдсон нэр дэвшигч анх удаа нэр дэвшиж байгаа өрсөлдөгчөө ялах боломж их байдаг гэсэн таамаглал дэвшүүлье. Ер нь олон оронд сонгуулийн эцсийн үр дүнд шинжилгээ хийж үзэхэд улс төрд олон жил болсон, олны танил хүмүүс улс төрд шинээр орж ирсэн өрсөлдөгчөө ялах магадлал өндөр байгаа нь тогтоогджээ. Нөгөөтэйгүүр сонгогчид улс төрийн туршлагатай, өөрсдийг нь өмнө нь төлөөлж байсан нэр дэвшигчид итгэх хандлага түлхүү ажиглагддаг. Улс төрийн намууд сонгуульд бэлтгэх, сонгуулийн тойрог хуваарилах стратеги боловсруулахад харьцуулсан улс төр судлалын энэ аргыг санаатай болон санамсаргүй байдлаар ашигладаг. Гагцхүү энэ нь туйлын үнэн, зайлшгүй болон гарцаагүй биелэх магадлал бүхий таамаглал болохгүй учраас улс төрийн хүчнүүд гэхээсээ улс төр судлаачдын судалгаа хийх шалтгаан, бас арга болох нь илүүтэй. Улс төр судлаач Тату Ванханен ардчиллын индексийг тооцоход урьдчилан таамаглах аргыг сонирхолтой хэлбэрээр ашигласан байдаг. Тэрээр Зүүн Өмнөд Азийн 16 улсын хувьд 1993 оны улс төр, иргэний эрх, улс төрийн оролцоон дахь бодит нөхцөл байдлыг суурь болгон 1997 онд тэдгээр үзүүлэлт хэрхэн өөрчлөгдөж болохыг урьдчилан

таамагласан байна. Улмаар дэвшүүлсэн таамаглалаа улс болгонд явуулсан экспертийн үнэлгээтэй харьцуулан дүн шинжилгээ хийжээ.

Бүдүүвч 2



Эх сурвалж: Tatu Vanhanen, *Democratization Index in the Polity Dataset*.
<http://www.janda.org/>

Ванханен Зүүн Өмнөд Азийн 16 орны ардчиллын нөхцөл байдлыг индексжүүлж үнэлэхдээ улс төрийн оролцоо, улс төрийн олон ургальч үзэл (өрсөлдөөн)-ийг шалгуур болгосон. Иргэд, улс төрийн намууд улс төрд чөлөөтэй оролцох эрх зүйн болоод нийгмийн боломж, нөхцөл, жижиг намуудын сонгуульд оролцсон байдал, авсан саналыг ардчиллын индексийг тодорхойлох үзүүлэлт болгосон байна. Дэвшүүлсэн таамаглал болон одоогийн үнэлгээний зөрүү нь ардчиллын үйл явцын хандлага хэрхэн төлөвшиж байгааг харуулна. Япон, Өмнөд Солонгос түүний таамаглаж байсан үнэлгээг авч чадсан бол Монгол, Филлипин, Малайз улсууд таамаглаж байснаас өндөр үнэлгээ авчээ. Бруней, Тайван, Хятад таамаглаж байснаас доогуур үнэлгээ авсан байна. Ванханен урьдчилан таамаг дэвшүүлэхдээ өнгөрсөн хугацаанд тухайн улсуудад ардчиллын үйл явц хэрхэн өөрчлөгдөж байсан мэдээллийг ашиглан, регрессийн шинжилгээ хийжээ. Өөрөөр хэлбэл түүний дэвшүүлсэн таамаг нь регрессийн шинжилгээний үр дүн байсан бөгөөд үүнийг шалгах зорилготой экспертийн үнэлгээнд тулгуурласан юм.

Одоо харьцуулсан судалгаа хэрхэн хийх аргачлалын тухайд тухайлсан ойлголтоо өргөжүүлэе. Харьцуулах арга нь цаг хугацаа, орон зайн харьцуулалт хийх боломж олгодог, тэр хэрээр ийм нөхцөл байдал шаарддаг Тиймдээ ч улс төрийн институт, үйл явцын түүхэн хөгжил, өөрчлөлтийг судлах аргыг түгээмэл ашигладаг. Энэ аргыг түүхчлэн

судлах диахроник (diachronic) арга гэнэ.¹¹ Тодорхой нэг улсын хувьд улс төрийн институт, үнэт зүйл, харилцааны тогтвортой байдал, өөрчлөлт, хөгжил ямар байгаад дүн шинжилгээ хийхэд энэ аргыг түгээмэл хэрэглэнэ. Агуулгын шинжилгээ хийхэд энэ аргыг хэрэглэж болох жишээг үүнээс өмнө цухас тэмдэглэсэн билээ. Тухайлбал, 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалаас өмнө Монгол улсад нэг намын удирдлагатай, улс төрийн авторитар дэглэм тогтож байсан. Түүнчлэн улс төр-эдийн засаг-нийгмийн бүхий л харилцааг улс төрийн цорын ганц хүчин өөрийн үзэл суртал, баримтлалын хүрээнд чиглүүлж байв. Тэр үеийн Монголын улс төрийн амьдралыг нам төвтэй байсан гэж томъёолох нь бий. 1992 оны шинэ Үндсэн хуулиар Монголд улс төрийн олон ургальч үзэл төлөвшиж, чөлөөт ардчилсан сонгуулиар сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагыг бүрдүүлж, төрийн эрх барих дээд эрх мэдлийг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай парламент ёс хэвшин тогтсон. Байнгын үйл ажиллагаатай хууль тогтоох байгууллагатай болсон нь улс төрийн түүхэн өөрчлөлт, хөгжлийг харуулна. Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.¹²

Диахроник харьцуулалт хийх аргаар улс төрийн тогтолцоо, нам, засгийн газар, парламент, шүүх, улс төрийн оролцоо, сонгууль, төрийн удирдлага, бодлогын өөрчлөлт, улс орны хөгжлийг цаг хугацааны голдиролд судална. Нөгөөтэйгүүр энэ арга нь дам хэлбэрээр тодорхой нэг улсад өрнөж байгаа улс төрийн түүхэн өөрчлөлтийг шинжлэхэд илүү тохиромжтой байдаг. Түүнчлэн хэд хэдэн улсыг харьцуулахдаа тэдгээр улсуудын парламент, засгийн газар, улс төрийн намуудын үүсэл, хөгжил, төлөвшлийг харьцуулан судлах зорилгоор түүнд тохирсон нарийн нийлмэл, хашир арга болгон хэрэглэх нь бий.

Дээрх аргатай ижил түвшинд хэрэглэдэг арга бол цаг хугацааны өөрчлөлтийг үл харгалзах буюу тодорхой тогтсон цаг хугацаанд ижил төстэй институт, үйл явцыг харьцуулах арга юм. Үүнийг шууд харьцуулах буюу синхроник (synchronic) харьцуулалт гэж нэрлэнэ.¹³ Синхроник харьцуулалтаар нэг төрлийн институтийн ялгаатай хийгээд ижил төстэй байдлыг олж тогтооно. Цаг хугацааны хүчин зүйлээс хамааран тухайн институт, зан үйл, хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг үл харгалзан түүнтэй ижил институт, юмс үзэгдэлтэй харьцуулах нь энэ аргын онцлог юм. Синхроник харьцуулалт хийснээр нэг төрлийн улс төрийн институт, зан үйл өөр орон зайд (улс орон, дэглэмд) хэрхэн бүрэлдэж, төлөвшиж, ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж болдог. Улс төрийн сонгууль ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улсуудад хэрхэн зохион байгуулагдаж байгааг тодорхой улсуудаар төлөөлүүлэн харьцуулж болох юм. Энд орон зайн өөрчлөлт гол биш тухайн цаг үед улс төрийн сонгууль (ерөнхийлөгч, парламент, орон нутгийн өөрөө удирдах байгууллага)-ийн сонгуулийг хэрхэн зохион байгуулсан,

¹¹ Andrew Heywood. Key Concepts in Politics. Palgrave 2000. p-123.

¹² Монгол Улсын Үндсэн Хуулийн 3-р бүлэг 20-дугаар зүйл.

¹³ Longman. Dictionary of Contemporary English. 1990. x-1072.

сонгуулиар улс төрийн хүчнүүдэд тэгш оролцоо, иргэдийн чөлөөт, шууд сонгох эрх хангагдсан эсэхэд үнэлгээ хийлгэж болно. Харьцуулсан судалгааны энэ аргын давуу тал нь байгаа зүйлийг байгаагаар нь тогтсон цаг хугацаанд харьцуулахад оршино. Иймд энэ төрлийн судалгааны материал нь цаашид диахроник харьцуулалт хийхэд ашиглах баримт бичиг болох нь бий.¹⁴

Дээрх хоёр судалгааны аргыг үр дүнтэй зохион байгуулахад мэдээлэл бүрдүүлэх баримт бичиг судлалын аргаар туслуулна. Диахроник, синхроник харьцуулалтын аль алинд нь судалж байгаа юмс, үзэгдлийн тухай баримт бичиг судлах, түүнтэй уялдан урьд өмнө нь бичиж тэмдэглэсэн зүйл, мэдлэг, онолыг ашиглах шаардлагатай болдог. Нэн ялангуяа диахроник харьцуулалтын суурь мэдээлэл нь түүхэн баримт, тэр цаг үед гарсан, бичигдсэн ном, товхимол байдаг. Судлаач харьцуулалт хийх мэдээллийг системтэй цуглуулж, ангилах, нэгтгэх арга зүй баримтална (архивын бүртгэл, сурвалжлага, алба ёсны статистик, түүх, судалгаа гэх мэт).¹⁵ Баримт бичиг судлалын аргыг тулгуур болгож байгаа үндсэн шалтгаан нь улс төрийн институт, болж байгаа хийгээд болоод өнгөрсөн үйл явцад туршилт хийж болдоггүйтэй холбоотой юм. Гэтэл байгалийн шинжлэх ухаанд судалж байгаа юмс, үзэгдлээ бодит байдалтай адилтгаж болох зохиомол (хиймэл лаборатори) орчинд туршин, шинжилж болдог

Нийгмийн судалгаанд түгээмэл хэрэглэгддэг тоон болон чанарын судалгааны аргыг харьцуулсан судалгаанд мөн адил хэрэглэдэг. Тоон болон чанарын судалгаа нь арга зүйн хувьд зарчмын ялгаатай. Тоон судалгаанд судалгааны объектыг өөр хооронд нь ялгах тоон өөрчлөлтийг үндэслэл болгодог бол чанарын судалгаанд тэдгээр объектуудын төрөл зүйлийн ялгааг олж тогтооно. Сонгогчдын ирц, улс төрийн жагсаал цуглаан, гэмт хэргийн гаралт гэх мэт тоон утгаар илэрхийлж болох үзэгдэл, үйл явцыг тоон шинж чанараар нь илэрхийлэх оролдлого нь тоон судалгааны үндэслэл болно. Ерөнхийдөө тухайн асуудалд энгийн хариулт өгч болох эсэх нь тоон судалгааны аргыг тодорхойлдог. Тоон судалгааг практикт түгээмэл хэрэглэдгийн зэрэгцээ олон тооны улсыг харьцуулан судлахад ач холбогдолтэй байдаг. Олон тооны улсыг харьцуулахад эн түрүүн тухайн улсуудтай холбоотой анхдагч тоо баримт, суурь үзүүлэлтийг харьцуулснаар улс төрийн институт, улс төрийн оролцооны талаар анхдагч төсөөлөл, ойлголттой бодог байна.

Чанарын судалгаа нь судлагдахууны шинж чанар, байр байдал, хандлага, өөрчлөлтийг нарийвчлан судалж, түүнд дүн шинжилгээ хийхэд тохиромжтой аргачлал юм. Чанарын судалгаа цөөн тооны улсыг харьцуулан судлахад тохиромжтой байдаг

¹⁴ Homewood III. The Theory and Method of Political Science. Dorsey Press 1965. p-199.

¹⁵ Баримт бичиг судлалын арга нь нийгмийн шинжлэх ухаан түгээмэл хэрэглэгддэг аргын нэг болно. Баримт бичгийг эх сурвалжаар нь анхдагч хоёрдагч, хэнд хамаарах байдлаар нь хувийн болон албан, төрөл хэлбэрээр нь онол, практикын, судалгааны, статистик гэх мэтчилэн ангилдаг.

бөгөөд олон тооны улсыг харьцуулахад судалгааны объектийн хэмжээнээс хамааран энэ аргыг хэрэглэхэд зарим талаар хүндрэлтэй байдаг. Иймд олон тооны улсыг харьцуулан судлахад энэ аргыг бусад аргатай хослуулан хэрэглэх нь зүйтэй гэж судлаачид үздэг байна.¹⁶ Харьцуулсан судалгаанд чанарын судалгаа хийх дараах гурван арга бий. Үүнд: түүхчилсэн дүн шинжилгээ (macro historical analyze), нарийвчилсан сурвалжлага (in-depth interview), дотроос нь ажиглах (participant observation)-ыг багтаана. Түүхчилсэн дүн шинжилгээ нь диахроник аргатай ижил төстэй байж болох хэдий ч энэ нь мэдээлэл цуглуулах арга төдийгүй тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлал юм. Харин диахроник арга нь чанарын болон тоон судалгааны аргуудыг хэрэглэн тодорхой судлагдахууны түүхэн өөрчлөлт, хөгжлийг тодорхойлох аргачлал юм. Иймд диахроник арга нь түүхчилсэн аргаас илүү өргөн цар хүрээтэй судалгааны үйл явц, үр дүн юм.


Чанарын судалгааны нарийвчилсан сурвалжлага, дотроос нь ажиглах арга нь л улс төрийн үйл явц, үнэт зүйлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг нарийвчлан тогтоож, тэдгээрт гүн гүнзгий дүн шинжилгээ хийхэд чиглэгддэг. Чанарын судалгааны тулгуур зарчим нь оролцоо (intervention) байдаг бол тоон судалгаанд судлаач энэ үйлдлээс аль болох зайлсхийх учиртай. Өөрөөр хэлбэл тоон судалгааны арга нь судлаачаас судалгааны объекттэй харьцах, түүнд нөлөөлөх явдлыг хамгийн бага түвшинд барьж, үүний эсрэгээр баттай эх сурвалжаас бүрдүүлсэн статистик тоо баримт хэрэглэхийг тулгуур зарчим гэж үздэг.

Харьцуулсан улс төр судалд дээрх хоёр аргыг мэдээллийн үнэн баттай байдлыг шалгах, нотлох зорилгоор хослуулан хэрэглэнэ. Тухайлбал, чанарын судалгааны асуулгын аргын нэг төрөл болох зорилтот бүлгийн ярилцлагаар цуглуулсан мэдээллийг ангилж бүлэглэн тоон судалгаа явуулах асуулга боловсруулахад хэрэглэж болно. Ингэснээр тоон судалгаагаар олж авахыг эрмэлзэж байгаа мэдээллийг системчлэн бүлэглэх боломжтой юм.

Харьцуулсан судалгаа нь төрөл бүрийн судлагдахуун, үзэгдэл, үйл явцыг илрүүлэх зорилго агуулдаг. Судлаач улс төрийн сонгуульд ялалт байгуулсан улс төрийн хүчний мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийн онцлогийг бусад намтай харьцуулан дүн шинжилгээ хийж болохын зэрэгцээ, хоёр болон түүнээс дээш тооны улсад улс төрийн тодорхой институтийн үйл ажиллагаа хэрхэн бүрдэж, үйлчилж байгаад дүн шинжилгээ хийж болно. Үүнтэй уялдан харьцуулсан судалгааны объектын тоо, түвшинг ангилсан арга зүй урган гарчээ. Нөгөөтэйгүүр энэ нь харьцуулсан улс төр судлалд дараах гурван үндсэн аргын аль нь судлагдахуун, судалгааны объектийг судлахад суурь үүрэгтэй болохыг тогтоох шалгуур болно. Судлагдахууны онцлогоос хамааран судалгаа нь дараах төрөл хэлбэртэй байна. Үүнд: 1) дан ганц улсын судалгаа, 2) цөөн тооны улсын судалгаа, 3) олон тооны улсын судалгаа. /зураг 3-ийг үзнэ үү/

¹⁶ Todd Landman. Issues and Methods in Comparative Politics in Introduction. Routledge 2002. p-4.

Бүдүүвч 3



Эх сурвалж: Todd Landman. Issues and Methods in Comparative Politics in Introduction. Routledge 2002. p-25. based on Santori (1970) and Mair (1996)

Судлагдахууны төрөл, зүйл нь түүний түвшинг давхар тодорхойлно. Судлагдахуун нь олон талт, нарийн нийлмэл үйл явц, институц, харилцааг хамарч байвал ахисан түвшний судалгаа явуулна. Судлагдахууны буюу хийсвэрлэлийн түвшнээс хамааран 1) доод, 2) дунд, 3) ахисан түвшний судалгаа гэж гурав бүлэглэнэ. Олон тооны улсыг харьцуулах судалгаа нь ахисан түвшний судалгаа юм. Гэхдээ дан ганц улсын судалгаанд янз бүрийн элемент, хүчин зүйлийг харьцуулж ахисан түвшний судалгаа хийж болно. Гагцхүү дийлэнх тохиолдолд харьцуулсан судалгаанд харьцуулж байгаа улсын тооноос шалтгаалан судалгааны хийсвэрлэлийн түвшинг тодорхойлох нийтлэг хамаарлын арга зүй үйлчилдэг.

Олон тооны улс харьцуулах судалгаа нь (том n)-ийн, цөөн тооны улс харьцуулах нь (жижиг n)-ийн судалгаа гэж нэрлэгддэг. Энд байгаа (n) хувьсагч нь судлаачийн харьцуулж байгаа улс, объектийн тоог илэрхийлнэ. N хувьсагчийн тоо нэмэгдэхийн хэрээр хийсвэрлэлийн түвшин нэмэгдэнэ. Үүнийг нэг талаар судалгааны түвшин ахидаг гэж ойлгож болох боловч дан ганц улсын судалгаанд ч мөн адил хувьсагчдын тоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх замаар судалгааны түвшинг ахиулж болно. Олон тооны улсын судалгаанд ердөө ганц хувьсагчийн хүрээнд буюу сүүлийн сонгуульд сонгогчдын

санал өгсөн байдалд тоон харьцуулалт хийх замаар уг судалгааны түвшинг бууруулах боломж бий.¹⁷

Жон Стюарт Милл 1843 онд туурвисан “Логик систем” бүтээлдээ улс төрийн системд харьцуулалт хийх сонгодог арга санал болгосон. Энэ аргыг цөөн тооны улсыг харьцуулан судлахад түлхүү хэрэглэдэг байна. Үүнд: “маш төстэй системийн төсөөлөл” most similar system design, “маш ялгаатай системийн төсөөлөл” most different system design болно. Маш төстэй системийг төсөөлөх арга нь өөр хоорондоо ерөнхийдөө ижил төстэй (зарим тухайлсан шинж чанарыг үл харгалзан) системийг харьцуулдаг. Ж.Миллийн санал болгосон маш төстэй системийг төсөөлөх аргаар ижил төстэй систем, улсуудад илэрч болох ялгаатай шинж чанар, үнэт зүйл, институцийг олж тогтоон, дүн шинжилгээ хийнэ. Үүний эсрэгээр ялгаатай системийг төсөөлөх арга нь олон талаар бие биеэсээ ялгаатай системийг харьцуулан, байж болох ижил төстэй шинэ чанарыг олж тогтоох явдал юм. Энэ хоёр системийн харьцуулалтад гарцаагүй чанарын судалгааны аргыг суурь болгоно. Харьцуулалт хэрхэн хийхийг дараах байдлаар тайлбарлаж болно.

Хүснэгт 3

Системийн харьцуулалт хийх арга

	<i>Төстэй системийн төсөөлөл</i>			<i>Ялгаатай системийн төсөөлөл</i>		
	<i>ялгаа</i>			<i>зөвшилцөх</i>		
	Улс 1	Улс 2	Улс ф	Улс 1	Улс 2	Улс ф
Шинж чанар	a	a	a	a	D	g
	b	b	b	b	F	h
	c	c	c	c	E	i
Нөлөөлөх хүчин зүйл	x	x	x биш	x	X	x
Тайлбарлах үр дүн	y	y	y биш	y	Y	y

¹⁷ Lijphart, A. (1971) Comparative Politics and Comparative Mehtod. The American Political Scinece Review, 65 (3):689

Эх сурвалж: http://en.wikipedia.org/wiki/Comparative_politics

Зүүн талын гурван баганад байгаа төстэй системийг төсөөлөх аргаар харьцуулах улсуудын үндсэн шинж чанар нь а, b, с гэх мэтчилэн ижил байна. Харин зарим нөлөөлөх хүчин зүйл нь ижил байх бөгөөд тайлбарлах үр дүн ялгаатай. Өөрөөр хэлбэл судлаач эдгээр улсуудыг харьцуулан ялгаатай шинж чанарын олж тогтооно. Баруун талын гурван баганад байгаа улсын хувьд ялгаатай системийн төсөөлөл хийгдэх бөгөөд харьцуулж байгаа улсуудын шинж чанар нь өөр хоорондоо эрс ялгаатай байх юм. Гагцхүү нөлөөлөх хүчин зүйл болон тайлбарлах үр дүн нь ижил төстэй байна. Зорилго нь өөр хоорондоо ялгаатай улсуудыг харьцуулан ижил төстэй шинж чанарын олж тогтоох.

Түүх, шашин, хэл, соёл, улс төрийн дэглэм, эдийн засгийн харилцаа нь ижил улсуудын хувьд төстэй системийн төсөөллийн арга хэрэглэхэд үр дүнтэй байдаг. Тодорхой үйл явц, үзэгдэл нь тухайн тохиолдолд үр дүн болж байвал түүний шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор ялгаатай системийг төсөөлөх аргыг хэрэглэх нь онол, практикийн хувьд ач холбогдолтой байдаг. Судлаач Е.Вольф 1968 онд энэ аргаар Орос, Хятад, Мексик, Хойд Вьетнам, Алжир, Куба-д өрнөсөн хувьсгалд тариачдын оролцоо, хамтын хүчин чармайлт онцгой нөлөөтэй байсан шалтгаан нөхцөлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийхэд энэ аргыг хэрэглэсэн байна.¹⁸

Энэ бүгдээс эцэст нь дүгнэхэд харьцуулсан судалгаа нь нэгэнтээ шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг, нэн ялангуяа нийгмийн шинжлэх ухаан түүний салбар судлагдахуун болох улс төр судлалд практик ач холбогдолтой арга болжээ. Судлаач энгийн харьцуулалтын зэрэгцээ нарийн нийлмэл харьцуулалт хийх арга замаар юмс үзэгдлийн зүй тогтол, хувьсал өөрчлөлт, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, онцлох шинж чанарыг нээн илрүүлж, улмаар түүгээр дамжуулан асуудлын гол зангилааг олж тогтоох боломжтой. Түүнчлэн харьцуулсан судалгааны түүхэн болон практик туршлага нь аливаа асуудлыг шийдвэрлэх арга зам, гогцоог олж нээх үндэс болох нь бий. Энд тайлбарласан харьцуулсан судалгааны арга зүй, аргууд нь улс төрийн шинжлэх ухааны онол, практикт хүлээн зөвшөөрөгдсөн, түгээмэл дэлгэрсэн хандлагууд болох тул улс төр судлалтай нэгэн дээвэрт багтдаг нийгмийн шинжлэх ухааны бусад салбар судлагдахуунд ч мөн адил нэвтрүүлж, туршиж, хэрэглэж болох нь эргэлзээгүй. Иймд харьцуулсан судалгааны эдгээр аргыг тухайн судлагдахууны онцлог, хүрэх гэж буй зорилго, хүлээгдэж байгаа үр дүнтэй уялдуулан хэрэглэх боломжтой.

¹⁸ Wolf, E (1969) Peasant Wars of the Twentieth Century, New York: Harper Torchbooks.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛТ ТӨРИЙН СУДАЛГААНЫ ОНОЛ АРГАЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Г.Түмэннаст

МУИС, НШУС, Социологи, Нийгмийн ажлын тэнхим

Түлхүүр ойлголтууд

Нийгмийн хамгаалалт төр (Welfare state), нийгмийн хамгаалал (Social security), нийгмийн хамгааллын бодлого (Social welfare policy), нийгмийн хамгаалал төрийн уг сурвалж (Social origin of welfare state), нийгмийн хамгааллын шалгуур үзүүлэлтүүд (Social welfare indicators).

Товч агуулга

Энэхүү өгүүлэлд орчин үеийн төрийн үндсэн хэв маяг, дүр төрх болсон нийгмийн хамгаалалт төрийн мөн чанарын тухай, өөрөөр хэлбэл орчин үеийн нийгмийн системийн салшгүй нэгэн бүрэлдэхүүн, төрийн зайлшгүй гүйцэтгэх чиг үүрэг болсон нийгмийн хамгааллын талаар хийгээд нийгмийн хамгаалалт төрийн үүсэл, сурвалжийн талаар, түүнчлэн энэхүү олон талт институцчилэгдсэн арга хэмжээнүүд нь төрийн үйл ажиллагааны системд ямар байр суурь эзлэх талаар авч үзэх болно.

Ойлголтыг сурвалжлахуй

Судлаачдын үзсэнчлэн нийгмийн хамгаалалт төр¹⁹ нь бодит байдал болохын хувьд XIX зууны сүүлийн хагасаас баруун европт бүрэлдэн тогтсон бол, харин ойлголтын хувьд 1970-1980-аад оны үеэс эхлээд социологи, дараа нь улс төрийн шинжлэх ухаан,

¹⁹Англи хэлнээ *welfare state* харин герман хэлнээ *wohlfahrtstaat*, харин орос хэлнээ “Государство всеобщего благоденствия” хэмээх ойлголтоор илэрхийлдэг. Монгол хэлнээ үүнийг “Халамжит төр”, “Буянлаг төр”, “Хангалуун төр” гэх мэтчилэн орчуулах нь нийтлэг ажиглагддаг. Нийгмийн хамгааллын ул үндэстэй судалгааны ажлуудыг харж байхад энэ орчуулгууд нь түүнийг бүрэн илэрхийлэх боломжгүй бөгөөд нийтлэл, шинжлэх ухааны бус хэлэлцүүлгийн үеийн орчуулгууд болох нь харагдаж байна. Тиймээс үүнийг “Нийгмийн хамгаалалт төр” гэсэн ойлголтруу орчуулах нь зүйтэй мэт санагдаж байна. Хамгийн товчхоноор үндэслэвэл welfare хэмээх ойлголт нь нийгмийн хамгааллын бүхий л арга хэмжээнүүдийг хамарсан, тухайлбал зөвхөн халамжийг бус даатгал, хангамж, тусламжийг бүхэлд нь багтааж, тухайн улс оронд хүмүүсийн нийгмийн эмзэг байдал, эрсдэлд хариу үзүүлэх цогц арга хэмжээний системийг багтаан илэрхийлж байгаа юм. Үүнтэй зэрэгцэн утга агуулгын хувьд ойролцоо “Социаль төр” гэсэн ойлголт байх ба үүнийг нийгмийн хамгаалалт төр хэмээх эл ойлголттой шууд адилтгахад зарим талаар төвөгтэй. Уг өгүүллийг тэрлэгч дараагийн удаа тэдгээрийн хоорондын харьцааны талаар хөндөхийг хүсч байгаа болно.

хожмоо нийгмийн бодлого, хамгааллын салбарт гэх мэтээр тус тус нийгмийн шинжлэх ухааны эргэлтэнд орж, нийгмийн систем дэх хамгааллын үйл ажиллагаа институциональ түвшинд судлагдаж ирсэн байна. (Кауфманн. 2001:17) Орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны түлхүүр ойлголтын хувьд түүний агуулгыг сурвалжлаваас *Оксфордын толинд* “нийгмийн хамгаалалт төр нь тэтгэвэр, хамгааллын тэтгэмж, эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ болон бусад арга хэмжээг явуулах замаар аль нэг улсын засгийн газрын зүгээс улсынхаа хүн амын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах хариуцлагыг өөртөө хүлээж байгаа тогтолцоог хэлнэ” (Оксфордын улс төрийн толь. 1995:526) гэсэн бол *европын холбооны нийгмийн хамгааллын толь бичигт* “нийгмийн хамгаалалт төр нь тэтгэвэр, эмнэлгийн үйлчилгээ, өвчний болон ажилгүйдлийн тэтгэмж болон бусад арга хэмжээгээр өөрийн иргэдийн эрүүл мэнд хийгээд сайн сайхан байдлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бүрэлдэж буй олон талт, нарийн нийлмэл тогтолцоо мөн” хэмээжээ. (Нийгмийн хамгааллын нэр томъёоны тайлбар толь. 1996:430) Эндээс үзэхэд нийгмийн хамгаалалт төр хэмээх ойлголт нь юутай ч, **нэгт** төрийн зүгээс хүн амынхаа өмнө өөртөө хүлээж байгаа үүрэг хариуцлагыг, **хоёрт** энэхүү үүрэг, хариуцлага нь хүн амын нийгэм, эдийн засгийн баталгаат байдлыг хангахын тулд буй болдог, **гуравт** ийнхүү үүрэг, хариуцлагаа тодорхой бодлогын арга хэмжээнүүдийн тусламжтайгаар хүлээж байгаа, **дөрөвт** энэ нь явсаар нийгэмд олон тал бүхий нарийн нийлмэл системийг бий болгодог гэсэн шинж тэмдгүүдийг агуулж байна.

Гэвч энэхүү ойлголт нь маргаангүй нэг мөр зөвшилцсөн агуулгатай байж чаддаггүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энд германы судлаач Шмидийн хэлснээс ишлэвэл “нийгмийн хамгаалалт төр хэмээх ойлголт нь утгазүйн хувьд улс төр, үзэл суртлын агуулгатай, харин түүнийг шинжлэх ухааны хэрэглээнд хөтлөх нь ярвигтай асуудал болж байна. Шинжлэх ухааны хэрэглээнд энэхүү ойлголт нь ихээхэн хазайлттай утгыг илтгэж байх нь ч бий. Тухайлбал Германд ажиллах хүчний уналт, эрсдлийн үед тэдний орлогыг баталгаажуулах төрийн үүргийг түлхүү ойлгож байхад, англи саксоны орнууд дах хэлэлцүүлэг нь хамгаалалт төрийн арга хэмжээнд найдвартай боловсролын тогтолцоог илүүд тооцож байх жишээтэй”. (Ж. Шмид. 2000:33-34) Улс орнуудын соёл, уламжлал, ноёлох суртал, шашны итгэл үнэмшил, эдийн засгийн хөгжлийн хандлага зэргээс хамаараад нийгмийн хамгаалалт төр нь янз бүрийн агуулгаар хөгжиж ирснийг бодолцох ёстой юм. Нийгмийн хамгаалалт төрийн судалгааны загалмайлсан эцэг гэгдэх Э.Андерсен дэлхийн хөгжилтэй улс орнуудад нийгмийн хамгаалалт төрийн гурван үндсэн хэв маяг оршин байгааг “Хамгаалалт капитализмын гурван ертөнц” хэмээх алдарт бүтээлдээ судлан дэвшүүлсэн ажээ. Түүнийхээр капиталист ертөнцийн хамгаалалт төрийн гурван том тэнхлэг нь *умардын буюу скандинавын, эх газрын европын, англи саксоны* загварууд мөн бөгөөд тэдгээр нийгмийн хамгаалалт төрийн хэв маягууд нь тодорхой шалгууруудын дагуу өөр хоорондоо хүчтэй ялгардаг байна. (К.Улрих. 2005:46)

Нийгмийн хамгаалалт төрийн үүслийг мөшгөх нь

Нийгмийн хамгаалалт төрийн үүсэл, хөгжил нь нийгмийн салбарын судлаачдын хувьд ихээхэн сонирхолтой асуудал мөн. Барууны судлаачдын дунд нийгмийн хамгааллын түүхийг судалсан ажил цөөнгүй бий. Тэдгээрээс харж байхад нийгмийн хамгаалалт төрийн үүсэлд харгалзуулж буй түүхэн цаг хугацааг үндсэндээ хоёр чиглэлд хувааж үзэж болно. **Эхнийх нь** ядуурлын асуудал хот, улсын анхаарлын төвд орж ирсэн тэр үе буюу үүнийг дундад зууны хожуу үеэс сэргэн мандлын эхэн үед хамааруулж байна. Энэ үеэс ядуурлын асуудал сүм хийдийн асуудал байснаа хотын албадын хариуцах ажил болж ирсэн хэмээн үздэг. Эл үед европт хотжилтын үндсүүд тавигдаж, уламжлалт хөдөө аж ахуйн феодалын тогтоц унаж эхэлсэн бөгөөд томоохон хот, хот улсуудад хүн амын төвлөрөл явагдсан байна. Ингэхдээ удаа дараалсан ган гачиг, үүнээс үүдсэн ургацгүй байдал, хижиг тахлын дэгдэлт, өлсгөлөн гуйланчлал хотын улсын амьдралд ихээхэн хүндрэл бэрхшээлийг үүсгэж, нийгмийн дэг ёсонд нөлөөлөх хүртлээ өсөн томорсон байна. Тухайлбал Польшийн судлаач Геремекийн бичсб8нээр Европын түүхэнд XVI зууны дунд үеэс сүүл үе хүртэл хэд хэдэн мөчлөгтэй ургацгүй байдал тохиож, олон зуун хүнийг хамарсан хижиг тахал өвчин дэгдэж, хүн амын нас баралтыг жам ёсны байдлаас хэд дахин илүү хэмжээнд аваачжээ. (Б.Геремек. 1995:159) Энэ үед эх газрын Европын орнууд болон Англи улсад ядуурлын эсрэг нийгмийн хамгааллын өнгө аяс бүхий хууль тогтоол, зарлигууд гарч эхэлсэн байдаг. XVI зууны дэнд үеэс эхлэн гарсан эдгээр арга хэмжээнүүд нь нэг талаас нийгмийн дэг ёсыг хадгалах, ядуурал, гуйланчлалаас үүдэлтэй эмх замбараагүй байдлыг намжаах, ядуус, хэрэн хэсүүчлэгсэд, гуйланчлалын эсрэг албадан хөдөлмөрлүүлэх, шийтгэх буюу репресионист агуулга бүхий, нөгөө талаас ядуу, үгээгүй иргэдийн нийгмийн наад захын амин зуулгыг хангах, эмчилгээ сувилгаанд хамруулах зорилготой байсан юм. (Г.Түмэннаст. 2009:256) Ядуурлын эсрэг, ядуусын амьдралын наад захын баталгааг хангах эдгээр арга хэмжээ цаашид хөгжсөөр сэргэн мандлын шувтаргад оргил үедээ хүрсэн нь Британий “Элизабетийн ядуусын тухай хууль” байлаа. Либертаризмын орчин үеийн төлөөлөгч Д.Боаз ядуурлын талаарх иргэний нийгмийн үүрэг, хариуцлагыг XIII зууны үеэс төр өөртөө булааж авсан гэж бичсэн байдаг нь сонирхол татдаг. Ядуурлын асуудлаар төрийн бодлого, зохицуулалт явуулж эхэлсэн баримтууд XVI зуунаас европын хот улсуудад холбогдож байгаа бол харин Монголын эзэнт гүрний үеэс төрийн хамгаалал, халамжийн бодлого үүссэн нь түүхэн баримт буй. Энэ талаар тухайлбал дэлхийн хамгийн анхны нийгмийн хамгаалалт төр бол Монголын их гүрэнд хамаарах талаарх судлаачдын хийсэн дүгнэлт бас бий. Тухайлбал Б.Баабар дэлхийн соёлын хөгжлийн түүхэнд Монголчуудын оруулсан есөн хувь нэмрийн нэг нь нийгмийн хамгааллын системийн үүслийг тавьсан

хэмээгээд үүндээ Өгөөдэй хааны ядуусыг тэтгэх сангийн түүхэн баримтыг тавьсан байна. (Ардын эрх сонин. 2006: 07 сар. № 238)

Нийгмийн хамгаалалт төрийн үүслийн талаарх **удаах тайлбарлал нь** аж үйлдвэрийн хувьсгалын өрнөл үед буюу XIX зууны сүүл үед хамаатуулж байгаагаар илэрнэ. Нийгмийн хамгаалалт төрийг жинхэнэ утгаараа энэ үед үүссэн гэж үзэж буйг судлаачдын үзэл бодолд тулгуурлан дараах байдлаар үндэслэж болох юм. Тэдгээр нь *нэгдүгээрт* төрийн нийгмийн хамгааллын бодлого буюу хүн амын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ нь хот, нутаг дэвсгэрийн нийтлэгээс халин гарсан, улс гүрний хэмжээнд зохион байгуулагдсан, *хоёрдугаарт* энэ үеэс төр өөрөө нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд бодит утгаараа нэгэн субъект болж оролцох болсон явдал юм. Учир нь нийгмийн хамгааллын үндсэн арга хэмжээ болсон нийгмийн даатгал (*төрийн нийгмийн даатгал*) энэ цаг үед үүссэн бөгөөд судлаачын үздэгээр түүнээс өмнө үүссэн нийгмийн хамгааллын басхүү нэгэн үндсэн арга хэмжээ болох халамжийн үйл ажиллагаа нь үндэсний төрийн бодлого, үйл ажиллагаа гэхээсээ хотын, орон нутгийн хүй элгэнд хамаатай зүйл буюу өөрөөр хэлбэл даатгал нь макро түвшний, харин халамж нь мезо түвшинд харгалзах зүйлүүд ажээ.

Юутай ч нийгмийн тусламжийн тогтолцоо нь хүний хамтын амьдралын бүхий л үеийн туршид ямар нэг хэмжээгээр, аль нэг түвшинд хамт байж ирсэн үзэгдэл авч түүхийн тодорхой үед, тодорхой нөхцөлд бичил хүрээнээс үлэмж хэмжээнд, тухайлбал хүмүүс хоорондын ёс суртахуун болон сүсэг бишрэлд дулдуйдсан өдөр тутмын харилцаанаас орон нутаг, цаашилбал улс орны түвшинд төрийн эрх мэдэлд тулгуурлан зохион байгуулагдах зайлшгүй шаардлага буй болжээ. Өөрөөр хэлбэл хөгжлийн явцад тусламж нь институцчилэгдсэнээр мезо болон макро түвшний зүйл болж хувирсан гэж үзэж болох бөгөөд нийгмийн бодлого, хамгаалал нь нийгмийн системийн түвшин дэх тусламжийн хэлбэрүүд гэж хэлж болно. (Луис Лови. 1986:23) Нийгмийн хамгаалалт төрийн уг сурвалж Монголын эзэнт гүрэнд холбогдох байдлаар цаад тал нь 700 орчим жилийн, харин европын хот улсуудад харгалзахдаа 400 гаруй жилийн тэртээнээс үүссэн бол Пруссийн нийгмийн хамгаалалд хамаарахын хувьд 140 орчим жилийн тэртээд орчин үеийн утгаараа бүрэлдэн тогтжээ.

Өнөөгийн судлаачдын бүтээлд нийгмийн хамгаалалт төрийн түүхэнд ул мөрөө үлдээсэн хоёр том эргэлтийг *Бисмаркийн болон Бэвэриджийн загварууд (Bismark and Beveridge Models of welfare state)* бүрэлдэн бий болсон явдал хэмээн үздэг. Эл хоёр нийгмийн хамгаалалт төрийн туршлага нь дэлхийн улс орнуудын социалист болон капиталист тогтолцооноос үл хамаараад үлэмж тархсан төдийгүй ерөөс нийгмийн хамгааллын тогтолцооны үлгэр болж чадсан байдаг. (Г.Түмэннаст. УБ:2009) Тухайлбал нийгмийн хамгаалалт төрийн түүхэнд XIX зууны хоёрдугаар хагасаас XX зууны эхний хагас хүртлэх хугацаанд Бисмаркийн засаглалын буюу Пруссийн Германы нийгмийн

хамгааллын загвар европ төдийгүй, бусад тивийн улс орнуудад үлэмж тархсан бол, харин дэлхийн II дайны дараа бүрэлдэн тогтсон, Бэвэридж тэргүүтэй Британий Хөдөлмөрийн намын засгийн газрын хэрэгжүүлсэн социаль төлөвлөгөө нь дорхноо дэлхийн улс орнуудад түгэн тархсан байна. Энэхүү хоёр загвар нь нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэхдээ харилцан адилгүй зарчим, механизмуудыг бүтээх бөгөөд энэ талаар судлаачдын зурагласан байдлыг харж болох юм. (Д.Доэринг. 2004: 38)

Нийгмийн хамгааллын түүхэн загварууд

Зорилтот хэмжээ	арга	Бисмаркийн загвар оноос (1880)	Бэвэриджийн загвар оноос (1945)
Ядуурлыг бууруулах	Гол арга хэрэгсэл	Төрийн бус	Төрийн (наад захын баталгааг хангахад баримжаалсан нийгмийн даатгал)
	Туслах хэрэгсэл арга	Төрийн (хэрэгцээнд баримжаалсан)	Төрийн (хэрэгцээнд баримжаалсан)
Амьжиргааны баталгааг хангах	Гол арга хэрэгсэл	Төрийн (орлогод баримжаалсан нийгмийн даатгал)	Төрийн бус (хувийн хэвшлийн эрмэлзэл)
	Туслах хэрэгсэл арга	Төрийн бус	Төрийн бус (хамгааллын нөхөн гүйцээх бие даасан тогтолцоонд тооцогдохгүй)

Ерөнхийд нь нийгмийн хамгаалалт төр үүсч, хөгжихөд нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйлсийг тэмдэглэж болох юм. Үүнд юуны өмнө *шашны итгэл үнэмшлийн хүчин зүйлийг* хэлж болох агаад нийгмийн хамгаалалт төрийн үзэл санааны уг сурвалж нь шашнуудын итгэл, үнэмшилтэй, тэр дундаа барууны ертөнцийн оюун санааны эх сурвалж болсон Христийн итгэл үнэмшилтэй олон сэжмээр холбогддог. Европын нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь шашны энэрэл, нигүүлсэл, Христийн шашны зүгээс ядууст хандах хандлагатай хүйн холбоотой. (Г.Түмэннаст. 2009:17) Хоёдугаарт *байгалийн болон биологийн хүчин зүйлийн* нөлөөг дурдаж болох бөгөөд үүнд ургацгүй байдал, хүн амын өвчлөлт, түүний тархалт зэргийг хамруулж үзвэл зохино. Хот улсын зүгээс ядуусыг сувилах эмнэлэг, сувиллын газруудыг ажиллуулахад анхаарч эхэлсэн нь энэ үеийн нийгмийн халамжийн нэг үндсэн чиглэл болж байв. *Гуравдугаарт* ерөөс хот улсын зүгээс ядуурлын асуудалд анхаарлаа хандуулах түүхэн зайлшгүй нөхцөл нь *хотжилт хийгээд хотын хүн амын ядуурлын хүчин зүйл* байсан билээ. Уламжлалт аж ахуйгаас болон хөдөө аж ахуйн хамжлагын харилцаанаас хотын аж ахуйн хэв маягт шилжиж эхэлсэн тэр

цагаас л эхлэн хотын хүн амын нийгмийн асуудлаар хот, нутаг дэвсгэрийн нийтлэгийн (*parish-сүмийн зсаглалын үеэс тогтсон засаг захиргааны нэгж*) зүгээс анхаарал хандуулах шаардлагатай болжээ. Дээр дурдсанчлан хотын хүн амын гэнэтийн өсөлт нь нийгмийг эмх замбараагүй байдалд түлхэж, хотоор нэг хэрмэл иргэд, гуйлгачид, ядуус бөөгнөрч хамтын амьдралын дэг ёсыг алдагдуулахад хүргэж байжээ. Тиймээс европт хотын халамжийн албад үүсэн, ядуурлыг бууруулах, ядууст тусламж дэмжлэг үзүүлэх, нийгмийн дэг ёсыг хадгалах, иргэний бүртгэл, харъяаллыг цэгцлэх, нэг ёсондоо хотыг цэгцлэх, эмх журманд нь оруулах зорилгыг агуулсан арга хэмжээг явуулж эхэлсэн юм. (Б.Геремек. 1995:162) Европын түүхэнд XVIII зууны хоёрдугаар хагасаас Англид эхлэн өрнөж, улмаар эх газрын орнуудад өргөжин, хүчээ авсан, ерөөс хүний нийгмийн хөгжлийн түүхэнд эргэлт авч ирсэн үйл явдал бол *аж үйлдвэржилтийн хувьсгал* билээ. *Аж үйлдвэржилтийн хүчин зүйл* нь нийгмийн хамгааллын хожмын хөгжилд маш чухал нөлөө үзүүлсэн агаад аж үйлдвэржилтийн эхний үе шатан дах ажилчин ангийн өсөн тэлэлт, тэдний нийгмийн эмзэг байдал нь хүн амын олонхид чиглэсэн нийгмийн хамгааллыг сайжруулах хөдөлгөөнүүд нийгэмд өрнөхөд хүргэж, нийгмийн хамгааллын асуудлыг төрийн бодлогын зайлшгүй нэг чиглэл болгох нэг нөхцөл болж өгсөн билээ. Германы нийгмийн ажлын онолч Э.Энгелке “Ажилчин ангийн эмзэг байдал нь төрийн нийгмийн бодлого зайлшгүй төрөн гарах нэг урьдач нөхцөл болсон бөгөөд аж үйлдвэржилтийн эрин дэх тэдний эмзэг байдал нь хүнд хүчир хөдөлмөр, амь насанд хийгээд эрүүл мэндэд аюултай ажлын байр, өчүүхэн бага цалин хөлс, эмэгтэйчүүд, хүүхдийн ажил эрхлэлт, ихээхэн хэмжээний осол аваар, өвчлөл зэрэг өдөр тутмын дүр зургаар илэрч байсан юм. Бүхэлдээ ажилчид болон тэдний гэр бүлийнхэн хөдөлмөр, орон байр, амьдралын хувьд туйлын хүнд нөхцөлд байж, хүний амьдралын чанар газар сайгүй хөсөр хаягдсан байв хэмээн тодорхойлсон байдаг.” (Э.Энгелке. 1998:98) Эцэст нь *улс төр, үзэл суртлын хүчин зүйлийг* авч үзэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Зарим судлаачдын үзсэнээр түүхэн дэх хүн амын олонхийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх буюу “нийгмийн хамгаалалт төр”-ийг цогцлуулах зорилго бүхий улс төрийн зарим хөдөлгөөн нь дэлхийн II дайны дараа өрнөсөн явдлыг барууны ардчилсан ертөнцөөс дэлхийн бөмбөрцгийн нөгөө талд босч ирж буй **коммунист** дэглэмд өгсөн хариу байсан гэж үзэх нь бий. Хүн амын сайн сайхан байдлыг хангах нь коммунист бус замналаар замнасан улс оронд хамгийн төгс утгаараа боломжтой гэдгийг харуулах нь мэдээж барууны ардчилсан ертөнцийн нэг том зорилго байсан юм. Тиймээс ардчилсан ертөнц болох Англид нийгмийн хамгаалалт капитализмыг бүтээн байгуулах хөдөлгөөн үүссэн бөгөөд үүнийг “Бэвэриж төлөвлөгөө” (*Beveridge plan*) хэмээн нэрлэдэг. (В.Р.Вэндт. 1990:273-274)

Нийгмийн хамгаалалт төрийн судалгааны шалгуур үзүүлэлтүүд

Өрнөдийн судлаачдын нийгмийн хамгаалалт төрийн судалгааны бүтээлүүдээс харж байхад янз бүрийн шалгуур үзүүлэлтүүдийн тусламжтайгаар түүний мөн чанарыг тодорхойлох оролдлого хийсэн байх юм. Гэсэн хэдий ч уг асуудлыг судлан шинжлэхэд ихээхэн ач холбогдолтой гол шалгуур, үзүүлэлтүүдийн талаар авч үзэх боломжтой билээ. Ихэвчлэн нийгмийн хамгаалалт төрийн харьцуулсан шинжилгээ хийсэн бүтээлүүдээс тэдгээрийг гарган авах боломж бүрдэж байна. Тухайлбал Америк, Их Британи, Германы судлаачдын бүтээлүүдэд **нэгдүгээрт**, нийгмийн шударга ёстой холбоотой, **хоёрдугаарт**, нийгмийн хамгааллын бодлогын арга механизм, аргачлалтай холбоотой, **гурвдугаарт**, нийгмийн асуудал, түүний байр байдалтай холбоо хамааралтай гурван бүлэг шалгуур үзүүлэлтүүдийн тусламжтайгаар улс орнуудын нийгмийн хамгаалалт төрийн мөн чанар, онцлог, ялгаатай байдлыг тодорхойлж байна.

Нийгмийн шударга ёстой холбоо бүхий шалгууруудад нийгмийн шударга ёсны индекс (*Soziale Gerechtigkeit*), нийгмийн баялгийг дахин хуваарилах түвшин (*Soziale Umverteilungsgrad*), зах зээлээс хамгаалах түвшин (*dekommodifizierung*), нийгмийн багтаалт (*social inclusion*), нийгмийн эв нэгдэл (*social cohesion*), нийгмийн үйлчилгээний квот (*sozialleistungsquote*), нийгмийн хамгааллын зардал (*state expenditure on social welfare*), нийгмийн босго (*social minimum*) зэргийг дурдаж болох юм.

Дээрх шалгуур үзүүлэлтүүд нь нийгмийн хамгааллын тогтолцооны үндсэн асуудлуудын нэг болсон баялаг хуваарилалтын байдлыг бүхэлдээ илтгэн харуулах бөгөөд эргээд тухайн нийгэмд шударга ёсны суурь нөхцлийг, нийгмийн тэгш бус байдлыг багасгахад чиглэсэн баялгийн хуваарилалт ямар түвшинд байгааг тусгана. Тухайлбал нийгмийн үйлчилгээний квот (*sozialleistungsquote*) хэмээх хэмжигдэхүүн нь тухайн улс оронд нэг талаас баялаг хэрхэн хуваарилагдаж байгааг, нөгөө талаас хүн амын нийгмийн суурь баталгааг хэрхэн хангаж буйг илэрхийлдэг. *Үндэсний нийт бүтээгдэхүүнд* нийгмийн үйлчилгээнд зарцуулж байгаа мөнгөний хэмжээг харьцуулан гаргасан энэ хэмжээ тухайн улсын нийгмийн үйлчилгээний квот болдог. (Г.Баекр, Г.Нагл, Р.Биспинг. Вийсбаден. 2008:107)

Нийгмийн хамгааллын бодлогын арга механизм, аргачлалтай холбоо хамаарал бүхий шалгууруудад нийгмийн суурь баталгааг хангах арга механизм (*soziale mindetssicherung*), амьжиргааны доод түвшин (*minimum living standart*), орлого тогтоолт (*means testing*), ядуурлын шугам (*poverty line*), тусламж, дэмжлэг шаардлагатай хэсгийг баримтлах зарчим (*residualism*), зах зээлийн дараах орлого буюу засгийн газрын шилжүүлэг (*post market income & government transfer*) зэрэг зүйлийг нэрлэх боломжтой. Эдгээр нь шалгуурууд нь тухайн нийгэмд оршин буй нийгмийн хамгааллын тогтолцооны хийгээд тухайн улсын төрийн зүгээс хэрэгжүүлж байгаа нийгмийн хамгааллын бодлогын

агуулга, мөн чанарыг, цаашилбал нийгмийн хамгааллын арга механизм, технологийг тодорхойлоход ихээхэн чухал байдаг.

Нийгмийн асуудал, түүний байр байдалтай холбоотой шалгуур үзүүлэлтүүдэд ядуурлын түвшин (*poverty rate*), тархалт (*poverty spread*), ядуурлын гүнзгийрэл (*armutstiefe*), мэдрэмж (*armutssensibilitaet*), ажилгүйдлийн түвшин (*unemployment rate*), нийгмийн тэгш бус байдлын индексүүд тухайлбал Жинийн үзүүлэлт (*Gini coefficient*) зэрэг багтана. Эдгээр нь нийгмийн хамгааллын тогтолцооны мөн чанарыг шууд хөндөхгүй ч, эргээд тухайн нийгэмд нийгмийн хамгааллын ямар тогтолцоо оршин үйлчилж байгааг, түүний нийгмийн амьдралд үзүүлж буй үр нөлөөллийг тодорхойлох чухал сэжмүүд болдог.

Товч дүгнэлт

Энэхүү өгүүлэлд нийгмийн хамгаалалт төрийн мөн чанарын талаар, түүний үүсэн буй болсон социаль уг сурвалж, нийгэм, түүхийн хүчин зүйлийн талаар хөндөн тавьсан болно. Түүнчлэн орчин үеийн нийгэм дэх төрийн нэг зайлшгүй чиг үүрэг болсон хүн амын нийгмийн хамгааллын тогтолцоог судлах шалгуур үзүүлэлтүүдийн тадаар товч авч үзсэн юм. Манай улс төр судлал, социологи болон бусад шинжлэх ухаанд төдийлөн их судлагдаагүй энэ асуудлын талаар судлаач өөрийн байр суурийг илэрхийлсэн хэрэг бөгөөд цаашид шинжэх ухаан судалгааны нэр томъёо, ойлголт ухаглахууны хувьд ч хүн амын нийгмийн хамгааллыг цогцлоох төрийн бодлого, үйл ажиллагаа, институцууд, тэдгээрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө гээд олон асуудал судлагдахууны хувьд атраараа байгааг тэмдэглэх хэрэгтэй байна.

Номзүй

1. Oxford Concise Dictionary of Politics. IAIN McLean. 1995
2. Dictionary of social protection terms. English, Russian, French, German. By TACIS Program. 1996
3. Franz-Xaver Kaufmann. Die Herausforderung des Sozialstaates. Suhrkamp Verlag. Frankfurt am Main. 2001
4. Louis Lowy. Sozialarbeit/Sozialpaedagogoik als Wissenschaft im angloamerikanischen und deutschsprachigen Raum. Stand und Entwicklung. Lambertus-Verlag. Freiburg im Briesgau, 1983
5. Josef Schmid. Wohlfahrtstaaten im Vergleich. 2 Auflage.leske Budrich opladen. Stuttgart 2002
6. Gerhard Baecker, Gerhard Naegele, Reinhard Bisping und andere. Sozial Politik und Soziale Lage im Deutschland, Band 1, Grundlagen. Arbeit, Einkommen, Finanzierung. 4 Auflage. Fachverlage Gmbn, Wiesbaden. 2008
7. Carsten G. Ulrich. Soziologie des Wohlfahrtstaates. Kampus Verlag. Frankfurt in Main. 2005
8. Ernst Engelke. Theorien der Sozialen Arbeit. Lambertus Verlag, Freiburg in Briesgau. 1998
9. Wolf Rainer Wendt. Geschichte der Sozialen Arbeit. 3., Ueberarbeitete und erweiterte Auflage. Ferdinand Enke Verlag. 1990
10. Bronislaw Geremek. Geschichte der Armut. Elend und Barherzigkeit in Europa. Artemis Verlag. Muenchen. 1995
11. Dieter Doering. Sozialstaat. Frankfurt am Main. June. 2004
12. Г.Түмэннаст. Нийгмийн ажлын түүхийн удиртгал: Жам ёсны тусламжаас нийгмийн хамгаалалт ертөнц өөд. УБ. 2009 он

“ЦАГААН ТҮҮХ” ЗОХИОЛ ДАХЬ ХОЁР ЁСНЫ ҮЗЭЛ

М.Саранцэцэг

МУБИС, ТНУС-ийн философи-дидактикийн тэнхим

ХУРААНГУЙ

Аливаа улс үндэстэн туулсан замаа эргэн харж, өнгөрсөн түүхээ судлан дүгнэж түүнээс сургамж авч, тэр үндсэн дээр урагшлан хөгжиж байдаг билээ. Тийм ч учираас Монгол төр ёсны үүсч хөгжиж ирсэн түүхийг нарийвчлан судлах, үнэн зөв бодитойгоор дүгнэж цэгнэх, уламжлал болгон сэргээх ёстой зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлэх, тэдгээрийн ач холбогдолыг ухаарч ойлгох явдал юу юунаас эрхэм билээ. Монгол улсад эрх зүйт төрийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэх зорилт тавин ажиллаж байгаа өнөө үед энэ нь бүр ч чухал болж байна. Монголчууд эртнээс нааш улс орныхоо тухайн үеийн нөхцөл байдал, хүмүүсийн ахуй амьдрал, зан үйл, ухамсрын түвшин, нийгэм эдийн засаг, улс төрийн амьдрал, аж байдлыг сайтар тусгасан тэдгээртэй нийцсэн хууль цааз гаргаж хэрэгжүүлж байсан нь амьдралд “үйлчлэх” чадвартай тул тэдгээрийг нийтээрээ хүндэтгэн үздэг байжээ.

Монголын төр ёс, түүний түүхэн уламжлалыг нотлон харуулах олон арван бүтээл байдгийн дотор «Арван буянт номын цагаан түүх» онцгой чухал байр эзэлдэг юм. Тэр нь Монголыг монголоор нь байлгах, монголоор нь авч үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Монгол төр хууль цаазны алтан сан хөмрөгт дорвитой хувь нэмэр болсон сурвалж бүтээл хэмээн зүй ёсоор үнэлэгдэн, хадгалагдаж байна.

«Цагаан түүх» - төр ёсны эх сурвалж

«Цагаан түүх» нь эртнээс гадаад, дотоодын эрдэмтдийн анхаарлыг татаж иржээ. Эх сурвалжийн энэхүү мэдээнээс үндэслэвэл:

1. «Цагаан түүх»-ийг анх Хубилай цэцэн хаан [1215-1294] зохиосон гэж зарим эх сурвалжид тэмдэглэсэн байдаг.
2. Хутагтай сэцэн хунтайж «Цагаан түүх»-ийн хоёр эхийг тулган үзэж, шинжлэн бичсэн гэж байна.
3. «Цагаан түүх»-ийг Жи-Жунгийн тэргүүн /1330/ оноо зохиосон гэж мэдээллэсэн байна.

Ингэхлээр өдгөө манай үед хүрч ирсэн «Цагаан түүх»-ийн хувилбар нь даруй гурван шатыг дамжин хэлбэршсэн байна гэж дүгнэх бүрэн боломжтой юм. Эдгээр үе шат нь “... нээгдүүгээрт, 1260-1294 он буюу Юан улсын төрийн байгуулалыг хоёр ёсны зарчмын үүднээс эмхлэн байгуулж, төлөвшүүлж тогтоосон үе. Чухамхүү энэ үед төрийг хоёр ёсны зарчмын дагуу эрхлэн хөтлөх тухай Хубилай хааны олон зарлиг гарч төрийн байгууллын

үйл ажиллагаанд нэвтрэн хэрэгжиж байжээ. *Хоёрдугаарт*, 1330 он буюу Жи-Шуний анхдугаар он. Энэ онд хааны ордны бичгийн мэргэн түшмэд Юан улсын төрд нүүрлэн ирсэн хямралыг гатлан давахын үүднээс төрийг засах тухай Хубилай хааны зарлигууд олтгойдон зөрчигдөх болсон тул тэдгээрийг эмхэтгэн «Цагаан түүх» хэмээн эхлэл төгсгөл бүхий ном болгосон бололтой. *Гуравдугаарт*, 1570-аад он буюу Монгол орноо хоёр зуу шахам жил үргэлжилсэн улс төрийн бутралыг даван туулахын үүднээс «Цагаан түүх»-ийг эрэн олж, түүнийг өөрийн цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хянан боловсруулсан Хутагтай сэцэн хунтайжийн үе¹ гэсэн үе шатуудыг дамжиж өдгөө бидний гарт үлдэж ирсэн «Цагаан түүх»-ийн тэр эх хэлбэржиж тогтсон бололтой. Тэгэхдээ хэдийд хэн гэгч зохиосон бэ? гэдэг асуулт өнөө хэр нэгэн мөр болон шийдэгдээгүй байгаа бөгөөд одоогоор эрдэмтэдийн дунд уг асуудлаар гурван янзын санал байна. Үүнд:

Нэг. "... «Цагаан түүх»-ийг Хубилай хаан зохиосон"² гэж зарим эрдэмтэд үзэж байна. Тухайлбал Өвөрмонголын ардын хэвлэлийн хорооноос эмхлэн "Арван буянт цагаан номын түүх" (151 тал хуудастай) хэмээх номыг 1981 онд хэвлэжээ. Энэ номонд эрдэмтэн Ли Ү Жин Сүэ тайлбар зүүлт хийж хэвлэхдээ "... уг зохиолыг Хубилай хаан бичсэн"³ гэжээ. Энэ саналыг цөөнгүй эрдэмтэн дэмждэг.

Хоёр. «Цагаан түүх»-ийг зохиогч нь лам хуврага хүн байсан бололтой гэж нөгөө хэсэг эрдэмтэд үзэж байна. Академич Ш.Нацагдорж "Цагаан түүхийн тухай" гэдэг өгүүлэлдээ, «... «Цагаан түүх» бол Хубилай цэцэн хааны зохиосон зохиол биш ... харин түүний даалгавараар аль нэгэн шадар эрдэмтэн, сайд зохиосон байх. «Цагаан түүх»-нд шашны нөлөөлөл тун их, Төвдийн шашны тухай өгүүлэх ба лам нарын эрх ашгийг дээдлэн гаргасныг үзвэл «Цагаан түүх»-ийн зохиогч нь лав лам хуврага хүн байсан бололтой. Хубилай хааны үед их нөлөөтэй байсан Төвдийн Пагва лам «Цагаан түүх»-ийг зохиоход ихээхэн оролцож байсан нь дамжиггүй биз.»⁴ хэмээн дурдсан байна.

Гурав. Германы монголч эрдэмтэн Сагастер 1976 онд «Цагаан түүх»-ийг герман хэлнээ орчуулсан байх бөгөөд, тэрбээр «Цагаан түүх»-ийг Хубилайн даалгавраар ямар нэг эрдэмтэн хүн зохиосон байж магадгүй гэж бичжээ. Чухамхүү XIII зууны 80-90 ээд оны үед «Цагаан түүх»-ийг Хубилай хаан өөрөө санаачилж, боловсруулахдаа ойрын шадар хүмүүс буюу эрдэмтдийг өргөнөөр татан оролцуулсан нь эргэлзээгүй.

«Цагаан түүх»-нд Монгол төрөөс аливаа шашин шүтлэгт ялгаваргүйгээр хандах зарчмыг онцлон тодорхойлсон. Энэ нь угтаа Монгол төрийн уламжлалт бодлого юм. Мөнх хаан "Тэнгэр бурхан хүний гарын таван хурууг урттай, богинотой заяасны нэгэн адилаар улс түмэн бүрт өөр өөр шүтлэг өгсөн" тул эзлэн дагуулсан улс түмэн бүр өөр өөрийн язгуур шашнаа шүтэн баримтлах эрхтэй гэж айлдсан байдаг нь учиртай. Гэхдээ энэ бол Монгол төр бүх шашинд тэгш жигд хандаж байсан гэсэн хэрэг огт бус. Монгол төр үндэсний уламжлалт соёл иргэншил, хөрс сууриа хадгалан бэхжүүлэх хэрэгцээ, эрх ашгийнхаа үүднээс, чухамхүү төрийн бодлогоор дамжуулан тэр бүх шашин шүтлэгийн дотроос нэгийг нь сонгон өөрийн болгох, дэмжин авч явах учиртай байсан. Тийм шашин нь Монголын эзэнт гүрний эхэн үед бөөгийн шашин, Юан гүрний цагаас эхлэн бурханы

шашин тус тус болж асан нь илэрхий билээ. Ерөөс бүх шашин суртахууныг нэгэн адил баримтлан хамгаалдаг тэдгээр бүгдэд нэгэн адил үндэслэн тулгуурладаг тийм төр гэж хаана ч байсангүйг хүн төрөлхтөний түүх гэрчилж байна.

Тус шастирын үндсэн үзэл санааг хоёр ёсны үзэл баримтлал бүрдүүлдэг нь тодорхой. Тэгээд ч тус сурвалж бичгийн оршилд түүний агуулгыг нягтлаж хураангуйлан “үнэн хоёр ёсны тэгшид эндүүрэл үгүй явуулахуйн товчоон арван буянт номын Цагаан түүх” гэж тодорхойлсон нь санамсаргүй хэрэг бишээ. Чингэхүйеэ, хоёр ёсон гэж юу вэ? Түүний эн тэргүүн хоёр ёсыг аль буй хэмээвээс:

«...Номын төр тарни, судар хоёр хийгээд

Ертөнцийн төр энх, гилбэр хоёр ёсноос...»⁵ хэмээн түүнийг тодорхойлжээ.

Өөрөөр хэлэхүл энэхүү хоёр ёсон хэмээгч нь шашин төр хоёр буюу, хүмүүний энэ ертөнцийн хэрэг зол жаргал- энх амгаланг эрхлэгч ертөнцийн төр буюу хааны төр хийгээд хүмүүний сэтгэл оюуны хэрэг, хойд насны зол жаргалыг эрхлэгч номын төр буюу шашны төр хэмээгч хоёр зүйлийн төр байх ажгуу. Үүнд бурханы шашны сургуулиар хүмүүнийг энэ ертөнцийн(сансарын) зовлонгоос гэтэлгэгч их хөлгөний буюу судрын зам, нууц(очир) хөлгөний буюу тарнийн зам хэмээгч хоёр зам мөр байх тул шашны төр нь тэр бүхнийг хамарсан судрын ба тарнийн хэмээх хоёр заагт, нөгөө ертөнцийн төр нь ард оныг элбэрэн нигүүлсэх, энэрэн тэтгэхүйн үйлсийг эрхлэгч энх төр хийгээд төрийн албадлага хүчирхийллийн үүргийг хэрэгжүүлэгч гилбэр буюу дайчин төр хэмээх хоёр хэсэгт тус тус ангилагдах ажгуу. Эдгээрийг бүхэлд нь хоёр ёсны дөрвөн их төр хэмээн нэрийдэх хийгээд энх төрийг төрийн эзэн хаан голлон эрхлэж, харин төрийн захиран дарангуйлах чиг үүргийг түүний түшмэд голчлож хэрэгжүүлэх учиртай ажээ.

Юан улсын төрийн байгууллыг бүрэлдүүлэхдээ нэг талаас хаан тэргүүлэн түшмэдийн эрхлэн хэрэгжүүлэгч хааны төр буюу иргэний төр, нөгөө талаас улсын багш тэргүүн лам хуврагуудын эрхлэн хэрэгжүүлэгч шашны төр буюу сүм хийдийн байгуулалыг зэрэгцүүлэн босгож өөр хооронд нь шүтэлцүүлж тавьсан байна. Чухам ингэж харын(иргэний) болон сүм хийдийн байгуулал зэрэгцэн оршиж, өөр өөрийн үйлийг эрхлэж, бас бие биеэ нөхөж чадсан цагт сая “Үнэн номын засаг хивийн зангиа мэт алдаршгүй, хүнд хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй”⁶ болох учиртай. Энэхүү хоёр ёсны аль аль нь дутаж болшгүй гэдгийг «Цагаан түүх»-нд:

«...Ер хоёр ёсноор эс явбаас буян хилэнц хоёр, цагаан хар хоёр, хүнд хөнгөн хоёр, үнэн худал хоёр, сайн муу хоёр, жаргал зовлон хоёр, эд бүхний ялгалыг үл мэдэхүйн тул тэр мэт номын засаг үгүй бөгөөс амьтан там дор унаюу, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдрэх болюу ... лам багшдаа шүтвээс бодьсунгийн мөр ольюу. Буянт хаанд шүтвээс ертөнцийн улс сайтар амирлиюу»⁷ гэж үндэслэн дүгнэсэн байна.

Тийнхүү бурхны шашны ухааны хамгийн язгуур онолын нэг үйлийн үрийн шүтэн барилдлагын хуульд үндэслэн хүмүүсийн энэ хойд хоёр насны зол жаргал, сайн сайхныг хангахын тулд “номын ба ертөнцийн хэмээх хоёр засаг зайлшгүй”⁸ гэж үндэслэсэн ажээ. Учир шалтгаан иймийн тул түүгээр “Үнэн номын төр дотоод зүрхэн, хүнд хааны төр гадны

хар нүдэн мэт буюу”⁹ гэж тэдгээрийн аль аль нь орхигдон дутагдаж болшгүй гэдгийг зүйрлэн илэрхийлжээ.

“Цагаан түүх”-нд “... дээд шашны үндсэн номын эзэн лам ба их төрийн эрхэн ертөнцийн эрхэт хаан”¹⁰ хийгээд гэж төрийн хэрэг, шашны хэрэг хоёрыг эрс зааглажээ. Төрийн хэргийг зөвхөн ертөнцийн эрхт хаан хийгээд түүний түшмэд эрхлэж явуулна, тэд шашин номын хэрэгт үл оролцоно. Мөн шашин номын үйлийг номын эзэн Гүүшри(хааны багш буюу улсын багш) хийгээд түүний харъяат хуврагууд эрхлэн явуулна. Тэд тэдний хэрэгт үл оролцоно. Энэ зарчмыг «Цагаан түүх»-д «хоёр ёсыг холил үгүйеэ тус бүр сайтар тогтоохуй»¹¹ гэж томъёолжээ.

Улмаар энэ хоёр ёсыг тус бүрийг эрхлэн хэрэгжүүлэгч байгуулал, зэрэг дэв тэр тус бүрийн эрхлэх чиг үүргийг чанд ялган тогтоожээ. Тийнхүү өрнө дахинд дундад зуун, сэргэн мандалтын үеийг туулж, шашны инквизацийг үзэн өнгөрүүлж байж хүрч ирсэн хүн төрөлхтний сэтгэлгээ, иргэншлийн нэгэн томоохон ололт болсон сүм хийдийг төрөөс тусгаарлах, шашны бус иргэншилт төрийн үзэл санаа «Цагаан түүх»-нээ өвөрмөц хэлбэрээр тавигдаж байгаа нь сонирхолтой байна. Гэхдээ Юан улсад шашны ба ертөнцийн хэмээх адил тэнцүү, эрх тэгш хоёр байгуулал, хоёр төр байгаа юм бас биш юм. Харин «Цагаан түүх»-нд дээрхи хоёр ёсны дөрвөн төрийг нийтэд нь басхүү «хаан хүмүүний харъяат дөрвөн их төр»¹² гэж бүхэлдээ улс орны дээд эрхэт эзэн нь эцсийн дүндээ төрийн эзэн хаан гэдгийг онцолжээ. Энэ нь тухайн үед монголын төр бурхны шашныг чухал нэгэн холбоотон туслагчаа болгосон хэрэг юм.

Монголын төрт ёсны сэтгэлгээний үүднээс үзвэл «Цагаан түүх»-нд Юан улсын төрийн болон шашны байгууллагыг хэрхэн тогтоож хуульчилсан нь сонирхолтой. Үүнд ч шашны байгууллагын тухайд шашин номын төрөл бүрийн салбарын хэргийг эрхлэн гүйцэтгэгч лам хуврагуудын нийт тоо нь 20 гаруй зэрэг дэвийг нэрлэн дурдсан буй. Ертөнцийн төрийн тухайд бол төрийн эзэн хаанаас эхлэн төрөл бүрийн шат түвшинд холбогдох 80 гаруй албан тушаал бүртгэгджээ.

Хаан төрийн албаны бүх түшмэдийг нийтэд нь гадаад, дотоод хэмээн хоёр ангилж байсан нь дотоод түшмэдийн зэрэглэлд түмний ноёноос дээшихийг хамруулдаг төрийн албаны нэн өндөр, бэрх ямба байсан бололтой. Юан төрийн гадаад түшмэд их бага бүгд 2730, дотоод түшмэд нь 121 болж байжээ. Төрийн байгуулалыг эмхлэн бүрдүүлэхтэй уялдуулан төрийн эзэн хааны эрхлэн гурван их үйлс, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их бэлгийг тодорхойлсон нь төрт ёсны сэтгэлгээний сонирхолтой баримт болж байна. Үүнд гурван их үйл:

- Улсыг номын ёсоор залж амгалан болгох
- Төрийн ёсоор засаж, жаргал эдлүүлэх
- Цэргийн явдлыг хичээж улсыг батлан хамгаалах явдал юм.

Энэ их гурван үйл бол Монголын хааны төрөө засахын гол үзэл санаа юм.

Их дөрвөн төр хэмээх нь:

1. Их хөлгөний ёсон амгалангийн төр

2. Хааны барих энх төр
3. Нууц хөлгөний ёсон жига төр
4. Түшмэдийн барих дайчин төр хэмээх дөрвөн төр мөн гэнэ.

Энд хаан хүмүүн бурхны шашныг удирдлага болгож, хоёр ёсны зарчмыг тууштай тогтоон хэрэгжүүлэх учиртай гэдгийг товойлгон тавьжээ.

Зургаан үлгэр нь:

Монголын хаадын төрийг зассан өмнөх үеийн дууриалал
Төр засах журмын тухай бурхан багшийн сургаал, зарлигийн уламжлал
Төр ёсыг явуулах ёслол дүрмийн үлгэр
Дур зоргоороо явж үл болохын дууриалал
Цэрэг байгуулж төрөө хамгаалахын уламжлал
Арвилан хэмнэж өсгөн үржүүлэхийн уламжлал болно.

Энэ бол төрөө засахад өмнөх үеийн түүхийн сургамжийг харгалзан үзэхийн үндэслэл юм.

Долоон их бин:

Өнгөрснийг хайж олох гүн ухаан
Ирээдүйг угтаж мэдэх оточ
Битүүг тааж мэдэх үлэмж мэргэн
Эдүгээ ахуйг бүрэн төгс мэдэх үнэн мэдэл
Бусдын самбаа өгүүлэхийг урьдаас олж мэдэх гайхамшиг цэцэн
Ая авын явдлыг ёсоор мэдэж чадах баатар
Ухааныг төгсгөх гэгээн билэг болой.

Долоон их бин нь Монголын хаадын эрдэм мэдлэгийг эрхэмлэн хүндэтгэх үзэл санааг илэрхийлжээ.

Есөн их бэлгэ:

Хараа ихэт хар туг- бусдыг айлгах бэлгэ
Хашгираа ихэт улаан бүрээ- хамаг хүнддэхийн бэлгэ
Хүч ихэт алтан хор- бие сахихын бэлгэ
Цог ихэт шар үхэр- олноо өргөхийн бэлгэ
Зангарга ихэт алмас илд- засаг явуулахын бэлгэ
Чийрэг сайн алтан эмээл- явдлын бэлгэ
Ээл ихэт- хүнд бүс тогтоохын бэлгэ
Өндөр далбарт исэр /сэнтний суудал/- суудлын бэлгэ

Түшлэг сайт өрлөгүүд- найз нар арга бэлгэ эд буюу хэмээн тэмдэглэжээ. Юан улсын үед 3 зүйлийг 3 хонжин, 3 төрийг 4 тайж, 6 их дууриалыг 6 гэрби, 7 бинг 7 зайсан, 9 бэлгийг 9 өрлөг тус тус эрхлэж байжээ.

«Цагаан түүх»-нд номын засаг явуулж буюу лам нарын биеэ авч явах төр ёсыг тогтоож: Лам нарын уухын дээд цай, амттаны дээд чихэр, идэхийн дээд боов зэрэг ариун идээнд шүтэж, амьтныг алж, нүгэл хийж болохгүй. Буянт хаанд шүтэх, лам багшийг оройдоо мөргөх, ядам бурхныг зүрхэндээ сэтгэх, хамаг амьтныг амраг хөвүүн мэт асрах, ариун

санваарыг хичээн сахих, 4 өглөгийг тасралтгүй өгөх, бурхны номын хичээн сурах, 4 цаглашгүйг үнэнээр хичээх, 3 эрдэнийг шүтэх, нууц тарнийн «тангаргийг сахих, буян үгээгүй хоёрыг тэгш сэтгэх, хоёр түйтгэрээ арилгаж, хоёр чуулганыг хураах, 10 хар нүглийг тэвчих, 10 цагаан буяныг хураах, 5 хорыг дарж, 5 билгэ бэлгийг бясалгах» хэмээн өгүүлжээ.

«Цагаан түүх»-нд бас эгэл харчуудыг биеэ авч явах төр ёсыг сайн үйл үйлдэх, сургаалтай явах, мууг тэвчих 3 зүйлд багтаан тогтоожээ. Үүнд: «сайн явахыг муу үйлээр эвдэх, худал үйлст шунахгүй, үүрд сайн үйлсийг хичээх, шашны ёсыг хичээн сурах, лам багшийн сургаалд эс орвоос хорт этгээдтэй учрах, эцэг эхийн сургаалд эс олвоос муу үйлтэй учрах, эзэн хааны зарлигийг эс сонсвоос битүү торонд унах, шавийн ёсоор эс явбаас тангаргуудыг эвдэх, бусдаас ихэмсэглэн би хэмээвээс хар шулмаст хатгагдах, дураар загнаваас багшаас хагацах, элбэрэлгүй ламыг тэвчих, өршөөлгүй хааныг тэвчих, асралгүй ноёдыг тэвчих, эд ашигт шуналтай түшмэдийг тэвчих, муу хүнийг ихэд эс асрах, сайн хүнийг ихэд эс магтах, лам хүнийг эдэд үл горилох, хаан ихэстэй эсрэгэлцэх, хааныг санг эс хомоотгох, багш хүний эдийг эс булаах» хэмээжээ.

«Цагаан түүх»-нд бурхан шашны номлолыг дэлгэрүүлэн хөгжүүлэх гол арга замыг тодорхойлсон юм.Тухайлбал:

Бурхан, ном, хувраг хэмээх 3 эрдэнийг өргөн хүндлэх
Бурхан суртахууныг наран мэт мандуулах
Сүм хийд барих, ном судар бичих, суврага босгох
Бумбын шашинтанг эс мөргүүлэх
Сүм хийдийн дэргэдүүр эс авлах
Бацаг санваарыг хичээн сахих
Мааний зургаан үсгийг унших
Ад зэтгэрт золиг өгөх
Үхсэн хүнд буян хийхийг тус тус өгүүлэн заажээ.

«Цагаан түүх»-нд өгүүлэх ёс суртахууны хэм хэмжээнүүдийг дагаж мөрдөх нь номын ёсонд тохирч хааны засагт нийцэх ажээ. Тиймээс ч «Цагаан түүх» номонд үүнийг үндэслэн

«...Үүлгүй тэнгэрийн хүйтэн сумнаас хатуу
Өвсгүй газрын хумхи өргөснөөс ширүүн
Санвааргүй тойн үнэн номыг салхинд хийсгэнэ

Төр үл мэдэх ноёдын засаг уулнаас ч хүнд...»¹³ хэмээн эрдэм номгүй тойн, төрийн мэдлэггүй ноёдын засгийг шүүмжилж, бурхан, ном, лам, хуврага, эцэг эхдээ их ачлал хийх гэвэл ламын тангаргыг нүдний цөцгий мэт хайрла, хааны зарлигийг зүрх мэт сэтгэн эцэг, эхийн сургаалыг амь мэт ухаж ойлгохыг чухалчилжээ.

Хубилай хаан хоёр ёсыг дурсан тэмдэглэх өдрүүдийг бий болгосон нь ёс суртахууны шилдэг чанаруудыг улс оронд хэвшүүлэн тогтооход чухал ач холбогдолтой болсон юм. Хубилай хаан тухайн үедээ 4 цагийн буян үйлдэгч дурсгалын өдөр(хавар, зун, намар,

өвлийн буян) Бурхан Шигамуны дурсгалд, 4 цагийн хурим үйлдэх дурсгалын өдөр, Чингэс хааны амьдрал, үйлтэй холбогдсон чухал өдөр зэргийг эзэнт гүрний хэмжээгээр заавал тэмдэглэх хатуу журам тогтоон хэрэгжүүлж байжээ.

Хубилай хаан орон нутгийн ноёд, засаг захиргаа явуулахдаа энэхүү шашин төр хоёрыг тэгш явуулах зарчмыг заавал баримтлах ёстой гэж үзээд энэ тухай бас “ 5 өнгө, 4 хар их улсад аравт, зуут, мянгат, түмт, түг түмний ноёд нь улс, улс, аймаг, аймагт тус тус мэдэгдтүгэй. Хоёр ёсыг холил үгүйеэ тус бүр сайтар хичээгдэхүй”¹⁴ гэж хуульчилан заасан байна.

Юан улсын үед хоёр ёсоор эс явсан хүнийг хатуу шийтгэдэг байв. Тухайлбал: муу үйлдсэн лам нарыг ламаас гаргаж эрүүдэн хол газар цөлөх, хар хүн худал хэлбээс хэлийг нь огтлох, хулгай хийвээс нүдийг нь сохлох, хов хэлж төр үймүүлвээс алах ялтай байжээ. Үүний хамт хос ёсыг хатуу баримтлан эндүүрэлгүй сахин явсан хүмүүс сайшаал шагнал хүртдэг ёс бас буй болсон байжээ.

Хубилай хаан сайн түшмэдийг сонгон хэрэглэх нь уг төрийн мандах буюу доройтохтой шууд холбоотой асуудал гэж үзэж “... шулуун мэргэдийг олж их зэрэгт оруулбаас хааны сэтгэлийг бүтээн улсыг амаршуулан өөрөө хүнд их алдартай больюу. Муу ардыг ихсийн дүрд болговол улсыг зөвхөн хааны үйлсыг эвдэж өөрсдөө гутамшиг танхай болмой. Түүгээр сайтар шинжлэн гүн онож мэдтүгэй”¹⁵ хэмээжээ.

Дүгнэлт

Монголын төрт ёсны сэтгэлгээ төрөөс дэлхийн асуудалд, бөө мөргөлөөс бурхны шашны үзэл сургаалд дэвшин орсныг «Цагаан түүх» илтгэн харуулж байна. “...«Цагаан түүх» хэмээх энэхүү зохиол нь дундаж зууны түүхийн турш монгол төрт ёсны сэтгэлгээний түүхнээ хутагт Августины “Эрхэт тэнгэрийн хөг” зохиолын гүйцэтгэсэн шиг тийм их үүргийг Монголын уламжлалт төрт ёсны сэтгэлгээний хувьд «Цагаан түүх» гүйцэтгэсэн юм”¹⁶ гэж хэлж болно. Түүгээр ч Монголын гүн ухааны, тухайлан төрт ёсны сэтгэлгээний түүхнээ тус зохиолын гүйцэтгэсэн үүрэг, учир холбогдол тодорхойлогдох юм гэж үзнэ.

Эш татсан зохиолууд:

1. Монголын философийн түүх II дэвтэр УБ 2000 42-р тал
2. “Арван буянт номын цагаан түүх” ӨМХ Хөх хот 1981 25-р тал
3. С.Жалан-аажав “Арван буянт номын цагаан түүхийн тухай” УБ 1998.
4. Ш.Нацагдорж “Монголын феодализмын үндсэн замнал” УБ 1997 126-р тал
5. Монгол улсын арван буянт номын цагаан түүх оршивой УБ 1998 42-р тал
6. Мөн тэнд, 43-44-р тал

7. Мөн тэнд, 42- р тал
8. Мөн тэнд, 48-р тал
9. Мөн тэнд, 49-р тал
10. Мөн тэнд, 52-р тал
11. Мөн тэнд, 52-р тал
12. Мөн тэнд, 48-р тал
13. Г.Лхагвасүрэн Төр сүм хийдийн харилцаа орчин үе УБ 1998 95-р тал
14. Мөн тэнд, 50-р тал
15. Мөн тэнд, 52-р тал
16. Мөн тэнд, 53-р тал

УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ, ҮЙЛ ЯВЦ

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН СОНГУУЛИЙН КАМПАНИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОЛОГИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖ

Ц.Ганболд

доктор, проф

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

Ц.Мөнхцэцэг

доктор

МУБИС, Улс төр социологийн тэнхим

Аливаа улс төрийн намын үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг нь сонгуулийн кампанийг амжилттай явуулж ялалт байгуулах явдал байдаг билээ. Тийм учраас энэхүү илтгэлд Монголын улс төрийн намуудын сонгуулийн кампанийг дэлхийн улсуудынхтай харьцуулахад ямар байна, орчин үеийн технологийг хэрэглэх боломж ямаршуу байгааг авч үзэхийг зорилгоо.

Нэг. Сонгуулийн кампанийн дэлхийн чиг хандлага

Өрнөдийн улс орнуудад 1990-ээд оноос сонгуулийн кампанийн бүхий л үйл ажиллагаанд судлаачид, PR-ийн зөвлөх, спин доктор²⁰, имиж мейкерүүд зэрэг мэргэжилтнүүдийн үүрэг нөлөө нэмэгдсэн бөгөөд сонгуулийг эрхлэн явуулах нь өндөр түвшний мэргэшсэн үйл ажиллагаа болж хувирсан учраас судлаачид орчин үеийн сонгуулийн кампанийг пост-модерн буюу мэргэжлийн кампани гэж нэрлэдэг байна. (Tenscher 2006) Нийт сонгогчдын дунд сурталчилгаа хийж байсан уламжлалт аргууд үеэ өнгөрөөж тодорхой зорилтот бүлгүүд рүү чиглэсэн өвөрмөц мессеж, тактикуудыг хэрэглэх болсон бөгөөд фокус бүлгийн ярилцлага, мэдээллийн мониторинг, теле-маркетинг²¹ гэх мэт шинэ технологиудыг хэрэглэж байна. Сурталчилгааны арга хэлбэр, сувгууд өмнөхтэй харьцуулбал илүү хялбар, энгийн, цэнгээнт өнгө аяс бүхий болж хувирчээ.

²⁰ Хэвлэл мэдээллийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх. Спин докторууд нэр дэвшигчид болон улс төрийн намууд хэвлэлд хэзээ, ямар мэдээлэл, ярилцлага өгөх, яаж өгөх, ямар үр дүнг үзэгч, сонсогчдод авчрах талаарх бүхий л үйл ажиллагааг удирдан чиглүүлж, найруулдаг байна.

²¹ Зар сурталчилгааг утас, E-майл, факс гэх мэтээр хэрэглэгчид шууд хүргэх коммуникацийн хэлбэр.

Ийнхүү сонгуулийн кампанийн хэв маяг өөрчлөгдөх болсон нь нийгэм, сэтгэл зүйн учир шалтгаантай юм. 1970-аад оны сүүлчээс Өрнөдийн ихэнх улсад сонгогчдын идэвх оролцоо суларч, улс төрийн намуудын тогтвортой дэмжигчид буурах үйл явц эхэлсэн юм. Ийнхүү улс төрийн намын тогтвортой дэмжигчид буурах болсноор санал өгөлтөө нэг сонгуулиас нөгөөд өөрчилдөг “хөвдөг сонгогчдын” тоо нэмэгдэхэд хүргэв. Тийм учраас сонгуулийн кампани, хэвлэл мэдээллийн үүрэг нөлөө сонгогчдын санал өгөлтөнд хүчтэй нөлөөлөх болсныг судлаачид онцолдог. (Swanson 1996) Өрнөдийн сонгогчдын санал өгөлт өмнөх үетэй харьцуулахад илүү савлагаатай болсон хэдий ч сонгогчид болж байгаа улс төрийн үйл явцад илүү шүүмжлэлтэй ханддаг болсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. (Darren 2006) “Хөвдөг сонгогчид” аль нэг намд тогтвортойгоор саналаа өгдөггүй юм. Тиймээс улс төрийн намуудын зүгээс сонгогчдыг татах, саналаа өгөхийг уриалах, мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдээ танилцуулах үйл ажиллагаа буюу сонгуулийн кампани нь хэвлэл мэдээллээр дамжсан ихээхэн өртөг өндөртэй коммуникаци болж хувирсан байна.

Хоёр. Дэлхийн улсуудын сонгуулийн кампани ба Монголын сонгуулийн кампанийн харьцуулалт

Монголын улс төрийн намуудын сонгуулийн кампани ямаршуу түвшинд байгааг Өрнөдийн улсуудын сонгуулийн кампанийн үндсэн онцлогтой харьцуулах замаар авч үзье.

- **Сонгуулийн кампанийн өртөг зардал.**

Улс орнуудын сонгуулийн кампанийн зардал жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд зардлын үндсэн цөм нь мэргэжлийн зөвлөхүүдийн үйл ажиллагаа, олон нийтийн санаа бодлын болон мэдээллийн мониторингийн судалгаа, телевизийн сурталчилгаанд зарцуулагдаж байна. Монгол улсын хувьд мөн адил сонгуулиас сонгуульд улс төрийн намуудын зардал нэмэгдэж байна. Гэхдээ зардлын бүтэц нь Өрнөдийн улсуудынхаас нэлээд ялгаатай. Тухайлбал, хэвлэл мэдээллийн сурталчилгаанд зардлын үлэмж хэсэг чиглэхийн хамт сонгогчидтой хийх нүүр тулсан уулзалт, ухуулга сурталчилгааны товхимол, нийтийг хамарсан өдөрлөг, арга хэмжээ зэрэгт нэлээд мөнгө зарцуулж байна. Мөн зарим тохиолдолд сонгогчдын саналыг мөнгөөр худалдан авахад ихээхэн хөрөнгө зарах болсон нь ажиглагдаж байна. Хөгжлийн ялгаанаас хамаарч хот, хөдөөгийн тойргууд дахь сонгуулийн зардал юунд зарцуулагдсан нь өөр өөр байдаг. Хөдөөгийн тойргуудад зардлын үлэмж хэсэг нь сум, багаар зочлох, сонгогчдод бэлэг гардуулах, нүүр тулсан уулзалт хийх зэрэгт зарцуулагддаг бол хотын тойргуудад зардлын цөм нь хэвлэл мэдээллийн сурталчилгаа, түүн дотор телевизийн сурталчилгаанд чиглэдэг. Харин Өрнөдийн улсуудынхтай адил мэргэжлийн зөвлөхүүдийн үйл ажиллагаа,

сонгогчдын зан үйлийн болон мэдээллийн мониторингийн судалгаанд хангалттай мөнгө зарцуулж чадахгүй байна.

- **Сонгуулийн кампанийн удирдлага**

Өрнөдийн улс орнуудын улс төрийн намуудад сонгуулийн кампанийг үндэсний хэмжээнд явуулах үүрэг бүхий тусгай байгууллага байдаг бол Монголын улс төрийн намуудын сонгуулийн кампанид голлох үүрэгтэй байгууллага нь орон нутгийн намын байгууллага юмуу эсвэл нэр дэвшигчийн штабууд болох нь ажиглагдаж байна. Энэ нь тойргийн хэлбэрээр сонгуулийг зохион явуулж, нэр дэвшигчийн тоглолт хүчтэй байдаг мажоритар системтэй тодорхой хэмжээнд холбоотой байж болох юм. Харин АНУ, Герман зэрэг улсуудад мэргэжилтнүүдээс бүрдсэн тусгай байгууллага улс төрийн намуудын сонгуулийн кампанийг гардан явуулдаг. Монголын ихэнх намууд сонгуулийн кампанид нэгдмэл зохион байгуулалт, стратегитай оролцдоггүй, нэр дэвшигчид тухайн тойрог дэх хуучны туршлага, танил хүмүүсийн дэмжлэг зэрэгт үндэслэн сонгуулийн кампаниа явуулах нь түгээмэл байна. Гэхдээ сонгуулийн кампани дахь төвлөрсөн удирдлага нам тус бүр дээр ялгаатай байгаа юм.

2008 оны сонгуулийн кампаниас харахад МАХН-тай харьцуулахад АН-ын сонгуулийн кампани илүү төвлөрсөн бус байлаа. АН-ын сонгуулийн ерөнхий штабаас боловсруулсан мөрийн хөтөлбөр, TV сурталчилгааг эс тооцвол бүх нэр дэвшигчид кампаниа намаас ямар нэгэн удирдамж авалгүй өөрсдөө явуулсан юм. Харин МАХН-ын хувьд сонгуулийн төв штаб мөрийн хөтөлбөр, телевизийн сурталчилгаанаас гадна сөрөг сурталчилгааг нэгдсэн байдлаар явуулж байснаараа АН-аас ялгаатай байв. Гэхдээ МАХН-ын сонгуулийн кампанийг бүхэлд нь үзвэл орон нутгийн байгууллага ба нэр дэвшигчид голлох үүрэгтэй байв. Мөн энэ удаагийн сонгууль олон мандаттай явагдсан тул нэг намаас нэр дэвшигчид хоорондоо өрсөлдөх, бие биеийн эсрэг үйл ажиллагаа явуулах гэх мэт зүйлс нэлээд ажиглагдсан юм. (Ц.Мөнхцэцэг 2009)

- **Сонгуулийн кампанийн тусгай байгууллага, мэргэжилтнүүд**

Хөгжингүй орнуудын улс төрийн намуудын сонгуулийг эрхлэн явуулах байгууллага нь PR-ийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээлэл, олон нийтийн санаа бодлын судалгаа, интернэт кампани, сөрөг сурталчилгаа, өрсөлдөгчийг ажиглах гэх мэтээр мэргэшсэн үйл ажиллагаа явуулах тусгай нэгж, агент, зөвлөхүүдтэй байдаг. Монголын улс төрийн намуудын хувьд МАХН, АН зэрэг улс төрийн гол намууд сонгуулийн кампанид зориулж тусгай нэгж, албыг байгуулан ажиллуулдаг. Монголд улс төрийн коммуникацийн мэргэжилтэн буюу хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах талаар мэргэшсэн хүмүүс ховор тул нэр дэвшигчид аль нэг телевиз, сонингийн тодорхой сэтгүүлчтэй гэрээ байгуулан өөрийн сурталчилгаа, мэдээллийг бэлтгүүлэх байдлаар хэвлэл мэдээлэлтэй харилцах үйл ажиллагаагаа явуулж байна.

- **Олон нийтийн санал асуулга**

Аливаа сонгуулийн кампанийн үр дүн, сурталчилгааны үр нөлөөг тодорхойлох, цаашдын арга хэмжээний чиглэлийг гаргахад сонгогчдын зан үйлийн судалгаа гол үүрэг гүйцэтгэдэг. Тийм учраас дэлхийн улс орнуудын сонгуулийн кампанийн нэгэн чухал хэсэг нь сонгогчдын зан үйлийн судалгаа байдаг юм. Олон нийтийн санал асуулгыг кампанийн эхэн, өрнөл, сүүл хэсэгт гэх мэтээр тодорхой давтамжтайгаар явуулахаас гадна нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн, өрсөлдөгчийн болон өөрийн нэр дэвшигчтэй холбоотой гарсан сенсаац, дуулиан, нийтийг хамарсан арга хэмжээ гэх мэт чухал үйл явдлын дараа олон нийтийн санаа бодлын өөрчлөлтийг тандах зорилгоор явуулдаг байна. Жишээ болгож АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийг дурьдая. 2008 оны АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн эхэнд буюу 8 сарын 29-нд Бүгднайрамдах намаас нэр дэвшигч Жон Маккейн дэд ерөнхийлөгчид Аляска мужийн захирагч Сара Пэлинг нэр дэвшүүлснийг зарлахад түүний рейтинг эрс өсч Ардчилсан намаас нэр дэвшигч Барак Обамагаас даруй 10 пунктээр илүү гарсан юм. Сара Пэлинг дэд ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нь Бүгднайрамдах намын судлаачдын зөвлөгөөний үр дүн байлаа. Учир нь олон нийтийн санаа бодлын судалгаагаар Хиллари Клинтонг дэмжиж байсан цагаан арьст эмэгтэй сонгогчдын саналыг татах зайлшгүй шаардлагатай нь тогтоогдсон байна. Тиймээс Хилларигийн дэмжигчдийг татахын тулд Сара Пэлинг нэр дэвшүүлсэн аж. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр олон нийтийн санаа бодлын судалгаа өндөр давтамжтай хийгдэж байсан. Тухайлбал, олонд алдартай Гэллап институт долоо хоног болгон санал асуулга явуулж байсан бол Реал Клеар Политикс хэмээх байгууллага сонгуулийн кампанийн оргил үе буюу 10 сарын 29-нөөс 11 сарын 2-ны хооронд үндэсний хэмжээний 14 санал асуулга явуулжээ. ХБНГУ-ын хувьд Бундестагийн 2009 оны 9 сард явагдсан сонгуулийн кампанийн үеэр судалгааны бие даасан 13 байгууллага үндэсний хэмжээний судалгаа хийсэн бөгөөд эдгээр төвүүдийн прогноз сонгуулийн дүнтэй тун ойр гарсан юм.

Монгол улсын хувьд улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн кампанийн үеэр олон нийтийн санаа бодлын судалгаа явуулах, судалгааны дүнг нь ашиглах нь түгээмэл болж байна. 2008 оны УИХ-ын сонгуулийн жишээн дээр үзэхэд бараг бүх нэр дэвшигчид ямар нэг байдлаар судлаачидтай хамтран ажиллаж сонгуулийн кампанидаа олон нийтийн санаа бодлын судалгааг хэрэглэсэн юм. Нийслэлийн зарим нэр дэвшигчид сонгуулийн кампанийнхаа явцад хүн амын дунд санал асуулгыг хэд хэдэн удаа явуулж сурталчилгааны ажлын үр дүнгээ хянаж сайжруулах алхам хийж байсан билээ.

- **Политайнмент буюу цэнгээнт улс төр**

Өрнөдийн орнуудын улс төрийн үйл явцыг тодорхойлогч нэгэн хүчин зүйл бол цэнгээнт улс төр юм. XX зууны сүүлчээр дэлхийн улс орнуудын улс төрийн талаарх мэдээлэл, сонгуулийн кампанийн сурталчилгаанд цэнгээнт өнгө аяс, урлаг, уран сайхан хүч түрэн орж ирж болсон бөгөөд судлаачид энэ үзэгдлийг “политайнмент” (politics+entertainment=politainment) буюу “улс төр+зугаа цэнгээн=цэнгээнт улс төр” (Doerner, Ludgera, 2003) гэж нэрлэх болсон юм. Улс төрчид сонгуулийн кампанидаа урлаг, спортын бүх төрлийн авьяас чадвар, бусдаас ялгарах содон шинж, өвөрмөц хобби, хошин шогийн мэдрэмж, илтгэх чадвараа ашиглаж имиж бүрдүүлж байна. Сонгуулийн кампанидаа цэнгээнт улс төрийг анх удаа амжилттай хэрэглэсэн улс төрч бол Холливудын кино од асан Р.Рейган байв. Тэрбээр сонгогчидтой хийх уулзалтын үеэр улс төрийн хошигнол, уран илтгэл гэх мэтээр жүжигчний авьяасаа ашиглаж сурталчилгаа хийж байжээ. Үүнээс хойш АНУ-ын ерөнхийлөгч Б.Клинтон, Их Британийн ерөнхий сайд Т.Блэйр, ХБНГУ-ын канцлер Г.Шредер нар илтгэх чадвараа амжилттай ашигласан улс төрчид гэж тооцогддог юм. АНУ-ын өнөөгийн ерөнхийлөгч Б.Обамагийн хувьд ч дуу хоолойны өнгө, илтгэх чадвар нь сонгуулийн ялалтанд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх талтай. Б.Обамагийн хувьд сонгуулийн кампанидаа АНУ-ын түүхэнд байгаагүй нэг шинэ зүйл нэвтрүүлсэн нь хоёр хамтлаг, нэг дуучнаар “Тиймээ бид чадна”, “Барак Обама”, “Үндэстнийг нэгтгэе” хэмээх дуунуудыг дуулуулж клип хийлгүүлсэн явдал юм. Гэвч энэ дуунууд олонд төдий л хүрч чадаагүй байна. ХБНГУ-ын 2009 оны Бундестагийн сонгуулийн кампани лидерүүдийн хувийн тоглолт, уран илтгэл багатай уйтгартай, үзэх харах юм багатай болсон гэж судлаачид үзсэн. (Peter Schneider 2009) Зарим нь энэ удаа сонгуулийн кампанигүй сонгууль явагдлаа гэсэн байна. (Michael Weigl (2009) Сонгогчдын дөнгөж 36.1% оролцсон энэ сонгуулиар Улс төрийн голлох намууд болох ХАХ 32%, СДН 27.9%²-ийн санал тус тус авсан нь уг намуудын хувьд сүүлийн 60 жилийн түүхэнд байгаагүй бага саналд тооцогдож байна.

Цэнгээнт улс төрийн дараагийн нэг илрэл бол улс төрийн ток шоу юм. Өмнө дурьдсанаар Өрнөдийн улсуудад 1980-аад оноос эхэлсэн улс төрийн намуудын тогтвортой дэмжигчид буурч улс төрөөс хүнийсэх явдал нь мөн тэр хэмжээгээр улс төрийн нэвтрүүлэг, мэдээллийн үзэгч, сонсогчдын тоог бууруулсан байна. Үүний улмаас телевиз, сонингууд үзэгч, уншигчдаа тогтоон барихын тулд тэднийг татах сонирхолтой арга бодож олсон нь улс төр ба цэнгээнт нэвтрүүлгийн өнгө аясыг хослуулсан улс төрийн нэвтрүүлэг, ток шоу²²-нууд юм. Улмаар хүмүүс төдий л сонирхдоггүй улс төрийн асуудлуудыг хөнгөн хэлбэрээр олон нийтэд хүргэх арга хэрэгсэл нь цэнгээнт өнгө аяс бүхий ярилцлагын төрлийн нэвтрүүлгүүд болж хувирсан байна.

²² Ярилцах шоу буюу үзүүлбэр, тоглолт гэсэн утгатай. Улс төр, эдийн засаг, хувь хүний амьдрал гэх мэт бүхий л асуудлаарх ярилцлагын төрлийн нэвтрүүлгийг хэлнэ. Шоу гэсэн утгаараа ийм нэвтрүүлэг нь цэнгээнт элемент, жүжигчлэл, хошин шогийг агуулсан байх нь олонтаа.

Өрнөдийн улсуудын сонгуулийн кампанийн коммуникацид газар авч буй урлаг, зугаа цэнгээний хүчин зүйлс Монголд ч мөн ажиглагдаж байна. Гэхдээ Өрнөдийн улсуудаас ялгаатай нь улс төрчид уран илтгэл, жүжиглэх чадвараараа олныг татах гэхээс илүүтэйгээр урлагийнхнаар өөрсдийн сурталчилгаа хийлгэж байна. Улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгогчидтой хийх уулзалт, нийтийг хамарсан арга хэмжээнд дуучид, жүжигчдийг оролцуулан урлагийн тоглолт хийлгэж сонгогчдыг мөрийн хөтөлбөр, асуудлыг шийдэх чадвараар татахын оронд “улс төрийн бус” хүчин зүйлсийг ашиглаж байгааг арилгахын тулд 2005 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 37.11.13-д сонгуулийн сурталчилгаанд *“биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулахыг”* хориглосон нэмэлтийг оруулсан билээ. Ийнхүү сонгуулийн кампани дахь “улс төрийн бус” хүчин зүйлсийг хориглох ородлого байгаа ч жил жилийн сонгуулиар урлаг, спортын алдартнууд нэр дэвшигчдийн сурталчилгаанд чухал байр суурь эзэлсээр байгаа нь сонгуулийн кампанид улс төрчид гол дүр бус, туслах дүр бүтээж гол асуудлаас өөрсдийгөө хөндийрүүлэхэд хүрч байна. Ялангуяа 2009 оны ерөнхийлөгчийн сонгуулийн кампанид МАХН-аас нэр дэвшигчийн сонгуулийн кампани дахь урлаг, спортынхны сурталчилгаа “уран сайхны хэтрүүлэг” болоход хүрсэн билээ.

Өрнөдийн политайнмент Монголын сонгуулийн кампанид илэрч буй дараагийн нэг хэлбэр нь улс төрийн ток шоу юм. Сонгуулийн кампанийн үеэр улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн телевизийн сурталчилгааны гол хэрэгсэл нь ток шоу болсон нь 2008 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн кампаниас харагдаж байлаа. Албаны уур амьсгал, нэг хэв загварт баригдахгүйгээр харьцангуй чөлөөтэйгээр сонгогчдод өөрсдийгөө таниулах боломжийг олгодог улс төрийн нэвтрүүлэгт оролцох нь имиж бүрдүүлэх нэгэн чухал суваг болдгийг манай улс төрчид нэгэнт ойлгож ихээхэн хөрөнгө хүч хаях болсон байна. Гэхдээ Монголын телевизүүдийн ток шоу гэж нэрлэгдэх ярилцлагын нэвтрүүлгүүд нь Өрнөдийнхөөс нэлээд ялгаатай, шоу гэхээс илүүтэй хэлэлцүүлэг, ярилцлагын хэв маягт хамаарагдахаар байгаа юм. Ток шоу сурталчилгаанд ашиглах байдал нийслэл Улаанбаатарын тойргуудад түгээмэл байснаас бус хөдөө орон нутагт айл өрхөөр ухуулга хийх, сурталчилгааны хэвлэмэл материал тараах, сонгогчидтой уулзалт хийх зэрэг уламжлалт аргууд хүчтэй байсан билээ.

- **Халз мэтгэлцээн**

Дэлхийн улсуудын сонгуулийн дүнд нөлөө үзүүлэгч чухал үйл ажиллагаа нь намын лидерүүдийн халз мэтгэлцээн билээ. Дэлхийн улсуудын сонгуулийн кампанийн практикийн дагуу халз мэтгэлцээний гол мөн чанар бол бодлогын асуудлаар намын лидерүүд өөр хоорондоо мэтгэлцэх, өрсөлдөгчийн байр суурийг няцаах, сул талыг илрүүлэх явдал юм. Халз мэтгэлцээнд тавигдах асуултыг зөвхөн тухайн телевиз бэлдэж улс төрчид хязгаарлагдмал хугацааны дотор хариулах шаардлагатай байдаг. Сонгуулийн кампанийн төгсгөл дэх улс төрийн лидерүүдийн халз мэтгэлцээн нь тухайн намын

сонгуулийн кампанийн ерөнхий дүр зураг, мөрийн хөтөлбөрийг нэгтгэн дүгнэдэг тул ихэнх сонгогчид сонирхон үздэг телевизийн сурталчилгаа болдог билээ. Тийм учраас халз мэтгэлцээнд тухайн лидер хэрхэн оролцох нь сонгуулийн эцсийн дүн хүчтэй нөлөө үзүүлдэг юм. Халз мэтгэлцээний журам, явагдах газар, хугацаа зэргийг зохицуулсан тусгай байгууллагууд байдаг. АНУ-ын хувьд нэр дэвшигчдийн халз мэтгэлцээнийг БНН болон АН-ын хамтран байгуулсан Ерөнхийлөгчийн мэтгэлцээний хороо хэмээх байгууллага зохион явуулдаг юм.

УИХ-ын сонгуулийн кампанийн үеэр бидний хийсэн судалгаанаас Монголын сонгогчид халз мэтгэлцээнийг сонгуулийн сурталчилгааны хамгийн хүсүүштэй хэлбэр гэж үздэг нь харагдсан. (Д.Бадамдаш нар 2009) Гэвч манай улс төрийн намуудын лидерүүдийн халз мэтгэлцээн Өрнөдийн улсуудын халз мэтгэлцээн шиг явагдахгүй байна. Тухайлбал, 2008 оны 6 сарын 26-нд ТВ 5-аар явагдсан МАХН ба АН-ын дарга нарын, сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдөр буюу 6 сарын 27-нд МҮОНТВ-ээр явагдсан улс төрийн намуудын дарга нарын халз мэтгэлцээнүүд мэтгэлцээн бус, асуулт хариулт болсон гэх мэтээр судлаачдын шүүмжлэлд өртсөн юм. (Д.Цэрэнжав 2008) Харин 2009 оны ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн сүүлчийн өдөр явагдсан МАХН ба АН-ын нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн өмнөх практиктай харьцуулахад арай дэвшил гарсан байв. Гэвч хөтөлгөчийн ур чадвар, мэтгэлцээний журам хангалтгүй байснаас болоод нэр дэвшигчид мөн л харилцан няцаалт хийх, мэтгэлцэх боломж тааруу байсан юм.

- **Мэдээллийн технологийг ашиглах байдал**

XXI зууны мэдээллийн технологийн дэвшлийг улс орнууд сонгуулийн кампанидаа нэвтрүүлж байна. Тухайлбал, АНУ-ын ерөнхийлөгч Барак Обама E-майл кампани өрнүүлж олны өмнө хэлсэн үг бол бусад сурталчилгаагаа явуулж байсан. Мөн түүний веб хуудсанд өдөрт дунджаар 20 мянган хүн нэвтэрч байжээ.(Wikipedia 2009)

2008 болон 2009 оны сонгуулиудаас харахад Монголын улс төрийн намууд ч тодорхой хэмжээгээр мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах болсон байна. Ялангуяа нийслэл Улаанбаатарын зарим нэр дэвшигчид веб хуудас ажиллуулах, oloo.mn, news.mn зэрэг хэрэглэгч олонтой веб хуудаснуудад өөрийн сурталчилгаа байрлуулах, тойргийн сонгогчдодоо хандан утсаар мессеж явуулах зэргээр мэдээллийн технологийн шинэ хэлбэрүүдийг коммуникацидаа хэрэглэсэн билээ.

Гурав. Монголын улс төрийн намуудын сонгуулийн кампанид орчин үеийн технологийг хэрэглэх боломж, тулгамдаж буй асуудал

Монголын улс төрийн намууд сонгуулийн кампаниа Өрнөдийн улсуудын жишгээр явуулах тухайд хууль эрх зүйн болон холбоо харилцааны гэх мэт бусад орчин тодорхой

хэмжээгээр бүрэлдсэн юм. Мөн үндэсний хэмжээнд нэвтрүүлэг цацдаг телевизүүдийн тоо 2009 оны байдлаар зургаа, үйл ажиллагаа явуулж байгаа телевизийн тоо 68 болов. Үүний зэрэгцээ өртөг зардал багатай коммуникацийн суваг болох интернэтийн үйлчилгээ эрчимтэй тархаж мэдээллийг богино хугацаанд олон хүнд хүргэх боломжтой боллоо. Гэвч эдийн засаг, нийгэм, соёлын зарим хүчин зүйлээс шалтгаалан орчин үеийн технологийг хэрэглэхэд бэрхшээл учирч байна. Тухайлбал, хөдөөд хэвлэл мэдээллийн хүртээмж, гэрэл цахилгааны хангамж тааруу тул интернэт, телемаркетинг зэрэг орчин үеийн коммуникацийн сувгуудыг хэрэглэх байтугай телевизийн сурталчилгаа явуулахад төвөгтэй байдаг. Мөн сонгуулийн кампанид сурталчилгааны уламжлалт аргуудыг хэрэглэхэд ч бэрхшээл гарах боллоо. Жил ирэх тутам айл өрхөөр ухуулга хийх, ухуулгын материал тараах гэх мэт нүүр тулсан сонгуулийн сурталчилгаа хийх, олон нийтээс санал асуулга авах үйл явц төвөгтэй болсоор байна. Сонгогчдын дунд улс төрөөс хүнийсэх, сонгуулийг үл тоомсорлох байдал газар авсан нь сонгуулийн кампанид сөргөөр нөлөөлж байгаа юм. Энэ байдал нийслэл Улаанбаатарт илүүтэй илэрч байгаа юм.

Мөн коммуникацийн орчин үеийн сувгуудыг сонгуулийн кампанид хэрэглэхэд олон нийтийн дунд буруу ойлголт төрөх, болгоомжлох хандлага ажиглагдаж байна. Телемаркетинг буюу сонгогчдод шууд коммуникаци хийх E-майл явуулах, утсаар мессеж явуулах зэрэг аргуудыг 2008 оны парламентын болон 2009 оны ерөнхийлөгчийн сонгуульд улс төрийн зарим нам, нэр дэвшигчид хэрэглэсэн. Мөн судалгааны зарим байгууллагууд утсаар санал асуулга явуулах оролдлого хийж байсан боловч сонгогчдын дунд энэ төрлийн коммуникацид төдийлөн дасаагүйтэй холбоотойгоор үл ойлголцол үүсэх явдал нэлээдгүй гарсан юм. Хэвлэл мэдээллийнхэн эдгээр үйл ажиллагааг хүний эрхэнд халдлаа, хувийн нууцад нэвтэрлээ гэх мэтээр буруу тайлбарлан нэвтрүүлж байсан.

Дараагийн нэг бэрхшээл бол сонгогчдын зан үйлийн судалгаа, хэвлэлийн мониторинг хийх мэргэжлийн судлаачид, судалгааны байгууллагууд дутагдалтайгаас судалгаа явуулдаг зарим байгууллага, хувь хүн судалгааны асуулгаас эхлээд түүвэр, мэдээлэл цуглуулах, боловсруулах үе шатанд алдаа гаргах, анхдагч мэдээллийг буруу авах зэргээс улбаалан бодит байдалд үл нийцэх чанаргүй судалгаа хийх болсон нь ажиглагдаж байна. Нөгөө талаас сонгуулийн кампанийн үеэр олон нийтийн санал асуулгын дүнг хэвлэлд нийтлэх тухай эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас сөрөг үзэгдлийг бий болгож байна.

Нэр дэвшигчид санал асуулгын дүнг өөрт ашигтай байдлаар хуурамчаар хэвлэн нийтлэх нь ердийн үзэгдэл болов. Ингэхдээ гол төлөв өөрийн нам, нэр дэвшигчдийн рейтингийг өндөр байгаа мэтээр олон нийтэд танилцуулж байлаа. Сонгуулийн кампанийн үеэр олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тараагдсан ихэнх санал асуулга аль нэг нам нэр дэвшигчийн захиалгаар хийгдэж бодит дүнг гажуудуулсан байх нь олонтаа байв. Санал асуулгыг хэвлэлд нийтлэх талаар зохицуулалт байхгүй тул бодит бус дүн мэдээлэл

тараагдаж, улмаар сонгогчид болон улс төрчдийн дунд олон нийтийн санаа бодлын судалгааны дүнд эргэлзэх, үл тоомсорлох байдал газар авч байна.

Сонгуулийн кампанийг амжилттай явуулахад гол үүрэг гүйцэтгэдэг мэргэжилтнүүд болох PR-ийн зөвлөх²³, имиж мейкер, спин доктор, улс төрийн сэтгэл зүйчид ховор, энэ чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжилтнүүд хуруу дарам цөөн байгаагаас улс төрийн нам ба нэр дэвшигчид гол төлөв сэтгүүлчдийг ажиллуулах, тэднээр сонгуулийн кампанийн коммуникацийн үйл ажиллагааг хариуцуулж байгаагаас олон нийтийн санаа бодол, сэтгэл зүйн цаад учир шалтгааныг тооцоолох, улс төрийн бодлогын хувьд мэргэшсэн зөвлөгөө авах боломжгүй байна. Улс төрийн намууд энэ байдлыг даван туулахын тулд бусад улс орнуудаас мэргэжилтэн урьж сургалт хийлгэх, зөвлөгөө авах гэх мэтээр оролдлого хийж байгаа ч төдийлөн хангалттай бус байгаа юм.

Цаашид сонгуулийн систем энэ хэвээр байх уу, пропорциональ юмуу холимог болж өөрчлөгдөх үү гэдгээс улс төрийн намуудын сонгуулийн кампанийн хэв маяг шууд хамаарч өөрчлөгдөх болно. Тухайлбал, пропорциональ системийн үед өнөөгийнхтэй адил хувь нэр дэвшигчдийн имиж чухал үүрэг гүйцэтгэж, тойрогт тэмдэглэлт өдөр хийх, шашны зан үйл, бэлэг сэлт гардуулах байдлаар сурталчилгаа явуулах боломжгүй болно. Тийм учраас улс орныг хамарсан өргөн хүрээтэй, мэргэшсэн кампани явуулах шаардлагатай болох юм.

Судалгаанаас үзэхэд хүмүүсийн мэдээлэл авдаг үндсэн сувгуудын дотор телевиз давамгайлж байгаа ч интернэт гэх мэт бусад сувгийн нөлөө өсч байгаа аж. 2003 онтой харьцуулахад 2008 онд интернэтийн хэрэглээ 3.5 дахин нэмэгдсэн бол мэдээллийн уламжлалт сувгууд болох сонин, радиогийн хэрэглээ бага зэрэг буурч байгаа юм. Ялангуяа нийслэл Улаанбаатарын иргэдийн дунд интернэтийн хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, 63 хувь нь ямар нэг байдлаар интернэт хэрэглэж байгаа юм. Ийнхүү Монгол улсад интернэт хэрэглэгчдийн тоо бусад сувгуудтай харьцуулахад хурдацтай өсөн нэмэгдэж байгаа нь сонгуулийн кампанийн коммуникацийн цаашдын чиг хандлагад эерэгээр нөлөөлөх үндэстэй юм. Учир нь улс төрийн хувьд хамгийн идэвхгүй бүлэг болох залуучуудын дунд интернэтийн хэрэглээ давамгайлж байгаа нь улс төрийн намуудын зүгээс залуучууд руу коммуникаци хийхдээ интернэтийг ашиглах хямд бөгөөд үр дүнтэй боломжийг нээж байгаа юм.

Өнөөгийн улс төрийн үйл явц, сонгогчдын зан үйлийн чиг хандлагаас харахад цаашид улс төрийн намуудын хувьд сонгуулийн кампанийг явуулах нь өнөөгийнхтэй харьцуулахад ихээхэн бэрхшээл төвөгтэй үйл ажиллагаа болох төлөвтэй байна. Өрнөдийн орнуудад 1980-аад оноос эхэлсэн улс төрөөс хүнийсэх үйл явц Монголд мөн

²³ Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг PR-ийн мэргэжилтнүүдийг олон улсын жишгээр зөвлөхүүд гэдэг. Харин манайд пиарчид, пиаршик гэх мэтээр нэрлэж байгаа нь учир дутагдалтай юм.

ажиглагдаж байна. Сонгогчдын идэвх буурч, улс төрөөс хүнийсэх боллоо. Тийм учраас улс төрийн намуудын хувьд мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдээ сурталчлан таниулахаас гадна өөрийн дэмжигч сонгогчдоо сонгуульд оролцохыг уриалах давхар ажил нэмэгдэж байгаа юм. Улс төрийн намууд сонгуулийн кампанийг сүүл үеийн арга технологиор, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор, сонгогчдын санаа бодол, сэтгэл зүйн онцлог, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа зэргийг харгалзан өндөр түвшинд явуулж байж л ялах боломжтой болно.

Сонгуулийн кампанийг хөгжингүй улсуудын жишгээр явуулахын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай юм. Үүнд:

- Сонгуулийн кампанийн үеэр улс төрийн намууд, нэр дэвшигчид, судалгааны байгууллагуудын зүгээс олон нийтийн санаа бодлын судалгааны дүнг нийтлэх, нэвтрүүлэх талаар эрх зүйн зохицуулалт хийх. Тухайлбал, уг судалгааг захиалагч, судалгаа хийсэн байгууллага, судалгааны арга зүй, түүвэр, алдааны хязгаар, судалгаа явуулсан хугацаа зэргийг тодорхой зааж нэвтрүүлэх хэрэгтэй байна.
- Сонгогчдын хамгийн хүсүүштэй сурталчилгааны хэлбэр нь халз мэтгэлцээн байдаг тул сонгуулийн кампанийн үеэрх халз мэтгэлцээнийг асуулт хариулт бус олон улсын жишгийн дагуу мэтгэлцээн хэлбэрээр явуулдаг болох. Үүний тулд улс төрийн намууд харилцан тохиролцож мэтгэлцээний журам, зохицуулалтыг нарийвчлан гаргадаг болох.
- Сонгогчдын хамгийн идэвхгүй хэсэг болох залуучуудын бүлэгт сурталчилгаа хүргэхийн тулд веб хуудас, чат, E-майл ашиглах нь үр дүнтэй. Учир нь залуучуудын хувьд нэр дэвшигчтэй хийх уулзалт, арга хэмжээнд очдоггүй, айл өрхөөр тараасан ухуулга сурталчилгааны материал уншдаггүй тул тэдэнд хүрэх гол суваг бол телевиз болон интернэт юм. Мөн цаашид гадаадад суугаа сонгогчдын саналыг авах нь хуулиар нээлттэй болсон тул интернэт нь эдгээр сонгогчдод хүрэх хямд бөгөөд үр дүнтэй хэрэгсэл болох юм.
- Монголын сонгогчдын оролцоо буурч, улс төрөөс хүнийсч байгаа тул тэднийг сонгуульд татан оролцуулах, амжилттай кампани явуулахын тулд сурталчилгааны өнөөгийн хэв маягийг өөрчлөх. Тухайлбал, сурталчилгааны үеэр айл өрхөөр ухуулга сурталчилгааны товхимол тараах, сонгогчдод бэлэг сэлт гардуулах гэх мэт уламжлалт хэлбэрүүдээс татгалзах, телевизийн сурталчилгаа, ток шоуны хэв маягийг сонирхолтой, цэнгээнт өнгө аястай болгон өөрчлөх хэрэгтэй юм.
- Улс төрийн намуудын сонгуулийн кампанийн бүхий л үйл ажиллагаанд мэргэжилтнүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, шинжлэх ухааны үндэстэй судалгаа, зөвлөгөө, имиж мейкинг, маркетингийн үйл ажиллагааг ашигладаг болох.

Ном зүй

Монголын хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа. 2009. 3 сар
Д.Бадамдаш, Ц.Мөнхцэцэг, Г. Цогтбаатар “Монголын сонгуулийн кампанийн хэв маяг,
улс төрийн намуудын сонгуулийн стратеги” нарын хамт. Монгол дахь сонгуулийн үйл явц:
онол, практик. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ. 2009. 52-72
дахь тал

Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци: Монгол улсын жишээн дээр.
Диссертаци. УБ. 2009

Barak Obama Presidential Campaign, 2008. <http://en.wikipedia.org> веб хуудаснаас 2009 оны
9 сарын 28-нд татаж авлаа.

Darren G. Lilleker. (2006) Key Concepts in Political Communication. Sage Publications,
London

Michael Weigl (2009). Election without campaign.
<http://aicgsgermanelection2009.blogspot.com> веб хуудаснаас 2009 оны 10 сарын 16-нд
татаж авлаа.

Peter Schneider (2009). Germany's election campaign is a crashing bore, but it shouldn't be.
The Daily Star. September 24, 2009.

Swanson, P.Mancini. (1996) Politics, Media and Modern Democracy: An International Study of
Innovations in Electoral Campaigning and their Consequences. London

Tenscher Jens. (2003) Professionalisierung der Politikvermittlung? Politikvermittlungsexperten
im Spannungsfeld von Politik und Massenmedien, VS Verlag fuer Sozialwissenschaften,
Wiesbaden

УЛС ТӨРИЙН НАМЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

С.Мөнхбат

доктор

МУИС, НШУС-ийн Сургалтын албаны эрхлэгч

С.Зүльфикар

доктор

Удирдлагын Академи, Нийгмийн Удирдлагын тэнхмийн эрхлэгч

Оршил.

Нам бол нийгэмд тодорхой үүрэг хүлээдэг улс төрийн институт юм. Улс төрийн намын нийгэмд хүлээдэг үүрэг нь түүний мөн чанартай холбоотой. Улс төрийн намын мөн чанар нь нийгмийн хөгжил дэвшлийг хангахын төлөө бодлого хөтөлбөр дэвшүүлж түүнийгээ сонгогчдоор үнэлүүлэх замаар засгийн эрхийг авах, үгүй ядаж түүнд оролцохын төлөө эрмэлзэж үйл ажиллагаа явуулж байдгаар илэрдэг. Ийм учраас аливаа намын нийгэмд хариуцлага хүлээх байдал нь тухайн намын оршин байх үндэс, нийгэм-улс төрийн амьдралыг удирдан зохион байгуулах чадвараар хэмжигдэнэ. Учир нь улс төрийн нам ерөөсөө өөрийн, бас гишүүдийнхээ төлөө байдаг иргэний нийгмийн байгууллага ч биш, нийгмийн хөгжил дэвшлийг хангах бодлогтой түүнийгээ хэрэгжүүлэх зорилгод чиглэн ардчилсан сонгуулиар засгийн эрхийг авахын төлөө ажилладаг улс төрийн байгууллага. Нийгмийн төлөө гэдэг нь парламент, засгийн газрын бодлогоор дамжуулан ард түмнийг сайн сайхан амьдралд хүргэх улс төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж ажиллахыг хэлэх бөгөөд нийгмийн зүгээс тийм байхыг хүсэн дэмжлэгийг үзүүлж мөн хариуцлагыг үүрүүлж байдаг.

Хариуцлага нь (Турк – sorumluluk, Араб –Mes’uliyet , Хятад – ze reng) аливаа хүн, этгээд өөрийн эрх үүрэгт хамаарч байгаа зүйлс, үйл ажиллагааны үр дүн, үр дагаварыг бүрэн хариуцах гэсэн ойлголтыг илэрхийлж байна. Англи – responsibility, франц- responsabilite гэсэн нэр томъёо нь response -хариу үйлдэл; хариуцах, ability - чадах, чадвар гэсэн холбоос үг бүтээж байгаа бөгөөд ямарваа үйлдэл, үйл ажиллагааг хариуцах чадвар гэсэн утга илэрхийлж байна. Хариуцлага гэсэн ойлголтыг орос - ответственность, Герман - verantwortung гэж томъёолсон нь мөн дээрхийн адил утга санаа агуулж байна. Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толь бичигт хариуцлагыг “харилцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн” гэсэн утгаар тайлбарлажээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс хэвлүүлсэн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д хариуцлагыг харилцах үйлийн нэр, ажил үүргийг биедээ хүлээсэн байдал гэж тодорхойлсон байна.

Хариуцлага гэсэн ойлголт нь хамрах хүрээ, шинж чанар, үйлчлэх орчноосоо үүдэн янз бүрийн хэлбэртэй байж болно. Тухайлбал, хувь хүн, гэр бүл, нийгмийн бүлэг, ёс суртахуун, хууль, улс төр, эдийн засгийн хариуцлагын тухай ярьж болно. Нийгмийн хариуцлага гэсэн ойлголт нь англи хэлэнд – social responsibility гэсэн хоршоо үгээр томъёолсон байна. Түүнчлэн хариуцлагыг чанарын ойлголт болгож үзэхийн зэрэгцээ түүнийг хэмжиж тооцож болох үзэгдэл, үйл явцын үр дүн, үр дагавар гэж үзсэний үндсэн дээр social accountability гэж Дэлхийн банкнаас гаргасан албан баримт бичгүүдэд бичсэн байна.²⁴

Ямартай ч хариуцлага бол (англи- social responsibility) нийгэмтэй хамт үүссэн бөгөөд түүнийг илэрхийлсэн ухагдахуун нь философийн гүн гүнзгий утгатай. Хариуцлага нь Өрнийн хийгээд Дорно дахины орнуудад харилцан адилгүй ойлгогдож, хэрэгжиж ирсэн байдаг. Өрнө дахинд хуулийг дээдэлдэг, хуулийн өмнө бүх нийтээрээ тэгш байх, хууль бүхнээс дээгүүр засагладаг эрх зүйт төр оршин тогтнож эхэлснээс хариуцлагыг чухалжилж үзсэн бол Дорно дахинд ёс суртахууны хэм хэмжээг үйл байдалдаа шингээж хариуцлагыг бараг өөрөө өөртөө хүлээлгэдэг тогтолцоо хэмээн үзэх үзэл олон зууны турш ноёрхож ирсэн юм. “Ийм болохоор ёс суртахууны үзэгдэл болсон хариуцлагыг нийгэмтэй холбон авч үзэхдээ нийгмийн философи, бүр тодруулбал ёс зүйн философийн асуудлууд руу халин ордог нь”²⁵ Дорнын онцлог юм.

Манай философич, эрдэмтэн Б.Даш-Ёндон “Нийгмийн хариуцлагын асуудал бол ёс суртахууны асуудал юм...хариуцлага алдана гэдэг нь хүн гэдэг амьтан амьдралынхаа ноцтой нэгэн зарчмыг, ёс суртахууныхаа зайлшгүй чухал нэг ойлголтоо алдаж байна гэсэн үг” хэмээн *Улс төр ба нийгмийн хариуцлага* сэдэвт өгүүлэлдээ бичжээ. Тэрээр мөн хариуцлага ба үүргийн ялгааг гаргахдаа Америкийн улс төрийн философич Л.Штраус, улс төрийн сэтгэл судлаач Э.Фромм нарын “хариуцлагын өөрийн утга нь солигдож буй тухай эсхүл энэ үгийг “үүрэг” гэдэг үгийн утгаар сольж ярьдаг болсон тухай” санааг үндэс болгож Монголын нөхцөлд хэрхэн хэрэглэж буйг тодруулахдаа “хариуцлагатай ажил алба”, “хариуцлага хүлээхэд бэлэн”, “хариуцлагыг хүлээнэ” гэсэн үгнүүдийг жишээлж “хэрэв үүрэг, хариуцлага гэдэг үгүүдийг адитган ойлгоно гэвэл, тэгээд хариуцлагын утгыг үүргээр солино гэвэл дээр хэлсэн “хариуцлагатай ажил алба” гэдэг нь “үүрэгтэй ажил алба” гэсэн монгол хэлэнд байдаггүй утгагүй хэллэг гарч ирнэ, бас “хариуцлага хүлээхэд бэлэн” гэсэн үг нь “үүрэг хүлээхэд бэлэн” гэсэн санаа болчихно, гэтэл энэ хоёр санаа бие биедээ сөрөг утгатай билээ. **Үүрэг хүлээгээд биелүүлээгүйн муу үр дагавар нь**

²⁴ World Bank Institute, Social Accountability in the Public Sector: A Conceptual Discussion and Learning Module, 2005, Washington D.C. USA .

²⁵ Б.Даш-Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. Эрдмийн ертөнц. УБ., 2009

хариуцлага хүлээх, хариуцлагад унах явдал юм²⁶ гэж үүрэг, хариуцлагын хоорондын ялгааг философи агуулгаар тодорхой гаргасан байна.

Энэ бүхнээс үзэхэд хариуцлага бол зөвхөн хүний л өвөрмөц мэдрэхүй, үйл ажиллагааныхаа үр дүнг хүлээх чадвар болж таарч байна. Хүн ч бай, хамт олон ч бай, улс төрийн нам ч бай, нийгэм ч бай хувь заяаныхаа эзэн байх нь хариуцлагын агуулга мөн. Ингэж үзвэл *“хариуцлага гэдэг нь ямар нэгэн хохирол гаргахгүй байх эрмэлзлэл мөн бөгөөд хариуцлага хүлээх гэдэг нь гарсан хохиролыг (эд материалын хийгээд оюун санааны) нөхөх, арилгах явдал”*²⁷ юм.

Аливаа хариуцлага нь түүнийг хүлээх эзэнтэй байх учиртай. Ингэхлээр хариуцлага бол ухамсарлагдсан байх бөгөөд ухамсарласан мөртөө зөрүүлж үйлдвэл хариуцлага алдаж буй хэрэг болно. Ийм учраас энэ бүхнийг бичмэл хууль болон ёс суртахууны хуулиар зохицуулдаг нийтлэг жишгийг хүн төрөлхтөн бий болгожээ. Энэхүү зохицуулалт нь зөвхөн нийт нийгмийн шинжтэй байх ёстой бөгөөд эндээс нийгмийн хариуцлага гэдэг ойлголт гарч ирнэ.

Иймд бид улс төрийн хариуцлагаар дамжсан нийгмийн хариуцлагын асуудлыг улс төрийн нам дээр жишээлэн авч үзэхийг энэхүү илтгэлийг гол зорилго болголоо.

Улс төр ба нийгмийн хариуцлага.

Улс төрийг нийгмийн хариуцлагатай холбоно гэдэг нь нийгмийн хариуцлагын тухай ойлголтыг ёс суртахуунтай холбож үзнэ гэсэн үг бөгөөд цаад мөн чанараараа улс төр бүхэлдээ “хариуцлага” гэсэн утга санааг тээж явдагт гол утга учир оршино. Өөрөөр хэлбэл улс төр нь алдаа гаргахгүй байх эрмэлзлэл байдаг бол хариуцлага нь хохирол гаргахгүй байх эрмэлзлэл юм²⁸.

Улс төрийн хариуцлага нь үйл явц болохынхоо хувьд улс төрийн зорилго, ашиг сонирхол, хэм хэмжээ ба итгэл найдвар, хариуцлагатай үйл ажиллагаа, түүний үр дагавар гэх мэт үндсэн ойлголтуудтай холбогдож улам тодордог. Иймд улс төрийн хариуцлага нь улс төрд оролцогчдын үйл байдал ба улс төрийн үйл ажиллагааных нь үр дагавартай холбогдуулан улс төрийн субъектэд хандах хандлагыг тодорхойлдог нийгмийн хариуцлагын нэг төрөл болдог юм. Харин нийгмийн хариуцлага нь бусад хэлбэрийн хариуцлагаа нэгтгэгч, зангидагч, агуулагч шинжтэй. Хүн ч бай нийгэм ч бай хувь заяаныхаа эзэн байх нь хариуцлагын агуулга мөн. Энэ санааг иш үндэс болгон давтан хэлэхэд хариуцлага гэдэг нь хохирол гаргахгүй байх эрмэлзэл юм.²⁹

²⁶ Б.Даш-Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. Эрдмийн ертөнц. УБ., 2009

²⁷ Б.Даш-Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. Эрдмийн ертөнц. УБ., 2009

²⁸ Мөн тэнд

²⁹ Б.Даш-Ёндон. Философи сэтгүүл, х-11. УБ.,2009

Ийнхүү улс төр бол хариуцлага юм гэсэн ойлголтын гаргалгааг хийхэд хүргэж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл улс төрийн намын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа нийгэмд хохирол учруулахгүй байх нь улс төрийн намын нийгмийн хариуцлага болон гарч ирнэ гэсэн үг.

Улс төрийн шинжлэх ухаанд нийгмийн хариуцлагыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хоорондын тэнцвэр, харилцан хяналтын тогтолцоогоор дамжуулан төрийн албан тушаалтныг нээлттэй бөгөөд тогтмол хугацаанд шагнах буюу шийтгэх арга зам гэж үздэг. Өөрөөр хэлбэл “төр засаг, төрийн удирдлагын зүгээс нийгмийн хүлээлтийг хангахад чиглэсэн үүргийн биелэлтийг илэрхийлэх ойлголт юм”³⁰ Иймд хамгийн өргөн хүрээнд нийгмийн хариуцлагын тухай асуудал хөндөгддөг бөгөөд нийгмийн хариуцлагад төрөөр дамжуулж бодлогоо нийгэмд хүргэдэг улс төрийн намын хариуцлагын асуудал онцгой байр суурьтай. Эндээс *намын нийгмийн хариуцлагыг харилцан хүлээсэн үүрэг ба хамтарч тогтоосон дүрэм журмыг зайлшгүй биелүүлэх болон тэдгээрийг зөрчсөн тохиолдолд шийтгэхэд бэлэн байх явдалд үндэслэсэн бөгөөд, шагнал нь улс төрийн дэмжлэгээр (дэмжиж санал өгөх, сонгуулийн сурталчилгаанд нь оролцох, эерэг ухуулга хийх гэх мэт), шийтгэл нь улс төрийн эс дэмжлэгээр (санал эс өгөх, эсэргүүцэх, сөрөг сурталчилгаа хийх гэх мэт) тус тус илэрдэг, улс төрийн хүрээн дэх субъектүүдийн харилцан үйлдэлд суурилж, итгэлцэл, бодит байдлын хоорондын харилцааны нийлэмжээр илэрхийлэгдэж байдаг нийгэм-улс төрийн тогтсон механизм гэж үзэж болно.*

Намын нийгмийн хариуцлага нь улс төрийн хариуцлагын шинжийг өөртөө бүрнээ агуулж, нийгмээс намыг үнэлэх үнэлгээ нь иргэд сонгуулиар дэмжиж санал өгөх, эс өгөх, улс төрд нааштай болон сөрөг хандах зэрэг олон үнэлэмжийн цогц илэрэл болж байдаг. Намаас нийгмийн өмнө хүлээх хариуцлагын хамгийн оргил нь намаас төртэй харилцах харилцаа тэрхүү харилцааны шинж, агуулгад байдаг бөгөөд нам нь өөрийн ашиг сонирголоос илүүтэйгээр нийгмийн сонирхлыг илэрхийлж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллан, төрийн бодлогоор дамжуулж нийтийн өмнө хариуцлага хүлээнэ. Хариуцлага тооцох үйл ажиллагааг иргэд эсвэл иргэний нийгмийн байгууллага явуулна.

Улс төрийн намыг нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэж байдаг албан ёсны бүлэг, нэгдэл гэж тодорхойлдог билээ. Орчин үеийн парламент ёсны төлөвшил нь улс төрийн намын үүсэл, хөгжлийг түргэтгэсэн гэж улс төр судлаачид үздэг. Иймд улс төрийн намын нийгмийн хариуцлагыг нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг ихэсгэх, сөрөг нөлөөг багасгах үүргээр тодорхойлж болохоор байна. Нийгмийн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас хариуцлага нь эерэг болон сөрөг хандлагатай байна.³¹ Өөрөөр хэлбэл энэ нь улс төрийн намын функционал шинж юм. Цаашилбал функционал намын тухай асуудал

³⁰ Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006

³¹ Чулуундолгор. Философи эрхийн судлал. XXIII боть, х-167. УБ., 2008

ч үүнээс үүдэлтэй гарч ирсэн юм. Иймд улс төрийн намын функционал шинж чанарыг шалгуур болгон нийгмийн хариуцлагын хэлбэр, хамрах хүрээг авч үзэх нь тухайн асуудлын онолын болоод прагматик уялдаа холбоог шинжлэх боломж олгож байна.

Улс төрийн намын нийгмийн үүрэг буюу нийгмийн харилцаанд түгээмэл гүйцэтгэх функцийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Нийгмийн төлөөллийг хангах
- Элитүүдийг төлөвшүүлэх, сонгох, томилох
- Улс төрийн бодлого боловсруулах
- Улс төрийн бодлого, шийдвэрээ нийгэмшүүлэх
- Нийгмийн зөвшилцөлийг хангах, эв нэгдийг бэхжүүлэх
- Нийгэм дэх сонирхлын бүлгүүдийн хүсэл сонирхлыг агрегацчилах
- Төр, засгийг эмхлэн байгуулах, тогтворт байдлыг хангах, чадваржуулах зэрэг болно.

Намын нийгмийн хариуцлагын механизм нь *гадны* буюу *босоо*, *дотоод* буюу *хэвтээ* гэсэн хоёр чиглэлтэй байдаг.


Нэг. Хариуцлагын босоо тогтолцоо нь улс төрийн нам, улс төрийн элит, лидерүүдээс олон нийттэй харилцах харилцааг илэрхийлэх ба энд ард түмэн гол хянагч нь байна. Өөрөөр хэлбэл энд сонгуулиар сонгогдсон эрх баригч улс төрийн хүчнүүд хийгээд бусад намуудыг сонгогч олон түмэн, ард иргэдтэй холбож хариуцсан ажлаа тайлагнахад нь гүүр болж өгдөг бүхий л тогтолцоо, институтуудын хэлхээ холбоог хамруулна.

Улс төрийн намын хариуцлагын босоо чиглэл нь ихэвчлэн сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг асуудлаар дэвшигдэн тавигдах нь олонтаа байдаг. Нөхцөл байдал, цаг хугацаа, эдийн засгийн боломжоо бодитой үнэлж чадалгүй дан ганц улс төрийн зорилгоор нийгмийн амлалт өгч, төлөөллийн эрх олж аван улмаар үүнийгээ гүйцэлдүүлж чадахгүй байх нь тухайн улс төрийн нам нийгмийн төлөөлийн үүргээ биелүүлээгүй буюу нийгмийн хариуцлагаа алдаж буйн нэг илрэл болно. Улмаар энэ байдал нь сонгогчдын улс төрийн намуудад итгэх итгэл, сонгуулийн оролцоог бууруулдаг. Тухайлбал, 1992 оноос хойш явагдсан парламент, ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулиудын оролцоо, идэвхийг харьцуулж үзвэл сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчдын оролцоо буурч байгаа бөгөөд үүний цаад шалтгаануудын нэг нь улс төрийн намуудын нийгмийн хариуцлага улам бүр суларч ирсэнтэй холбоотой.

Сонгогчдын сонгуулийн ирц буурах нийтлэг зүй тогтол ардчилсан дэглэмтэй олон улс оронд, нэн ялангуяа хөгжингүй улсуудад ажиглагдаж байгаа хэдий ч Монголд нийгмийн гишүүдээс улс төрд хандах хандлага, сонирхол, хамаарал өндөр байдаг

нөхцөл байдлыг шалгуур болгох аваас сонгуулийн ирц буурч байгаа нь улс төрийн намуудын хариуцлагагүй үйл ажиллагаатай ямар нэг байдлаар холбогдож байна. /зураг .1/

Сонгуулийн оролцооны бууралт



Сүүлийн үед сонгуульд нэр дэвшүүлэх, сонгуулийн үр дүнг харгалзан улс төрийн томилгоо хийх, төр засгийн өндөр албан тушаалд томилогдсон хүмүүс өөрийн багаа бүрдүүлэхэд мэдлэг боловсрол, туршлага дадлага, мэргэжлийн ур чадвар зэрэг шалгуурыг биш, харин улс төрийн намыг хөрөнгө санхүүгээр болон бусад хэлбэрээр дэмжсэн, улс төрчдөд үнэнч зүтгэсэн, нутаг ус, садан төрлийн болон нэг ангид суралцаж байсан зэрэг албан бус шалгуурыг урьтал болгодог практик тогтох хандлагатай боллоо. Энэ байдлаас болж өнөөгийн “Монголын засаг төрийн, цаашилбал улс төрийн хүрээний элитүүдийг улс төр-эдийн засгийн бүлэглэлүүд бүрэлдүүлж байна”³² гэсэн санаа бодол олон түмний дунд газар авч байна. Энэ бол нам нийгмийн хариуцлагаа буруу ухамсарлаж олны хүндэтгэлийг хүлээх байдал нь дордож буй нэг илрэл мөн.

Улс төрийн өндөр мэдлэг чадвар, туршлагатай хүний нөөц бүрдүүлэх, тэднийг улс төр, төрийн албанд байршуулах нь улс төрийн намын хүний нөөцийн төдийгүй нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн чухал бодлого байдаг. Хүний нөөцийн бодлого нь дан ганц чадварлаг улс төрчдийг бэлтгэх, сонгох, томилох үйл ажиллагаа байгаад зогсохгүй намын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн хариуцлагатай улс төрийн хүчин байх нөхцөл мөн билээ. Намын хүний нөөцийн алдаатай бодлого нь төрийн ажил, үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлдөг нь сүүлийн жилүүдэд төрийн ажил, үйлчилгээнд иргэдээс ирүүлж байгаа шүүмжлэл, өгч байгаа таагүй үнэлгээ зэргээс илэрхий байгаа бөгөөд улс төрийн намуудын боловсон хүчний алдаатай бодлого нь

³² АЗШҮБТ: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006. 62 дахь тал

намын нэр хүндийг ихээр унагаж, түүний нийгмийн хариуцлагыг сулруулахад хүргэж байна.

Зүүн Азийн Барометр судалгааны дүнгээс үзэхэд Монголд ардчиллын тулгуур институт дотроос нам хамгийн бага үнэлгээтэй буюу олон нийтийн дунд итгэл даахгүй гэж үзэх институтуудыг тэргүүлж³³ байгаа бол АЗШҮБТ-ийн судалгаагаар намуудад итгэх итгэл буурсан гэж судалгаанд оролцогсодын 35.4 хувь үзсэн бол 55.2 хувь нь намуудад итгэх итгэлд өөрчлөлт ороогүй гэж, харин зөвхөн 9.1 хувь нь итгэл нэмэгдсэн³⁴ гэж тус тус хариулсан нь намууд нийгмийн хариуцлагаа хэр зэрэг биелүүлж байгааг харуулсан үнэлэлт юм.

Мөн сонгуулийн кампанит ажил шударга, ил тод, хуулийн хүрээнд явагдах зарчим ихээхэн гажуудаж байгаа нь намын нийгмийн хариуцлага суларсантай холбоотой билээ. Сонгууль хэдийгээр намын нийгмийн хариуцлагыг дүгнэдэг шалгалт мөн боловч нөгөө талдаа намуудын нийгмийн хариуцлаггүй үйл ажиллагаа, үйлдэл хийх боломжийг сонгууль олгож байгаа нь хаа хаанаа цаашид анхаарвал зохих асуудлууд их байгаа нь харагдаж байна. Ийм байдлын тодорхой жишээ бол сонгуульд бие биетэйгээ “мөнгө”-өөр өрсөлддөг жишиг тогтож, “намууд хамаагүй юм амлаж өр тавьчихаад салам нэхэгддэг, сонгогчдыг буруу зуршилд дасгаж, сонгуулийг нэг нь мөнгө салгах, нөгөө нь өр тавьж хахуульдаж байгаад ч хамаагүй өндөр албан тушаалд хүрдэг”³⁵ арга болтол нь гажуудуулсан явдал бол намууд нийгмийн хариуцлагаа алдсаны хамгийн том жишээ мөн.

Судалгааны байгууллагын хийсэн судалгаанаас эрх барьж буй хоёр намаас нийгэм юу хүлээж байгааг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд эхний гуравт а. *амлалтаа биелүүлж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх*, б. *шударга байх*, в. *эх орны хишгийг өгөх*³⁶ гэсэн гурван асуудлууд орсон байна.


Эх орны хишгийг өгөх эсэхт өгсөн иргэдийн хүлээлт

³³ Зүүн Азийн Барометр судалгаа. УТБА. УБ., 2005

³⁴ АЗШҮБТ: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006.70 дахь тал

³⁵ Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006. 63 дахь тал

³⁶ ММСГ-ээс явуулсан “Монголын улс төрийн өнөөгийн нөхцөл, байдал” сэдэвт социологийн судалгаа. УБ., 2009. 8 сар



Эх сурвалж: “Монголын улс төрийн өнөөгийн нөхцөл, байдал” сэдэвт судалгаа. ММСГ. УБ., 2009. 8 сар.

Өнөөдөр Монголын нийгмийн харилцааг 400 гаруй хууль зохицуулж байгаа гэх боловч хуулиас гадуур амьдрал “цэцэглэсэн” хэвээр байна. Хуулиас дээгүүр эсвэл хууль зөрчсөн аргаар хэрэгцээгээ хангаж, ажил хэргээ бүтээдэг ёс тогтсон нь нийгмийн шударга ёсыг үгүйсгэж, олон нийтийн дургүйцлийг нэмэгдүүлж байна. Үүнтэй шууд холбоотой асуудал бол авилгал юм. Авилгалтай хамгийн их нэр холбогддог институт бол улс төрийн нам. Монгол улс олон улсын байгууллагын судалгаагаар авилгал багатай орны байрнаас хойш ухарсаар байна. Авилгалын индексээр 75 хувьтай байна. Сонгуульд нэр дэвших, улс төрийн өндөр албан тушаалд томилогдох зэрэг намаас гардаг улс төрийн шийдвэрүүд ямагт авилгалтай холбоотой хардалт сэрдэлтийг дагуулдаг нь нийгмийн сэтгэл зүйд нам авилгад өртөмтгий байгууллага гэдэг үнэлэмжийг төрүүлэхэд хүргэж байгаа юм.

Дэлхийн банкнаас санал болгосон нийгмийн хариуцлага хүлээх 5 хэмжээсийн хүрээнд улс төрийн намын нийгмийн хариуцлага хүлээх чадварыг намын нийгмийн үүрэгтэй холбож тайлбарлах байдал сүүлийн үед нэлээд дэлгэрч. Үүнд:

- Нийгмийн хариуцлагыг сэдэлжүүлэх бүтэц (Incentive structure). Намын гишүүдийн ёс зүйн кодекс болон нийгмийн хариуцлагатай гишүүдийг урамшуулах (хариуцлагатай албан тушаал, ажил үүрэгт томилох гэх мэт) харилцаа нь намын удирдлага, улс төрийн ажилтан, гишүүдийн дунд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх буюу сэдэлжүүлэх үндэс юм.
- Нийгмийн хариуцлага хүлээх хэлбэр (Accountability for what). Нам өөрийн бодлого, үйл ажиллагаа, улс төрийн лидерүүдийн алдаатай болон буруутай үйл ажиллагааг хэрхэн үнэлж цэгнэж байгаа нь нийгмийн хариуцлагын хэлбэрийг тогтоох шалгуур болно. Өөрөөр хэлбэл чухам юунд, юуны төлөө хариуцлага хүлээх вэ гэдэг нь тодорхой байх ёстой.

- Институтчлалын түвшин (Level of institutionalization). Нийгмийн хариуцлагыг хангах бүтэц зохион байгуулалт, механизм нь намын улс төрийн үйл ажиллагааг нийгмийн хариуцлагатай болгоход үйлчилдэг.
- Оролцооны түвшин (Depth of involvement). Намын дотоод ардчилал, гадаад нээлттэй байдлын түвшин нь улс төрийн намын нийгмийн хариуцлагын түвшинг тодорхойлох нөхцөл болно.
- Оролцооны хамралт (Inclusiveness of Participation). Намын бодлого, шийдвэр, үйл ажиллагаанд нийгмийн ямар төлөөллийг хамруулж байгаа нь нийгмийн хариуцлагын бас нэг шалгуур болдог байна.

Өнөөдөр Монголд УИХ, Засгийн газрын түвшинд сонгогчдын өмнө хүлээх хариуцлагаас намын үүрэг даалгавар, сахилга батын асуудал чухал, засгийн газрыг хянах бодит хяналтгүйгээр, түүнийг дэмжих талдаа байдаг нь хариуцлагын босоо тогтолцоо хэрэгжихэд саад учирдаг талаар судлаачид өгүүлдэг. Хариуцлагын босоо тогтолцоонд улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагууд нь иргэдийнхээ ашиг сонирхол, эрэлт хэрэгцээг илрүүлэн гаргах, нэгтгэн боловсруулахад чухал бөгөөд төр, засаг нь эдгээр ашиг сонирхлыг бодлого хөтөлбөр болгон болвсруулах чадамжтай байх ёстой. Энэ нь төр засгийн ил тод байдлаас шууд хамаарна³⁷. Хариуцлагын энэхүү гинжин холбоосын эцсийн шатанд уг үйл явцыг баталгаажуулах эрх мэдлээ урвуулан ашиглах, авилгалаас сэргийлэхэд хариуцлагын энэхүү тогтолцоо чухал юм.

Хоёр. Улс төрийн намын нийгмийн хариуцлагын хэвтээ чиглэлийн үндсэн зарчим нь улс төрийн аливаа шийдвэрийн талаар намын гишүүд, дэмжигчид болон тухайн намын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд асуулга тавьсан тохиолдолд тэд хариулах тайлагнах үүрэгтэй байхад чиглэнэ. Энэ нь мэдээлэл, тайлбар, үндэслэгээ, дэмжлэг зэргийн үйлчлэлээр илэрнэ. Монголд энэ чиглэлийн хариуцлагын асуудалд нам, намаас нэр дэвшиж сонгуульт алба хашиж буй албан тушаалтны хоорондын харилцаанд нэлээдгүй маргаан дэгдээж, өнөө хүртэл нарийн зохицлыг олоогүй зүйлүүд цөөнгүй илэрдэг. Юуны урьд энд нам, парламентын гишүүний харилцааны асуудал хамаарна. Парламентын гишүүний намын өмнө хүлээх хариуцлага, намын сахилга батыг хэрхэн сахих талаар хуулийн нарийн зохицуулалт байдаггүйээс аль нэг улс төрчийн алдаатай бодлого, үйл ажиллагааны “гор”-ыг нам амсдаг байдал нь намын нийгмийн хариуцлагыг унагах нэг нөхцөл болж байна. УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх, эргүүлэн татах нөхцөлд намын бүлгийн оролцооны талаар заалт байхгүй, намын гишүүний хувьд парламентын гишүүнд хариуцлага тооцох харилцаа хуулиар зохицуулагдаагүй зэрэг эрх зүйн шинжтэй төгс бус харилцаанууд намын хэвтээ чиглэлийн хариуцлагыг дээшлүүлэхэд тээг болж байна.

³⁷ Н.Чулуундолгор. Улс төрийн хариуцлагын тухай. Философи эрхийн сэтгүүл. XXIII боть. УБ., 2008

УИХ-ын тухай хуульд УИХ-ын гишүүн нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлэгт заавал орж ажиллах ёстой гэсэн хатуу заалт байхгүй ба тухайн бүлгийн харъяаллаас татгалзсан тохиолдолд өөр бүлэгт нэгдэн орж болох тухай³⁸ заалт байдаг. Хуулийн энэ заалт, зохицуулалтаас гардаг сөрөг үр дагавар нь намын хэвтээ чиглэлийн хариуцлагад илрэхдээ намын нэгдсэн бодлогыг үл ойшоох, ашиг сонирхлын үүднээс өөр намын бүлэгт орж ажиллах зэрэг намын нийгмийн хариуцлагатай холбоотой асуудлууд дээр маргаантай зүйлүүд цаашид нэлээдгүй гарах нөхцөл болж байна.

Манайд парламентат ёсны жишгээр улс төрийн чадварлаг сөрөг хүчин төлөвшиж чадаагүй байгаа нь намын нийгмийн хариуцлагыг тооцоход хүндрэл учруулж байгаа юм. “Сөрөг хүчнүүд эрүүл саруул үзэл бодол, санаа оноогоо уралдуулж, эрх баригчдыг онож шүүмжилж, улс орны хөгжилд дэм үзүүлэхээсээ илүү ямар үнэ цэнээр ч болов нэр олж авах “шоу” хэт хөөцөлддөг гажгаас салж чадахгүй байна. Чухам үүнтэй зохиомол улс төржилт холбоотой бөгөөд энэ нь нийгмийг хардалт сэрдэлгээр амьсгалахад хүргэж хүлцэл тэвчил, харилцан ойлголцол, зөвшилцөл, итгэлцэл, хамтран ажиллах ёс алдагдаж нэг үгээр нүдэнд үл үзэгддэг нийгмийн үнэт капиталыг үрэн таран хийж байна. Намчирхах явдлаас болж төрийн байгууллагын ажил хэрэг төдийгүй нийгмийн эрх ашигт хохирол учрах болов”³⁹. Нийгэмд өрнөж буй энэ бүх үйл явц нь улс төрийн намын нийгмийн хариуцлага ихээр унасныг харуулж буй бөгөөд цаашид улс төрийн намын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхийн тулд дараах алхмуудыг хийх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд,

1. Улс төрийн намууд үзэл баримтлал, үнэт зүйлсээ нийгмийн орчин, нөхцлөөс тодруулан гаргаж, амьдралд хэрэгжүүлэх, намын бодлогын шинжлэх ухаанч байдлыг нэмэгдүүлэх
2. Намууд сонгуульд хэрэгжихүйц амлалт, мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж ажиллах, үр дүнг тооцох механизмыг төлөвшүүлэх
3. Намын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлогын асуудлаа эргэн харж, орчин үеийн улс төрийн намын хөгжилд гарч буй дэвшилтэт хэлбэр хэв маягийг авч хэрэглэх, тэр чиглэлд хөгжих хөтөлбөр боловсруулж ажиллах
4. Нийгмийн бүлгүүдийн эрэлт хэрэгцээг зөв мэдэрч ажиллах, тэдний дэмжлэгийг авахад чиглэсэн бодлого, хөтөлбөр гаргаж ажиллах, нийгэмтэй харилцах коммуникацийг шинэ арга барилуудыг бий болгох

³⁸ УИХ-ын тухай хуулийн 21.3 дахь заалт

³⁹ Ш.Содном бусад... “Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль”. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. ЭШ-ний хурлын эмхэтгэл. УБ., 2009. 8 дахь тал.

5. Намууд сонгуулийн стратеги төлөвлөлтөө шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, сонгуулийн өрсөлдөөний шударга, тунгалаг эрх зүйн орчинг бүрдүүлэх, улс төрийн мэргэшсэн байдлыг чухалчилж үзэх
6. Хөгжингүй орнуудын намын хөгжил төлөвшилтийн туршлагыг судлах, ололт амжилтыг Монголын онцлогт нийцүүлэн хэрэглэх замаар намын төлөвшилтийг хангаж нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.

Ашигласан ном, материал

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Ё.Довчин. Харьцуулсан улс төр судлал. УБ., 2006.
3. Ф.Фукуяама.Төрийг бэхжүүлэх нь. XXI зууны засаглал ба дэлхийн дэг журам. Орч. Г.Ганболд. УБ., 2005
4. Р.Даль. Ардчиллын тухай. УБ.,2004.
5. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ШУА, ФСЭХ.УБ., 2006
6. Alexis de Tocqueville. Democracy in America. New York., 1968
7. Micheal.J.Sodaro.Comparative Politics:A Global Introduction.New-York.,2001
8. М.Дюверже. Политические партии. М., 2000
9. Werner Prohl. Sumati. L. Voters Voices. People's perception of Mongolia's Political and Economic transition as reflected in Opinion polls from 1995 to 1997. UB., 2008
10. Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт боломж. Үндэсний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ.,2005
11. Г.Чулуунбатар. Монголын бизнес эрхлэгчид. УБ.,2000. /Судалгааны тайлан/
12. Д.Ганхуяг. Улс төрийн нам, улс төрийн өрсөлдөөн, сонгуулийн үйл явц. УБ.,2005. МУИС. Социологи сэтгүүл. 1 247
13. Katz.R.S.; Mair P. Changing models of party organization and party democracy: The emergence of the cartel party// Party Politics.Vol.1.No.1. January 1995
14. Katz.R.S.; Mair P. Cadre, Cath-All or Cartel?// Party Politics.Vol.2.No.4. January 1995

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН ДАХЬ НАМ СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА

Ж.Төртогтох

доктор

МУИС, НШУС

Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн эрхлэгч

Оршил

Орчин үед өрнөдийн улс орнуудын улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн намын онол, практикийн асуудлыг авч үзэхдээ дараах зарим асуудалд түлхүү анхаарах болжээ. Тухайлбал, намын системийн хэв маяг, намын үзэл суртлын ялгарал, зохион байгуулалтын загвар болон тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлс, намын гишүүнчлэлийн хэлбэрүүд зэрэг уламжлалт гэж болох суурь асуудлуудын зэрэгцээ удирдлага ба гишүүнчлэлийн шинэ механизм, нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалт, намын бодлогын хөгжилт, санхүүжилт, түүний эх үүсвэр, жендэрийн оролцоо, хандлага, намын коммуникацийн хөгжилт, түүнчлэн намын дотоод ардчилал зэрэг нам судлалд харьцангуй шинээр буюу шинэ хандлагаар авч үзэх болсон цөөнгүй зүйлс багтана.

Энэхүү өгүүлэлд тэдгээрээс зарим гол асуудлын талаарх өрнөдийн орнуудын улс төрийн шинжлэх ухааны судалгааны чиглэл, хамрах хүрээ, судлах зүйлс болон рациональ үр дүнгүүдийн талаар тоймлон авч үзнэ. Тухайлбал, намын системийн хэв маяг, үзэл суртлын ялгарал, намын зохион байгуулалтын загвар болон тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлс, намын удирдлага ба сонгон шалгаруулалт, намын бодлогын хөгжилт ба дотоод ардчилал зэрэг асуудлыг авч үзсэн болно.

Өнөө үед улс төрийн намын судалгаанд авч үзэж буй уг асуудлууд нь өрнөдийн улс төрийн шинжлэх ухааны судалгаа ба сургалтанд нийтлэг хэрэглэж буй зохиол, бүтээлд тодорхой тусгалаа олжээ. Тэдгээр бүтээлийг энд бүгдийг нэг бүрчлэн агуулгын хувьд тоочин нурших нь илүүц боловч улс төрийн нам, улс төрийн институт ба үйл явцын талаарх аливаа судалгаа, эрдэм шинжилгээний эрэл хайгуулд тус дэм болох үүднээс тоймлон авч үзсэнээ хуваалцаж байна.

Намын системийн хэв маяг ба үзэл суртлын ялгарал

Улс төрийн намын системийн талаарх судалгаа баруун Европын орнуудад хүчтэй хөгжсөн гэж болно. Энэ нь нэг талаас баруун Европын ардчилсан улс төрийн дэглэмийн бэхжилт нь улс төрийн намуудын тоон өсөлт болон ардчиллыг дэмжих олон нийтийн дэмжлэгийн харьцангуй тогтвортой бөгөөд өндөр түвшин зэрэгтэй нөгөө талаас олон нийтийн улс төрийн санаа бодлын ялгарал, түүнийг намуудын хувьд төлөөлөн илэрхийлэх ялгарал их буюу олон янз байдагтай холбоотойгоор намууд сонгуульд оролцохдоо ба сонгуулийн дараа үйл ажиллагаагаа явуулахдаа эвсэх, хамтрах үзэгдэл түгээмэл болсон зэрэгтэй уялдаатай байна.

Намын системийн талаарх өргөн хүрээний шинжилгээ нь намуудын тоо, бэхжилт, үзэл суртлын ялгарал, дэмжигчдийн бааз суурь, түүнчлэн удирдлагын болон зохион байгуулалтын асуудлыг авч үзэхтэй нягт уялдаатай байдгаараа өрнөдийн орнууд дахь улс төрийн нам судлалын гол чиг хандлагын нэг байж ирсэн гэж болно. Намын тоо болон бэхжилтэд сүүлийн үед гарч ирж буй хандлага нь улс төрийн үзэл суртлын хувьд зүүний чиг баримжаа бүхий намуудын тоо өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ намууд зохион байгуулалтын хэв шинжээсээ илүү үндэсний хэмжээнд сонгогчдод танигдсан ерөнхий дүр төрхөөрөө ялгарах болсон байна. Ардчилсан дэглэм бүхий бүс нутаг дахь тухайлбал АНУ дахь хоёр намын систем болон Зүүн Ази дахь улс төрийн лидерийн давамгайлал бүхий улс төрийн сонирхол, эрх ашгийн төвлөрөл болон зохион байгуулагдаж буй намуудыг харьцуулж үзэхэд улс төрийн үзэл суртлын ялгарал, намуудаар дамжин зохион байгуулагдаж буй түүний илрэл зэрэг нь улс төрийн нам судлалд онолын тулгамдсан асуудал хэвээр байна. Тухайлбал, Өмнөд Солонгост улс төрийн намууд байгуулагдах, тарах, эвсэх, тэр ч байтугай нэрээ солих явдал элбэг бөгөөд цаг хугацаа төдийлөн шаардахгүй өрнөж байдаг энэ процесс нь үзэл суртлын хамаарлыг намын системийн тогтворгүй орчинд судлан үзэх шаардлагатай болгодог ажээ (Kim, 2008: 160-167).

Намуудыг ангилж үзэх үндсэн арга зам нь намын үзэл суртлын хувьд зүүнээс баруун тийш гэсэн спекрт тавьж үзэх явдал юм (Roskin et al., 2008: 203). Америкийг оролцуулаад өрнөдийн ардчилсан орнуудад намын системийг үндсэн дөрвөн бүлэгт хуваан авч үзэж байна (Blondel, 1990: 302-310). Тэдгээр нь хоёр намын систем, хоёр-хагас намын систем, зонхилогч нам бүхий олон намын систем, зонхилох намгүй олон намын систем юм. Гэхдээ өрнөдийн ардчилсан орнуудад намуудыг зарим тодорхой категориор ангилан авч үзэхэд бэрхшээлтэй байдаг. АНУ гэхэд л намуудыг үзэл суртлын нэг хэв маягт харьцуулан жишихэд төвөгтэй байдаг бол олон намын систем бүхий зарим орнуудын улс төрийн намуудаас үзэл суртлын ялгарлын хувьд этгээд гэж болох дүр төрх ажиглагддаг. Тухайлбал, Голландад хоёр консерватив нам байдаг бол Финляндад

Шведийн нам, Швейцарид бүр Тариачдын нам, Гар урчуудын нам, Буржуйчуудын нам гэх зэрэг намууд байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, намын системийн ангилалд үзэл суртлын ялгарал, улс төрийн чиг баримжаа зэргийг шалгуур болгохдоо намын гадаад имиж буюу улс орны хэмжээнд танигдсан байдал, намын нэр, үндсэн платформ дахь тунхаглал зэргийг сонгуулийн мөрийн хөтөлбөр болон улс төрийн эвсэл болоход баримталж буй бодлоготой харилцан уялдаа холбоонд нь авч үзэх шаардлагатай болж байна.

Намын системийг хэд ч ангилан үзэх нь нээлттэй асуудал хэдий ч гурван-намын систем, эсвэл улс төрийн тодорхой гурван бүлэг бүхий систем бие даасан ангилын түвшинд харагдахгүй байгаа нь үзэл суртлын ялгарал болон сонгогчдын санал өгөлт, дэмжлэгийн хүрээ зэргээр тайлбарлагддаг. Олон намын систем дэх зонхилох намуудын хувьд барууны эсвэл зүүний ялгарал хүчтэй илрэх нь түгээмэл, харин төвийн чиг баримжаа бүхий улс төрийн зонхилох нам буюу намууд бүхий систем барууны ардчилалд төдий л элбэг ажиглагдахгүй байна.

Намын зохион байгуулалтын загвар болон тэдгээрт нөлөөлөх

хүчин зүйлс

Намын зохион байгуулалтын маш өргөн хандлага намын хөгжилд гарч ирсэн нь тодорхой юм. Учир нь намын шинэ бүтэц эсвэл үйл ажиллагаагаа явуулах шинэ процедур аль аль нь нам бүтцийн хувьд хөгжих гадаад хүчин зүйлс болон намын дотоодод илэрч буй үзэгдэл, нөлөөний үр дүнд хөгжиж өөрчлөгдөж ирсэн байдаг. Намын зохион байгуулалтын загварыг судлах өрнөдийн улс төрийн шинжлэх ухааны хандлага ч үүнд тулгуурлаж байна.

“Лидер давамгайлсан” нам, “Алдартнуудын нам” (зарим тохиолдолд “кадр”-ын нам гэдэг), “төлөөллийн” (олон түмний?) нам, “корпоратист” нам, “ардчилалд тулгуурласан” нам гэсэн нийтлэг таван загварт намын зохион байгуулалтыг авч үзэх хандлага зонхилох болжээ. Эдгээр загвар нь нэг талаасаа намын дотоод дахь үйл ажиллагааны зохион байгуулалт эсвэл үйл ажиллагаанд тулгамддаг бүтцийн шинжтэй асуудлуудыг ялган авч үзэхэд чиглэгдэж байгаа мэт боловч анхааралгүй өнгөрч боломгүй өөр нэг асуудал нь зохион байгуулалтын нийтлэг загвар бүр нь ардчиллын ялгаатай түвшнүүд эсвэл ардчилалжилт буюу ардчилсан реформын хэрэгжилтийн өөр өөр тусгал болон судлагдаж байна. Зарим загвар нь бусдаасаа улс төрийн системийн хөгжлийн түүхэн тодорхой үеийг харьцангуй илүү санагдуулам байгаа бол аль ч загвар нь бүрмөсөн хуучирч үеэ өнгөрөөсөн гэж болохооргүй байгаа нь анзаарагдаж байна.

Аль ч загварын элементүүд нь улс төрийн шинээр тогтсон болон хуучин ардчилсан систем дэх орчин үеийн намуудад хадгалагдаж байгаа бол бүр илүү сонирхол татам нь улс төрийн шинжлэх ухаанд судлаж буй өрнөдийн ардчилал дахь нэг ч нам аль нэг

загварыг дангаар нь бөгөөд төгс төлөөлөхгүй байгаа явдал юм. Тиймээс намын зохион байгуулалтыг дэглэмүүдийн харьцуулсан анализын түвшинд ч тэр, мөн нэг системийн (улсын) дотоод дахь улс төрийн сонирхлын ялгарал, төлөөллийн судалгааны хүрээнд ч тэр улс төрийн намыг зохион байгуулахад нийгмийн аль бүлэг жинтэй нөлөө үзүүлж байна гэдэгтэй, өөрөөр хэлбэл улс төрийн сонирхол нам болон зохион байгуулагдах нийгмийн суурь, эсвэл оршин байсан улс төрийн болон эрх зүйн орчин дахь намын харилцааг зохицуулах уламжлалт хэм хэмжээ, шалгууртай холбон судлах нь орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд нам судлалын нэгэн арга зүй болон урагшилж байна. Өрнөдийн орнуудад нийтлэг ажиглагдаж буй дээр цухас дурьдсан загваруудыг тоймлон авч үзье.

Лидер давамгайлсан намууд ерөнхийдөө олон түмнийг уриалан, сонирхол ба эрх ашгийн зарим тохиолдолд санхүүгийн эх үүсвэр зэргийн төвлөрөлд тулгуурлан зохион байгуулагдаж байна. Лидер нь намын “эрмэлзвэл зохих” мөрийн хөтөлбөрийг зохион бүтээж, санаачлан хийдэг бөгөөд нам нь лидерийнхээ нэрээр үгүй ядахад олон түмэнд танигдсан зохиомол нэр буюу тодотголоор нэрлэгдэх, нийгэмд танигдах нь нэн түгээмэл. Орчин үеийн бараг бүх ардчилсан системд амжилт, нэр хүнд бүхий олон намууд энэ загварт тохирч байдаг нь намыг үүсгэн байгуулсан эсвэл давамгай удирддаг лидертэй холбоотой юм. Италийн улс төрийн шинжлэх ухаанд Сильвио Берлусконийн Forza Italia буюу Итали Урагшаа намыг жишээ болгон судлах нь түгээмэл байна. Италийн Ерөнхий сайдын албыг дөрөв дэх удаагаа хашиж буй Сильвио Берлусконийн хэмээх тус нам нь улс төрийн үзэл суртлын хувьд либерал консерватив (Forza Italia, 2009), эсвэл христийн ардчилсан буюу социал демократ (Moroni, 2008), зарим тохиолдолд либерал (Massari, 2004) зэргээр үзэл суртлын ялгарлын түвшинд өөр өөрөөр тайлбарлагдаж байдаг нь Италийн улс төрийн шинжлэх ухааны судалгаанд намын системийн ангилалд ч, зохион байгуулалтын загварт ч харагдаж байдаг нь сонирхолтой юм.

Лидер давамгайлсан загвар бүхий намуудын хувьд намын дарга нь нэг бол *заяагдмал* байдалтай (өөрөө сонгогдсон ч гэж болох юм) эсвэл намаа өөрөө үндэслэн байгуулсан (үзэл санаа, сонирхол, эрх ашиг, санхүүгийн аль ч талаасаа), эсвэл намын нэлэнхүй гишүүдийн дэмжлэгтэйгээр уг эрх мэдэлд хүрсэн, эсвэл өмнөх удирдлагын зүгээс залгамжлах томилгоо буюу гэрээс авсан байдаг онцлогтой ажээ.

Гэхдээ лидер давамгайлсан нам гэхээр заавал ардчилсан бус эсвэл ардчиллын эсрэг байх албагүй байдаг. Үнэн хэрэгтээ шинээр ардчилагдсан болон ардчиллын олон арван жилийн туршлагатай аль ч улсад дарангуйллын эсрэг эсвэл өмнөх ардчилсан бус дэглэмийнхээ эсрэг тэмцэгчдийг тойрон хүрээлсэн нам нь бас л нэг төрлийн лидер давамгайлсан намын загвар болсон байдаг. Тухайлбал, Өмнөд Африкийн Нельсон Мандела, Өмнөд Солонгосын Ким Дэ Жун тэргүүтэй намуудыг нэрлэж болно.

Өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн намын хөгжлийг ардчилсан тогтолцооны бэхжилттэй холбон авч үзэхдээ 19-р зуунд ардчилсан шинжтэй намууд үүсэн гарч ирснээр зонхилох лидерүүд тодорч гарч ирэх нь хумигдсан гэж үздэг. Энэ нь ганц харизмат лидерийг тойрон зохион байгуулагдахаасаа илүү намын бюрократууд, орон нутаг дахь намын нэгжийн удирдагчид болон бусад сонгогдсон лидерүүдээс бүрдсэн бага хэмжээний гэж болох удирдах бүлэг давамгайлсан намууд үүсч эхэлсэнтэй холбоотой байж. Нам удирдлагаа “дүрмийн бус” аргаар шилж сонгох буюу хуйвалдах, үгсэн тохирсны дараа нийтэд болон гишүүддээ танилцуулах зэргээр намын удирдах эрх мэдлийг цөөн лидерүүд хоорондоо далд хэлбэрээр шилжүүлэх болсонтой холбоотойгоор намын зохион байгуулалтын “алдартнуудын” буюу “кадрын” загвар дүр төрхөө олж эхэлсэн ажээ.

Улмаар кадрын намууд зохион байгуулалтын арай шинэлэг ч гэж болох хэлбэрийн эрэл хайгуул хийж эхэлсэн нь улс төрийн шинжлэх ухааныг улс төрийн үзэл суртлын судалгаандаа намын загваруудыг зайлшгүй уялдуулан авч үзэх шаардлагыг нөхцөлдүүлсэн байдаг. Шинэ маягийн социалист болон хөдөлмөрийн буюу тодорхой зүүний чиг баримжаа бүхий намууд өрнөдөд гарч ирснээр зохион байгуулалтын загварын хувьд намын шинэ хэв маяг тодорч эхэлсэн байдаг. Сонгуульд оролцох эрхгүй байсан зүүний чиглэлийн намууд дэмжигчдийнхээ улс төрийн нэгдлийг тогтоон барих, улс төрийн үйл ажиллагаандаа олон түмнийг идэвхтэй татан оролцуулах зэрэг эрх ашгийн үүднээс сонгуулийн хооронд намын тогтвортой байдлыг хангахын тулд байнгын зохион байгуулалтанд орох шаардлага гарч ирсэн байдаг. Тэдгээр намууд орон нутагтаа болон үндэсний хэмжээнд төлөөлж чадахуйц гишүүд болон бүлгүүдэд илүүтэй анхааран нэгж байгууллагуудаа төдийгүй намын бусад бүтцийг зохион байгуулах болсон. Энэ нь улс төрийн лидерүүд болон дэмжигчдийн холбоог бэхжүүлэхэд чиглэсэн намын бие даасан загварыг гаргаж ирсэн байдаг.

Энэ хэв маягийн намыг Дювержье нөгөө талаас нь буюу *шүтэн бишрэгчдийн* (эсвэл дагагчдын ч гэж болох юм) нам (Duverger, 1954) гэж авч үзсэн байдаг. Латин Америкийн орнуудад, тухайлбал Аргентинд Пероны, Бразилд Варгасын байгуулсан намыг тус тус үүнд нэрлэж болох юм. Түүнчлэн, Иракт Саддам Хуссейны Арабын Сэргэн Мандлын Нам (Ba'ath – Бааф) энэ хэв маягт тохирох саяхны жишээ юм.

Дотоод ардчиллаа тунхагласан олон намууд үүгээрээ жирийн гишүүд, дэмжигчдээ намын бодлого, үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцох боломж олгож байгаагаар илэрхийлж байдаг. Гэхдээ жирийн гишүүд, дэмжигчдийн эрх мэдэл эсвэл идэвхтэй оролцоо, сонирхол улам бүр давамгайл болж ирэх нь намуудыг энэ өөрчлөлтөнд зохицсон гэхээсээ илүү энэ өөрчлөлтийг зохицуулахад саад бага учруулах зохион байгуулалтын загварыг эрж хайхад хүргэсэн байна. Гэсэн хэдий ч жирийн гишүүд, дэмжигчдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх байдлаар зохион байгуулалтын шинэ эрэл хайгуул нь хэзээ ч

ардчилсан маягийн загвар хайх цорын ганц арга зам байгаагүй нь сонин. Иймээс зарим намууд зохион байгуулалтын хувьд “корпоратист” гэж нэрлэж болохоор буюу намын дотоод дахь янз бүрийн түвшний албан тушаалыг сонирхож буй лидерүүдийн төлөөллийг хангасан бүлэг буюу багт тулгуурласан загварт хүрсэн байна. Тухайлбал тийм бүлгүүдийн төлөөлөл нь корпоратив шинжтэй байдгийн нэг нийтлэг илрэл нь намд шууд бусаар гишүүнчлэлтэй болдог буюу намын гишүүнчлэл ба албан тушаалын эрхийг сонирхлын зөвшилцлийн дүнд саад бэрхшээл багатайгаар олж авсан байдаг (Poguntke, 1998: 156–79) оршдог ажээ. Корпоратист загвар бүхий намуудын жишээ гэвэл Их Британийн Хөдөлмөрийн нам, Шведийн Социал Демократ нам, Австрийн Ардын Нам, Мексикийн Хувьсгалт Нам зэргийг нэрлэж болох юм.

“Ардчилалд тулгуурласан” загвар бүхий нам өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд судалгааны бас нэг чухал сэдэв болж байна. Сүүлийн жилүүдэд, өрнөдөд улс төрийн намын дотоод дахь төлөөллийг хэрэгжүүлэх зарчим ба зохицуулалтанд шүүмжлэлтэй хандах болжээ. Энэ шүүмжлэл нь хувь хүний болон бүлгийн эрх ашигт тулгуурласан зохион байгуулалтын уламжлалт гэж болох загваруудыг нэлэнхүйд нь хамарч, үүндээ “ардчилсан маягийн” эсвэл “ардчилалд тулгуурласан” эсвэл бүр “олон нийтийн ардчилал” гэж болохоор зарчмыг намын зохион байгуулалтын шинэ загвар болгох саналаар илэрхийлэгдэх болжээ. Ерөнхийлөн хэлбэл, энэ загварын гол үндэс нь бүх нийтийн санал асуулга буюу олон нийтийг хамгийн их хэмжээнд хамарч болох процедурыг намын дотоод дахь шийдвэр гаргах болон нөөцийг хуваарилахад өргөн хүрээнд оролцох боломжид тохируулан хэрэглэх явдал юм. Намын энэ загвар нь 1980-аад оноос Европод хүч түрэн гарч ирсэн шинэ маягийн зүүний намуудад тодорхой илэрч эхэлсэн байдаг. Намын шийдвэр гаргахад дэмжигчдийн шууд үүрэг ролийг хангаж өгөх зохион байгуулалтыг бүрдүүлдэг нь энэ загварын гол онцлог юм.

Товчдоо, дээр дурдсан зохион байгуулалтын таван загвар нь орчин үеийн намуудыг зохион байгуулалтын өөрчлөлтийн хувьд эсвэл шийдвэр гаргах зарчим ба үйл ажиллагааны чиглэлийн хувьд нь ялгаж судлахад тохиромжтой. Улс төрийн намуудын хувьд ардчилагдана гэдэг нь хамгийн түрүүнд хэрхэн зохион байгуулагдах асуудалтай холбогддог. Түүнчлэн эрх мэдлийн төвлөрөл ба нөөцийн хуваарилалт, эсвэл шийдвэр гаргах зарчим ба гишүүд дэмжигчдийн боломжит оролцоо зэргийг шийдвэрлэж буй хувилбарууд намын зохион байгуулалтын талаарх улс төрийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд голлох байр суурь эзэлсэн хэвээр байна.

Намын “хоёрдмол” удирдлага ба сонгон шалгаруулалт

Юуны өмнө намын удирдлага гэдэгт хамаарах үндсэн хоёр ойлголт байгааг дурьдах хэрэгтэй. Эхнийх нь улс төрийн намын өөрийн удирдлага (үүнийг бид категори 1.

гэе) буюу ихэнх улсад намын дарга зарим тохиолдолд намын ерөнхий нарийн бичгийн дарга, мөн намын дотоод *иерархи* буюу шаталсан зэрэг дэвтэй холбоо бүхий системд эдгээр албан тушаалын дараа орох нарийн бичгийн дарга нар, алба, хороо зэрэг дотоод бүтцийн удирдах албан тушаалтнууд юм. Тэгвэл удаах нь парламентад тухайн нам суудал авсан тохиолдолд парламент дахь улс төрийн намын бүлгийн удирдлага (үүнийг бид категори 2.) буюу намын бүлгийн ахлагч, тэргүүн, дарга, дэд дарга зэргийг илэрхийлж байдаг. Тухайн улсын эрх зүйн зохицуулалт болон улс төр, эрх зүйн шинжлэх ухаанд хэрэглэгддэг ойлголт, агуулгын ялгаа ба нийлэмж зэргээс шалтгаалан улс төрийн намын эдгээр удирдлагыг янз бүрээр авч үзэх явдал бий.

Улс төрийн нам нь удирдлагаа тодруулах өөрийн процедурыг тогтоосон байдаг (Scruton, 1996: 406). Парламентын болон ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрийн ялгаатай байдлаас төдийлөн хамааралгүйгээр улс төрийн нам өөрийн удирдлагаа сонгох үйл явц нь улс төрийн сонгуульт албан тушаалд тухайн намаас дэвших нэр дэвшигчээ сонгох явдалтай холбоотой байх нь түгээмэл. Тиймээс аль ч намын дотоод дахь удирдах албан тушаалтны сонголт, томилгоо, ер нь аливаа өрсөлдөөн нь цаад утгаараа сонгуульд тэргүүн ээлжинд нэр дэвших давуу эрхийн төлөөх өрсөлдөөн болж хувирдаг учиртай ажээ.

Парламентын засаглал бүхий ихэнх улсад парламент дахь намын бүлэг нь тогтсон хэм хэмжээнд тухайлбал хуулиар зохицуулагдсан тодорхой шаардлагад үндэслэн удирдлагаа парламентад сонгогдсон гишүүд өөрсдөө сонгодог боловч зарим тохиолдолд удирдлагаа намаасаа буюу гишүүдийн дунд явуулсан санал асуулгын дүнд үндэслэн сонгох явдал байна. Тухайлбал, Их Британийн Консерватив нам парламентын Нийтийн танхим дахь намын бүлгийн удирдлагаа намын хурлаас эсвэл намын гишүүдийн дунд өргөн хэмжээний санал хураалт явуулсны дүнд сонгодог нь улс төрийн намын өөрийн удирдлага (категори 1.) ба намын парламент дахь зохион байгуулалтын удирдлагын (категори 2.) асуудлыг уялдуулсан механизм болсон байна. Ингэснээр улс төрийн нам, парламент, засгийн газар гэсэн улс төрийн болон төрийн институтын коммуникацийн нэгэн илэрхийлэл болох болжээ. Гэхдээ бид энд парламентын засаглалын орчинг харгалзах нь зүйтэй юм. Весминстерийн систем ба улс төрийн дэглэмийн нийцтэй байдал нь дан ганц бүх нийтийн сонгуулиар байгуулагддаг парламентад хууль тогтоох эрхээс гадна гүйцэтгэх засаглалын байгууллагыг томилох эрх олгосноор илэрхийлэгдэнэ гэвэл учир дутагдалтай байдаг. Учир нь Их Британид улс төрийн уламжлал ба үндсэн хуульт ёсны хөгжлийн түүхэн учир шалтгаантай холбоотойгоор төрийн тэргүүн, түүнээс харьцангуй хараат бус Ерөнхий сайд бүхий засгийн газар, улс төрийн угсаа хэргэм бүхий элит танхим болон нийтийн сонгуулийн дүнд бүрддэг танхим зэрэг нь улс төрийн системд нэг цогц бүрдэл болон хөгжсөн байдаг. Үүнээс үзэхэд улс төрийн намыг дан ганц улс төрийн сонирхлын институтжилтийнх нь хувиар төдий биш харин төрийн засаглалын

институтийн салшгүй “анд” эсвэл “холбоотон” болохынх нь хувьд улс төрийн системийн идэвхтэй механизм болгон хувиргасан байна.

Өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн намыг улс төрийн бодлогыг удирдан чиглүүлэгч төдийгүй улс төрийн институт, үйл явцыг холбох механизмын үүднээс судлан үзэж буй (Shively, 2007: 249-272) нь ч дээрхтэй холбоотой юм. Иймээс улс төрийн намын талаарх судалгаанд түлхүү авч үзэж буй асуудлын нэг нь улс төрийн намын өөрийн удирдлагын хоёрдмол орчинг улс төрийн олон намын чөлөөт өрсөлдөөн бүхий сонгуулийн дүнд бүрэлдэхүүн нь бүрддэг төрийн засаглалын институтын бие даасан байдал ба улс төрийн систем дэх легитим чанар ба олон нийтийн итгэл даах байдал зэрэгтэй холбон авч үзэх явдал болж байна.

Намын бодлогын хөгжил ба дотоод ардчилал

Намын бодлого нь нэг талаас намын дотоод дэг журам, үйл ажиллагааны чиглэл, баримтлах үзэл баримтлал ба практик арга хэмжээний харилцан уялдаа зэргийг нөгөө талаас төрийн бодлого, үйл ажиллагааны альтернатив хувилбарууд улс төрийн намын бодлого, мөрийн хөтөлбөр зэрэгт тусган илэрхийлэх нь түгээмэл. Гэвч намын бодлогыг тодорхойлоход зайлшгүй авч үзэх болсон асуудлуудаар дамжин намын дотоод ардчилал, удирдлага ба гишүүдийн харилцаа зэргийг судлах нь улс төрийн шинжлэх ухаан дахь нам судлалын нэгэн чухал сэдэв болж байна.

Улс төрийн хөгжлийн нэг чухал шинж нь төрийн бодлогод олон нийтийн санаа бодлыг хамгийн боломжит байдлаар тусгах явдал юм. Энэ асуудлыг бүр өнгөрсөн зууны эхээр төрийн хөгжил, ардчиллын өсөлттэй холбон авч үзэж байсан нь сонирхолтой. Сонгуулийн оролцоо өсөн нэмэгдэх, пропорциональ төлөөлөл, гүйцэтгэх эрх мэдлийг олонхи болсон намд хариуцуулах, тогтвортой давтамж бүхий сонгууль, орон нутгийн өөрийн удирдлагын байгууллага (төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран), ард нийтийн санал асуулга явуулах өргөн боломж, санаачлага зэрэг асуудалтай ардчилал, улс төрийн хөгжлийг хамтад нь улс төрийн шинжлэх ухаан эхнээсээ л судалж байсан (Gettell, 1922: 101) зэрэг нь намын бодлого болон улс төрийн нам ба төрийн бодлогын харилцан уялдаа холбооны асуудал тус шинжлэх ухааны зангилаа асуудлын нэг байсны илрэл юм.

Орчин үед ч тэр намын гишүүдийн үүрэг роль илрэх гол талбар нь зөвхөн намын удирдлага болон намын бүтцийн нэгж, алба зэрэгт нэр дэвшүүлэх, өрсөлдөх, орж ажиллах зэрэг институциональ хүрээгээр хязгаарлагдахгүй харин ч намын платформ, зарчим, бодлого, сонгуулийн мөрийн хөтөлбөр зэргийг боловсруулахад оролцох боломжоор хангагдах зэрэг илүү функциональ хүрээгээр тодорхойлогдон улмаар эдгээр нь намын дотоод ардчилал, өрсөлдөөн зэргийг илэрхийлэх болжээ. Энэ нь ч улс төрийн намын талаарх орчин үеийн судалгаа, шинжилгээнд тусгалаа олж байна. Тухайлбал,

намын бодлогын талаарх дотоод хэлэлцүүлэг, санал солилцох уулзалт, ярилцлага зэрэгт гишүүдийн оролцоо, санал илэрхийлэх, зөвлөгөө өгөх боломж, намын үзэл баримтлал, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах зарчмын асуудал зэргийг боловсруулах, зохиох хүнийг сонгох, шалгаруулах нээлттэй байдал, намын дотоод дахь өргөн хэмжээний буюу нийт гишүүдийг хамарсан санал асуулга зэргийг намын бодлого боловсруулах асуудлын тухайлсан судалгаанд илүүтэй анхаарах болжээ.

Намын удирдлагыг эсвэл тухайн намаас улс төрийн сонгуульд нэр дэвшигчийг сонгох зэргээс ялгаатай нь сонгуулийн кампанийн платформоос бусад бараг бүх төрлийн шийдвэр ихэвчлэн намын дотоод зохион байгуулалттай уялдаатайгаар төлөвлөгдөж, хэрэгждэг нь намын бодлого, намын зохион байгуулалт гэсэн өөр өөр асуудлыг хамтад нь авч үзэх шаардлагыг төрүүлж байна.

Намын аливаа чухал санаачлага, шийдвэрийг өргөн олон нийтэд мэдээлж, тэдний хүртээл болгох нь улс төрийн бодлогын хөгжилтийг улс төрийн намуудын хөгжлийн асуудалтай хамтад салшгүй нэг хэсэг болохыг харуулж байгаа боловч энэ нь зөвхөн тэрхүү шийдвэр ба санал, санаачлага нь зөвшилцөлд тулгуурлахаас гадна намын хувьд болон намаас улс төрийн системд удирдан захирах хүч бүхий болон хэрэгжихээр болсон тохиолдолд л гэдгийг улс төрийн намын бодлого, дотоод ардчиллын судалгаанд онцолж байна (Bunwagee and Kasenally, 2005: 22). Энэ нь намын жанжин шугам болон түүний функциональ илрэл ба төрийн бодлогын хоорондын уялдаа холбоо намын дотоод шийдвэр гаргах процессд гишүүдийн оролцоо ба нөлөө эсвэл тэдний саналд тулгуурласан шийдвэр аль аль нь улс төрийн намыг ардчиллын институт хэмээн авч үзэх бололцоог олгож байгаагаар илрэнэ.

Улс төрийн намуудын хувьд тэр бүр нэлэнхүй гишүүдээ хамарсан санаа бодлын судалгаанд тулгуурлаж тухайлбал сонгуулийн мөрийн хөтөлбөрөө гаргах нь огт боломжгүй мэт байсан үе өнгөрч буй нь улс төрийн шинжлэх ухаанд намын дотоод ардчиллын асуудлыг ул суурьтай авч үзэхийн тулд бодлогын хөгжилт, түүний олон талт боломжит хувилбаруудыг хамтад нь судлах шаардлагыг ийнхүү зүй ёсоор нөхцөлдүүлж байна.

Учир нь намын бодлогын хөгжилтэнд зөвхөн жирийн гишүүд хувь нэмэр оруулах төдийгүй тухайн намын гишүүн бус хүмүүсийн санаа бодол ч тусгагдах боломжтой байх нь бодлогын цар хүрээг өргөжүүлэх төдийгүй намыг ардчилсан институтын хувьд илүү өргөн олон нийтийн болгох учиртай ажээ.

Судалгааны эрэл хайгуул

Ардчилсан улс төрийн дэглэм нь бүх нийтийн сонгууль, чөлөөт хэвлэл, хүний эрх зэрэг тулгуур үнэт зүйлсэд тулгуурлахын зэрэгцээ нөгөө талаасаа иргэдийг төлөөлөх,

нийтийн сайн сайхан байдлын төлөө удирдан засаглах чадвар бүхий тогтвортой улс төрийн намууд нь улс төрийн системийн чухал элемент байсаар байна. Энэ нь санамсаргүй илэрч буй үзэгдэл биш болох нь ялангуяа Хантингтоны томъёолсон “ардчиллын гурав дахь давалгаа”-наас хойш дангаар захирах нэг намын эсвэл цэргийн дарангуйллын зэрэг тоталитар болон авторитар дэглэмийн тодорхой хэлбэр бүхий системээс ардчилалд шилжсэн орнуудын хувьд нийтлэг үзэгдлийн хэмжээнд хүрч буй иргэд ба тэдний сонгосон эрх баригчдын хоорондох хүнийсэлт, улс төрийн идэвхгүйжил, ардчиллын ололтоос илүүтэйгээр тохиолдох болсон хөгжлийн эсрэг нийгмийн болон улс төр-эдийн засгийн аливаа сөрөг үзэгдэл зэрэг нь тэдгээр орнуудын улс төрийн намуудын хувьд томоохон сорилт болон гарч ирж буйгаар тайлбарлагдах болжээ.

Улс төрийн харьцангуй динамик институт болохын хувьд намуудад тулгамдаж буй тэдгээр сорилт нь улс төрийн өөрчлөлт ба ардчилсан хөгжлийн үйл явцтай нягт уялдаатай. Илүү идэвхтэй бөгөөд уян хатан өөрчлөгдөж буй намын олигархчлал, түүнчлэн улам бүр хүнийсгэгдэж байгаа иргэд ба улс төрийн институтын харилцаа зэрэг нь улс төрийн хөгжлийн хувьд ээдрээтэй үзэгдэл болохын зэрэгцээ улс төрийг буюу улс төрийн бодлогыг судалгаа шинжилгээний үндсэн объектоо болгон авч үздэг улс төрийн шинжлэх ухааны хувьд судалгааны шинэ эрэл хайгуул болон орон зай, мэдээллийн уламжлалт бус эх үүсвэр болон судалгааны аналитик бус арга зэргийг зайлшгүй нөхцөлдүүлж байна. Энэ өгүүлээр дэвшүүлж буй зарим санаа, судалгааны эх сурвалж болон бүтээлийн тойм зэрэг нь цаашид улс төрийн намын дагнасан буюу ахисан түвшний судалгаанд, түүнчлэн улс төрийн ардчилал ба намуудын хөгжлийн хэтийн төлөвийн уялдаа зэрэг асуудлыг сонирхдог эрдмийн ба улс төрийн практик хүрээний хэн бүхэнд санаа өгөх ач холбогдолтой болов уу хэмээн найдна.

Ашигласан ном зохиол

Blondel, Jean (1990) Types of Party Systems, in Peter Mair (ed) *The West European Party Systems*, Oxford: Oxford University Press, 302-10

Bunwaree, Sheila and Kasenally, Roukaya (2005), *Political Parties and Democracy in Mauritius*, EISA

Duverger, Maurice (1954), *Political Parties: Their Organization and Activities in the Modern State*, New York: Wiley

Forza Italia, available at <http://www.intute.ac.uk/cgi-bin/fullrecord.pl?handle=20080408-12070485> (accessed on October 12, 2009)

Gettell, Raymond Garfield (1922), *Introduction to Political Science*, revised edition, Boston: Ginn and Company

Gunther, Richard and Diamond, Larry (2003), 'Species of Political Parties: A New Typology', *Party Politics*, 9, 167-99

Kim, Chae-han (2008) The Ideological Affiliations of Political Parties, in The Korea Herald and The Korean Political Science Association (eds) *Political Change in Korea*, Korea: Jimoondang, 160-67

Massari, Oreste (2004), *I partiti politici nelle democrazie contemporanee*, Laterza, Rome-Bari

Moroni, Chiara (2008), *Da Forza Italia al Popolo della Liberta*, Carocci, Rome

Poguntke, Thomas (1998) Party Organisations, in Jan van Deth (ed) *Comparative Politics: The Problem of Equivalence*, London: Routledge, 156–79

Randall, Vicky (2005) Case Study One: Political Parties, Their Social Ties and Role in Political Change, in Burnell & Randall (eds) *Politics in Developing World*, Oxford University Press

Roskin, Michael G., Robert L. Cord, James A. Medeiros, Walter S. Jones (2008), *Political Science: An Introduction*, Tenth Edition, Pearson Prentice Hall

Sartori, Giovanni (1976), *Parties and Party Systems*, Cambridge University Press

Scruton, Roger (1996), *A Dictionary of Political Thought*, Second Edition, London: Macmillan General Books

Shively, W.Phillips (2007), *Power & Choice: An Introduction to Political Science*, Tenth Edition, NY: McGraw-Hill

УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ БА НАМУУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ё.Довчин

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Г.Цэнд-Аюуш

докторант, ахлах багш

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

1990-ээд оноос эхлэлтэй Монголын ардчилсан хувьсгалын үр дүнд хуучны захиргаадалтын систем, нэг нам төвтэй үзэл сурталжсан дэглэм, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн механизмыг халж өөрчлөх, зах зээлийн харилцаа, чөлөөт өрсөлдөөн иргэдийн эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх нэгэн зорилго дор улс төрийн намууд үүсч үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч тодорхой үзэл суртлын номлол баримтлан нийгмийг өөрчлөн байгуулах бүрэн цэгцтэй концепци боловсруулж баримтлан мөрдөж хэрэгжүүлэх гэхээсээ илүүтэй сонгогчдын саналыг өөрсөддөө татах, популист амлалт, манипулятив шинжтэй суртал ухуулгыг гол болгож, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага тэр бүр ухамсарлахгүй байна. Ардчилсан дэглэм тоталитаризмаас ялгаатай нь төрөөс аль нэг үзэл суртлыг албан ёсны улс төрийн үзэл суртлаар зарладаггүй, харин заагран ялгарч хоорондоо өрсөлдөгч үзэл суртлууд нь төрийн улс төрийн бодлого, үзэл баримтлалын олон ишт тулгуур болж өгөх ёстой байдаг. Ер нь сүүлийн үед үзэл суртлаас цэрвэх хандлага нэлээдгүй газар авах болсон. Энэ учир бидний дэвшүүлж байгаа асуудал бол улс төрийн үзэл суртал гэж юу болох, улс төрийн шинжлэх ухааны болон практик амьдралд хэрхэн эерэг, сөрөг нөлөө үзүүлж ирсэн, түүний нийгмийн хөгжилд гүйцэтгэх чиг үүрэг, ач холбогдлын талаар судлаачдын үзэл бодлыг нэгтгэн дүгнэх, нөгөө талаар ардчилалд шилжиж байгаа монголын өнөөгийн нөхцөлд улс төрд үзэл суртал хэрэгтэй юү? хэрэгтэй бол чухам ямар үзэл суртал хэрэгтэй вэ? улс төрийн намуудын үзэл баримтлалын төлөвшил, хандлага ямар байна вэ? зэргийг хөндөж судлаачдын анхаарлыг хандуулахыг зорив.

Мөн нийгмийн ардчиллын хүрээнд энэ асуудлаар санал бодлоо хуваалцах болно. Ардчилал, зах зээл жам ёсны аян зөнгөөрөө учраа олох ёстой гээд орхидог үе нэгэнт өнгөрчээ. Зах зээл, ардчилал тодорхой үзэл баримтлалд суурилсан улс төрийн бодлогод хэрхэн холбогдох вэ? Учир нь энэ бүгд хүн бүрийн, нийгмийн бүлэг бүрийн амьдралд

тусдаг. Улс төрийн үзэл суртал нэг талаас хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалсан үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр цогц, нөгөө талаас улс төрийн засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн шинжийг хангах үнэт зүйлсийн илэрхийлэл мөн. Энэ утгаараа үзэл баримтлал хэмээх ухагдахуун нь үзэл суртал хэмээх ухагдахуунтай адил утгаар хэрэглэгдэх явдал байдаг бөгөөд гагцхүү сүүлийнх нь харьцангуй өндөр түвшинд системчлэгдсэн байдгаараа онцлог талтай. Мөн үзэл баримтлал, үзэл суртлыг аль алиныг нь итгэл үнэмшлийн, ертөнцийг үзэх үзлийн систем гэж үзэх явдал байдаг. Жишээ нь: “Марксын сургаал үнэн зөв учир бүхнээс хүчтэй” гэсэн Лениний үг түүний итгэл үнэмшлийн бэлэг тэмдэг бөгөөд тэрбээр марксизмыг ажилчин ангийн үзэл суртал хэмээн бичиж байв. Тиймээс бид үзэл суртал бол өөртөө ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлсийн систем, практик үйл ажиллагааны хөтөлбөрийг багтаасан цогц ойлголт гэсэн санааг иш үндэс болгож байна. Үзэл суртлын асуудалд судлаачид өөр өөрсдийн аспектаар хандаж олон янзын тайлбар хийсэн байдгаас харахад эл ойлголт маш өргөн хүрээтэй болох нь харагдана. Тухайлбал, хувь хүний үзэл бодол, бүлгийн болон намын үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзлийн систем, тэр ч бүү хэл миф хүртэл үзэл суртлын хүрээнд хамрагдан тайлбарлагдах нь цөөнгүй.

Анх XVIII зууны Францын сэтгэгч Дестют де Траси шинжлэх ухааны эргэлтэд “үзэл суртал” хэмээх нэр томъёог оруулж ирсэн бөгөөд тухайн үедээ “үзэл санаануудын тухай шинжлэх ухаан” гэж нэрлэжээ. Энэ үеэс үзэл суртал, онол харилцан хамааралтай хөгжиж ирсэн байна. Тухайн үедээ Наполеон үзэл сурталчдыг илэрхий хуурмаг үзэл санаа, төсөөллүүдийн жинхэнэ мөн чанарыг ойлгодоггүй, онолчирхдог гайхлууд гэж үзэж байв. Хожмоо үзэл суртал нийгмийн оюун санааны хүрээнээс нэгэнт хальж улс төрд нэн чухал үүрэг гүйцэтгэх болсон бөгөөд аливаа улс төрийн үйл ажиллагаа тодорхой аливаа үзэл суртлуудын илэрхийлэл болон өрнөж хөгжсөөр ирсэн. Энэ ойлголтыг судлаачид олон талаас нь судалж, нийгмийн улс төр, эдийн засаг, социаль болон соёлын харилцаануудтай холбогдуулан үзэл баримтлалаа дэвшүүлж ирсэн. Тухайлбал, К.Маркс үзэл суртлын мөн чанарыг эдийн засаг, социаль хүчин зүйлтэй холбон тайлбарласан бол Ф.Ницше үзэл суртал нь эдийн засгийн харилцаанаас үл хамаарах соёлын гүнд боловсордог үзэгдэл гэж үзсэн байдаг. К.Мангейм үзэл суртлыг нийгмийн хүчин зүйлс, тэдгээрийн дотроос шашин шүтлэг, улс төрийн байр суурьтай нөхцөлдүүлэн судалсан байдаг. Үзэл суртлын онол, номлол дотор түүнийг хуурмаг ухамсар хэмээн тайлбарлах нь бий. Энэ нь нэгдүгээрт, үзэл суртал бүхнийг сонирхлын “дурангаар шагайх” учир үзэл суртлаа дэвшүүлэгч талын эрх ашигт нийцүүлэн бодит байдлыг гуйвуулах боломжтой, хоёрдугаарт, үзэл сурталчдын үзэл бодол хуурамч байх нь тэд хэсэг бүлгийн ашиг сонирхолд хөтлөгддөг, гуравдугаарт, үзэл суртлын хуурамч шинж бодит байдлын өөрийнх нь хуурмаг байдлаас шалтгаалдаг, дөрөвдүгээрт, үзэл суртал оршин буй нийгмийн байгууллага өмгөөлж хамгаалдаг зэргээр ярьж бичдэгээс үүдэлтэй бололтой. Тэгвэл шинжлэх ухаан гагцхүү объектив, үнэн мэдлэгийг чухалчилж, хэн

нэгний эрх ашигт автагдалгүй үзэгдлийн зүй тогтлыг байгаа чигээр нь нээн харуулдаг гэж үздэг. Үзэл суртал хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн үнэт зүйлсийн систем. Үзэл суртал хувь хүнд хандахаасаа илүүтэй олон түмэнд ханддаг. Тиймээс улс төрийн намууд олон нийтийг өөртөө татах, дайчлах, зохион байгуулалтанд оруулж нэгтгэх хэрэгцээ шаардлагаараа хөтөлбөрийнхөө бааз суурь болгож аль нэгэн нийцтэй үзэл суртлыг хүлээн зөвшөөрч, эсхүл тэр дагуу үзэл баримтлалаа боловсруулж дагаж мөрдөх уламжлал бий болсоор удаж байна. Ингэхлээр үзэл суртал байх ёстой зүйл. Нөгөө талаар үзэл суртал бодит байдлыг хамгийн хялбар цэгцтэй томъёолж, олон түмний ухамсар, сэтгэхүйд хүрч ойлгогдох, нөлөөлөх чадвараараа бүхнээс хүчтэй бас бодит байдлыг өөрчлөхийг эрмэлздэг. Энэ байдлаараа үзэл суртал улс төртэй холбогддог. Тиймээс үзэл сурталын зарчмууд, үнэт зүйлсийг баримтлах нь дотоод, гадаад бодлогын зорилтуудыг шийдвэрлэх нэг нөхцөлд тооцогдох болсон. Үзэл сурталын асуудалд эерэг, сөрөг байдлаар хандаж ирсэн байдал түүхэнд байсаар ирсэн одоо ч байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Ялангуяа үзэл сурталд тохуурхсан байдлаар хандах, хэн нэгэн хүний, хэсэг бүлгийн сэтгэл хөдлөл, эрх ашигтай холбоотой мэтээр үзэх явдал одоо ч байна. Тэгэхлээр үзэл сурталын мөн чанар, ач холбогдлын тухай асуудал гарч байна.

Анги бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлдэг учир үзэл суртал хуурмаг шинжтэй гэсэн санаа явсаар нэгэн үед үзэл суртлаас татгалзахад ч хүргэсэн байдаг. 1960 онд АНУ-д Д. Беллийн “Үзэл сурталын төгсгөл” нэртэй ном гарсан. Энэхүү номын гол агуулга өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд гарсан “үзэл сурталгүйжүүлэх” үзэл баримтлалын тусгал байсан юм. Дайны дараа үе нь үзэл сурталын дараах эрин цаг байх ба улс төрийн амьдралд фашист, коммунист дэглэмийн тогтоосон эрх чөлөөгүй байдлын айдсаас ангижрах, шинжлэх ухаан техникийн хувьсгалын үр дүнд өргөн олон түмний аж байдал сайжирч, нийгмийн бүтэц өөрчлөгдөн, ангийн зөрчил, тэмцлийг хууль зүйгээр зохицуулах боломжтой боллоо. Ийнхүү үзэл суртал үеэ өнгөрөөсөн тул орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэм түүнгүйгээр аливаа асуудлыг шийдвэрлэж чадна гэж нотолдогт энэ үзэл баримтлалын гол санаа оршино. Зарим судлаачид тухайлбал, америкийн улс төр судлаач Ф. Фукуяма (1990) аж үйлдвэржсэн нийгэмд “хуурмаг” үзэл сурталын оронд технократ ухамсар хангалттай гэж үзээд “үзэл сурталгүйжүүлэх” гэдгийг хүний нийгмийн амьдралыг барууны либерал ардчилсан зарчимд тулгуурлан бүхэлд нь өөрчлөн байгуулах явдал гэж үзэхийн хамт либерал ардчилал хүний нийгмийг удирдах сүүлчийн хэлбэр байх ёстой гэсэн үзэл бодлыг илэрхийлсэн байдаг.

Гэвч “үзэл сурталгүйжүүлэх” үзэл баримтлал явуургүй болохыг нийгмийн хөгжлийн практик амьдрал харуулсан юм. 1970-аад онуудад дэлхий дахинаа өрнөсөн ардчилсан хийгээд чөлөөлөх хөдөлгөөнүүдэд “дахин үзэл сурталжуулах” үзэл баримтлал дэвшигдэж олон нийтийн ухамсрыг эзэмдэх, нийгэмд шинэтгэл хийх, улс орны байр суурийг дэлхий нийтэд бэхжүүлэх нэн чухал хүчин зүйл, үндэсний нэг нөөц гэж үзэх болсон. Мөн үзэл

суртлын зарчмууд, үнэт зүйлсийг баримтлах нь дотоод, гадаад бодлогын зорилтуудыг шийдвэрлэх нэг нөхцөлд тооцогдох болжээ. Гэхдээ үзэл суртлыг объектив байх, үнэн байх шинжлэх ухааны шалгуураар хэмжих нь тохиромжгүй, түүний үзэл санааны нөлөө нийгэмд хэр зэрэг тусав гэдгээр үнэлэхийг санал болгожээ. Энэ тухай америкийн улс төр судлаач Р.Макридис улс төрийн олон ургальч үзэл суртал зэрэгцэн оршиж байгаа нь нийгмийн бүх бүлэг давхраа дэлхий ертөнцийг адилхан дурангаар шагайж харах бололцоо олгож байна гэж зүйрлэн хэлсэн байдаг. Ингэхлээр үзэл суртлын орон зай ямагт олон янз \плураль\ улс төрийн үзэл баримтлалууд зэрэгцэн оршиж, бие биесээ нөхөн сэлбэж, ижилсэж нэгдмэл систем бүрдүүлэх нөхцөл ардчилсан нийгэмд нээлттэй байдаг. Тоталитар дэглэмийн үед төрийн нэг үзэл суртал улс төр, оюуны амьдралд ноёрхолоо тогтоосон байхад ч контр үзэл суртлууд ил бишээр оршиж байх нь хэвийн зүйл билээ. Энэ бүхнээс үндэслэн орчин үеийн нийгмийн амьдралд үзэл суртлын ач холбогдлыг дараахь хүчин зүйлсээр тодорхойлж болохоор байна. Үүнд:

1. Үзэл суртал нийгэм дэх эмх замбраагүй, чиг зүггүй байдлыг цэгцлэн тэр чанараараа нийгмийг нэгтгэгч, дайчлагч, тогтворжуулагч үүрэг гүйцэтгэнэ. Өнөө үед дур зоргоороо авирлах, "Би эрх чөлөөгөө эдэлж байна. Бусад нь надад падгүй" нэрээр бусдын эрх чөлөөнд халдах, засаг, хууль ёсыг юман чинээнд бодохоо больсон ийм гаж үзэгдэл лавширвал нийгмийг анархи байдалд хүргэнэ. "Дэг журмыг хэрэг дээр нь хангасан байгуулал бол диктатур биш, харин ардчилал мөн" гэж Ги. Эрме (1994) хэлсэн байдаг.

2. Үзэл суртал зориудын худал хуурмаг төөрөгдүүлэл байх албагүй, бидний амьдарч буй нийгэм-соёлын орчны нөлөөллөөр зарим үндэслэл, үзэл баримтлалын ач холбогдол нь эдүүгээд таарч зохицохоо больсон байж болох талтай ч үзэл суртал ертөнцийг үзэх үзлийн хувьд улс төрийн нам, хэсэг бүлгийн үзэл бодол, баримтлал төдийгүй олон түмний ертөнцийг үзэх үзэл, улс төрийн суурь ухамсрыг төлөвшүүлэхэд ихээхэн нөлөөлнө.

3. Амьдрал дээр шинжлэх ухаан тэр бүр хариу өгч чадаагүй олон асуудлаар шийдвэр гаргах хэрэг гардаг ба үүнд үзэл суртал тусална.

4. Бодит байдлын нарийн ээдрээг хялбарчлан хураангуйлан томъёолж олон түмний ухамсарт хүргэж, амьдрал тэмцлийн болон бусадтай хэрхэн харилцах арга замыг ойлгуулж, чиглүүлж өгдөг.

Улс төр бол бололцоог дайчлах, хэрэгжүүлэх урлаг гэж үзэж болно. Түүхээс үзэхэд гарамгай улс төрчид, уран илтгэгчид бас стратегчид байсан. Тэд стратегийн талтай практик зорилтуудыг шийдэх асуудал дээр олонхи тохиолдолд үзэл суртлыг ашиглаж олон түмнийг итгүүлж, ойлгуулж, дайчилж чадаж байсан. Дахин давтахад итгэл үнэмшилгүй бат итгэл гэж үгүй билээ. Иймд үзэл суртал зорилгоо тодорхойлох, хүмүүст

хүргэж ойлгуулах чадвараараа шинжлэх ухаанаас хавьгүй илүү байдгийн олон жишээг бид мэднэ.

Улс төрийн зохиол, бүтээлээс харахад улс төрийн үзэл суртлыг тайлбарлах хоёр үндсэн хандлагыг товойлгон авч үзэх боломжтой байна. Нэгд, улс төрийн үзэл суртлыг хэсэг бүлгийн ашиг сонирхолын үүднээс улс төрийн ахуй, бодит байдлыг тусгасан үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр цогц мөн гэж үздэг бол хоёр дахь нь улс төрийн үзэл суртал тухайн нийгмийн улс төрийн дэглэмийн легитим шинжийг нь баталгаажуулдаг үнэт зүйлсийн систем гэдэг. Өөрөөр хэлбэл үнэт зүйлс нь улс төрийн үзэл суртлын түвшинд тавигдсанаар итгэл үнэмшил, чиг баримжаа өгдөг өвөрмөц чадавхаараа нийгмийн эвдрэл, задралыг тогтоон барьж нийт үндэстний эв нэгдэл, эрч хүчийг хангах чадвартайг онцолж байна. Энэ хоёроос эхнийх нь манай орны орчин үеийн улс төрийн ухамсар, сэтгэлгээнд зонхилж ирсэн бололтой. 1980-аад онд германы улс төрч У.Матц үзэл суртал нь нийгэм ноцтой хямарсан үед гарч ирсэн үнэт зүйлсийн систем гэсэн санаа дэвшүүлж, хэрэв дундад зуунд шашин хүмүүсийг нэгтгэж байсан бол одоо үүнийг төр үзэл суртлын тусламжтай хийх ёстойг гэсэн нь сонирхол татдаг. Энэ бүхнээс дүгнэн үзвэл үзэл суртал улс төрд чухал үүрэгтэйгээр үл барам учир шалтгааныг тодорхойлогч шинжтэй гэж үзэх үндэс байна. Европ, Америкд капитализм, зах зээлийн харилцааны хөгжлийн нөлөөгөөр анги бүлгийн хүчтэй ялгарал гарч тэдний ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалсан улс төрийн үзэл суртлууд үүссэн тэдгээр орнуудтай харьцуулан үзэхэд бидний ойлгож байгаагаар монголчуудын хувьд улс төрийн үзэл суртлын ийм уламжлал ХХ зууны эхэн хүртэл байгаагүй, харин этатист ухамсар, сэтгэлгээ голлож байсан бололтой. Харин хоёр дахь хандлагын тухайд гэвэл үзэл суртал үнэт зүйлсийн систем болохынхоо хувьд монголын төрт ёсны түүхэнд улс төрийн үзэл суртал огт үгүй байсан гэж үзэх нь учир дутагдалтай болно. Учир нь монголчуудын олон зууны туршид хуримтлуулсан соёлын өвийг үнэт зүйлсийн соёл гэж болох бөгөөд түүний дотор улс төрийн үнэт зүйлс дээгүүр зиндаанд тавигдах нь зүйн хэрэг билээ. Төрөө дээдлэх ёс, үндэс угсаа, хэл соёл, эх нутгаа гэх сэтгэл, үзэл бодол монголчуудын улс төрийн соёлын цөм болж үнэт зүйлсийнхээ хувьд үндэстнээ бэхжүүлэн нягтруулж ирсэн бөлгөө. Хүчтэй төр, хүчтэй удирдагчийг хүсэмжлэх нь ард олон дарангуйлагчийг мөрөөдсөн хэрэг огтхон ч биш, харин ёс суртахуун, дэг журам, сахилга, үүргийг хүндэтгэн дагадаг монголчуудын төрт ёсны өнө эртний “инстинк”-ийн илрэл гэвэл зохилтой. Монгол түмний энэхүү улс төрийн соёл бүхэлдээ үнэт зүйлсээр тодорхойлогддог тул монголчууд эрх ашгаа хамгаалуулах гэхээсээ үнэт зүйлс, эрхэмлэлд илүүтэй итгэж, амьдралын утга учраа тэдгээртэй жишиж ухаарч ирсэн. Ийнхүү монголчуудын хувьд үнэт зүйлсээ даган мөрдөхийг олз ашгаас дээгүүр тавьдаг бөгөөд үнэт зүйлс нь өөрийн үүргээ гэсэн үйл хэргээ гүйцэлдүүлэхэд нь өдөөн дуудах шалтгаан болж өгдөг байжээ.

1920-иод оноос ангич үзлийг тугаа болгосон барууны марксизм Монголд албан ёсны үзэл суртал болж дэлгэрсэн нь үнэт зүйлсээ баримжаалдаг монголчуудын улс

төрийн үнэлэмж, төсөөлөлтэй илт зөрчилдсөнийг туулж өнгөрүүлсэн түүх харуулсан. Үүний зэрэгцээ үндэсний тодорхой үнэт зүйлс социалист үзэл суртлыг хүлээн авахад зарим талаар таатай хөрс болж, үнэт зүйлс, эрхэмлэлээ гэх итгэл тэмүүлэл социализмд итгэх итгэлээр солигдсон билээ. Хэдийгээр марксизм-ленинизмийг монголын нийгмийн оюун санааны үндэс болсныг тунхагласан ч хэрэг дээрээ номчирхол, суртал нэвтрүүлгийн аяс давамгайлж уг үзэл суртал монгол орчинд төдийлөн хэвшиж чадаагүйг 90-ээд оны өөрчлөлт төвөггүй нотолсон юм. Энэ үеэс Монголыг бас “үзэл сурталгүйжүүлэх” үзлийн хаялга тойроогүй бөгөөд марксизм төдийгүй бүх “изм”-ийг үлдэн хөөх аяны хөлд үзэл суртал гэдэг ойлголт давхар нэрвэгдэн улс төрийн үзэл суртлаас цэрвэж болгоомжилж, шүүмжлэх хандлага давамгайлах болсон. 1990 онд марксизмыг эсэргүүцсэн үзэл санааны давалгаа хүчтэй өрнөж байсан үед яруу найрагч Цэндийн Чимиддорж “Болор цом”-ын наадам дээр “мал яаж маллахаа марксизмаар заалгахгүй” гэж шүлэг уншиж шагнал гардан авч, оюутнууд марксизм-ленинизмийг, МАХН-ын түүхийн хичээлийг судлахгүй гэж эсэргүүцэл илэрхийлж байлаа.

Гэсэн хэдий ч 1992 онд батлагдсан Үндсэн хууль, олон ургальч үзлийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн явдал, монголд бүрэлдсэн улс төрийн олон намуудын тогтолцоо, байнгын ажиллагаатай парламентын үйл ажиллагаа зэрэг нь намууд оршин тогтнох хоорондоо ялгаран зааглагдахын тулд өөрийн гэсэн үзэл баримтлалтай байх шаардлага тэр үеийн нөхцөл байдлаас зүй ёсоор урган гарсан юм. Үүнээс үүдэн улс төрийн хүчнүүд үзэл суртал тийш эргэж, нэгэн цагт гэрийн хаалгаар гарч одсон “изм”-үүд өөр дүр төрхийг олж гэрийн тооноор буцаж ирсэн гэж хэлж болно. Учир нь намууд үзэл санааны төлөвшлийг олохдоо барууны сонгодог улс төрийн үзэл суртлуудыг баримжаалж эхэлсэн юм. Нийгэмд янз бүрийн үзэл санаа баримтлалууд зэрэгцэн орших, өрсөлдөх, харилцан үйлчлэх, бие биеэ нөхөн сэлбэх, ойртох, ижилсэх үйл явц идэвхижин одоо хэр үргэлжилсээр байна. Энэ зурвас үеийг үзэл сурталын дискурс гэж нэрлэж болно. Ийм нөхцөлд намуудын үзэл баримтлал ч, үзэл суртал ч үндэсний үнэт зүйлсийн систем, хүн төрөлхтөний нийтээр хүлээн зөвшөөрсөн ардчиллын нийтлэг үнэт зүйлс хоёрын зааг дээр боловсруулагдах учиртай болов уу. Энэхүү дискурсын үед улс төрийн нам, хүчнүүдийн улс төрийн үзэл баримтлалын нийтлэг бааз суурь нь үндэсний ардчилсан үзэл байх болов уу гэж бид дараах зүйлийн иш үндэс болгон үзэж байна. Уг үзэл суртал нь үндэсний хийгээд ардчилсан нийтлэг үнэлэмжийн харилцан шүтэлцэлийн төвлөрсөн илэрхийлэл байх болно. Энэ үзлийн үндсэн бүрдэл нь монгол түмний үндэсний ухамсар, уламжлалт соёл, гүн ухаан, үзэл бодол, сэтгэл зүйн цогцолбор бөгөөд өөрийн төрт ёсоо хэрэгжүүлж байгаа монгол түмний улс төрийн ухамсрын илэрхийлэл болсон үндэсний үзэл санаа юм. Гэхдээ бид үндэсний үзлийн тухай ярихдаа үндсэрхэг үзлээс ялгаж ойлгож байгааг энд зориуд тэмдэглэж байна. Улс төрийн системийн нэг бүрдвэр нь улс төрийн ухамсар, улс төрийн соёл, улс төрийн үзэл суртал байх учиртай. Уг нь төрийн эрх барих болсон намууд өөрсдийн үзэл сурталаа төрийнх гэж тулгаад байхгүй аль ч намын

эрх барьж буй үед мөрдөгдөж болохуйц төрийн үзэл суртлыг боловсруулж мөрдөх нь чухал билээ. Энэ бодомжийн араас төрийн “хар” хайрцагны бодлого гэгч яригдах ёстой. Улс төрийн намуудын үзэл суртал нь төрийн бодлого, бүхэл бүтэн үзэл баримтлалын тулгуур нь болж өгөх учиртай. Плюраль ардчилалын нөхцөлд аль нэг үзэл суртлыг амьдрал дээр сонгуулийн дүнгээр парламентад олонхи суудал авсан намын үзэл суртал тухайн үедээ давамгайлах шинжтэй байж болохыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ сонгуулийн үр дүнгээс үл шалтгаалан залгамжлан авах зарчмууд, суурь үнэт зүйлстэй байдгаараа төрийн бодлого онцлог юм. Одоогийн олон ургальч үзлийн нөхцөлд янз бүрийн үзэл суртлуудын өөр хоорондын зөрчилдөөн тэмцэл зөвхөн үзэл санааны өрсөлдөөний хүрээнд л байх учиртай. Энэ явцад олон түмний сэтгэл санаа оюун ухааныг эзэмдэн гарч ирсэн үзэл суртал төрийн өмнө тулгарч байгаа зорилтуудыг шийдвэрлэхэд том хүч болох нь дамжиггүй. Тиймч учраас өнөөгийн нөхцөлд үзэл суртлын үүрэг, ач холбогдол өндөржиж байна. Намууд төрийн бодлого боловсруулж тодорхойлох гол институт. Намууд байна гэдэг бол үзэл суртал байна гэсэн үг. Нам бол улс төрийн хэсэг бүлэг. Үзэл суртал бол тэрхүү хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалдаг үнэт зүйлсийн систем. Өрнөдийн нэртэй судлаач И.Ильин 1956 онд Мюнхенд хэвлүүлсэн “Хууль зүйн ухамсрын мөн чанарын тухай” номондоо “намын хөтөлбөрийг төрт ёсны шинжтэй болгож чадах цорын ганц хүч бол хууль зүйн боловсронгуй ухамсар. Ийм ухамсар байвал нэг нам нөгөө намаасаа тухайн нам хэний эрх ашгийг хамгаалж байна вэ? Гэдгээр ялгарахгүй. Харин энэ нэгдмэл эрх ашгийг хэрхэн ойлгож байна вэ? Гэдгээрээ ялгарана. Тэгвэл намуудын тэмцэл нь анги, бүлгүүдийн санаархлын өрсөлдөөн бус, улс төрийн янз бүрийн ойлголтын маргаан байх болно. Ийм нөхцөлд улс төрийн бодлого далд иргэний дайны шинжтэй байхаа больж, жинхэнэ өндөрлөгтөө хүрнэ. Зорилго нэг байхад өөр өөр ойлголтын талынхан маргалдах нь бүтээлчээр хамтран ажиллах боломж бий болгоно. Ингэхдээ улс төрийн бодлого зах зээлийн үймээн шуугиан шиг юм байхгүй, харин эв санаагаа нэгтгэх эрэл, жам ёсны зөв зүйтэйн сургууль байх болно” гэжээ. Ер нь үзэл суртал намын үзэл баримтлалын суурь дэвсгэр болдог утгаар нь либераль, консерватив, социалист, социал-демократ, коммунист гэж ангилагддаг. Монголын намууд хэдийгээр хөтөлбөр, баримт бичгүүддээ үзэл баримтлалаа тусгасан байдаг ч ялгаа нь төдийлөн харагдахгүй байна.

Бодлогын хувьд амлалт, популист хөтөлбөр зонхилсон олон нийтийн сэтгэл хөдлөл, амьдралын гачаал, хүндрэл бэрхшээл тоочсон, бас тооцсон прагматик тал нь давамгайлсан бодлого явуулаад байх шиг. Намууд нэгдэх, салах явдал их гарах болсон. Зүүний болон барууны чиглэлийн нэгдэж байгаа нь парадокс. Улс төрийн засаглалын дээд эрх мэдэлд хүрэх л гэсэн санаархал зорилго нь давамгайлж үзэл суртлаар “мангаа” хийж улс орныг хөгжүүлэх цогцолбор үзэл баримтлалын уралдаан өрсөлдөөнөөс зайлсхийж байгаатай утга нэг болж байна. Уул нь намууд энэ тал дээр үзэл номлол, оюунаа уралдуулж улс орон хөгжих альтернатив бодлого боловсруулж

өрсөлддөг баймаар. И.Ильин бичихдээ "хэрэгжиж болох эсэх" зарчмын үүднээс намууд "хамгийн дээд" ба "наад захын" хоёр хөтөлбөртэй байх бөгөөд тэгэхдээ..."хамгийн дээд хөтөлбөр" нь нарийндаа бол хөтөлбөр ч биш, санааны зорилгыг өгүүлсэн байна.Өөрөөр хэлбэл бидний ойлгож байгаагаар улс орны хөгжлийн тухай цогц үзэл баримтлал юм. Нийгмийн,улс төрийн хөгжилд өөрийн зайлшгүй дэс дараалал байдаг. Тэр дарааллыг алдагдуулбал уршиг балаг нь удахгүй мэдэгдэж нам гайтай утгагүй үйлдлийн замд орж,төрийг хөнөөнө гэсэн байдаг. Эндээс дүгнэж үзвэл манайд энэ шилжилтийн үед үзэл суртал хэрэгтэй байна гэж хэлж болмоор. Германы улс төрч У.Матц (1992) үзэл суртал нь нийгэм ноцтой хямарсан үед гарч ирсэн үнэт зүйлсийн систем. Дундад зуунд шашин хүмүүсийг нэгтгэж байсан бол одоо төр үүнийг үзэл суртлын тусламжтай хийх ёстой гэсэн нь бидний сонирхол татаж байгааг дахин тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тиймээс үзэл суртал улс төрд чухал үүрэгтэйгээр үл барам учир шалтгааныг тодорхойлогч шинжтэй гэх үндэс байна. Намуудын үзэл баримтлалаар дамжуулж олон нийтийг нэгтгэх, нягтруулах, дайчлах хэрэгцээ их өсч байна. Нам үзэл суртлаа сайн боловсруулна гэдэг бол мэдээж нарийн чимхлүүр ажил. Онолын, оюуны өндөр мэдлэг, соёл, туршлага шаардах нь зүйн хэрэг. Намууд үүнээс шантарч, зайлсхийж боломгүй. Энэ бол хариуцлага,ёс зүйн шаардлагын асуудал.Нам бол маш том улс төрийн хүчтэй бүлэг. Эгнээндээ мянга мянган янз бүрийн ажил, мэргэжлийн иргэдийг багтаасан бүлэг. Энэ бол асар том потенциал хүч, нөөц мөн. Харин үзэл баримтлалаас хөндий байхыг хэн хүсдэг вэ? гэвэл карьер хөөгчид. Тэд үзэл баримтлалынхаа төлөө хариуцлага хүлээхээс айдаг, үзэл баримтлалыг хоосон популист амлалтаар орлуулахыг хичээдэг. Энэ бол нам доторхи хэсэг бүлгийн оюуны ядуурал, хоосрол биш үү. Үзэл суртлууд интеграцчилагдаж байгаатай холбоотойгоор намууд ижилсэх, ойртох хандлагатай болж бас үзэл суртлууд бие биесээ нөхөн сэлбэж зэрэгцэн оршоод үнэт зүйлсээрээ баяжаад явж байна. Энэ утгаараа манайд социаль ардчилал өрнөж байна гэсэн үг. М.Вебер намыг тодорхойлохдоо улс төрийн нам нь үзэл санаа нэгтнүүд чөлөөтэй эвлэлдэн нэгдсэн нийгмийн холбоо юм. Намууд гол төлөв хөтөлбөртөө тодорхойлсон бодлогоо амьдралд хэрэгжүүлэх эрмэлзэлтэй иргэдийн холбоо, тиймээс намуудын зохион байгуулалтын хэлбэр тодорхой хэмжээгээр үзэл суртлаар тодорхойлогддог. Жишээ нь: АНУ-д гол хоёр нам болох Бүгд Найрамдах нам, Ардчилсан нам "нээлттэй" намууд бөгөөд гишүүнчлэлээсээ өгсүүлээд сонгуулийн өмнөх кампанийг хэрэгжүүлэхдээ тодорхой зохион байгуулалтанд ордог. Аль нэгэн анги бүлгийн эрх ашгийг марксизмийн үзэл суртлаар намын харьяалалд багтаадаг улс төрийн практик үеэ өнгөрөөжээ. Эл асуудлаар Англи, Итали, Германд олон нийтийн дунд явуулсан судалгаа санал асуулгын дүнгээс тодорхой харж болно. Жишээ нь: Англид өөрийн ангийн харьяалалаа ухамсарласан гурван ажилчин тутмын нэг нь "ажилчны" гэж нэрлэсэн намын эсрэг, харин консерваторуудын төлөө, Италид, Христосын ардчилсан эсхүл барууны бүлэглэлүүдийн төлөө, Германд, Христосын ардчилсан холбооны эсхүл либералуудын төлөө саналаа өгчээ. Харин сонирхолтой нь лейбористууд, коммунистууд, социалистуудыг биеийн

хүчний хөдөлмөртэй огт холбогдолгүй хүмүүсийн давхраа болох төрийн түшмэл, үйлчилгээний хүрээний ажилтнууд, сэхээтнүүд дэмжсэн байх юм. Нам хүчтэй байх тусам бюрократ аппарат хүчтэй байдаг бөгөөд түүний дээд удирдлагад нь намын олон түмний болон сонгогчдын сэтгэл санаа, улс төрийн хүчний харьцааг тооцож улс төрийн шийдвэрийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг олигархи, лидерүүд байдаг байна. Ер нь улс төрийн үзэл суртлын платформ нь ангийн болон шашны хэв маягийн намууд дээр илүү тодорхой харагддаг. Энэ нь үзэл сурталжсан дэглэм бүхий орнууд дахь фашист, коммунист, шашны намуудын хөтөлбөрт тусгалаа олсон байдаг. Тэгэхдээ үзэл суртлын системийн сөрөг үр дагаварын тухай ярихдаа аль ч нийгэм хүмүүсийн үзэл бодлоороо эвлэлдэж нэгдэх хүсэл тэмүүлэл, хэрэгцээг үгүйсгэж чадаагүй, чадах ч үгүйг тэмдэглэх хэрэгтэй.

Улс төрийн системийн системийн бүрдүүлэгч институтүүдийг уг системийн араг яс гэж үзвээс улс төрийн үзэл суртал, улс төрийн ухамсар, соёл нь тэдгээрийг холбогч мах, булчин, судас юм. Эндээс улс төрийн ухамсар, үзэл суртал, улс төрийн системийн хувьд нэг салшгүй дэд систем нь болж байна. Тиймээс улс төрийн системийн бат тогвортой байдлыг хангаж хөгжүүлэх тал дээр төрийн бодлогыг боловсруулж, шийдвэр гаргахад шийдвэрлэх үүрэг хүлээсэн намууд үзэл баримтлал, үйл ажиллагаагаа уралдуулан ажиллах ёстой болов уу. Юуны түрүүн улс төрийн салбарт улс төрийн нэгдмэл үзэл сурталд суурилсан, социаль салбарт иргэд нь сайн сайхан аж төрөх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн, эдийн засгийн салбарт улс орноо түргэн хурдацтай хөгжүүлэх макро, микро бүтэц төлөвшүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй цогцолбор бодлого хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ардчилал зах зээл бол нэг зоосны хоёр тал.

Зах зээл бүхнийг шийднэ гээд зөнд нь хаяж болохгүй. Иймд зах зээлийн сөрөг үр дагаварыг нөхөх бодлого шаардагдана. Энэ нь нийгмийн чиг баримжаатай зах зээлийг хөгжүүлэх талаар намууд үзэл баримтлалаа боловсруулж уралдуулах ёстой болов уу.

Ер нь улс төрийн ном зохиолд индивидуаль болон социаль ардчилалын тухай бичсэн байдаг. АНУ-д нэг дэх чиглэл давуутай хөгжсөн байхад, эх газрын европын улсуудад хоёр дахь чиглэл хөгжсөн байх жишээтэй.

Бидний ойлгож байгаагаар Монголд социаль ардчилал нь илүү тохиромжтой гэж үзэх онолын-практикийн үндэслэл байна.

Ардчилал зах зээлгүйгээр хөгжиж чаддаггүй бол зах зээл ардчилалгүйгээр оршиж болдог гэснийг өрнөдийн улс төрийн шинжлэх ухаан нэгэнт нотолсон. Үүнийг практик дээр манай өмнөд хөршийн хөгжлийн жишээ бодитой харуулж байна. Америкын эрдэмтэн Р.Даль төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг ардчилалд нийцнэ хэмээн үзсэн байдаг нь илүү бодитой үзэл баримтлал гэж бид үзэж байна.

Зах зээл зохицуулалттай байх уу, үгүй юу гэгдээс нийгмийн шударга ёсны асуудал гарч ирнэ. Ялангуяа нийгмийн баялгийг хувиарлахаас үүдсэн аливаа зөрчлийг зрхицуулж шийдвэрлэхээр үйл ажиллагаа явуулж байгаа бол тэнд улс төрийн бодлого заавал байна. Ардчилсан улс төрийн бодлого л эрх чөлөө, тэгш байдлын тусын тулд зах зээлийн урсгал хүчийг хазаарлах бололцоо олгоно.

Тэгш ёс, эрх чөлөө хоёрыг адил хэмжээнд авч үзэх, энэ хоёр хоорондоо таарч тохирч байвал түүнийг нийгмийн шударга ёс гэж үздэг. Эрх чөлөө ямар хэмжээнд байна. Тэр чинээгээрээ нийгэмд шударга ёс тогтдог. Тэгш байдал бол улс төрийн бодлогоор биеллээ олно.

Либераль үзэл тэгш байдлаас эрх чөлөөг /Ж.Локк/, ардчилсан үзэл эрх чөлөөнөөс тэгш байдлыг /Ж.Ж.Руссо/ илүүд эрхэмлэн үздэг. Эндээс дүгнэхэд бүх үзэл суртал дээрх хоёр дээр л тогтдог. Иймд намууд эрх чөлөө ба тэгш ёсыг хооронд нь зохистой холбож өгөх тал дээр үзэл баримтлалаа уралдуулж ажиллах ёстой болов уу. Энэ бол улс төрийн урлаг, улс төрийн зөв бодлого мөн.

Аль ч улс , АНУ , Их Британ, Франц, Орос, Япон , Хятад бүгд хөгжил,соёл ирэншлээрээ өөр өөр ч нэг гол шинжээрээ адил. Бүгд төр улсынхаа зорилгыг хэрэгжүүлэхэд иргэдийг татан оролцуулах сонирхолтой. Иймд үзэл суртал бол орчин үеийн төр улс олон түмнийг дайчлах гол арга хэрэгсэл болдог. Нэг үгээр орчин үеийн үзэл суртал хамтын хүчин чармайлтад хүмүүсийг нэгтгэхийг зорьдог. Үзэл суртал бүрийн зорилго, түүнд хүрэх арга өөр өөр, гэвч үзэл суртал бүр тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд олон түмнийг дайчлахын хувьд нэг юм.

Дестют де Траси үзэл санааны үндсэн зорилго нь нийгэм ба улс төрийг сайжруулахад оршино. Өөрөөр хэлбэл “үзэл санааны шинжлэх ухаан”-аас гаргаж авсан мэдлэгийг нийт нийгэмд хэрэглэх, улмаар хүмүүсийн амьдралыг сайжруулахыг хичээх ёстой гэж үзсэн. Иймд үзэл санаа бүр эхнээсээ улс төртэй нягт холбогдсон нь тодорхой болдог.

Ашигласан ном зохиол

L.Baradat. 1991. Political ideologies. USA

Ги. Эрме. Ги . Культура и демократия. М.,1994

И.Ильин. Хууль зүйн ухамсарын мөн чанарын тухай. Мюнхен.,1956.

Ф.Фукуяма. Конец истории. // США: Экономика, политика, идеология. //1990 №5

У.Матц. Идеологии как детерминанта политики в эпоху модерна // Полис. 1992 №1-2

К.Манхейм. Идеология и утопия // Новое время. 1990 № 14

Ё.Довчин. Улс төрийн үзэл суртлын асуудалд8 МУИС. ЭШБ. 2002. № 8

Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсрын төлөвшлийн асуудалд. МУИС. “Политологи” сэтгүүл .2009. № 4

ПАРЛАМЕНТ ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Д. Болд-Эрдэнэ

доктор, профессор

ШУА-ын Фиолософи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн эрдэмтэн
нарийн бичгийн дарга

Төрийн засаглалын харилцаан дахь улс төрийн намын үйл ажиллагааны гол талбар нь *парламент* юм. Намууд парламентад *бодитой оршин үйлчилж буй сонгуулийн хэлбэрийн дагуу явуулсан сонгууль; сонгогчдын итгэл дэмжлэг; сонгуулийн кампанийн зөв менежмент; намын нөөц чадвар* гэсэн үндсэн механизмаар дамжин орж ирдэг. Парламент дахь улс төрийн намын үүрэг хариуцлагын асуудлыг бодитой авч үзэхийн тулд парламент дахь **“намын байр суурь”, “үүрэг”, “хариуцлага”** хэмээх харилцан хамаарал бүхий нэр томъёо тэдгээртэй холбоотой асуудлыг юуны өмнө тодруулах хэрэгтэй болно.

Парламент дахь намын байр суурь, үүрэг

Парламент дахь *намын байр суурь* нь улс төрийн намын үйл ажиллагааны анхдагч нөхцөл болдог. Намууд эхлээд парламентад улс төрийн бие даасан институтын хувьд хууль ёсны байр сууриа олж авах учиртай, харин үүний дараагаар нь тэдний парламентад гүйцэтгэх үндсэн чиг үүрэг нь хэрэгждэг.

Улс төрийн шинжлэх ухаанд парламент дахь **“намын байр суурь” / position /** хэмээх ойлголтыг *намууд парламентын дотоод үндсэн бүтэцтэй уялдан холбогдож, тэнд засаглалыг хэрэгжүүлэх улс төрийн гол институтын хувьд хууль ёсны статус олж авах хэлбэр буюу парламентынхүрээнд намын легитимжих үзэгдэл* гэж тайлбарладаг.

Парламент дахь намын байр суурь, жин нөлөөг нь түүний *парламентад авсан суудалын тоо буюу мандатын тоогоор/* Англи: *Parliamentary seats*, Орос: *Парламентская места/* хэмждэг. Парламентад орж ирж буй намуудын тоог судлаач М. Лааско, Р.Таагепер, М.Шугарт нар парламент дахь *“намуудын үр ашигтай тоо”* хэмээн нэрлээд / зарим судлаачид *“бодит тоо”* хэмээдэг/ тэдгээрийг тооцох эмпирик судалгааны нарийн аргачлалыг санал болгосон байдаг. Тэдний үзэж байсанаар хууль бүтээх үйл ажиллагаанд намууд саадгүйгээр оролцож, төрийн бодлогод бодитой

нөлөөлөхийг намуудын “*үр ашигтай тоо*” хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь сонгуульд оролцсон намуудын бүх тооноос сонгогдсон нь цөөн байх тохиолдол юм.

Р. Таагепер, М.Шугарт нар бичихдээ: “бүх байгаа намуудын тоог бус, харин намуудын үр ашигтай тоог ашиглахын давуу тал нь ач холбогдол бүхий намуудыг, ач холбогдол багатай намуудаас ялгаж салгах оновчтой арга юм. Хамгийн бага намын төлөөллийн индекс сул байдаг бол бусдаас том намынх нь оролцоо их байдаг” хэмээсэн байдаг.⁴⁰

Монголын өнөөгийн парламентад МАХН -45 /59,2 %/, АН – 28 /36,8 %/ бусад нам, эвсэл 3 /0,04 %/ мандаттай байна. Р.Таагепер, М.Шугарт нарын аргачлалаар тооцож үзэхэд МАХН-ын парламент дахь жин нөлөө бусад намуудаас илүү байх нь илэрхий юм.

Парламент дахь намуудыг байр сууриар нь *олонхи, цөөнх* гэж ангилдаг нь нийтлэг жишиг билээ. Р.Таагепер, М.Шугарт нар парламентын намуудын үр ашигтай тоог *хиймэл буюу бүтээмэл олонхи, бодит олонхи, бодит цөөнх* гэсэн ойлголтоор дамжуулан ялгаж үзсэн байдаг. Тэдний үзэж байгаагаар *хиймэл буюу бүтээмэл олонхи* гэдэг нь томоохон нөлөө бүхий намууд сонгуульд олонхийн санал аваагүй хэрнээ парламентад суудлын олонхийг авах тохиолдол байдаг бол авсан санал, суудлын тоогоороо олонхи болохыг *бодит олонхи* хэмээдэг Харин сонгуульд оролцсон аль ч нам санал, суудлын олонхийг аваагүй бол *бодит цөөнх* гэдэг байна. Манай орны хувьд гол төлөв бүтээмэл болон бодит олонхи (бодит олонхи /1992 /, бүтээмэл олонхи /1996, 2000, 2008/) бүрэлдэж байсан. Харин 2004 онд бодит цөөнх бүрдэж байсан нь сонин баримт юм. 2008 оны парламентын сонгуулиар МАХН парламентын олонхи, АН цөөнх буюу парламентын оппозици болсон билээ. Парламент дахь намуудын байр суурь, статус, жин нөлөөгөөр нь *парламентын эрх баригч нам эвсэл, парламентын сөрөг нам, парламентад суудалтай нам, парламентын гаднах буюу бүртгүүлсэн нам* гэж ялгаж үзэж болдог.⁴¹

Хүснэгт №1 Парламентын намуудын үр ашигтай тоон хэв шинж

Намын үр ашигтай тоон хэв шинж	Монголд
<i>Бүтээмэл олонхи</i>	1996, 2000, 2008
<i>Бодит олонхи</i>	1992
<i>Бодит цөөнх</i>	2004

Намууд парламентад зохих тооны мандатаа авч, байр сууриа эзэлсэний дараа тэдгээрийн **парламент дахь үүрэг** хууль ёсны шинжтэй болдог. *Намын парламент*

⁴⁰ Л.В. Сморгунув. Намын системийн эмпирик шинжилгээ. Бодлогын шинжилгээ –II. /Эрдэм шинжилгээний бичиг /. УБ.,2008. 140 дахь тал.

⁴¹ Д.Болд-Эрдэнэ . Монголын улс төрийн нам, намын системын төлөвшил. УБ., 2008.

дахь үүрэг /функц/ гэдэг нь *парламентын оршин тогтнох түүний хэвийн тогтвортой байдлыг хангах намуудын оролцоо, үйл ажиллагааны тодорхой төрөл хэлбэрийн систем* юм. Парламент дахь олонхи буюу эрх баригч намын үндсэн үүрэг нь *бодлого боловсруулах, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах* явдал байдаг бол парламентын цөөнх буюу сөрөг нам хүчин нь *олонхийг шүүмжлэх, хяналт тавих, бодлого, шийдвэрийн альтернатив хувилбарыг санал болгох* үндсэн үүрэгтэй байдаг. Өнөөдөр МАХН эрх баригч намын үүргийг хүлээж байгаа бол АН парламентын оппозици нам мөн билээ. Манай өнөөгийн УИХ-д албан ёсны оппозици байхгүй хэмээн зарим судлаачид үздэг. Үүнд үнэний хувь бий боловч АН-д парламентынхүрээнд олонхийг хянах, шүүмжлэх боломж механизм ямар нэг хэмжээгээр байгаа юм.

Парламент дахь намуудын хариуцлага

“Хариуцлага” хэмээх категори философи, улс төр, эдийн засаг, эрх зүй, төрийн удирдлага, сэтгэл судлал зэрэг олон шинжлэх ухааны зааг уулвараас авч үздэг. Философи утгаараа хариуцлага гэдэг ойлголт нь “...хохирол гаргахгүй байх эрмэлзлэл юм. Иймээс хариуцлага хүлээх гэдэг бол хохирлыг нөхөх явдал юм” гэж судлаач Б.Даш-Ёндон онцолсон байна.⁴² “Хариуцлага” хэмээх ойлголт нь олон талт хэлбэр дүрстэй. Сэтгэгч Карл Поппер “*Нээлтэй нийгэм ба түүний дайснууд*” гэдэг номондоо “*Ёс суртахууны хариуцлага*”, “*шийдвэр гаргах хариуцлага*”, “*хувийн хариуцлага*”, “*бүлгийн хариуцлага*”, “*сонголт хийх хариуцлага*” гэсэн үгнүүдийг олноор хэрэглэсэн болохыг судлаач Б.Даш-Ёндон гярхай анзаарсан байдаг.⁴³ Нийгмийн хариуцлагын нэг том хэлбэр нь улс төрийн хариуцлага юм. Улс төрийн хариуцлагын нэг үндсэн бүрдэл нь улс төрийн намын хариуцлага юм. Харин намын хариуцлагын гол хэлбэр нь *намын парламент дахь хариуцлага* мөн билээ.

Хариуцлага түүнийг хүлээх эзэн зайлшгүй байх ёстой. Үүнийг улс төрийн шинжлэх ухаанд “*хариуцлагын субъект*” хэмээн нэрлэдэг. Улс төрийн хариуцлагын нэг гол субъект нь *нам* юм. Улс төрийн намын парламент дахь хариуцлагыг түүнд эзлэж буй намуудын байр суурь, жин нөлөө, гүйцэтгэх үүрэгтэй нь холбон авч үзэж болно. Энэ тохиолдолд парламент дахь намын хариуцлагыг хэв маягаар нь “*эрх баригч олонхын намын хариуцлага*”, “*оппозици цөөнхийн намын хариуцлага*”, “*парламентад суудалтай намын хариуцлага*” хэмээн ялган зааглаж болох юм. Харин хэлбэр дүрсийн хувьд нь “*бодлого боловсруулах хариуцлага*”, “*бодлого тодорхойлох хариуцлага буюу шийдвэр гаргах хариуцлага*”, “*шүүмжлэх хариуцлага*”, “*хянах хариуцлага*”, “*альтернатив бодлого санал болгох хариуцлага*” хэмээн ангилж болмоор санагдана. Түүнчлэн “*ашиг сонирхолыг нэгтгэх буюу сонирхолын агрегаци хийх хариуцлага*”, “*намын төлөөлөх хариуцлага*”, “*хянах хариуцлага*”, “*ёс зүйн хариуцлага*” гэж ялган үзэж ч болох билээ.

⁴² Б.Даш –Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. Оюуны ертөнц. 2009 №1, 11 дахь тал.

⁴³ Б.Даш –Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. “Оюуны ертөнц” сэтгүүл. 2009 №1,8-9 тал.

Намын төлөөлөх хариуцлага.

Нам нь нийгэм дэх олон бүлэг, давхаргын эрх ашиг, санаа бодлыг өвөрмөц байдлаар төлөөлөн илэрхийлэгч институц болдог. Иймд улс төрийн намын парламент дахь нэг чухал үүрэг нь төлөөлөх чиг үүрэг байдаг. Энэ нь нийгмийн олон сонирхолуудыг намууд парламентад төлөөлөн илэрхийлж буй байдлын түвшин юм. Үүнтэй уялдан парламент дахь намын төлөөлөх хариуцлагын тухай асуудал гарч ирдэг. Намын төлөөлөх чиг үүргийн тухай Л.Даймонд, Р.Гюнтэр нар бичихдээ: "...нийгмийн төлөөллийн чиг үүрэг нь сонгуулийн үеэр бүлгүүдийн дэмжлэг авахын төлөө өрсөлдөөний явцад илрэнэ. Мөн сонгуулийн дараа буюу хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх үеэр хууль тогтоох салбарт илрэнэ."⁴⁴ гэсэн байдаг. Эндээс үзвэл парламентад намууд төлөөлөх чиг үүргээ дагасан хариуцлагыг ямагт хүлээж байдаг нь тодорхой юм.

Харин намын төлөөлөх хариуцлага нь ***нэгд*** намын бодлого хөтөлбөрийг дэмжигчдийн эрх ашиг, санаа бодлыг төлөөлөх хариуцлага, ***хоёрт*** тухайн намын нэрийн өмнөөс төрийн засаглалын бүтцэд ажиллаж буй гишүүдийн эрх ашгийг төлөөлөх хариуцлага, ***гуравт*** намын удирдагч, лидер манлайлагчдыг төлөөлөх хариуцлага, ***дөрөвт*** намын бодлого, хөтөлбөрийг төлөөлөх хариуцлага зэргээр тус бүр төвлөрөн илэрдэг гэж үзэж болохоор байдаг.

Манай намуудын хувьд төлөөлөх хариуцлагын мэдрэмж нь харилцан адилгүй байгаа юм. Гэхдээ манай намууд парламентад ямар ч атугай төлөөлөх хариуцлагаа ухамсарлаж, үүргээ гүйцэтгэх байгаа гэдэгтэй маргах хэрэггүй. Харин манай намуудын төлөөлөх хариуцлагыг ухамсарлан мэдэрч байгаа байдлын түвшин, хариуцлагын хэрэгжилт цаг үеийн шаардлага, шалгуурт хэр зэрэг нийцэн тохирч буй эсэхийн тухайд марган хэлэлцэх, шүүмжлэх, засч залруулах зүйл багагүй бий.

Намын төлөөлөх хариуцлагын хэрэгжилттэй холбогдон гарч ирсэн нийтлэг нэгэн шүүмжлэл бол *парламент дахь намууд гишүүд, дэмжигчид, олон түмнээсээ тасран салж, тэдний эрх ашиг сонирхолыг парламентад хангалттай төлөөлж чадахгүй байгаа тухай* асуудал юм. Олон түмний итгэл дэмжлэг бол улс төрийн алив намын хувьд онцгой чухал юм. Хэрвээ нам итгэл, дэмжлэгээ алдвал улс төрийн нөлөө, байр сууриа алдаж буй хэрэг бөгөөд үүнгүйгээр нам улс төрд бодитой орших аргагүй болдог. Тиймээс олон түмний итгэл дэмжлэг нь намын орших, эс оршихын нэгэн хэмжүүр болж байдаг нь үүнтэй холбоотой юм. Ингэхлээр улс төрийн намын парламент дахь төлөөллийн үйл ажиллагааны нэг үндсэн хэлбэр нь жирийн гишүүд, дэмжигчид, сонгогч олон түмний нийтлэг ашиг сонирхолыг хамгаалан илэрхийлэх явдал юм. Харамсалтай нь манай улс төрийн намууд жирийн гишүүд дэмжигчид, сонгогч олон түмний язгуур эрх ашгийг

⁴⁴ Edited by Larry Diamond and Richard Gunther. "Political Parties and Democracy" \ The Johns Hopkins University Press. Baltimore and London. 2001. \ pp. 8

хамгаалан илэрхийлэх тал дээр бага анхаарал хандуулдаг нь нууц биш билээ. Монголын улс төрийн намуудыг жирийн гишүүд болон нийгэмээсээ хэдийнээ тасран хөндийрсөн атлаа намын нэрээр нэр хүнд албан тушаал горилогчид, намын мөнгө санхүүгийн цөөхөн тооны олигархи бүлэглэлийн эрх ашгийг үхэн хатан хамгаалж байдаг. Намууд сонгуулийн үед л сонгогч түмнээ сая санаж, ухаан орцгоодог гэсэн шүүмжлэл нийгэмд ихээхэн газар авсан нь ажиглагддаг. Үүнтэй уялдан намуудыг “олигаржсан” бүлэглэл төдий болж хувирлаа хэмээн үзэх болсон.

Парламент дахь намын бүлгийн гишүүдийн төлөөлөх хариуцлагыг тооцож чадахгүй байгаагийн нэг илрэл нь *гишүүдийн тойргийн сонирхолд хэт хөтлөгдөсөн сэтгэл зүйг даван туулж чадахгүй байгаа явдал* юм. Сонгогдсон тойргынхоо сонгогчдын төлөө санаа тавих нь манай парламентын гишүүдийн хувьд зүйтэй боловч түүндээ хэт хөтлөгдөн өөрийн үндсэн үүргээсээ гажсан зүйлээр хөөцөлдөж аж ахуйн жижиг асуудалтай хэт хутгалдан, худаг ус гаргах, сургууль, эмнэлэг барих гэх мэтэд хөрөнгө мөнгө ахиу хуваарилуулах гэж зүтгэдэг нь яавч сонгогчдоо төлөөлсөн хэрэг биш билээ. Зүй нь тэрхүү аж ахуйн асуудлыг зөв зохистой шийдвэрлүүлэх бодлогын шинжтэй шийдлийг тухайн хууль тогтоомжид “суулгуулах” талаар анхаарч ажиллах, холбогдох салбарын яамдын сайд нарт асуулга тавих шаардлага өгөхийн төлөө ажиллаж байвал сая зөв зүйтэй төлөөлөл болохсон билээ.

Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх нэг томоохон чиг үүрэг бол *төрийн албаны байгууллагад өөрийн төлөөлөгчдийг шилж сонгон дэвшүүлэх, ажиллуулах, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төлөөлөх явдал мөн* билээ. Хэдийгээр төрийн алба бусад байгууллагад ажиллаж буй өөрийн албан хаагчдыг нам төлөөлөн хамгаалах нь түүний нэг үүрэг мөн боловч энэ нь илэрхий ажлын хариуцлага алдсан, ёс зүйн алдаа гаргасан, чадвар мэдлэг муутай хүмүүсийг илтэд хамгаалан хайцаална гэсэн үг бишээ. Намын “*эрх ашгийн төлөөлөл*”-ийн үйл явц нь ямар ч нөхцөлд хуулийн хүрээнд шударга, ил тод байх учиртай. Гэтэл манай намуудын хувьд байдал тэр бүр ийм байж чадахгүй байна. Өнөөдөр олон түмэнд итгэл алдсан, ажлын хариуцлага муутай, гэмт хэрэгт холбогдсон, мөнгө төгрөг идэж шамшигдуулсан, хуйвалдаан, хутган үймүүлэх үйлд гаргуун хүмүүс намд орох тэр дундаа бүр нөлөө бүхий намд шургалахыг оролдох, түүнийг нь ч намууд хайцаалан өөгшүүлэх, тэр ч байтугай өндөр албан тушаалд дэвшүүлэн ажиллуулах явдал мэр сэр байсаар байна. Хариуцлага тооцоход намчирхан ялгаварладаг, намын нэрээр ял завших нь ч байна. Сонгогч олон түмнийг тохуурхан, худал ярьж амладаг этгээдүүд намд шургалан том намын хаалт халхавчинд ордог явдал ч гарч байна. Энэ бүхэнд намын зүгээс тодорхой хандаж, шударга зарчимч шүүмжлэл өрнүүлэх явдал тэр бүр харагдахгүй байна. Энэ байдал нь улс төрийн намын “*эрх ашгийн төлөөлөл*”-ийн үйл явц буруу зохисгүй голдирлоор явагдах үүд хаалгыг нээж өгөхөд шууд нөлөөлж байна.

Өнөөдөр улс төрийн намуудын удирдагчдын нэр хүнд, чансаа төдий л сайнгүй байна. Тэгсэн атлаа өөрийн нэр хүндийг намаараа хайцаалдаг, түүнд дулдуйддаг, үл тоомсорлодог, мэдэн будилдаг, олон түмнийг басамжилдаг явдал байсаар байна. Энэ бүхэнд нам хариуцлага тооцдоггүй, намын дотоод асуудал нэрээр хойш тавьдаг, мартагнуулдаг явдал байх учиргүй юм. Зүй нь намын нэрийн өмнөөс шударга үнэнч ажилласан, улс орондоо их зүйлийг хийж бүтээж буй жирийн гишүүд, дэмжигчид, намын сонгуульд албан тушаалтнууд, лидер манлайлагчдаа нам хуулийн хүрээнд үнэн зөв, бодитой дэмжиж туслах, хохирсон эрх ашгийг нь төлөөлөн хамгаалах учиртай юм. Тэгэхдээ өнөөдөр төрийн ихэнх албан хаагчид намаасаа хууль ёсоор түдгэлзсэн тохиолдолд намуудын “эрх ашгийн төлөөлөл”-ийн хүрээ нилээд хумигдах болсоныг анхаарахгүй байх аргагүй. Хэдий тийм боловч улс төрийн намын чиг үүргийн системд намын “эрх ашгийн төлөөлөл” байсаар байх нь мэдээж билээ. Ийм тохиолдолд монголын улс төрийн намууд сонгогч олон түмэн, жирийн гишүүд дэмжигчид, намын сонгуульд болон төрд зүтгэж буй улс төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах, түүнийг төлөөлөн илэрхийлэх явдалд намын үйл ажиллагааны чухал чиглэл байх учиртай юм.

Нийгэм дэх ашиг сонирхлыг нэгтгэн уялдуулах \агрегаци\ хариуцлага.

Нам нь парламентад сонирхолын артикуляци, агрегацийн аль алиныг нь гүйцэлдүүлэх чадвартай өвөрмөц институц юм. Америкийн нэрт судлаач Г.Алмонд, Дж. Пауэлл, К.Стром, Р.Дальтон нар сонирхолын агрегаци хийх нь улс төрийн намын гол үүрэг байдаг тухай бичихдээ: “Ашиг сонирхолын агрегаци бол иргэд бүлгүүдийн улс төрийн шаардлага нэгтгэгдэж улс төрийн бодлогын хөтөлбөр болох үйл ажиллагаа юм. Ардчилсан хийгээд ардчилсан бус системүүдэд ашиг сонирхолыг нэгтгэхэд улс төрийн намууд онцгой чухал рольтой байна. Нам бүр \эсвэл түүний нэр дэвшигчид\ ямар нэг улс төрийн бодлогын төлөө байж, үүнийгээ дэмжүүлэхэд эвслийг бий болгохыг эрмэлздэг.”⁴⁵ хэмээн бичсэн байдаг. Эндээс үзвэл намуудын хувьд нийгэм дэх олон ашиг сонирхолыг нэгтгэн уялдуулах үүрэг нь тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үндсэн бөгөөд гол чиг үүрэг болох нь тодорхой байна. Намууд ашиг сонирхолыг нэгтгэх үндсэн дээр улс төрийн бодлогын зохистой байж болох хувилбарыг боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэхийг зорьж байдагаараа улс төрийн бусад институцээс ялгагдах онцлогтой байдаг.

Монголын улс төрийн намууд улс төрийн үзэл санаа, бодлогын хувьд барууны хийгээд зүүний тэгэхдээ тэдгээрийн төвч үзэл санаа, бодлого, байр суурийг чиг баримжаа болгож байгаа юм. Зүүн төвийн үзэл түүнд суурилсан бодлого байр суурийг МАХН, харин баруун төвийн үзэл, бодлогыг Ардчилсан нам \АН\ ерөнхийдөө баримжаалж буй болно. Монголын бусад гуравдагч намуудын хувьд дээрх томоохон намуудын үзэл, байр

⁴⁵ Г.Алмонд, Дж. Пауэлл, К.Стром, Р.Дальтон “Харьцуулсан улс төр” \ онолын хүрээ \ . УБ., 2005. 112 дахь тал.

суурийг дагаж ялгарсан шинжтэй байна. Ингэхлээр Монголын нийгмийн улс төрийн намуудын үзэл санааны спектерийн ерөнхий хандлага нь улс төрийн үзэл санааны барууны болон зүүн төвийн үзэл санаа, бодлого болж байна.

Гэвч МАХН болон Ардчилсан нам, бусад намуудын сонирхолын агрегацийн дүнд боловсрогдсон бодлого, хөтөлбөр, парламентад гаргаж буй шийдвэрээс үзвэл тухайн намуудын бодлого, чиглэлээс нилээд зөрсөн, их төлөв нийгмийн халамж, үйлчилгээг гололсон, популист маягийн, хэрэгжих боломж магадлал муутай, амлалтын шинжтэй зүйл нилээд тусгагдсан нь харагддаг. Энэ байдал тус намуудын бодлого, хөтөлбөрийн ялгамж зөрөөг бүдэгрүүлж, улс төрийн чухам аль чиглэлийн баримтлал, бодлоготой нам болохыг таниж мэдэхэд бэрхшээл учруулдаг. Манай намуудын баримтлан явуулж буй эдийн засгийн болон бусад чиглэлийн бодлого, шийдвэрт барууны гэхээсээ их төлөв зүүний чиглэлийн баримтлал давуутай илэрдэг нь нийтлэг зүйл болжээ. Энэ нь юуны өмнө сонгуулийн үеэр өөрийн суурь бодлого, чиглэлээсээ хазайж, сонгогчдын санал, дэмжлэгийг илүүтэй авахын тулд явуулсан алсын хараагүй, тактикийн хувьд буруу үйл ажиллагаанаас үүдэлтэй болох нь тодорхой байна.

Манай улс төрийн намуудын хувьд бодлого үзэл санаагаа сонгуулийн хөтөлбөртөө тусгадаг ч энэ нь их төлөв бодит байдал, амьдралаас хол хөндий, нөхцөл байдлын бодит шинжилгээнд төдийлөн суурилж чаддаггүй, тэгсэн атлаа их төлөв сонгогч олон түмний сэтгэл зүйд нийцүүлсэн хоосон амлалт, үл биелэх утопи төлөвлөгөөг чухалчилдаг нийтлэг дутагдал ажиглагддаг. Нийгмийн чиглэлийн амлалт, их хэмжээний мөнгө төгрөг өгөх, ойр зуурийн ахуй хэрэгцээний болон бусад цаг үеийн амь аргацаасан амлалт, үйл ажиллагаа намуудын сонгуулийн хөтөлбөрийн гол чиг шугам болж буйг нуух хэрэггүй юм. Тухайлбал 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр МАХН болон АН-ын гаргаж тавьсан эх орны хишиг, эрдэнийн хувь, сая болон сая таван зуун мянган төгрөг, хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл бологсодын таван зуун мянга зэрэг нь эдийн засгийн их хямралын үед улсын төсөвт ихээхэн хүндрэл учруулж буйн зэрэгцээ намуудын улс төрийн унаган үзэл бодлоготой нь төдийлөн таарч нийцэхгүйд хүргэж байна. Тэр ч байтугай намуудын зарим биелэх биелэхгүй сонгуулийн үеийн амлалт нь сонгогчдийг доромжлон басамжилсантай эгээ адил утгаар ойлгогдоход хүрч байгаа билээ. Энэ бүхэн нь намуудын парламентад хийх ашиг сонирхолын агрегацийн үйл ажиллагаанд ихээхэн саад тотгор, асуудал бэрхшээлийн үүсгэж байгаа юм.

Парламент дахь намын сонирхолын агрегаци хийх үйл ажиллагааны хариуцлагын нэг бүрдэл нь намууд бодлоготой, үнэнч тууштай зогсож, түүнийгээ хамгаалах явдал юм. Гэхдээ энэ нь нөхцөл байдлын өөрчлөлт хувиралын мэдрэмж муутай, хэт хатуу, муйхарлан зүтгэх байдлаар бодлогоо хамгаалах гэсэн үг ерөөс биш юм. Намын бодлогын төлөөллийн хамгаалах хэлбэр нь нам тухайн цаг үеийн нөхцөл байдал, хүн ардын бодол санаа, сэтгэл зүйн өөрчлөлт хувьсал, эгзэг ээдрээг бодитой мэдрэн түүндээ

нийцүүлсэн уян хатан бодлого хөтөлбөрийг баримтлах, шаардлатай үед зарим зохистой өөрчлөлт оруулах тэр ч байтугай буулт хийх чадвар байдаг. Үүнийг бодлогын хий эргэлт, эргэж хургах, эргэлзэн тээнгэлзэх, үндсээр нь өөрчлөх гэсэн утгаар биш, харин бодлогоо өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэн улам чамбайруулан төгөлдөржүүлэх гэсэн утгаар ойлгох хэрэгтэй юм. Энэ бүхнээс үзвэл бодлогын төлөөлөл гэдэг нь шууд утгаараа нам бодлого, хөтөлбөрөө уян хатан тэгэхдээ тууштай хамгаалан төлөөлөх явдал мөн ажээ. Монголын намууд бодлогын төлөөллийн энэ чухал зарчмыг улс төрийн үйл ажиллагааныхаа гол чиглэл болгох нь зохистой байна. Учир нь манай намуудын хувьд өөрийн үндсэн бодлого үл авцалдах тэс өөр бодлого баримтлах эсвэл бодлогоо муйхараар хамгаалан зөвтгөх, тулган хүлээлгэх, улс төрийн тухайн нөхцөл, тухайн нөхцөл байдлын өөрчлөлтийг бодитой мэдрэх чадвар сул байх дутагдал мэр сэр ажиглагддаг. Энэ нь нэг талаар Монголын намуудын бодлогоо төлөөлөх чадвар хангалтгүй, нөгөө талаар тэдний төлөвлөлийн үйл явц зохих түвшиндээ хүрч чадаагүйг харуулж байгаа баримт юм.

Парламент дахь намын хянах үйл ажиллагааны хариуцлага.

Хяналт нь парламент дахь намуудын үйл ажиллагааны салшгүй хэсэг, хариуцлага тооцох чухал механизм юм. Хяналт нь парламентад эрх барьж байгаа болон эрх барилцаж буй сөрөг намуудын аль алинд нь хамаатай билээ. Парламентынолонхийн намын хувьд гаргаж буй шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийн явцад хяналт тавих үүрэгтэй байдаг. Харамсалтай нь манай эрх баригч намын хувьд энэ үүргээ хэр зэрэг биелүүлж байгаа эсэх нь бүрхэг эргэлзээтэй байгаа юм. Гэтэл амьдрал дээр парламентаас гаргасан хууль тогтоомж нь амьдралын баялаг үзэгдлийг зохицуулах эрх зүйн чадамж сул, хоорондоо зөрчилддөг, амьдралаас хөндий их төлөв хэрэгждэггүй байдал ажиглагддаг. Үүнд тавих парламентад, парламентын гишүүдийн хяналт сул байна. Гэтэл гаргасан хуулийн биелэлтийг хянах хяналтын хариуцлага манай өнөөгийн парламентад үндсэндээ алга байгаа нь яав ч зөвтгөх аргагүй хэрэг юм.

Өнөөдөр монголын парламентад албан ёсны сөрөг хүчин байхгүй. Учир нь парламент дахь гол хоёр нам болох МАХН, АН –нь хамтран засгийн газраа байгуулсан тохиолдолд парламентад сөрөг хүчний хяналт хэрэг дээрээ үгүй байгаа юм гэгцгээж байна. Энэ нь нэг талаар үнэн боловч нөгөө талаар парламентад сөрөг хүчний хяналтын механизм ерөөсөө байхгүй гэдэгтэй бас бүрэн санал нийлэх аргагүй юм. УИХ –д парламентынхяналтын механизм ямар нэг хэмжээгээр бий юм. Үүнд: **нэгд**, АН хэдийгээр хамтарсан засгийн газарт орж ажиллаж байгаа ч парламентын хүрээнд шүүмжлэх, хяналт тавих боломж шавхагдаагүй. АН-ын шударга гишүүдийн зүгээс хамтарсан засгийн газрыг зоригтой шүүмжлэх хянах бололцоо бий. Ер нь хэдий хамтарсан ч гэлээ улс орны эрх ашиг сонирхлын үүднээс хамтарсан засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, зохих хяналт тавих бололцоотой, **хоёрт**, парламентад суудалтай нам, бие

даагчдын зүгээс хоёр голлох намуудын үйл ажиллагааг шүүмжлэн хянах бодит боломж өнөөдөр манай парламентад бий. Энэ механизм ч гайгүй сайн ажиллаж байгаа, **зуравт**, хэвлэл мэдээлэл, дөрөв дахь засаглалын хяналт, **дөрөвт**, иргэний нийгэм, олон нийтийн зүгээс парламентын намуудын үйл ажиллагаанд шүүмжлэн хянах асар их боломж нөөц бий юм. Ингэхлээр манай өнөөгийн парламент огт хяналтгүй парламент бас биш болох нь харагдаж байна. Гэсэн хэдий ч парламентийн хяналтын хариуцлага өнөөгийн УИХ-д бүрэн хангалттай байна гэж хэлэх аргагүй бөгөөд энэ тал дээр учир дутагдалтай, боломжоо гүйцэт ашиглаагүй, хязгаарлагдмал шинжтэй олон гажуудал, алдаа эндэгдэл байгаа нь илэрхий юм. Нэн ялангуяа сөрөг хүчин байх учиртай АН-ын хувьд парламентын олонхид тавих зүй ёсны хяналт хариуцлагаа умартан, тэдэнтэй үгсэн хуйвалдах, тал тохой татах, өмөөрөн зулгуудах, өөрсдийн бодлого, зарчимдаа тууштай байж чадахгүй, бөөрөнхийлөх, шүүмжлэн хянах үндсэн үүргийн хүрээнд байгаа боломжоо тэр бүр гүйцэд ашиглахгүй байгаа зэрэг дутагдал илэрхий ажиглагдаж байгаа билээ.

Ер нь цаашдаа парламентын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хүрээнд сөрөг хүчний үйл ажиллагааг цогцоор нь бүрэн зохицуулж өгөх, тэдний үйл ажиллагаанд зөв бодитой хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх нь туйлын чухал байгаа юм.

Парламентын намын ёс зүйн хариуцлага.

Парламент дахь намын хариуцлагын нэг чухал бүрдэл нь намын ёс зүйн хариуцлага юм. Энэ нь үнэн хэрэгтээ парламентад тухайн намыг төлөөлж байгаа парламентын гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ хариуцлагаар дамжин илэрч байдаг.

Парламент ёсны нийтлэг жишгээр парламентын гишүүн ард түмнээс олж авсан эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх албан үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон үйл ажиллагааг бусдын явцуу ашиг сонирхол, өөрсдийнх нь хувийн нөлөөллөөс ангид байлгах үүднээс мөн ард түмний ашиг сонирхол, итгэлийг даалгах үүднээс ёс суртахууныг хууль-нийгмийн үр дагавартай болгон “ёс зүй” хэмээх шалгуурыг тавьж өгдөг. Иймд парламентын гишүүний ёс зүй гэж парламентын гишүүн албан үүрэгтэйгээ холбогдуулан даган мөрдөж буй хуульчлагдан-журамлагдсан хэм хэмжээ юм⁴⁶. Парламентын гишүүний зайлшгүй даган мөрдөх ёс зүйн гол шаардлага нь:

- Хууль тогтоогч бусад нөхдийнхөө эрхийг хүндэтгэх;
- Бусдын гаргаж тавьсан нотолгоог гутаахгүй байх;
- Албадахаар сүрдүүлэхгүй байх;
- Сонгогчдынхоо эрх ашгийг хохироон ажиллахыг бусдаасаа хүсэхгүй байх;
- Санал шүүмжлэлийн үер хувийн тооцоо бодохгүй байх;

⁴⁶ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005, 127 дахь тал.

- Зорилгоо ил ойлгомжтой тодорхойлох;
- Намын удирдагчдад урьдчилан мэдэгдэхгүйгээр тэднийг эсэргүүцэхгүй байх;
- Парламентын гишүүний эсрэг, тойрогт нь сонгуулийн кампани явуулахгүй байх;
- Албан ажил, , сонгогчид, улс орны эрх ашгийг зөв хослуулах;
- Шударга ёсыг ягштал баримталдаг байх эдгээр болно.

Парламентын гишүүний ёс зүйн алдаанд төрийн ашиг сонирхлын дээгүүр хувийн ашиг сонирхлоо тавих, хэлэлцүүлгийн үеэр зүй бус үг хэлэх, зодолдох, бусдыг дайрч давшлах, хуралдааны дарга, гишүүдийг үг хэлээр доромжлох, эрх тушаалаа хэтрүүлж мөнгө зарцуулах, танхимын хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах, албаны унаа тэрэг бусад техник хэрэгслийг тогтоосон журам хэмжээг зөрчин хувийн зорилгодоо ашиглах, бусдыг албан тушаалаа ашиглан хохироох, сүрдүүлэх, хээль хахууль авах, өгөх, хууран мэхлэх, хутган үймүүлэх зэргийг ёс зүйн зөрчил буюу алдаа гэж үзэх төдийгүй энэ нь хор уршиг их бол эрүүгийн хариуцлагад татах үндэстэй байдаг.

Манай УИХ-ын гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор хангалттай сайн зохицуулж өгөөгүй юм. Манайд сонгогчдын зүгээс ёс өөрийн тойргын гишүүдэд зүйн хариуцлага тооцох ямар ч механизм байхгүй төдийгүй парламентын гишүүний онцгой бүрэн эрхэд хэн ч халдашгүйгээр хуульчилсан байдаг. Энэ нь ганцхан тухайн гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд л цуцлагдахаар зохицуулжээ. Сүүлийн үед парламентын гишүүнтэй холбоотой янз бүрийн асуудал гардагч тэр бүхнийг аль болохоор хамгаалан хаацайлах байдлаар шийдэхийг хичээдэг нь нууц биш юм. Харин УИХ-ын энэ оны 4 сарын 30 өдрийн 34 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг баталсан нь парламентын гишүүний ёс зүйг чандлан сахиуулах үйл хэрэгт бага боловч ахиц гарч буйн илрэл гэж үзэх учиртай юм. Одоо энэхүү ёс зүйн дүрмээ амьдралд ёсчлон сахиулах үүрэг УИХ-д оногдож байгааг л онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Ашигласан материал

1. Л.В. Сморгунов. Намын системийн эмпирик шинжилгээ. Бодлогын шинжилгээ –II. \эрдэм шинжилгээний бичиг\ . УБ.,2008.
2. Д.Болд-Эрдэнэ . Монголын улс төрийн нам, намын системн төлөвшил. УБ., 2008.
3. Б.Даш –Ёндон. Улс төр ба нийгмийн хариуцлага. Оюуны ертөнц. 2009.
4. Larry Diamond and Richard Gunter. “Political Parties and Democracy” \The Johns Hopkins University Press. Baltimore and London. 2001.
5. Г.Алмонд, Дж.Пауэлл, К.Стром, Р.Дальтон “Харьцуулсан улс төр”\онолын хүрээ\ .УБ., 2005.
6. Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005.

**МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН САНХҮҮЖИЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДСАН АСУУДАЛ: УЛС ТӨР- ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ**

Ж.Төртогтох

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Б.Эрдэнэдалай

магистрант

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Түлхүүр үг: *Улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн санхүүжилт, шударга, ил тод, нээлттэй байдал*

Оршил

Улс төрийн намын өдөр тутмын болон сонгуулийн кампанит ажлыг санхүүгийн эх үүсвэр, төсөв, хөрөнгөгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Сонгуулийн амжилтын нэг хөшүүрэг нь намын хөрөнгө санхүүгийн нөөц бололцоо байдаг тул санхүүжилт олох тухайлбал мөнгөн болон бусад эд хөрөнгөний хандив, дэмжлэг олох нь улс төрийн намын үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг болдог ажээ. Ялангуяа сонгуулийн үед хандив нь дангаараа санхүүгийн гол эх үүсвэр болдог байна.

Өргөн утгаараа улс төрийн намын хөгжиж, бэхжих нэг суурь нөхцөл нь түүний оновчтой санхүүжилтын асуудал байдаг. Улс төрийн институтын хувьд дотоод зохион байгуулалт, боловсон хүчин, намын мөрийн хөтөлбөр боловсруулах, бодлогын шийдэл боловсруулах, янз бүрийн түвшний улс төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, сонгуулийн кампанит ажлыг зохион явуулах, сонгуулийн үеийн болоод сонгуулийн бусад үед санхүүжилт чухал шаардлагатай байдаг нь тодорхой.

Энэхүү өгүүлэлд Монгол дахь улс төрийн намын санхүүжилтын асуудлыг сонгуулийн тогтолцоо, түүний удирдлага, зохион байгуулалттай холбон авч үзсэн. Ингэхдээ сонгуулийн үеэр улс төрийн намд өгөх хандивын хязгаарлалт, хяналтын механизм, санхүүжилтын ил тод байдал, улс төрийн нам эвсэл, нэр дэвшигч нь

сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг хаанаас олж авах болон сонгуулийн санхүүжилттэй холбоотой харилцааг хууль тогтоомжид хэрхэн тусгаж зохицуулсан, санхүүгийн зарцуулалтад хяналт тавих зэрэг тулгамдсан асуудлуудыг авч үзлээ.

I. Намын санхүүжилтийн ил тод байдал

Бүх нийтийн, тэгш, шударга, чөлөөт сонгууль нь тухайн орны ардчиллын гол шалгуур болж байдаг чөлөөт, шударга сонгуулийн хамгийн чухал үзүүлэлтийн нэг бол намын болон нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтын ил тод байдал юм. Улс төрийн намуудад ил тод, нээлттэй байдлаар санхүүжилт хийснээр улс төрийн намуудын институтжилтийн түвшинг нэмэгдүүлдэг (Walecki, 2006:1). Улс төрчид, улс төрийн намууд засгийн эрхэнд гарч, түүнийгээ бэхжүүлж хадгалахын тулд засаглалын нөөцийг ашиглах, төрийн мөнгийг хууль бусаар зарцуулах зэрэг үзэгдэл цөөнгүй ажиглагддаг. Энэ нь ялангуяа сонгуулийн үед илүү тод илэрдэг нь анхаарал татдаг. Тиймээс ч сонгуулиас сонгуулийн хооронд сонгуулийн кампанит ажлын цар хүрээ тэлж, улс төрийн намууд, тэдгээрийн нэр дэвшигчдийн сонгуулийн зардал нэмэгдэж тэр хэмжээгээр улс төрчид, улс төрийн намуудын “хөрөнгө босголт” буюу хандив, мөнгө цуглуулах үйл явц хурдсах, өргөжих хандлага ажиглагдаж байна. Улс төрийн энэхүү үзэгдлийн сөрөг үр дагавар нь “сонгуулийн кампанит ажлын явцад өр үүсэх нь авилгалыг нэмэгдүүлдэг нь дэлхий дахинд түгээмэл ажиглагдаж” (Шинэ толь, 2004:48) байгаагаар тайлбарлагдаж байна.

Сонгуулийн кампани болон намын санхүүжилтын ил тод байдал нь :

- Хэн мөнгө өгч байна?
- Хэр хэмжээний мөнгө өгсөн?
- Хэнд тэр мөнгө очиж байна?
- Ямар зорилгоор тэр мөнгө ашиглагдав? (Шинэ толь, 2004: 49) гэсэн асуултуудад ямар хариулт гарч ирж буйгаар тайлбарлагдах нь зохистой.

Судлаач Пинто-Душинский (2002) намын санхүүжилтийн асуудлыг ил тод зарлах зохицуулалтыг авч үзсэн байдаг. Улс төрийн намын санхүүжилтын ил тод байдал нь улс төрийн үйл ажиллагааны бүхий л түвшин дэх болон, ялангуяа сонгуулийн үеэр зарцуулж буй хөрөнгө мөнгөний хэмжээ, санхүүжүүлэх эх сурвалж, зарцуулалт зэргийг үндэслэлтэй тайлагнах, энэ талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй бөгөөд хүртээмжтэй хүргэх зэрэг асуудлыг илэрхийлж байдаг. Ил тод байдал нь улс төрийн намууд, нэр дэвшигчид өөрийн орлого, зарлагаа олон нийтэд дэлгэрэнгүй танилцуулах, хандивлагчид ба түүнийг хүлээн авч зарцуулагчдын нэрсийн жагсаалт, ямар хэмжээний хандивыг хэн, ямар байгууллага өгсөн, бусад ямар орлого олсон, тэрхүү хөрөнгийг ямар бараа, үйлчилгээ худалдан авах болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан болохыг дэлгэрэнгүй мэдээлэхийг хэлнэ. Энэхүү ил тод байдал нь иргэд олон нийт, улс төрийн намын гишүүд дэмжигчдэд улс төрчид болон улс төрийн намд ямар хэмжээний мөнгө, хэн өгсөн, түүнийг хэрхэн зарцуулсныг мэдэх боломж олгодог. Чухамдаа ийм орчин л улс

төр дэх мөнгөний нөлөөлөл хууль бус мөнгө болон санхүүжилтээс сэргийлдэг байна. Ялангуяа олон нийтийн байгууллагын хяналтын гол үндэс нь мэдээллийг ил тод болгох явдал юм (Ж.Сүхбаатар, 2002: 74-75).

II. Монгол дахь улс төрийн намын сонгуулийн үеийн санхүүжилтын эрх зүйн зохицуулалт: тулгамдсан асуудлууд, харьцуулалт

Манай улсад болж өнгөрсөн УИХ-ын удаа дараагийн сонгуулийн үйл явцыг ажиглахад сонгуулийн кампанийн санхүүжилтийн өртөг зардал улам өсөн нэмэгдэх хандлагатай байна (Хүснэгт 1.-ийг үзнэ үү). Энд үзүүлсэн зардлын хэмжээ нь зөвхөн албан ёсоор нийтэд мэдээлэгдсэн тоо хэмжээ юм. Энэ нь сонгуульд зарцуулагдсан бүх зардлыг бүрэн тусган илэрийлсэн хэрэг биш бөгөөд сонгуулийн кампанит ажлын зардлыг мөсөн уултай зүйрлэвэл түүний зөвхөн уснаас цухуйн харагдаж буй хэсэг гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 1.

УИХ-ын сонгуульд улс төрийн намуудын зарцуулсан зардлын хэмжээ

№	Он	Зардал
1.	1992	13 сая 708,2 мянган төгрөг
2.	1996	209 сая 349,1 мянган төгрөг
3.	2000	1 тэрбум 841 сая 679,8 мянган төгрөг
4.	2004	1 тэрбум 558 сая 358,8 мянган төгрөг ⁴⁷

⁴⁷ Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв, Сонгогчдын Глоб Интернешнл. 2004. “2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тухай СЕХ-ноос нийтлүүлсэн албан ёсны дүн мэдээ”. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг тайлан. Улаанбаатар. 64

5.	2008	8 тэрбум 91 сая 164,2 мянган төгрөг ⁴⁸
----	------	---

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий хорооны тайлан

Улс төрийн намын гишүүн нь намд гишүүний татвар, хандив өгөх тухай асуудлыг “Улс төрийн намын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлд “Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая, иргэдээс нэг сая төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно”⁴⁹ хэмээн тусгаж эрх зүйн зохицуулалтын үндсийг зааж өгсөн байдаг. Энэхүү заалт нь манай улс төрчид, намууд хандивлагчаас тодорхой төвшинд өөрийгөө хамгаалах чадвар бүрэлдээгүй байгаа явдлыг харуулж байгаа юм. Тухайлбал хуулийн этгээдээс намд өгч болох хандивыг 1 жилд 2 удаа өгч болно гэхээр 20 сая төгрөгийг нэг жилд өгнө. Энэхүү хандиваа сонгуулийн давтамжаар үржүүлбэл нэг хуулийн этгээд 80 сая төгрөгийг намд өгнө гэсэн үг болж байна. Харин иргэдээс энэ нь 8 сая төгрөг болно.

2007, 2008 оны байдлаар Монгол дахь улс төрийн намуудын гишүүд өөрийн намаас нэр дэвшиж сонгуульд өрсөлдөхийн тулд намдаа өгч буй хандивын хэмжээ 20 сая төгрөг (Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв, 2007: 33) байсан бол энэ асуудлыг 80 сая төгрөг болгох боломжтойгоор хуульд заасныг тооцоолон гаргалаа. Үүнээс үүдээд нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлын зардлаасаа өмнө нэр дэвших эрхээ олж авахын тулд өөрийгөө санхүүжүүлэх хандивлагчдыг хайхгүй гэсэн баталгаа байхгүй. Энэ асуудал нь эргээд сонгогдсон гишүүд нь ард түмэндээ бус хандивлагчдадаа үйлчлэх гаж гэмээр тогтолцоо бүрдэхэд хүргэж байна.

Үүнд аль болох олон хандивлагчаас бага мөнгө авч аль нэгэнд давуу байдал үүсгэхгүй байх, санхүүжилтэд иргэдийг олноор татан оролцуулах зэрэг олон төрлийн арга хэмжээ авч болох билээ. Хуулийн үзэл санаа ч үүнд чиглэгдсэн нь тодорхой. 2007 онд Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төвийн хамтарч хийсэн Улс төрийн намын санхүүжилтын мониторингийн тайланд “намууд хандивлагчдын нэр болоод хандивын хэмжээ, хандивтай холбоотой бусад мэдээллийг маш их нууцалж байсан” гэж дурьдсан нь манай улс төрийн намууд хуулийн дээрх заалтуудыг биелүүлэх нь хангалтгүй байгааг харуулж байна.

⁴⁸ Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороо. 2008. *2008 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тайлан*. Улаанбаатар. (URL: <http://202.72.246.30/>)

⁴⁹ 2005. “Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль”. *Төрийн мэдээлэл* 17 (338).

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 18 дугаар зүйлд “Нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна”, мөн 20 дугаар зүйлд “Намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина, Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж нийтэд мэдээлнэ” гэж заасан байдаг. Гэвч өнөөг хүртэл нэг ч нам өөрийн санхүүгийн тайлангаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтийн хүртээл болгожгүй байна. Мөн намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын байгууллага хяналт тавина гэсэн нь намын санхүүжилтын хяналтыг ёс төдий шинжтэй болгож, намуудыг дураар авирлах, хуулийн тодорхой бус байдлыг ашиглах өргөн боломжийг олгож байна.

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйл төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт: “Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ”⁵⁰ гэж заасан. Гэтэл намууд төсвөөс олгосон санхүүжилтыг УИХ-ын гишүүдийн тойрогт хэрхэн зарцуулах асуудал журамлагдаагүй байгаагаас 2006 оны байдлаар 356.2 сая төгрөгийг хуулийн дагуу тойрогт зарцуулах ёстой ч түүний 54 орчим хувь буюу 190,7 сая төгрөг нь л зориулалтын дагуу зарцуулагдсан бөгөөд үлдсэн хэсэг нь улс төрийн намын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулагджээ (Үндэсний Аудитын Газар, 2007: 12).

Монголын улс төрийн нам, эвслүүдийн төрөөс авсан санхүүжилтыг зарцуулсан ямар тооцоо, дүн байгаад хяналт тавих механизм байхгүй байгаа учраас УИХ-д суудалтай намууд төрөөс авах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өөрсдийн дураар нэмж, өөрсдөдөө таатай нөхцлийг бүрдүүлж ашиглахгүй гэсэн баталгаа байхгүй хэмээн дүгнэхэд хүргэж байна.

Улс төрийн намын тухай хуулийн 24 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай заасан. Намын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол Эрүүгийн хуулиар, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны хариуцлагыг шүүгч ногдуулах ба дараах зөрчилд албан тушаалтанг 40000-60000 төгрөг, намыг 200000-250000 төгрөгөөр торгохоор тогтоожээ.

Үүнд:

1. хуулиар хориглосон хэлбэрээр ашиг олох;
2. намын орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлбөрийг төлөх;
3. данснаас гадуур болон хуулиар тогтоосон хэмжээнээс илүү хандив авах;

⁵⁰ 2005. “Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль”. *Төрийн мэдээлэл* 17 (338).

4. хуулиар хориглосон этгээдээс хандив авах;
5. намын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэхээс зайлсхийх, аудит хийлгэсэн боловч нийтэд мэдээлээгүй бол дээрх хариуцлагыг хүлээлгэхээр байна.

Улс төрийн намын тухай хуулийн мониторинг хийсэн холбогдох заалтуудыг ажиглахад хуулийн хэрэгжилтийн байдал туйлын хангалтгүй байна. Хэдийгээр улс төрийн намын санхүүжилтын асуудал ил тод, нээлттэй, хяналттай байх талаар тодорхой заалтууд байгаа ч эдгээр нь хэрэгжихгүй, улс төрийн намууд дагаж мөрдөхгүй байна (Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв, 2007: 42). Хуулийн заалтууд зөрчигдлөө гэхэд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ нь тодорхой бус, хүлээлгэж буй хариуцлага нь сул, торгуулийн хэмжээ нь хэт бага байна. Иймээс улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн албан тушаалтан, байгууллагад хүлээлгэх хариуцлагын механизм нь хуулийг нэг мөр сахин биелүүлэх, хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгсэл болж чадахгүй байна.

III. Намын санхүүжилтын тулгамдсан асуудлууд: үр дагавар, зохицуулалт

Улс төрийн намын санхүүжилтын асуудлыг зохицуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж гаргавал:

1. *Улс төрийн тэгш байдал алдагдах буюу мөнгөний улс төр болж байна.*

Дэлхийн бусад оронд улс төрчид ба бизнес эрхлэгчид өөр өөрсдийн зорилготой байдаг бол манайд холилдох, сүүлдээ нэгээр нөгөөг нь хийх гэсэн сөрөг хандлага бий болжээ. Үүнийг “улс төрч хүн нөлөөгөө ашиглан бизнес хийж мөнгөтэй болох, бизнесмен хүн улс төр хийж мөнгөө өсгөх гэсэн үзэгдлээс харж болно” (Ч.Тамир, 2003). 2000 онд хийсэн судалгаагаар манай бизнес эрхлэгчдийн 44 хувь нь дунд түвшний албан тушаалтан, 24 хувь нь жирийн гүйцэтгэх сэхээтэн, 20 хувь нь удирдах ажилтан байжээ (Г.Чулуунбаатар, 2000: 67). Энэ нь төр засгийн байгууллагын ажилтнууд өмч хувьчлалд шууд оролцож, хувь хүртэж байсныг гэрчилнэ. Засгын эрхэнд байгаа хүмүүс нийгмийн баялгаас илүү хүртэж байгаа байдал нь шинээр төрж байгаа баячуудыг төрийн ямар нэгэн албан тушаалд очих гэсэн эрмэлзлийг төрүүлж байснаас улс төрийн намууд төр засагт орж ажиллах цорын ганц суваг нь болсон (Д.Ганхуяг, 2005: 63).

Улс төрийн намыг зөвхөн төрийн албан тушаалд очих арга хэрэгсэл болгож ашиглах, улмаар эдийн засгийн эрх ашиг, сонирхлоо хэрэгжүүлэх гэсэн хүсэл эрмэлзэл бүхий олигархи бүлэглэлүүд улам бүр өсөн нэмэгдэх нь нийгэм улс төрийн тэгш байдал алдагдах, улс төрийн харилцаа, улс төрийн хөгжил иргэдийн хүсэл сонирхол, санаа бодолд тулгуурлахаасаа илүү зөвхөн хөрөнгө мөнгө, санхүү эдийн засгийн явцуу ашиг сонирхолд түшиглэх зэрэг сөрөг үзэгдлийг нөхцөлдүүлэхэд хүргэх талтай юм. Энэ нь улс төрийн үйл ажиллагаа явуулж буй нийгмийн бүлгүүд улс төрийн засаглал, түүний нөөцийг дан ганц эдийн засаг, санхүүгийн сонирхлын өнцгөөс харж байгаатай ч холбоотой билээ.

2. Улс төрийн намын санхүүжилтын ил тод бус байдал нь авлигын нэг үндэс болж байна.


Улс төрийн намыг санхүүжүүлэх үйл явц далд, хяналтгүй байх нь авлига, хээл хахуулийн шинжтэй болж байна. Сонгогчдын боловсрол төвөөс явуулсан судалгааны дүнгээс харахад авлигад өртсөн байгууллагуудын жагсаалтанд улс төрийн намууд тэргүүлж байна. Улс төрийн намууд авлигад өртөх нь хэр түгээмэл вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 37,4 хувь нь түгээмэл, 27 хувь нь дунд зэрэг гэсэн хариулт өгсөн байна (Сонгогчдын боловсрол төв, 2003). Энэ нь олон нийтийн дунд улс төрийн намыг авлигатай салшгүй холбоотойгоор төсөөлөх нь түгээмэл байдгийг харуулахын зэрэгцээ улс төрийн намын нэр хүнд унаж байгааг илэрхийлж байна.

2006 онд Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5-р бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төслийн үнэлгээгээр “Улс төрчид хандив авдаг, бизнесийн хүрээнийхэн заавал аль нэг нэр дэвшигч буюу намд хандив өгч байх ёстой юм шиг хандлага сүүлийн үед хэвшмэл сэтгэлгээ болон хувирч байна. Өнөөдөр засгийн эрх барьж байгаа улс төрийн нам өөрсдийн хандивлагчид, тэдгээрийн төлөөлөгчдийг гүйцэтгэх засаглалын дээд, дунд шатны албан тушаалд томилох практик өргөн дэлгэрсэн байна” хэмээн дүгнэсэн байна (Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв, 2007: 20-21). Улс төрийн намын санхүүжилтийн асуудалд олон нийтийн хяналт, оролцоо байхгүй, гишүүд дэмжигчид, хандивлагчдад ч уг асуудал хаалттай байж, зөвхөн намын удирдлагын цөөн хүний хүрээгээр хязгаарлагдаж байгаа нь Монголд байгаа авлигын гол эх үндэс гэж дүгнэхэд хүргэж байна.

3. Төр иргэдэд үйлчлэх үүргээ умартаж байна.

Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтын өнөөгийн нөхцөл байдал нь төр ард иргэдэд үйлчлэх үүргээ умартахад хүргэж, улс төр, эдийн засгийн явцуу бүлэглэлийн эрх ашгийг төлөөлөхөд хүргэж байна. Сонгуульд ялсан намын бодлого тухайн намыг сонгуульд нэр дэвшихэд хөрөнгө мөнгөөр дэмжиж байсан хандивлагчдад ямар нэгэн байдлаар ашигтай байдаг эл үзэгдэл зөвхөн манай оронд ч бус бусад олон оронд түгээмэл ажиглагддаг болжээ. Үүнээс үүдээд иргэдийн намууд болон төрд итгэх итгэл үлэмж буурсаар байгаа нь “Сант марал” сангийн явуулсан судалгаанаас харагдаж байна (Зураг 1.-ийг үзнэ үү).

Зураг 1.



Эх сурвалж: *Werner Prohl, L. Sumati. Voter's Voices. 2008. p. 231*

4. Эдийн засгийн салбарын өрсөлдөөний үнэ цэнэ багасч байна.

Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөний үнэ цэнэ, шаардлага улам бүр багасах болсны нэг шалтгаан нь мөн л эрх мэдлийг ихэвчлэн эдийн засаг, санхүүгийн сонирхлын өнцгөөс харж байгаатай холбоотой юм. Сонгуульд ялсан намыг санхүүгийн хувьд дэмжигч тодорхой эдийн засгийн бүлэглэл нийгэм-эдийн засгийн бүтээн байгуулалттай холбоотой сонгон шалгаруулалт, төндэр зэрэгт шууд ялалт байгуулах зэрэг нь уг учир шалтгаантай холбоотой гэж болохоор байна. Үүнээс үүдэн улс төр, эдийн засгийн бодлого зорилго чиглэлгүй болж, шинжлэх ухааны үндэслэл тооцоогүй, хэн нэгний халаасанд мөнгө орж л байвал улс орны хөгжилд ноцтой хор хохирол учруулах нь хамаагүй мэт сөрөг үр дагавартай зүйл болсон. Ингэснээрээ зах зээлийн эдийн засгийн хамгийн гол үндэс болсон шударга өрсөлдөөний зарчмыг алдагдуулж байна.

5. Иргэдийн улс төрийн оролцоо буурч, сонгогчийн сонгуулийн зан үйл сүүлийн үед өөрчлөгдөж байна.

Сонгуулийн зардлын өсөлт, түүний хяналтгүй далд байдал нь сонгуульд хэн мөнгөтэй нь өрсөлдөхөд хүргэх ба энэ нь иргэдийн хувьд тэдний сонгуульд хандах зан үйлийг өөрчлөхөд хүргэж буйг өдөр тутмын амьдралаас харж болно (Ч.Тамир, 2003). Иргэд сонгууль болно гэхээр төрөл бүрийн үйлчилгээ, үнэгүй эд бараа тараах, мөнгө өгөх зэрэг материаллаг талаас харах сонирхол бий болсон. Энэ нь сонгууль бол ардчиллын тулгуур үзэл биш болж, харин ч иргэд өөрсдийн төрөө барих үйл хэрэгт оролцож байгаагаа ухаарахгүй мөнгөтэй нэр дэвшигчид өөрсдийн саналаа худалдах, мөнгөний тоо хэмжээ амалсан амлалтанд хууртах зэрэг үзэгдлүүд нийгэмд тархаж байна.

6. Монголын улс төрчдийн ёс зүй улам доройтож байна.

УИХ болон Засгийн газрын гишүүд улс төрийн нам болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилттай холбоотой асуудлыг хянах эрх, үүрэг байдаггүй боловч

парламентад төлөөлөл бүхий улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэх журам, санхүүжилтийн хэмжээг өөрчлөх, сонгуулийн тойргийн хэмжээг зааж өгдөг мөртлөө хууль эрх зүйн орчинг нарийн зохицуулж, хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой, хатуу чанд байдлаар зааж өгөх зэрэг асуудлыг хөндөхгүй, авч хэлэлцэхгүй байгаа нь манай улс төрчдийн ёс зүйн түвшин доогуур байгаатай шууд холбоотой.

Дүгнэлт

Улс төрийн нам, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн хяналтгүй, далд, зохисгүй байдал нь Монголд хэрэгжиж байгаа сонгуулийн системтэй шууд хамааралтай юм. Сонгуулийн мажоритар систем нь гол төлөв зонхилогч хоёр юмуу гурван намыг парламентын дийлэнх олонхийг бүрдүүлэхэд чиглэгддэг. Сонгуульд зонхилогч намууд өрсөлдөх нь сонгуулийн үеэр хэн их хөрөнгө, мөнгө зарцуулсан нь засгийн эрхэнд гардаг байдал бий болсон. Энэ нь улс төрийн намуудын хоорондох өрсөлдөөн эрс нэмэгдэхэд нөлөөлдөг бөгөөд цаагуураа мөнгө-санхүүтэй холбоотойгоор хөрөнгө босголтын хэмжээ нэмэгдэх, бүр цаашилбал тэрхүү хөрөнгө мөнгийг хурдан цуглуулах шаардлага гарч ирдэг.

1992 оноос хойшхи сонгуулиудад оролцсон улс төрийн намуудын кампанит ажлын санхүүжилт сонгууль бүрт нэмэгдэж байгаа нь улс төрийн нам болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтын далд, хяналтгүй механизмыг ил тод, нээлттэй болгох асуудлыг улс төр, эрх зүйн үүднээс зохицуулахыг шаардаж байна. Сонгуулийн санхүүжилтын асуудлыг гажуудуулж, хууль бус болгох магадлалыг өндөрсгөх үйл явцын үргэлжлэл бол 2008 оны УИХ болон Орон нутгийн сонгуулийг олон мандаттай, томсгосон тойргоор явуулах болсноос илт харагдана. Өмнөх сонгуулиудын үеэр нэр дэвшигч нэг мандаттай, нутаг дэвсгэр хүн амын хувьд харьцангуй жижиг тойрогтоо өөрийн сурталчилгаа, уулзалт, кампанит ажлаа явуулдаг байсан бол 2008 оны УИХ-ын сонгуульд урьд өмнө зарцуулж байснаас хэд дахин илүү хэмжээний хөрөнгө санхүү зарцуулсан нь улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг улам төвөгтэй, ээдрээтэй болгож байна.

Улс орны хөгжлийг хойш татаж, авилгал хээл хахууль болон бусад маш олон сөрөг үр дагавруудын гол шалтгаан болсон улс төрийн намуудын санхүүжилтдаа зарцуулдаг “их хэмжээний мөнгө”-ийг бүрдүүлэх үйл явц, санхүүгийн тайланг заавал ил тод, нээлттэй болгох шаардлагатай бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд маш нарийн хууль эрх зүйн зохицуулалтаас гадна хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэд, олон түмний хяналтыг нэмэгдүүлж, улс төрийн намын санхүүжилтын бүрдүүлэлт, зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг шаардаж, тэрхүү тайланг нь хянадаг, хэрэв хууль зөрчсөн бол хариуцлагыг хатуу чанга байдлаар оногдуулдаг болох зэрэг механизмуудыг бүрдүүлэх хэрэгтэй.

Ашигласан ном зохиол

1. Ганхуяг.Д. 2005. *Улс төрийн нам, улс төрийн өрсөлдөөн, сонгуулийн үйл явц.* Социологи, №247, 60-67
2. *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль.* 1992.
3. *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль.* 2005.
4. *Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль.* 2005.
5. Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв, Сонгогчдын Глоб Интернешнл. 2004. *2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтын мониторинг тайлан.* Улаанбаатар
6. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2005. *Олон нийтийн санаа бодлын судалгаа.* Улаанбаатар.
7. Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв. 2007. *Улс төрийн намын санхүүжилтын мониторинг.* Улаанбаатар.
8. Сонгогчдын боловсрол төв. 2003. *Авилгал судалгаа.* Улаанбаатар.
9. Сүхбаатар. Ж. 2002. “Сонгуулийн кампанийн санхүүжилт, дэлхийн чиг хандлага” илтгэл, ред. Ж.Ядамсүрэн, *Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь: эмхэтгэл.* Улаанбаатар.
- 10.Тамир. Ч. 200 “Улс төрийн намын санхүүжилт ба хандивлагчид” илтгэл. www.openforum.mn/.../Report_TamirCampaignMeeting_mong.pdf.
- 11.Тамир. Ч. *Улс төрийн нөхцөл байдал, олон нийтийн үнэлгээ судалгаа.* Улаанбаатар.
- 12.Чулуунбаатар. Г. 2000. *Монголын бизнес эрхлэгчид.* Улаанбаатар
- 13.Орч. Алтансүх. Б. 2004. “Улс төрийн хүрэн дэх мөнгөний урсгал, түүний ил тод байдал ба хяналтын тухай”. *Шинэ толь.* 147. 48-66
- 14.Pinto-Duschinsky, M. 2002, “Financing Politics: A Global View” in *Journal of Democracy* Vol. 13, Number 4, October 2002, pp. 69-89
- 15.Walecki, M. 2006, *Direct Public Funding of Political Parties* Recommendations prepared for the Latvian Corruption Prevention Combating Bureau.
- 16.Үндэсний Аудитын Газрын сайт. www.mnao.pmis.gov.mn
- 17.Нээлттэй Нийгэм Форумын сайт. www.forum.mn
- 18.Сонгуулийн Ерөнхий Хорооны сайт. www.gec.gov.mn

АРДЧИЛЛЫН ҮЙЛ ЯВЦ: УЛС ТӨРИЙН ХОШУУЧЛАЛ

Ч.Өлзийсайхан

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Д.Оюунчимэг

ахлах багш

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Ардчилал гэж юу вэ гэсэн асуултад “бид тухайн засгийн газрын зан үйлийг бүрэн хэмжээгээр тодорхойлдог болсон тохиолдолд л засгийн газрын дур зоргын авирлалд нөлөөлж, түүний үйлдлийг залан чиглүүлж байгаа тэр хүмүүсээс өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж чадна. Чухам энэ л ардчилсан засаглал юм” гэж Жон Стюарт Милль нэгэнтээ хариулт өгчээ. Роберт Даль асуудлыг шийдэхэд үр ашигтай оролцох, шийдвэр гаргахад санал тэгш өгөх, үнэн зөв, хүртээмжтэй мэдээлэлд тулгуурлан асуудлын мөн чанарыг ойлгох, хэлэлцэх асуудлыг хянах, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох боломж олгохыг бүхэлд нь ардчилалын үндсэн гол зарчмууд гэж авч үзээд эдгээрээс нэгийг нь орхих юм уу, гажуудуулахад ардчилал өөрөө алга болох аюултай гэж үзэж байсан билээ.

Харин улс төр гэдгийг засаглалд оролцох, засаглалыг хуваарилахад нөлөөлөх эрмэлзлэл гэж үзвэл улс төрийн амьдралд оролцох хүмүүсийн, түүний дотор хошуучлагчдын сэдэл тэмүүлэл, баримтлал нь өөр өөр байдаг ажээ. Тэд тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд улс төрийн амьдралд оролцож болно. Мөн өөртөө тодорхой ашиг гаргахаар юм уу, эсвэл сэтгэлийн хөдөлгөөндөө, түүнтэй нилээд төстэй сэтгэл зүйн хэлбэр болох сонирхолдоо хөтлөгдөн оролцож болох юм. Эцэст нь тодорхой зорилгыг хэрэгжүүлэх сонирхол үгүй байж болох ч нийгэмд тогтсон зан заншил уламжлалыг даган улс төрийн амьдралд оролцож болно. Улс төрд оролцож буй хүмүүс, тэдний дотор хошуучлагчид ч гэсэн үргэлж гэгээн ариун, ард түмний ашиг тусыг туйлын хичээсэн байдаг гэж үзэх үндэс байхгүй. Тэгэхээр ардчилал, түүний зарчмуудыг, хүмүүсийн улс төрд оролцож буй сэдэл тэмүүлэлтэй яаж зүй зохистой уялдуулах вэ гэсэн асуулт аяндаа урган гарч байна.

Ардчилсан нийгэм нь зөвхөн нэг хүн, нэг бүлэг, нийгмийн нэг давхраа өөрийн хүсэл сонирхлыг нийгмийн бусад хэсэгт байнга тулган хүлээлгэх боломжгүй болгосоор байна. Харин нэгэнт засгийн эрхэнд хүрсэн бол энэ хүртэл байсан нөхцлийг хөдөлгөхгүй байлгах сонирхол тухайн субъектэд байсаар байх нь бараг эргэлзээгүй зүйл юм. Монгол Улсын Ерөнхий Сайд С.Баяр төрийн өндөр албан тушаалаас сайн дураараа буусан нь манай улсын хувьд тоталитари улс төрийн системийн үед ч, ардчилсан системийн үед ч гарч байгаагүй онцгой үзэгдэл боллоо. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөө байсан ч эрх мэдлээсээ буух хүсэл төдийлөн төрдөггүйг Ким Чен Ир, Фидель Кастро зэрэг дарангуйлагч хошуучлагчид бодитойгоор нотолсоор л байна.

Орчин үе нь улс төрийн хүчин засгийн эрхийг адилхан хүсэх, хүрэх боломжийг олгож байдаг учраас ардчиллыг илүү хүчтэй шаардах болжээ. Ардчиллын онцлог, ард түмний эрх ашгийг хошуучлагчдын үйл байдалтай хэрхэн зүй зохистойгоор уялдуулах вэ гэдэг нь ардчиллыг бэхжүүлэх, төгөлдөржүүлэх гэдэг нэр томъёогоор илэрхийлэгдэж байна. Ер нь ардчилсан үйл явцын тодорхойлогч шалгуурт бүрэн хэмжээгээр нийцсэн засаглалын хэлбэр аль ч улсад байгаагүй. Гэхдээ эдгээр шалгуурын тусламжтайгаар ардчилсан засгийн газрын амжилт, боломжийг тодорхойлох стандартуудыг бий болгож болно. Ардчилсан улс бүрт улс төрийн субъектууд ардчиллыг яг адилхан хүсч, түүнийг төгс хэлбэрээр бэхжүүлэхийг эрмэлзэж, тэмүүлж байдаг гэж үзвэл энэ нь ихээхэн эндүүрэл болно. Жишээлбэл, АНУ-ын голлох хоёр нам болох БНН, АН хоёр ч олон түмний улс төрд оролцох оролцоонд өөр өөрөөр ханддаг. БН нам аль болох цөөн, АН аль болох олон хүн санал өгвөл ялдаг. Энэ нь эдгээр намууд ард түмний улс төрийн оролцоог сонирхох сонирхол өөр өөрөөр хандахад хүргэдэг. Манай улсын хувьд ч улс төрийн намуудын байр суурь бас л иймэрхүү байгаа нь сонгууль, нөхөн сонгуулийн товийг зарлах, сонгуулийн кампанийг зохион байгуулахад бас л ажиглагдаж байна. Ардчилалыг хошуучлагчдаас илүүтэйгээр ард түмэн их хүсч байдаг гэж үзвэл асуудлыг дараахь байдлаар тавьбал сэдвийн дагуу асуудал нилээд тодорхой болж өгөх болов уу.

- Ардчиллын үндсэн зарчмуудыг хошуучлагчид хэрэгжүүлэхийг хүсдэг үү?
- Хошуучлагчид ардчиллын төлөө байдаг уу?
- Хошуучлагчид ардчилсан зарчмыг гажуудуулахад тойрон хүрээлэгсэд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Хошуучлагчидаар ардчиллыг үгүй хийлгэчихгүйн тулд юуг анхаарах ёстой вэ?

Хошуучлагчийг нийгэм улс төрийн байгууллага, нийгмийн томоохон бүлэгт байнга нөлөө үзүүлж чаддаг чадварлаг хүн гэдэг талаас нь авч үзсэн ч, нийгмийн гишүүдийн үйл байдлыг чиглүүлж, зохион байгуулж байдаг засаглалд шийдвэр гаргагч чухал албан тушаалтан гэж үзсэн ч, хүмүүсийн нийтлэгийн билэг тэмдэг, үйл байдлын загвар жишээ бологч гэж үзсэн ч ялгаагүй, тэд бол нийгэмд хамгийн нөлөө бүхий шилдэг хүмүүс гэдэг нь ойлгомжтой. Хувь хүний хувьд тэр өндөрлөгт хүрсэн зам мөр нь адилгүй байж болох ч нийгмийн дундаж түвшнээс ямагт илүү чадварлаг, авьяаслаг нэгэн байдаг нь бараг

эргэлзээгүй. Тэдэнгүйгээр төр хэзээ ч нийгмийн үйл явцад тэргүүлэгч үүргээ гүйцэтгэж чадахгүй. Хошуучлагчид нийгэм түүхийн хөгжилд нөлөөлж, олон түмнийг дайчлан зохион байгуулагчид, улс төрийн үйл явцыг идэвхижүүлэгчид мөн. Улс төрийн хошуучлагчид төрийн болон намын өндөр албан тушаалд байхгүй байсан ч улс төрийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлэгчид юм. Хошуучлагч хэдийгээр өгөөмөр нигүүлсэнгүй нэгэн байсан ч гэсэн ганцаараа засаглалыг хэрэгжүүлэх боломжгүй байдаг нь, олон түмэнтэй шууд хамтран ажиллах боломжгүй байдал нь, үйл ажиллагаагаа үр дүнд хүргэхийн тулд институцлэгдсэн хэлбэрээр оршин тогтнодог нь тэднийг ардчиллын төлөө эргэлт буцалтгүй тэмцэгчид болгодоггүй юм.

Номхон дуугай иргэд бол хошуучлагчид өөрсдийн зорилго, зорилт, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой захирагдагсад байдаг. Ийм захирагдагсад хошуучлагчдыг дарангуйлагчид болгоход ч бас хамгийн тохиромжтой нөхцөлийн бүрдүүлж байдаг. Харин ардчилал бол иргэд нь хатуу шийтгэл, цээрлүүлэлт ирнэ гэж айхгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг шаардаж байдаг. Ардчилал, хошуучлагчид хоёрт бие биетэйгээ зөрчилдсэн, эхний нөхцөл энд гарч ирж байна.

Иргэн бүр, байгууллагын гишүүн бүр саналаа өгөх тэгш боломжоор хангагдах ёстой. Нэгэнт бүгдэд нь яг таалагдсан үр дүн гарах боломжгүй учраас олонхийн дэмжлэгийг хүлээсэн санал хураалтын үр дүнг бүгд хүлээн зөвшөөрөх ёстой болдог. Харин хошуучлагчид үүнийг үргэлж хүлээн зөвшөөрдөг гэдэг нь нилээд эргэлзээтэй юм. Жишээлбэл, манай улсын төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан цөөхөн хүмүүс гэхэд л өөрсдийн намаас олонхийн саналаар гарсан шийдвэрийг тэр бүр хүлээн зөвшөөрөөд байдаггүй, түүнийгээ тодорхой үйлдлээр харуулж байдаг юм уу гэмээр тал харагдаж байна.

П.Очирбат	1990-3 УТТ-ны гишүүн, МАХН-ын ТХ-ны е.н.б.д., БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга	1990-9-3-нд БНМАУ-ын ерөнхийлөгч	1993 он сөрөг хүчнээс МУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшсэн юм.
Д.Бямбасүрэн	СНЗ-ын орлогч, нэгдүгээр орлогч дарга	ЗГ-ын Ерөнхий сайд 1990	МАХН-аас гарч МСМН-ыг байгуулсан
М.Энхсайхан	АН-д УИХ-ын гишүүн, МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга,	АН-ын дарга, АН-ын ҮЗХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн	Үндэсний Шинэ намын дарга, ҮШН-ын УЗ-ийн гишүүн

	МУ-ын Ерөнхий сайд, МУ-ын шадар сайд		
Ж..Гомбожав	АИХ-ын депутат, МАХН-ын гишүүн	1990-9-аас АИХ-ын даргаар ажилласан.	МУНН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч
Н.Энхбаяр	МАХН-ЫН XXII их хурлаар МАХН-ын Е.н.б.д.-аар	УИХ-ын дарга, МУ-ын Ерөнхий сайд, МУ-ын Ерөнхийлөгч	2009 оны Чингэлтэй дүүргийн нөхөн сонгуульд МАХН-тай өрсөлдөж буй улс төрийн намаас нэр дэвшигчдийг дэмжсэн
Ө.Энхтүвшин	1995-96 РТХЭГ-ын дарга, Үнэн сонины эрхлэгч МАХН-ын нарийн бичгийн дарга	МАХН-ын нарийн бичгийн дарга, МАХН-ын удирдах зөвлөлийн гишүүн. УИХ-ын гишүүн	МАХН-ын дотод ардчилал шударга есыг бэхжүүлэх гэж жигүүр байгуулсан

Дээрхи хүснэгтээс харахад төрийн өндөр албан тушаалд улс төрийн намаар дамжин хүрч байсан хошуучлагчдын тодорхой хэсэг нь олонхийн саналаар намаас нэгэнт гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөлгүй өөр нам, улс төрийн хүчний дэмжлэгэд дулдуйдсан алхамуудыг хийж байжээ. Ардчилсан улс төрийн тогтолцоонд шилжсэнээс хойш ийм өндөр албан тушаалд ажилласан хүн цөөхөн байдагтай харьцуулан бодоход энэ бол нилээн хувь дарах тоо юм.

Ардчиллыг эрх мэдэл бүхий субъектууд хэрэгжүүлэхгүй байх сонирхол ихтэй байдгийг харуулах өөр нэг томоохон жишээ олон улсын харилцаанд тодорхой харагдаж байдаг. XIX-XX зуунд ардчиллыг хөгжүүлж бэхжүүлэгчид гэж үзэгдэж байсан Англи, Франц гэх мэт колони эзэмшигч улсууд Ази, Африкийн олон орныг өөрийн эрхшээл дор байлгахдаа ардчилал, чөлөөт зах зээлийн зарчмаар биш үндэстний хувьд тэднээс илүү учраас ноёрхох ёстой гэсэн харгис дэглэмийн байр сууринаас л хандаж байсан билээ.

Манайд МАХН-ын дотор Ерөнхийлөгчийн фракци нэртэй бүлэглэл бий болж 2003 оны 11 сард “Ерөнхийлөгчийн засаглалын төлөө хөдөлгөөн” байгуулагдаж байв. 2005-2009 онуудад Ерөнхийлөгчийн засаглал бүхий тогтолцоонд шилжих талаар нилээд санал санаачлагууд гарч байсан нь бас л хошуучлагчид маань эрх мэдлээ өргөжүүлэх хадгалах

боломжийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллаа юу гэмээр харагддаг. Ардчилал гэдэг нь ард түмэн ардчилалтай байхыг хүсэх төдийгүй удирдагчид нь бас түүнийг хүсэх явдал мөн.

Ардчиллын шаардлагыг хангахын тулд түүнд шингэсэн эрхүүд нь иргэдэд жинхэнээсээ хүртээмжтэй байх ёстой. Эрхийг цаасан дээр буулгах, тэдгээрийг хууль болгох, бүр үндсэн хуулиндаа тусгах нь ч хангалттай бус, харин тэдгээр нь нийгмийн амьдралын практикт нэвтэрч иргэдэд хүртээмжтэй болох нь гол юм. Социализмын үед ч манай улсын Үндсэн хуулинд эдгээр эрхүүд нь ямар нэг хэмжээгээр тусгагдсан байсан билээ. Харин ард түмэн ардчиллын зарчимд тулгуурласан иргэдийн эрхүүд нь практик амьдралд хэрхэн яаж хэрэгжих ёстой вэ гэдгийг мэдэхгүй, ойлгохгүй байсан учраас өнгөц харахад ардчилалтай мэт харагдавч үнэндээ ардчилал үгүйсгэгдэж байсан юм.

Хошуучлагчид ардчиллын зарчмыг гажуудуулахад түүнийг тойрон хүрээлэгсэд ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг гэж үзэж болно. Хошуучлагчид ямар нэг байгууллагыг түшиглэхгүйгээр үүргээ гүйцэтгэж чаддаггүй. Хүн төрөлхтөний түүхэнд хар мөр үлдээсэн харгис хошуучлагчид ганцаараа тийм их харгислалыг хийж чадахгүй байх байсан гэдэг нь ойлгомжтой. Сократ “хулгайч дээрэмчдийн бүлэг ч олзоо хуваахдаа баримтлах шударга ёсны зарчимтай байдаг” гэж байжээ. Удирдагчдын олон түмэнд хүлээн зөвшөөрөгдөх байдал дээр тулгуурласан тойрон хүрээлэгсэдийнх нь үнэнч дуулгавартай байдал нь дарангуйлагч дэглэмийг бэхжүүлж өгч байсан юм. Ард түмэн ямагт өөрсдийгөө чөлөөлөхийн төлөө тэмцлийнхээ ихэнх үед муу хааныг сайн хаанаар, муу хошуучлагчийг, сайн хошуучлагчаар солихын төлөө тэмцсэн байдаг. Өөрөөр хэлбэл ард түмэн түүхийн бүхий л үед ард түмний төлөө илүү ихийг хийж бүтээх хошуучлагчдын эрэлд явсан билээ.

Дэлхийн нэгдүгээр дайны дараа олон хүмүүс харгис хатуу дарангуйлагч дэглэмүүд нуран уналаа, ардчилсан шинэ төр гарч ирлээ гэж баярлацгааж байв. М.Горбачевын эхлүүлсэн өөрчлөн байгуулалтын жилүүдэд ч мөн л ардчилсан шинэ төр гарч ирлээ, эрх чөлөөний бүрэн ялалт боллоо гэж баярлаж байсан билээ. Гэтэл дуу дуугаа авалцан дарангуйлагч засаглалууд бий болж эрх чөлөө ардчиллын төлөө тэмцэж байсан хүмүүс маань нэг л мэдэхэд эрх чөлөөний дайснуудтэй нийлж ардчиллын нааштэй эхлэл бүрийг үгүй хийсэн юм. Үүнийг ард түмэн үгүй хийгээгүй, харин хошуучлагчид, түүнийг тойрон хүрээлэгсэд үгүй хийсэн гэдэг эргэлзээгүй. Коммунист дэглэмтэй байсан орнуудад тогтвортой ардчилал бий болгох талаар гарсан дэвшил янз бүрийн өнгө аястай байна. Төв Европ, Балтийн тэнгисийн орнууд шилжилтийг амжилттай даван туулсан бол Балканы хойгт байдал янз бүр, Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдхүүнд байсан улсуудын ардчиллын төлөв байдал янз бүр, ихэнхэд нь захиргаадалтын дэглэмүүд оршсоор байна. Хятад Вьетнам, Камбоджи авторитари дэглэм бүхий улс орнууд болжээ. Либерал ардчилал ерөөсөө хэврэг, хувийн эрх чөлөөг алдагдуулж түүнийг үндэсний эрх ашгаар нөхөн орлуулж байна.

Өнөөгийн ардчилсан нийгмийн зарчмууд нь эрх баригчдыг эрх мэдлээ хязгааргүй ашиглах боломж олгодоггүй юм. Хошуучлагчийн хүлээн зөвшөөрөгдөх байдал буюу хууль эрхийн чадамж гэдэг нь туйлын утгаараа шударга ёс, эрх зүйн асуудал бус, хүмүүсийн хувийн бодол, тусгалд байдаг харьцангуй үзэл баримтлал билээ. Энэ нь тодорхой цаг хугацаанд боломжтой. Ардчилсан тогтолцооны үед хэлсэн үг, хийсэн үйлдлийнхээ төлөө үйлийн эзэн өөрөө бусдын өмнө хариуцлага хүлээж байдаг. Өөрөөр хэлбэл сахилга, хариуцлага нь хянагчийн идэвхтэй эхлэл дээр биш, гүйцэтгэгчид буюу хошуучлагч, түүнийг тойрон хүрээлэгсэдийн идэвхтэй эхлэл дээр тулгуурлаж байдаг юм. Хошуучлагчид дангаараа ардчиллын үндсэн зарчмуудыг гуйвалтгүй баримтлах боломж нөхцөл хэр зэрэг бий вэ. Тойрон хүрээлэгсэд, эрх мэдэлд ойр буй хүмүүс хошуучлагчдад ийм бололцоог олгодог уу? Чингэс хаан

Уул мэт бие чинь

Нуран одвол

Улс олон Монголыг чинь

Хэн удирдах вэ

Тулгуур мэт бие чинь

Туйвж одвол

Туг их сүлдийг чинь

Хэн өргөх вэ

гэсэн Есүй хатны асуултанд хариулахын өмнө эхлээд өөрийн хөвгүүд болох Зүчи, Цагаадай, Тулуй нараас саналыг нь асуусан байдаг. Тэгвэл өнөөдөр Ельцин Путиныгаа, Путин Медведьевийгээ, Н.Энхбаяр, М.Энхболдыгоо, С.Баяр, Сү.Батболдыгоо нэр зааж сонгуулах нь хэр ардчилалтай хэрэг вэ? Өнөөдөр улс орны эрх ашгийг урьтал болгон улс төрийн хүчнүүдийг оролцуулан тогтвортой засгийн газрыг байгуулж, үүнийхээ үр дүнд, чухал ач холбогдолтой томоохон асуудлуудыг шийдэж, цэгцтэй ухаалаг яриагаараа олон түмний дунд хүндлэл хүлээж буй С.Баяр яагаад МАХН-ын XXIV их хурлаас намын дарга болж сонгогдож чадаагүй вэ? Үүнийг тухайн цаг үедээ хүлээн зөвшөөрөгдөж буй хошуучлагч өөрийн ээлж халаагаа өгөхдөө сонгогчдод нөлөөлж ардчиллын чухал шалгууруудын нэг болох гарааны тэгш байдал олгох гэсэн заалтыг зөрчсөнөөс үүдэлтэй гэж тайлбарлаж болох юм. Ингэж нэр заагдсан хэн нэгнийг заалнаас нэр дэвшигдэн гарах өрсөлдөгч ялах магадлал бараг үгүй юм. Ашиг сонирхлын янз бүрийн бүлэглэлүүд хошуучлагчийг ийм үйлдэл хийлгэхэд түлхдэг гэж таамаглаж болно. Учир нь сонирхлын бүлгүүд лобби явуулж зохион байгуулалт хийж зөвхөн өөрт ашигтай хэн нэгнийг гаргаж

ирэх нөхцөл бүрдүүлж байдаг нь хошуучлагчдаар ардчиллын нэг амин чухал зарчмыг үгүйсгэсэн алхам хийлгэхэд хүрдэг байж болно.

Улс төрийн удирдагчид бид ардчиллыг хүсч байна, харин улс орны эдийн засгийн засгийн хүнд байдал, ард түмний амжиргааны түвшний доогуур байдал нь ардчиллыг хэрэгжүүлэх боломж олгохгүй байна. Иймд улс орон хөгжил цэцэглэлтэнд хүрсний дараа, ард түмний аж амьдрал, соёлын түвшин өндөр болсны дараа ардчиллыг тогтооно гэж нотлохыг оролддог байна. Гэтэл өндөр хөгжил, техникийн дэвшил, баялаг бол ардчиллын баталгаа биш байдаг ажээ. Ф.Фукуяма “иргэншиж соёлжсон болон зэрлэг бүдүүлэг ард түмнүүдийн хоорондын ялгааг нацистуудын үхлийн хорих газруудыг үзсэний дараа гаргаж хэлэхэд тун хэцүү болсон байлаа” гэж бичсэн байдаг. Ард түмнийг эрх чөлөөнөөс айдаг, дарангуйллыг эрхэмлэдэг, төрийн эрх мэдэл, халамжийг хүсдэг сэтгэлгээтэй болгох боломж хошуучлагчид, эрх мэдэлтнүүдэд хангалттай байдаг. Ардчиллыг жинхэнэ утгаар нь бэхжүүлж, олон түмэн түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх ойлголт, боломжтой байх нь ийм дарангуйллаас сэргийлэх, нийгмийн хөгжил цэцэглэлтэнд хүргэх гол нөхцөл билээ.

Хошуучлагчид дарангуйлагч болоход нөлөөлөх нэг томоохон хүчин зүйл нь эрх баригчид удам залган төрийн хамгийн өндөр байр сууринд байгаа тохиолдол юм. Өвөг дээдсийн нь хийсэн үйлдэл нь олон түмний зүгээс ширүүн дайралтанд өртөх аюултай учраас тэд ардчиллыг дэмжихгүй хангалттай үндэслэлтэй байдаг. Мөн олон түмэнд өөрсдийн нь хийсэн нүгэл хилэнц, буруу үйлдэл нь ил гарах аюул нүүрлэвэл ардчиллыг эсэргүүцэгчид болж дарангуйллаар өөрсдийгөө хаацайлахыг эрмэлзэнэ. Мөн улс төрийн тогтворгүй байдал нь тэднийг өмнөх туршлагыг давтахгүйн тулд дарангуйлагчид болгож болох юм.

Хүн амын боловсролын түвшин дээшилж, мэдээллийн хэрэгсэл хөгжиж, хотжилт эрчимтэй явагдаж байгаа нь улс төрийн намууд, хошуучлагчид ардчиллыг хааж боох боломжийг багасгаж байна. Гэхдээ энэ нь олон түмэн улс төрийн боловсролгүй бол эсрэгээр нөлөөлж болох хүчин зүйл ч болж болох юм. Ардчиллыг хязгаарлах гэж эрх баригчдын зүгээс оролдох нь хэт хуучинсаг дүр бүхий улс төрийн хүчин болж харагдуулах нөхцөл байдал өнөөгийн байдлаар бүрдсэн байгаа тул тохирсон бодлого явуулж ардчиллыг бэхжүүлэх замаар өөрсдийн ололттой талыг сурталчилж нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх нь илүү ухаалаг алхам билээ.

Монгол улс 1985 онд чөлөөт бус орон, 1990 онд хагас чөлөөт орон, 1995 оноос хойш чөлөөт орон гэсэн ангилалд хамрагдаж байна. “Азийн барометр” судалгаанд “Монгол нь Зүүн Европын орнуудаас гадна коммунизмаас чөлөөт өрсөлдөөнт олон намын систем бүхий капиталист ардчилалд амжилттай шилжсэн цорын ганц орон” гэж тэмдэглэжээ. Гэвч энэ судалгаанд “албан тушаалтнууд чухал мэдээллийг олон нийтээс

нууцлах явдал хэр их гардаг вэ” гэсэн асуултанд манай иргэд “байнга болон ихэнхдээ мэдээллийг нуудаг” гэж 36.1% хариулжээ. Мөн “Төр засаг нь хууль зөрчихөд манай хуулийн систем яаж ч чадахгүй” гэж үзэж байна. Тэгш байдал хэр зэрэг хангагдсан бэ гэсэн асуултанд Монголд эерэг хариулт 23.2% байна. Энэ нь Азийн бусад орнуудаас, тодруулбал, Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Филиппин, Тайланд, Индонез, Сингапур, Гонконг, Вьетнам орнуудаас бүгдээс нь хамгийн доогуур байна. “Төр засаг нь ард түмнийхээ өмнө хариуцлага тайлагнах байдал хэр зэрэг вэ” гэсэн асуултанд Судалгаанд хамрагдсан Азийн бусад орнуудаас бараг манай улс хамгийн сүүлд 25.3% буюу 21.2 % үнэлсэн Өмнөд Солонгосын л өмнө байна. Ардчиллын төлөв байдлыг харуулдаг олон үзүүлэлтүүдэд манай улс сайн үзүүлэлтэй гарч байгаа боловч дээрхи хэдэн үзүүлэлтүүд нь манай ардчиллын түвшинг бууруулах хангалттай үнэлгээ мөн. “Иргэн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй” гэсэн зарчмыг ардчилсан улс орнууд дээдлэж ирсэн зарчим манайд хэрэгжих болтол нилээд бэрхшээлийг туулах шинжтэй байна.

“Алд бие минь алжааваас алжаатугай

Ахуй төр минь бүү алдартугай

Бүтэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай”

гэж Чингэс хааны эрхэмлэн үзсэн үзэл санааг улс төрийн хошуучлагчид, төрийн өндөр албанд байгаа хүмүүс эргэлзээгүй сахин мөрдөх аваас төрийн нуруу түвшин, түмэн олон амгалан байж, улс орон хөгжин цэцэглэх буй за.

ЗАСАГЛАЛ ДАХЬ ПАТРИМОНИАЛЬ, НЕОПАТРИМОН ХЭЛБЭРИЙН НОЁРХОЛ

Ц.Батболд

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Судлаачид уламжлалт нийгмийн үеийн хэмжээгүй эрхт хаант засаглалын төрийн аппаратыг патримониаль хэмээн нэрлэдэг. "Патримониаль" хэмээх ойлголт нь Ромын эзэнт гүрнээс эх үүсэлтэй. Августын засаглалын үеэс "patrimonium"⁵¹ гэдэг нэр томъёо эзэн хааны хувийн хөрөнгийг илэрхийлж байсан бөгөөд эзэн хаан төрийн сан хөмрөгийг Сенатад тайлагнахгүйгээр өөрөө захиран зарцуулдаг байв⁵². Үүнийг XVII зууны дунд үеэс Т.Гоббс улс төрд патримониаль төрийн хэлбэрийн тухай ойлголт маягаар анх дурьдаснаар улс төрийн хэллэгийн санд орж иржээ. Патримониаль гэдэг нь "латин гаралтай өмч эзэмшил болон өв залгамжлах"⁵³, гэсэн утгатай үг бөгөөд "өв залгамжилсан хэргэм зэрэг бүхий түшмэдтэй нэг хүний засаглалыг"⁵⁴ хэлж буй хэрэг юм. "XIX зууны эхэнд патримониаль төр гэсэн нэр томъёог Германы зарим эрдэмтэд хэрэглэж байсан боловч тэд патриарх патримон засаг төрийн хоорондох ялгааг олж хардаггүй байжээ"⁵⁵.

XX зууны эхээр М.Вебер засаглалыг патримониаль төрлийн ойлголтоор баяжуулж өгсөн төдийгүй, уламжлалт засаглалын төрлүүдийн нэг хэлбэр бөгөөд анхдагч патриарх ёсноос үүсэлтэй гэж үздэг. "Патриарх ёс"⁵⁶ нь эцгийн эрхт овог гэсэн утгыг илэрхийлсэн грек үг бөгөөд бурхан, тэнгэрээс заяасан угсаа залгамжилах ёсны бие даасан язгууртнууд бүхий төрийн тухай ойлголт юм. Угсаа залгамжлах ёс нь тухайн угсаатан ястан өөрсдийн язгууртан сурвалжтануудаа өөрсдийн эрх ашгийг хамгаалагч, тэнгэр язгуурт хүмүүс гэж үзэж иржээ.Энэ нь эзэн хаанаас үл хамааран үе улиран угсаа залгамжилж ирсэн үндэс угсааны "томилогоо" юм. Угсаа залгамжлах ёс нь хааны

⁵¹ Patrimonium- Ромын эзэн хааны хувийн хөрөнгийг илэрхийлж байсан латин үг юм.

⁵² Kamenka E. Bureaucracy. Oxford, 1989. P.63.

⁵³ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994. dilithium Press Ltd. x 1059.

Patrimony- 1.эцэг өвгөдөөс уламжлагдсан үе удам, 2.ямар нэгэн шинж чанар, шинж тэмдэг, тэр нь голдуу өв хөрөнгө уламжлал дээр гарч ирдэг.

⁵⁴ Oxford. Advanced learner's /dictionary/. London., 1994. p 906-907.

⁵⁵ Roth G. Introduction // Weber M. Economy and society. Berkeley, 1978. P.XCIV.

⁵⁶ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994. dilithium Press Ltd. p 1057.

(Patriarch) Патриархи – Нийгмийн байгууллын хэлбэр, жишээлбэл: овог, гэр бүлийн эрхэмлэх эцэг. Нийгмийн байгуулалд тулгуурлагдсан нийгэм, нийгэмлэг, улс гэдэг грек үгнээс гаралтай.

засаглалд ихээхэн бэрхшээл учруулдаг байв. Патриархал ёсны үеийн хааны засаглалын гол тулгуур нь түүний тойрон хүрээлэл бөгөөд үүнд шадар түшмэл, цэргийн жанжин, нөхөр цэргүүд (рыцарь) ордог аж. Учир нь хаанд дургүйцсэн угсаа залгамжилсан сурвалжит язгууртнууд хааны цусан төрлийн хэн нэгнийг дэмжин хааны эрх мэдлийг булааж авахыг эрмэлздэгт оршдог. Өөрөөр хэлбэл, патриарх ёсны үед хаан нас барахад хаан ширээний төлөө ураг төрлийн тэмцэл зайлшгүй үүсдэг бөгөөд сурвалжит язгууртнууд хуваагдан тэмцэлдэж улс орны тогтвортой байдлыг алдагдуулдаг байна. Энэ тэмцэлд ялсан нь ялагдагчидаа гэсгээн цээрлүүлж, ялагчдын талаас шинэ язгууртнууд нийгэмд элитийн солигдлыг бүрдүүлдэг. Хэмжээгүй эрхт хаант засаглалын үед угсаа залгамжилсан язгууртны үеийн дарамт шахалтыг эзэн хаан өөрийн хувийн удирдлагын аппаратыг бэхжүүлсэнээр зайлуулж чаджээ.

М.Вебер Европын хэмжээгүй эрхт хаант засаглалын үеийн түшмэл ёсны тухай “патримониаль бюрократ”⁵⁷ гэдэг ойлголтыг авч үзсэн. Өөрөөр хэлбэл, аж үйлдвэржүүлэлтийн өмнөх зурвас үеийн хаант засаглалын түшмэдийг өв, үе залгамжилсан уламжлалт “патримониаль бюрократ” гэж нэрийдэн түүнтэй рационал бюрократыг харьцуулан судалжээ. Засаглалыг эзэн хаанаас хараат түшмэдээр гүйцэтгүүлэн улс орныг хяналтандаа авч, тогтвортой засаглалыг бий болгох зорилго агуулж байсан Европын XVII-XVIII зууны үеийн бюрократизмээс өмнөх төрийн хэв шинжийг ийнхүү нэрлэжээ. Патримониаль нь хэмжээгүй эрхт хаант засгийн шинж төрхийг бүрдүүлдэг тогтолцоо байв.

Патримониал бюрократ бол цэрэг-улс төр, эдийн засгийн хүчний хувьд бие даасан, угсаа залгамжилсан хүчирхэг тайж язгууртнуудыг шахах зорилгоор эзэн хаанаас хараат төрийн түшмэдийг бүрдүүлэн язгуур угсааны цол хэргэм болон албан тушаалыг хаан хүртээж, өв залгамжлах эрхийг нь баталгаажуулах, эсвэл хүчингүй болгох тогтолцоог бүрдүүлсэнээр хааны эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн засаглал юм. Хаан түүний түшмэдийн засаглал нь эзэн хааны хувийн ашиг сонирхол болон угсаа залгамжлалыг хадгалахын хамт, түшмэлүүд, язгууртны эрх ямбыг хамгаалахад чиглэгддэг. Ямарч хувийн эдлэн, улсын удирдлага бүхэлдээ засгийн эрх баригчийн хувийн үзэл бодол, сонирхолд тулгуурладаг бол түүнийг хэрэгжүүлэгч түшмэд өөрийн сонирхлыг энэ хүрээнээс халихгүйгээр хэрэгжүүлэх ёстой аж. Энэ нь төрийг угсаа залгамжилсан хааны эзэмшил буюу түшмэдийн хувийн эдлэнгээс нэг их ялгагдахгүй болгосноор патримониаль төрийн мөн чанарыг харуулдаг ажээ.

Эзэн хаан болон түүний засаглалд үйлчилдэг түшмэдийн мөн чанар нь эзэндээ үнэнч зүтгэхэд чиглэгддэг бөгөөд тэд ч ийм чанарыг харгалзан сонгодог байна. Хааны мэдэлд буй цэрэг арми, бусад олон салбарыг санхүүжүүлэх асуудал байнгын бэрхшээлтэй асуудлын нэг болж байв. Эзэн хаан шан харамж хэлбэрээр хэргэм зэрэг,

⁵⁷ Weber M. *Wirtschaft und Gesellschaft*. Tubingen, 1976. S.621-623. Пер М.В.Масловского. *Хозяйство и общество / Царский патримониализм*.

цол ахиулахаас илүүтэй хэргэм зэрэг, албан тушаалыг үнэлэн худалддаг аж. Энэ нь нэг талаар эзэн хаан төрийн сан хөмрөгийг арвижуулсанаар засаглалаа хадгалж хамгаалахад нь тустай. Нөгөө талаар хааны соёрхсон цол хэргэм, албан тушаалууд нь уламжлалт угсаа залгамжилсан тайж язгууртнуудын байр суурийг сулруулдаг нь хаанд тустай байсан. Гэсэн хэдий ч төрийн чухал албан тушаалд дэвшүүлэх нь эзэн хааны энэрэл хайрын нэг илрэл бөгөөд тэр “фаворитизм”⁵⁸ хэлбэрээр зөвхөн өөрийн тойрон хүрээлэл буюу үнэнч итгэлтэй хүмүүсээ дэвшүүлдэг нь засаглалаа бэхжүүлэхтэй холбоотой нь зайлшгүй. Фаворитизм бол зөвхөн ах дүү, төрөл садан, итгэлт найз нөхдөө ашиглан байр сууриа хадгалах, үзэл бөгөөд энэ хүрээнд хамаарч болох бусад үзэгдэл (шүтэн бишрэх, зусар бялдуучлал, хээл хахууль гэх мэт)-ийг өргөн ашиглаж, эрх мэдлийн тойрон хүрээллийг бий болгох явдал юм.

Патримониал засаглалд патриархын нэгэн адил хувийн итгэлтэй байх зарчим нэгдүгээрт тавигддаг байна. Патримониал төрд эзэн хаан дунд, доод тушаалын түшмэл, алба хаагчдыг хөдөлмөрийн хуваарь, ямар нэгэн дүрэм журамгүйгээр, зөвхөн хувийн үзэмжээр томилдог байв. Р.Бендикс “иймэрхүү маягаар зохион байгуулагдсан том улс гүрнүүдэд ч гэсэн албан тушаалын ямар нэгэн системийг олж харах хэцүү байдаг”⁵⁹ гэжээ. Өөрөөр хэлбэл, алба хашигчдын эрх мэдлийн өрсөлдөөн нь уламжлалт угсаа гарал, ах дүү, төрөл садан, найз нөхөд, үндэс угсаа, нутгархал, хээл хахууль, албан тушаалын наймаа зэрэг “патернализм”⁶⁰-ын тойрон хүрээллийн дүнд сая тодорхой болж ирдэг байна. Тиймээс патримониал алба хашигчдын эрх мэдлийн хил хязгаарыг олж харахад хэцүү бөгөөд тэд хаан, шадар түшмэдийн хэнийх нь ивээлд багтаж буй, хэр эрх мэдэлтэй нь тэр бүр мэдэгдэхгүй.

М.Вебер “ийм албан тушаалтнуудад юу ч хийсэн зөвшөөрдөг байсан ба энэ нь засаглалын уламжлал ба эзэн хааны харъяат албад түүнд захирагдаж, тэд түүнийг эдийн засгийн хувьд барьж байх чадварыг хадгалах гэсэн сонирхолтой хоршиж байх ёстой”⁶¹ гэсэн байна. Патримониаль түшмэлүүд хааны адилаар өөрсдийн эрх мэдлээ хувийн эрх ямба (хувийн давуу тал) гэж үзэж, нийгмийн өмнө бус харин зөвхөн хаан, дээд түшмэдийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэж үздэг байв. Түшмэд өөрийн эрх мэдлээ хувийн онцгой эрх гэж үздэгээрээ уламжлалт ёсоор хааны нэрийн өмнөөс ямар нэгэн үйлдлийг өөрийн бодол, үзэмжээр шийдвэрлэх бөгөөд цөөнгүй тохиолдолд зөвхөн шагнал урамшуулал хүртэхийн үүднээс аливаа зүйлийг хийдэг. “Хамгийн эртний улс төрийн байгууллаас ч гэсэн эзний хувийн захиргааг бид олж үзнэ. Үүнд: өөрийн

⁵⁸ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994. dilithium Press Ltd. p 519. Favoritism – favor-it-ism: алагчлах буюу хэн нэгнийг илүүд үзэх, дэмжих, эсвэл нэг буюу бүлэг хүмүүсийг бусдаас илүүд авч үзэх, өөрөөр хэлбэл, тойрон хүрээлэлдээ илүү итгэж, эрх мэдлийг олгох явдал бөгөөд удирдлагын зүгээс өөрийн итгэл төрүүлсэн хүмүүсийг томилох систем юм. Энэ нь эсрэг утгаараа өөртөө үнэнч, итгэлтэй хүмүүсээр эрх мэдлийг тойрон хүрээлүүлэх явдал үзэл, хандлага юм. (Өөрөөр хэлбэл, зөвхөн ах дүү, төрөл садан, итгэлт найз нөхдийн нэгнээсээ үл урвах холбоог засаглалд ашиглан байр сууриа хадгалах, нэмэгдүүлэх үзэл)

⁵⁹ Bendix R. Max Weber: An intellectual portrait. L., 1966. P.345.

⁶⁰ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994. dilithium Press Ltd. p 1056.

Paternalism pa-ter-nal-ism: Энэ бол систем, зарчим бөгөөд үндэс угсаа, бизнес, хувь хүмүүсийг удирдах удирдлагын практик юм.

⁶¹ Weber M. Wirtschaft und Gesellschaft. Tubingen, 1976. S.597.

хөрөнгөнөөс биет болон мөнгөн шан, харамж олгодог эзнээс шууд хараат боолчууд, гэрийн албаныхан, зарц нар, дотно хүмүүс болон газар эзэмшигчдээр дамжуулан удирдлагыг гартаа авах, зардлыг өөрөө, эд хөрөнгөнөөс орох орлогоор төлөх, зөвхөн түүнээс хараат цэрэг байгуулах оролдлого хийнэ.”⁶² Энэ нь орчин үеийн төрийн хүнд сурталт бюрократ аппаратад зуршмал хэлбэрээр хадгалагдаж байдаг. Өөрөөр хэлбэл, орчин үеийн “нэг ч түшмэл өөрийн зарцуулж буй хөрөнгө мөнгө, өөрийн мэдэлд буй байшин барилга, нөөц, багаж хэрэгсэл, цэргийн техникийн өмчлөгч биш”⁶³ боловч улс төрийн эрх баригч эздийн (нам, бүлэглэл, харизматик лидер гэх мэт) хүслээр эрх мэдэл, албан тушаал, нийтийн сангаас хүртэх хуваарилалтын хувьд хараат байдал нь хууль ёсны ба хууль ёсны бус хэлбэрээр хадгалагдсаар байна.

Иймэрхүү маягаар засаглалын харилцаа хувийн шинжтэй байхын зэрэгцээ патримониаль удирдлага нь түшмэдийн албан тушаалд хувийн өмч мэт ханддаг. Патримониал удирдлагын түшмэд ямар нэгэн дүрэм журамд захирагддаггүй бөгөөд дур зоргоороо үйл ажиллагаа явуулдагт хэргийн учир оршдог. Патримониаль түшмэлийн засаглалын эрхийн үндэс нь эдгээр түшмэд албан тушаал, эрх ямбаа бүрэн эзэмшиж авах төдийгүй түүнийг өмчлөх, үе залгамжлуулахад оршдог. Ийм нөхцөлд төрийн түшмэд төрийн төлөө байхаасаа илүү өөрийн (тухайн үеийн улс төрч гэж ойлгож болох) эзэн ноёны ашиг сонирхлын төлөө байхын хамт, өөрийн хувийн ашиг сонирхлыг хэзээ ч хойш тавьдаггүй.

Патримониаль засаглалын бүтэц нь түшмэлийн хувийн шинж чанараас ихээхэн хамаардаг. Учир нь төрийн албан тушаалд томилох хууль ёсны шалгуур байдаггүй тул хувийн үзэмж, дотно харилцаа, хээл хахууль, тойрон хүрээлэл, зусар бялдуучлал, эрх баригчдад үнэнч байх нь шалгуурын үүрэг гүйцэтгэдэг. Гэвч түшмэдийн эдгээр эрх мэдэл нь эзэн хаан ба дээд түшмэдийн дур зоргоор хэзээ ч алдагдах нөхцөлтэй байдаг. Иймээс тэд эрх баригчдаас бүрэн хамааралтай байдаг боловч түүнийг хязгаарлах нэг арга нь доод шатандаа өөрийгөө дэмжигч ойр дотнын түшмэдийн тойрон хүрээллийг патернализмын зарчмаар буй болгох явдал байв. “Патримониаль удирдлагын бүтцэд албан тушаалын ба бүх нийтийн засаглалыг явуулах нь нэг талаас эзэн хаанд, нөгөө талаас түшмэлд өөрт нь үйлчилдэг бөгөөд тэд эзэнгүй зорилгод үйлчилдэггүй байна”⁶⁴.

Патримониал төрд түшмэдийн хувийн шинж чанарын гажуудал улам бүр төвлөрсөн бүтэц болох тусам тэр нь рационал засаглалтай болж чаддаггүй бөгөөд эцсийн бүлэгт патримониаль түшмэд эзэн хааны дуулгавартай зэвсэг болж байдаг ажээ. Учир нь патримониаль бюрократ нь төрийн тэргүүн ба түшмэлүүдийн хоорондын харилцааны хэлбэрдсэн эрх зүйн хэв шинжийг бус, харин хувийн харилцааны шинжийг

⁶² Вебер М. Улс төр бол шинжлэх ухаан мөн. Улс төр бол мэргэшил мөн. УБ., Орч Ү.Нямдорж. УБ., 2000. Suna group. X. 14.

⁶³ Вебер М. Улс төр бол шинжлэх ухаан мөн. Улс төр бол мэргэшил мөн. УБ., Орч Ү.Нямдорж. УБ., 2000. Suna group. X. 15.

⁶⁴ Weber M. Wirtschaft und Gesellschaft. S.598.

илүү ялгаж тодруулж өгдөг. Патримониаль бюрократад түшмэлийн хувийн шинж чанар, сэтгэл зүйн элементийн нөлөө өндөр байдаг нь иррациональ шинж давамгайлах болон язгуур угсааны засаглалын хадгалагдах нөхцлийг илүү бүрдүүлдэг байна. Тухайлбал, патримониаль бюрократад рациональ шинжүүд хичнээн их хөгжиж байсан ч гэсэн засаглалын харилцааны хувийн шинж чанар нь өөрчлөгдөхгүй үлдэнэ. Энэ нөхцөлд хууль, дүрэм журмын тодорхой бус байдал нь дунд, доод түвшинд ч түшмэдийг дүрэм журамгүй, хувийн үзэмжээр үйл ажиллагаа явуулах боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралыг зохицуулах нь хувь хүн буюу түшмэлийн хувь хүний мөн чанараас ихээхэн хамаарна гэсэн үг. Тиймээс тухайн төр, нийгмийн амьдрал сайн хаан, сайн түшмэлээс ихээхэн хамааралтай буюу хувь хүн улс төрийн идэвхтэй субъект болох боломж өндөр байдаг ажээ.

Патримониаль бюрократ бүхий улс гүрнүүдэд түшмэдийн эзэмших эрх мэдлийн эрмэлзлэлийг хязгаарлах янз бүрийн аргууд ч байсан аж. Тухайлбал эзэн хаан түшмэлийн албан тушаалд байх хугацааг хязгаарлах, тэднийг газрын эзэмшилгүй, нэр нөлөөтэй хамаатан садангүй орон нутагт томилох, цэргийн ба иргэний засаглалыг нэгтгэж нэг хүний гарт оруулахгүй байх, мөн өөрийн итгэлтэй хүмүүсээр дамжуулан байнга түшмэдийн үйл ажиллагааг хянаж байхыг эрмэлзэж байсан аж. Үүнээс гадна төвийг сахиж, зүйг баримтлах сонгодог арга бол нийгмийн эрх ямбатай давхрагаас гарал үүсэлгүй, өөрийн өмчийн эрх мэдэлгүй, ахих ирээдүйгүй дорд гаралтай хүмүүсийг дэвшүүлсэнээс үүссэн аж. Тэдгээр бага тушаалын түшмэд ихэвчлэн гавьяа зүтгэлийн үр дүнд албан тушаал олж авах бөгөөд дээрээс татах татлаа, дэмжлэггүйн улмаас төвийг сахиж, зүйг баримтлах нь тэдний оршин тогтнох гол шалгуур болж байв. Түүнээс гадна гадаад хүмүүсийг ашиглах явдал түгээмэл байсан бөгөөд энэ тохиолдолд тэдгээр нь эзэн хаанаас бүрэн хамааралтай байдаг аж. Ийм нөхцөлд түшмэлийн хувийн шинж чанар засаглалын легитим, нийгмийн амьдралд чухал үүрэгтэй болж ирдэг учраас түшмэл ёс буюу сайн түшмэлийн шинж чанарын тухай сургааль номлолууд уламжлалт нийгмийн үеийн улс орон бүрд тодорхой хэмжээнд бий болсон байдаг. Тухайлбал, Монголд түшмэл хүний есөн шинжийг дараах байдлаар тодорхойлж байсан бололтой.

Үүнд:

1. Эрдэм мэдлэг төгс. Бичиг эрдэмд хичээнгүйлэн суралцаж гэгээрсэн байх ёстой.
2. Холч ухаалаг. Удам судраар хөөн тодорсон, хурц хар ухаан бүхий алсын хараа, уужим ухаантай байх.
3. Өршөөнгүй сэтгэлт. Нигүүлсэнгүй сэтгэлийг барьж ард түмнээ асрагч байх.
4. Үнэнч шудрага. Төр улс, хаан эзэн, түмэн олондоо үнэнч зүтгэдэг төрийн зүтгэлтэн байх.
5. Ёс журамт. Төр ёс, түмэн олноо хүндэтгэсэн ёс журмыг баримтлагч байх.

6. Төв түвшин. Голч ухаан, түвшин сэтгэлийг эрхэм болгосон амьдралын ноён нуруутай байх.
7. Үйлс ариун. Бuzар булай ёс бус үйлсийг цээрлэн үл хийгч цэвэр ариун байх.
8. Бурууд хатуу. Ёс бус үйлдлийг үл зөвшөөрч төрийн цаазыг хатуу барьдаг байх.
9. Чин зоригт. Аливаад хүлээцтэй тэвчээртэй хандаж, ёс бус хандлага, дайралт, дарамтад үл автагч байх.

Энэ нь патримониаль төрд эзэн хаан болон түүнд үйлчлэгч түшмэдийн хувийн шинж чанараас төр, нийгмийн харилцаа ихээхэн хамаардаг гэдгийг харуулж буй хэрэг юм. Засаглал нь хувь хүний мөн чанараас хамаардаг тухайн цагийн патриархал болон патримониал системийн үед нийгмийн харилцаанд ажил хэргийг авч үзэх хугацаа, дүрэм журам байхгүй, тэдгээрийг үйлдвэрлэх, хариуцах харъяаллын байгууллагууд нь тодорхой бус, бүх юманд замбараагүй байдал ноёрхож, түшмэд хувийн үзэл бодол, эрх ашгийн үүднээс хандах байдал ноёрхсон, хээл хахууль нь бараг бүх зүйлийг шийдвэрлэхэд нөлөөлдөг, асуудлыг шийдвэрлэхдээ потизм, фаворитизм зэрэг овгийн байгуулал, хувь хүний хүчин зүйлүүд, эд хөрөнгө, тухайн хүний статус буюу язгуур угсаа, хэргэм зэрэг, танил тал, зальхай байдлын үүднээс ханддаг байсан аж. Үүний эсрэг патримониаль дэглэмийн гол тулгуур нь удирдлагын аппарат бөгөөд тэр нь эзэн хааны хувийн албадаас бүрдэж байдаг оршино. Гэвч нийгмийн харилцааны дээрх уламжлалт хэв шинжийг патримониал түшмэд эвдэж чаддаггүй байв.

Эцсийн бүлэгтээ эзэн хаад уламжлалт язгууртнуудын байнгын дарамт шахалтыг бууруулах зорилгоор цол хэргэм, албан тушаалыг худалдаж, шагнаж мөн зарим тохиолдолд өвлүүлсэнээр түшмэдийн тоо, тэдний эрх хэмжээ нэмэгдэн угсаа залгамжилсан уламжлалт тайж, язгууртнуудын байр суурь суларсан юм. Угсаа гаралгүй, эрх чөлөөгүй хүмүүсийг дэвшүүлсэнд дургүйцэх уламжлалт язгууртнуудын дургүйцэл нь төрийн удирдлагын процессын өөрийнх нь болон нийгмийн хэрэгцээ, шаардлагаар няцаагддаг байв. Патримониаль удирдлагын аппаратын онцлог үндсэн шинжүүдийн нэг нь тогтмол мөнгөн урамшуулал байдаггүй эсвэл бага байх явдал байсан. Тогтмол мөнгөөр цалин хөлс олгохын оронд бүх насаар нь тодорхой албан тушаалын эрх эдлүүлэх ба өмчлүүлдэг байна. Энэ нь ямар нэгэн хэлбэрээр хааны тарианы сангаас тариа будаа авах эрхтэй байх буюу албан акт баримт явуулсны төлөө тодорхой мөнгөн төлбөр төлдөг байж болох төдийгүй албан тушаалын эрх мэдлийн шийдвэрээ үнэлж амьдрах нөхцлийг нь хангадаг. Нөгөө талаар бага цалин олгож, хээл хахуулийг хориглосноор түшмэлүүдийг байнгын айдастай, бодит нэгдмэл хүч болгохгүй байхад чиглэгдэж байсан ажээ.

Хэмжээлшгүй эрхт хаант улс тогтсоноор төрийн засаглал патримониаль хэлбэрээр бэхэжсээр ирсэн аж. Ийнхүү эцэстээ патримониаль түшмэлүүд эзэн хааны ноёрхолд

ямар нэг хэмжээгээр хязгаар тавихад хүрдэг байна. “Эзэн хааны комиссарууд”⁶⁵ ийм түшмэдэд түшиглэн илүү их хэмжээгээр уламжлалт язгууртнуудыг хязгаарлаж эхэлсэн бол, тэдний үүрэг болон засгийн газрын ажил хэргүүд улам цогц болох тусам техник шинжтэй болж байлаа. Гэвч патримониаль түшмэлийн өөрийн албан тушаалдаа үнэн ч байх явдал нь “эзэнгүй зорилгод хандсан эзэнгүй үүрэг биш бөгөөд энэ нь юуны өмнө эрх баригчдад хандсан амин хувийн харилцаа ба хязгааргүй байдаг итгэлийг алдахгүй байхад үндэслэгдсэн зарцын (гар хөл бологчийн) үнэн ч байдал юм”⁶⁶. Эрх баригчийн тушаалууд ийм бүтцэд дур зоргоор эвдэгдэж, үгүйсгэгдэж байдаг төдийгүй ямар ч зохиомол дүрмийн дэргэд байнга давамгайлж дээгүүр тавигддаг аж. Гэвч патримониаль түшмэдийн үйл ажиллагаанд хуулийн хязгаарлалт бараг үгүй тул, тэд эрх мэдлээ хэмжээ хязгааргүй ашигладаг. Патримониаль түшмэдийн албан тушаал, эрх ямбаа бүрэн эзэмших гэсэн хандлага эрмэлзлийн эцсийн хөгжил нь түшмэд өөрийн ашиг сонирхлыг бэхжүүлэхэд чиглэгддэг байна. Ийм байдлаар түшмэд нь хааны энгийн албатаас аажмаар өөрсдийн албан тушаалаа эзэмших эрхийн төлөө горилогч онцгой эрхтэй давхрага болон хувирдаг. Энэ тохиолдолд эзэн хааны засаглал ба түшмэдийн захиргааны хооронд бодлогын болон харилцааны зөрчил үүсэх гол нөхцөл болдог. Эзэн хааны сонирхол бол хамгийн чухал албан тушаалд өөрийн хувийн албат буюу өөрөө шилж сонгосон хүмүүсийг гаргаж тавих асуудал байдаг ч, энэ нь зөвхөн түшмэл албан тушаалыг өөрийн болгож аваагүй тийм хүрээнд л биелэгдэх боломжтой. Харин албан тушаал, эрх мэдлээ хэдийн хувийн мэт болгосон нөхцөлд “эзэн хааны өөрийн ноёрхлоо тогтоож чадах хувийн чадвар (харизм) онцгой чухал ач холбогдолтой байдаг”⁶⁷ ажээ.

Патримониаль бүтэц оновчтой бус зохион байгуулагдсан, түшмэдийн эрх мэдлийн хүрээ болон хэмжээ хязгаар тодорхой бус, албан тушаалд дэвшихэд тэдэнд тусгай бэлтгэл шаардлагагүй байдаг зэрэг нь рационал аппаратын шинжийг бүрдүүлж чаддаггүй. Патримониаль түшмэдийн засаглалын эрхийн үндсэн зорилго нь эдгээр түшмэд албан тушаалаа түүнтэй хамт эрх ямбаа бүрэн эзэмшиж, өвлөж авахад л чиглэнэ. Ингэж эзэмших гэсэн хандлага эрмэлзлийн эцсийн хөгжил нь түшмэдийг бюрократ шинжээ бүрэн алдахад хүргэдэг байна. Өөрөөр хэлбэл, байгууллагаас гадуурх өөрийн хувийн легитимийн эх үүсвэртэй ийм түшмэлийг сахилга батаар барьж болдоггүй. Түшмэлүүд өөрийн удирдлагын хэрэгслийг бүрэн өмчлөн эзэмшинэ гэдэг нь патримониаль дэглэмийн төвлөрлийг сарниулах ба бюрократ бүтцийг задралд хүргэх аюултай байдаг. Гэхдээ эмпирик маягаар ажиглагддаг патримониаль бюрократад зарим нэгэн рациональ шинжүүд хөгжихийн хамт түшмэд удирдлагын хэрэгслэлийг эзэмших гэсэн хандлага гардаг ч энэ нь улс төрийн засаглалын шинж чанарыг бүрэн агуулж чаддаггүй учраас дэглэмийн төвлөрлийг бүрэн задлана гэсэн үг биш юм. Иймээс патримониаль бюрократ нь рационал бюрократ ба язгуур угсааны патриархал засаглал

⁶⁵ М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология /Полис/. М., 1997.

⁶⁶ Э.Н.Ожиганов. Политическая теория Макса Вебера, Критический анализ. Рига., 1986, с 112.

⁶⁷ Гайдено П.П., Давыдов Ю.Н. История и рациональность: Социология Макса Вебера и веберовский ренессанс. М., 1991. С.24.

хоёрын хооронд завсарын шинжтэй байр суурь эзэлдэг байна. Иймэрхүү патримониаль засаглалын систем зөвхөн Баруун Европын абсолют монархийн үед л бүрэн хөгжлийн төлөвөө олсон аж. Эзэн хааны ивээл доор шууд түүний хүсэлд бүрэн захирагддаг шинэ бюрократуудын давхарга ийнхүү бүрэлдсээр байв.

Төрт улсуудын хөгжлийн явцад эзэн хаан засгийн эрх барих сонирхлыг бэхжүүлэхэд санхүүгийн нөөц шаардлагатай болсны улмаас засаглалын оновчтой системийг тусгай бэлтгэгдсэн түшмэлүүдийн тусламжтайгаар хөгжүүлэхээс өөр аргагүй болсон байна. Ийнхүү засгийн газрын бодлого ба санхүүгийн хуваарилалтын асуудал нь нийгмийн бүлгүүдийг төлөөлсөн төлөөлөгчдөөр хэлэлцэгдэх нь улс орны хөгжил дэвшил, засаглалын тогтвортой байдлын баталгаа болж ирсэнээр, хааны эрхийг түшмэлүүд аажим аажмаар хязгаарласаар бүгд найрамдах засаглал тогтоох үндсэн нөхцлийг бүрдүүлж эхэлсэн ажээ.

Үндэстний төр улсуудын бэхжилт, үйлдвэржсэн нийгмийн ололт нь үндсэн хуульт ёс, бүгд найрамдах засаглалыг тогтоосноор улс төрийн засаглалыг хувааж, төрийн эрх мэдлийг хуваарилан түүний үйл ажиллагааг хууль, дүрэм журмын дагуу ажиллагч институтжсэн механизм болгосон билээ. Гэвч түүнд ажиллагч төрийн албан хаагчид хувь хүний хувьд хэн байх нь хамаагүй харин төрийн машины эд эс, эрэг шураг болон хууль, дүрэм журмийг баримтлагч, ямар ч сэтгэлийн хөдлөлгүй, хүйтэн хөндий, хүнд суртлын хүн машин болон хувирсан хэмээн шүүмжлэгдэж байв. Хүнд суртлын машин үйл ажиллагаагаа “Паркинсоны хууль”-иар тэлж, удирдлагын мөн чанарыг “Петрийн зарчим”-аар туйлшруулан, нийгэмд Р.Мертоны “дисфункц” үүсгэж, эдгээр нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлан, нийгмийн хөгжлийг саатуулагч механизм болсныг М.Крозье “Бюрократ феномен” бүтээлдээ “удирдлагын хямрал” буюу төрийн хэт оролцооны хямрал хэмээн тодорхойлжээ. Ийнхүү ХХ зууны 70-аад оны эцсээр эдгээр эрдэмтдийн үзэл санааг үндэс болгосон шинэ улс төрчид буюу неоконсервативчууд төрөн гарч төвлөрлийг сааруулж, төрийн оролцоог хязгаарлах болсоноор өнөөдөр дэлхий ертөнцийг хамарч буй засаглалын шинэтгэлийг эхлүүлсэн билээ.

Засаглалын шинэтгэл 1980-аад оноос эхэлж үндсэндээ хоёр чиглэлтэй хэрэгжин, хэд хэдэн үе шатыг дамжин явагдаж, эдүгээ нийтийн захиргааг бий болгох, төлөвшүүлэх асуудал руу ардчилал бэхэжсэн орнуудыг чиглүүлэх болов. Бид 1990 оноос энэ уур амьсгалд татагдан орж, улс төр, эдийн засаг, нийгмийн хэм хэмжээ, оюун санааны үнэт зүйлс зэрэг нийгмийн бүх дэд системд бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай тулгарсан билээ. Нийгмийн шилжилт, засаглалыг ардчилах үйл явц нь төрийн сонгодог бюрократ бүтцийг эвдэж, улс төрийн шийдвэрийг олонхийн төлөөллөөр зохистой гаргадаг ардчилсан засаглал, цомхон чадварлаг төр, орон нутгийн засаг захиргааны удирдлагыг нийтийн засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоонд өөрчлөн шилжүүлэх бодлого, зорилгыг бий болгосон юм. Гэвч өөрчлөлтийг хэрэгжүүлэх явцад төрийн чадвар,

мэргэжлийн автономи эрх чөлөө, төрийн албаны төвийг сахих зарчим, ёс зүй, үйл ажиллагааны үндсэн зарчим, хүний нөөцийн бодлого алдагдаж, засаглал нь хувь хүний мөн чанараас хамаарсан феодал маягийн төрийн шинэ хувилбар гэж нэг талаар хэлж болох неопатримон хэлбэр рүү хурдацтай чиглэх болов.

Г.Альмондын тодорхойлсоноор ардчилсан дэглэмд оролцооны улс төрийн соёл төлөвшдөг бол, харин ардчилсан Монголд оролцооны идэвхтэй улс төрийн соёлоос илүүтэйгээр өвгийн (овог, аймгийн уламжлалт патриархал ба патримониал) улс төрийн соёл неопатримон хэлбэрээр хүчтэй хөгжих болжээ. Улс төрийн соёлын неопатримон хэлбэр нь ардчилсан улс төрийн засаглал, төрийн удирдлагын механизмын оновчтой бус тогтолцооны үр дагавар болон илэрч байна. Улс төрийн дэглэм, төрийн удирдлагын тогтолцооны хэв маягаас хамаарч нийгмийн улс төрийн соёл төлөвшдөг аж. Тухайлбал, тоталитар дэглэмд иргэдийн улс төрийн соёл албатын хэв маягаар төлөвшдөг. Гэтэл Монгол дахь улс төрийн системийн боловсронгуй бус байдал, иргэдийн улс төрийн оролцооны хэв маягийг бүрдүүлж чадахгүй байгаа нь тэдний улс төрийн оролцоог уламжлалт өвгийн улс төрийн соёлын шинэ хэв маяг болох неопатримон хэлбэр рүү хүссэн хүсээгүй чиглүүлж байна. Жишээ нь: хэн нэгэн хүн эрх ашгаа хамгаалах болон амьдрал ахуйгаа дээшлүүлэхийн тулд төрийн байгууллагыг харснаас шууд л танил тал, найз нөхдийн холбоог ашиглан утасдахад л асуудал хялбар шийдвэрлэгдэж байна.

Нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинд уламжлалт нийгмийн харилцааны зарим элементүүд тодорхой хэмжээнд хадгалагдсаар ирсэн бөгөөд өнөө ч нийгмийн удирдлагад фаворитизм (ойр дотны тойрон хүрээллийг ивээлдээ бэхжүүлэн засаглалд ашиглах үзэл), потизм (үндэс угсаа, овгийн байгуулалд тулгуурласан нутаг дов жалганы нутгархах үзэл), непотизм⁶⁸ (албан тушаалын томилгоон дахь садан төрлийн нутгархах үзэл буюу эрх мэдэл, албан тушаалаа ашиглан хамаатан садан, найз нөхөддөө зөвшөөрөл олгох, мөн ах дүүгээ ажилд авах, өөд татах хэлбэр) патрон-клиентийн (ивээгч-үйлчлүүлэгчийн харилцаа), кронизм⁶⁹ (албан тушаалын томилогоо дахь найз нөхөд, нэг ангийнханы холбоо), графт⁷⁰ (бэлэг болон хэн нэгэн хүний хувийн ашиг сонирхлоор дамжуулан нөгөө хүний эрх мэдлийн шийдвэрт нөлөөлөх хэлбэр), хээл хахууль (bribery), хүчирхийлэл, зэрэг үзэгдэл тодорхой хэмжээнд оршсоор байна. Үүнийг орчин үед судлаачид үндсэн шинж чанараар нь “неопатримон”⁷¹ гэж нэрлэх болсон байна. Нийгмийн хөгжлийн үйл явцад “неопатримониализм”⁷²-ыг уламжлалт нийгмийн

⁶⁸ Oxford. Advanced learner's /dictionary/. London., 1994. Nepotism-Favouritism shown to relatives in conferring offices (Italian nepote nephew)- албан тушаалын томилгоон дахь садан төрлийн нутгархах үзэл.

⁶⁹ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. NY., 1994. Dilithium Press Ltd. p 345. Chronios гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд албан тушаал дахь найз нөхдийн түншлэл.

⁷⁰ Webster's Encyclopedic Unabridged Dictionary. NY., 1994. Dilithium Press Ltd. p 512. Graft²: Улс төр ба бизнесийн хууль бус ашиг орлого олоход ашигладаг, тухайлбал хахууль өгөх.

⁷¹ Christopher Clapham. of The Nature of the Third World State. <http://www.borders.co.uk/ebook/third-world-politics>

⁷² R.Fatton. State and Civil Society in Africa. Boulder, 1993. CO:Lynne Rienner Press. <http://www.worlded.org/docs/Publications/>

удирдлагаас хадгалагдаж үлдсэн удирдлагын харилцааны хоцрогдлын нэг хэлбэр гэж үздэг ч, нөгөө талаар зөв зохистой залуурдвал хүмүүсийн мөн чанар дахь байгалиас заяасан гэр бүл, үндэс угсаа, нөхөрлөлийн дотоод сэтгэлгээний салшгүй бат бэх нэгдлээс үүдэлтэй харилцаа гэж үзэж болно.

Неопатримониализм бол нийт хүн ам, үйлчлүүлэгчдийн шударга ёсны зарчим, дэг журмаар хэрэглэх ёстой үндэсний нөөц баялагийг тухайн улс орны удирдагчид ураг төрлийн болон бусад ойрын албан ёсны бус ивээгч-үйлчлүүлэгчийн холбоогоор өөрсдийгөө баян болгоход ашигладаг төрийн бүтцийн тухай нэр томъёо гэж ихэнх судлаачид үздэг. Тэд энэ үндэслэлийг засаглалын институцийн боловсронгуй бус байдал, иргэдийн улс төрийн соёлын төлөвшилтэй холбон авч үзэж тайлбарладаг. Тухайлбал, Р.Фаттон неопатримон бол “тухайн улс орны удирдагчид улс төрийн эрх мэдлийг зөвхөн өөрийн тойрон хүрээлэгчиддээ үйлчлэхэд ашигладаг явдлыг хэлнэ”⁷³. Өөрөөр хэлбэл энэ нь “гагцхүү олз ашгийн хойноос хөөцөлдөх үзэл бөгөөд өмчлөх эрхийг дахин хуваарилахад ямар нэг гэр бүл, садан төрөл, нутаг усныхан эсвэл ястан үндэстний болон нутаг жалгын явцуу хэсэг бүлгийн тодорхой ашиг сонирхолд хөтлөгдөн төрийн аппаратыг ашиглах явдал юм”⁷⁴ гэжээ.

Зарим нэг судлаачид патримониализмыг нийгмийн соёл, түүхэн хөгжлийн зүй тогтол дахь иргэншлийн ялгаатай хэлбэр, төр нийгмийн харилцаан дахь хүмүүсийн жам ёсны хөгжлийн үндэс талаас нь тайлбарлахыг санал болгодог. Тэд неопатримониализм бол ерөнхийдөө хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний тэгш, шударга байдал, түүний хууль, дүрэм журамд нийцсэн үйл ажиллагааны эмх журам, үндэсний нөөц баялгийг хуваарилах явдлыг хүмүүсийн мөн чанарт хандсан патрон-клинтийн харилцаагаар илүү хялбар шийдвэрлэж эрх баригчдын засаглалыг хадгалахад чиглэгдсэн нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоо юм гэж үздэг аж. Неопатримониализм нь өөрийн гэсэн ач холбогдолтой бөгөөд улс орны зах хязгаар, газар зүйн орон зайд богино хугацаанд тогтвортой байдлыг хангах, нийтийн интеграцыг хялбарчилдаг. Тэд энэ үндэслэлээ төрийн хүнд сурталт, дүрэм журмыг баримталсан хүйтэн хөндий харилцааны эсрэг тавьдаг байна.

Удирдлагын неопатримон хэлбэр бол “of *The Nature of the Third World State*”- ийн зохиогч Кристофер Клэнхэмийн тодорхойлсноор: “Ерөнхийдөө улс төрийн патримониал төрлийн тархалт нь захиргааны системд албан ёсны зохион байгуулалтын рационал-хуульчлагдсан чиг шугам болж байгууллагыг бүрдүүлдэг. Энэ нь нийтийн болон хувийн салбарын үйл ажиллагаатай хүчтэй эсрэгцсэн, ашиг хонжоо олох хувийн хэрэгцээг ашигладаг эрх мэдэл бүхий байгууллагын тогтолцоо юм”⁷⁵ гэжээ. Неопатримон хэлбэрийн томилогоо бодит эрх мэдлийг хуваарилсан иерархи пирамид бүхий харилцаа холбоотой төрийн бюрократ бүтцэд түгээмэл гардаг ч албан ёсоор нийгэмд хүлээн

⁷³ R.Fatton . *State and Civil Society in Africa* . Boulder, CO: Lynne Rienner Press.

⁷⁴ Ф.Фукуяама. Төрийг бэхжүүлэх нь. УБ., 2005. х 21

⁷⁵ Christopher Clapham of *The Nature of the Third World State*, <http://www.borders.co.uk/ebook/third-world-politics/3119062/>

зөвшөөрөгддөггүй. Гэвч неопатримон нь төрийн бюрократ бүтцийн доторх бодит эрх мэдлийг эзлэн өндөр албан тушаалтай зууралдаж байдаг төдийгүй улс төрийн институцийг сулруулж, хуулийн шийдвэр ба хэрэгжилтэд хахуулийн нөлөөг хүчтэй оруулж ирдэг. Харин эрх мэдлийн хуваарилалтын бүтцийг хэвтээ чиглэлд задлан, бие даасан эрх мэдлийг олгох бүрд улс төрийн институтууд, тэдгээрийн хууль дүрэм журмыг ойлгох явдлыг нарийвчлан авч үзэж хариуцлагын тогтолцоог шууд үр дүнд чиглүүлэхгүй бол, хууль, дүрэм журмыг ойлгох гуйвуулсан туршлага болон хариуцлага тооцдоггүй захиргааны бие даасан ноёрхолоос неопатримониализмын үндэс бүрддэг байна. Неопатримон нь үргэлж хууль ёсны бус байдаг онцлогтой бөгөөд хууль нийтлэг бол неопатримон нь захирамж, шийдвэрийг нийтлэг бусаар фаворитизм, непотизм, патрон-клинтийн гэх мэт элементүүдийн харилцаагаар гаргахад чиглэгддэг. Энэ талаараа зөвхөн хөгжиж байгаа орнууд ч бус ардчилал, плюрализм хөгжсөн АНУ зэрэг орнуудад ч түгээмэл байдаг үзэгдэл юм.

Неопатримон маягийн томилогоо, үйл ажиллагааны хэлбэр нь төрийн төвийг сахих үзэл баримтлалыг алдагдуулж, удирдлагын чадавхи, бие даасан байдлыг сулруулж, нийтийн засаглалыг хувийн засаглалын шинж чанарт ойртуулахыг оролдож байдаг. Энэ талаар Ж.Ж.Руссо...Хувь хүний хүсэл зориг бүх нийтийн хүсэл зоригийг төлөөлөн илэрхийлж чадахгүйтай нэг адил бүх нийтийн хүсэл зориг хувийн зорилго агуулах аваас өөрийн шинж байдлыг алдаж, хэн нэгэн хүн аливаа нэгэн үйлдлийг бүх нийтийн өмнөөс шүүн тунгаах эрхгүй болдог”⁷⁶ гэжээ. Үүний гол фактор нь улс төрийн дэглэм түүний засаглалын мөн чанартай холбоотой. Тухайлбал, хамгийн хүчтэй эсвэл хамгийн сул дорой хүнээр ч засаглалыг удирдан жолоодуулж болдог хуулийн хэм хэмжээний хураангуй үзэл баримтлал нь тэдэнд удирдах эрхийг олгож байдаг оршдог бөгөөд тэрхүү тогтолцоо болон институт нь дарангуйллын шинжийг агуулж байдаг онцлогтой. Неопатримониализм улс төрийн институт, байгууллагын байр суурь, нэр хүндийг гутаан завхруулах (үргэлж хууль бус) төдийгүй хахуульд идэгдэхэд хүргэдэг гэж шүүмжлэгддэг. Байгууллага гэдэг нэр томъёо нь социологи болон заримдаа нийгмийн институт гэдэг нэр томъёотой харилцан уялдаатайгаар эмнэлэг, шорон гэдэг шиг албан байгууллагуудыг тодорхойлоход хэрэглэдэг. Байгууллагад үүрэг роль бүхий зорилгыг хэрэгжүүлэх, зохицуулах аргачилал, үйл ажиллагааны соёл, зохион байгуулах бие даасан бүлгүүд оршдог. Тухайн байгууллагын үйл ажиллагаанд неопатримониализмын элементүүд оршсоноор байгууллагын мэргэжлийн чадавхийг сулруулж, үйл ажиллагааны соёлыг өөрчилдөг төдийгүй зорилгыг хэрэгжүүлэх зохицуулах аргачлалууд хязгаарлагддаг сөрөг үр дагавартай ч, бүлгүүдийн дотоод зөрчлийг илт бууруулдаг эсвэл бүр гүнзгийрүүлдэг байна.

Байгууллагын социологи нь институционализм болон неоинституционализмын хоёр өөр үзэгдлээр тодорхойлогддог. Институт нь ажил хэргийг гүйцэтгэх, нийгмийн хэв

⁷⁶ Поздняков “Улс төрийн философи”

журам, үүргийг хэрхэн яаж тогтоох тухай хууль эрх зүйн дүрэм журмаар нийгмийн харилцааны дэг журмыг бий болгодог. Институт нь нийгмийн амьдралыг бүрэлдүүлэх тогтвортой байлгах үүрэгтэй бөгөөд тэдгээрийн үүрэг ролийн гүйцэтгэлийг тодорхойлж байдаг онцлогтой. Институтуудын бүтэц түүний удирдамжууд хүний дотоод харилцааны дүр төрх болон шинж тэмдэгээр тодорхойлогддог. Неопатримониализмын элемент (төрөл садан, танил тал, патрон-клиент гэх мэт)-үүд институцийн хатуу шинж чанарыг сулруулж, нийгмийн харилцааны дэг журмыг албан бусаар тодорхой хувь хүн, бүлэгт шуурхай үйлчлэхэд чиглүүлдэг. Үүгээрээ неопатримон элементүүд шүүмжлэгдэж байсан институционализмын хатуу хөдөлшгүй, уян хатан бус шинж чанар, түүний нийгэмд гүйцэтгэх хүнд сурталжсан үүрэг, ролийг бууруулах үүрэг гүйцэтгэж байсан. Неоинституционализмын хандлага нь институтуудыг өөрийн гэсэн шинж төрхтэй бөгөөд бүлгийн гишүүдээр нийгмийн практикт дахин, дахин өөрчлөгдөн бий болж байдаг нийгмийн харилцаа, соёлын элементийн хувьслыг агуулагч хүчин зүйл гэж үздэг. Энэ хандлагаар неопатримониализмын элементүүд институционал хандлагад орж ирж болох бөгөөд нийгмийн хувьслын зүй тогтлоор хэрэгтэй нь үлдэж, хэрэггүй нь гээгдэнэ гэж үздэг. Тодруулбал, үлдээх гээгдэх үйл явцууд ч өөрсдөө улс төрийн ихээхэн тэмцлийг агуулж байдаг онцлогтой бөгөөд, сайн дураараа аяндаа алга болдог ёс заншил, хэв маяг гэж огт байдаггүй. Энэ утгаараа институтууд нь өөрөө байгууллага байж ч болно үгүй ч байж болно.

Неопатримониализмын элементүүдийг авч үзэхэд улс төрийн авлига гол байр суурийг эзэлдэг. Улс төрийн авлига нь ихэвчлэн танил тал, тойрон хүрээлэл, нутгархал, найз нөхөд, ивээгч-үйлчлүүлэгчийн холбоо харилцаагаар шууд эсвэл зуучлах хэлбэрээр дамжин явагдаж, улмаар хууль бус харилцааны сүлжээ үүсгэдэг онцлогтой. Улс төрийн авлига бол засаглалын хүчийг ашиглан засгийн газрын түшмэдийн хууль бус хувийн сонирхолд тулгуурласан албан үүрэгтэй холбоотой үйл ажиллагаа юм. Засгийн газрын эрх мэдлийн зохисгүй байдал нь нийтийн зорилгоос өөр бусад зорилготой холбоотойгоор бий болдог. Аливаа ардчилсан засаглалын шийдвэрт орж ирэх плюраль сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод, албан ёсны шугамаар хэрэгжээгүй тохиолдол бүр нийгмийн хардлага, авлигалын шинж төрхийг бүрдүүлж байдаг онцлогтой. Тэр дундаа улс төрийн өрсөлдөөний дүрмийг зөрчсөн гүтгэлэг, хавчлага, балмад бодлого улс төрийн авлигыг тодорхойлдоггүй. Гэвч үүнийг тодорхойлж буруутгах, улс төрийн тэмцэлд ашиглах оролдлогууд нь неопатримон элементүүдийн өрсөлдөгчөө дарах сонгодог арга хэрэгслийн нэг юм. Авлигалын хэлбэрүүд нь янз бүр бөгөөд хахуульдах, хүчирхийлэх, ая тал засах, ивээн тэтгэх, графт болон хэн нэгнээр дамжуулан ашиг хонжоо олох, завших зэргээр илэрч болдог. Мөн түүнчлэн зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд ч байдаг. Авлига нь сонгуульт хууль тогтоох байгууллагуудын үүрэг хариуцлагыг бууруулан бодлого боловсруулалтын бүрэн эрхт байдлыг мушгин гуйвуулдаг. Төрийн удирдлага дахь авлига нь үйлчилгээний хүртээмжтэй байдлыг багасгаж, шударга бус үйлдлүүдээр илэрхийлэгддэг. Авлига гүнзгийрсэн тохиолдолд

засгийн газрын институтуудын үйл ажиллагааг сулруулж, дарамт шахалтын үндсийг бий болгон төрийн албаны эрх мэдэл, албан тушаалыг худалдан авч, бас худалддаг. Энэ үед авлига нь өөрөө засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг хууль эрх зүйн хэм хэмжээ нэрийн дор тодорхойлж өгдөг бөгөөд ардчиллын үнэт зүйлс, тэвчээр, итгэл нь хоосорч, тэр нь элдэв хурал, цуглаан, арга хэмжээний илтгэл, ярилцлагын чимэг нэр төдий зүйл болдог. Өөрөөр хэлбэл, авлигал нь ардчилал, сайн засаглал нэрийн дор төрийн албан ёсны үйл ажиллагааг уланд аа гишгэж, хувь хүн, бүлгүүдийн ашиг сонирхлын төлөөх тэмцлийн зэвсэг болдог байна.

Э.Виддер 1896 онд анх хээл хахуулийн хууль эрх зүйн үндсийг нарийвчлан тодорхойлсон. Авлигал хоёроос дээш хүмүүс, бүлгүүдийн ашиг сонирхлын төлөөх тэмцлийн зэвсэг болдог бол, хахууль нь зөвхөн хоёр хүний хооронд өгч авалцдагаараа ялгаатай. Зарим улс оронд соёлын авлигал нийтийн дунд өргөн тархсан байдаг бөгөөд ямар нэгэн хахуульгүйгээр бизнесийг хөл дээр нь зогсооход маш их хүндрэл бэрхшээлтэй байдаг. Хахууль гэдэг нь ямар нэгэн ажил хэрэг бүтээх эсвэл төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай авахын тулд төлж буй үйлчлүүлэгчийн хууль бус төлбөр юм. Хахуулиар олж авсан үйлчилгээ бодит байдалд хахуулийн өртөгөөс илүү ашигтай байдаг нь хувь хүний рационал сонголт юм. Зарим тохиолдолд хууль дүрэм журмаар дамжуулан хахуулийн эрэлт хэрэгцээг бий болгодог ч байж болох юм. Хувийн салбарт, бизнесийн хахуулийн өртгийн өсөлт хууль тогтоол, эрсдэл, албан тушаалтнуудын гэрээ хэлцлийн менежментийн хөлс зэрэг төлбөрүүдэд нөлөөлөөд зогсохгүй, нийгмийн амьжиргааны өртгийг өсгөдөг. Улсын салбаруудад хахууль нь улсын хөрөнгө оруулалтанд нөлөөлдөг. Хахууль нь засгийн газрын үйлчилгээний чанар, дэд бүтцийн чанарыг бууруулж засгийн газар дахь төсвийн зарлагыг нэмэгдүүлдэг. Зарим хөгжиж буй улс оронд жилийн туршид идэвхтэй ажил эрхлэгч хүн амын талаас илүү хувь нь хахуульд төлбөр төлсөн гэсэн судалгааны тоо баримт байдаг. Практикт улс төрийн үйл ажиллагааны санхүүжилт зарим улс оронд тодорхой хууль ёсны байхад, нөгөө газарт хууль бус байдаг. Тухайлбал, зарим оронд сонгуулийн кампанид хандивлах нэг хандивлагчийн хязгаарыг хэтрүүлсэн тохиолдолд авлигад тооцдог байхад, зарим оронд тийм эрх зүйн заалт ч байхгүй ингэх нь намд зүтгэсэн гавьяа зүтгэлд тооцогдож төрийн албан тушаалаар урамшуулагдаж байх жишээтэй. Ийм неопатримон шинж бүхий зарим улс орнуудад засгийн газрын түшмэлүүд ядуурлыг даамжруулан өөрсдийн эрх мэдлийг тодорхойлогч болдог бөгөөд хууль ёсны ба хууль бус хоёрын хоорондын ялгаанд юу байгааг дүрслэхэд бэрхшээлтэй байдаг.

Төрийн албан тушаалыг өмчлөх, өв залгамжлах нь неопатримониализмын нэг элемент бөгөөд албан тушаалыг өвлөж авах хэлбэр Сири, Куба, Хойд Солонгост түгээмэл үзэгддэг. Улс төрийн албан тушаалыг өвлөх нь ардчилалд шилжиж буй болон ардчиллыг сэргээн тогтоосон улс орнуудад тийм ч ховор биш үзэгдэл бөгөөд энэ нь неопатримон хэлбэрийн илэрхийлэл юм. Тухайлбал, УИХ-ын сонгуульд эхнэр, дүү, хүүхэд нь үе залгамжлан сонгогдож буй нь уламжлалт улс төрийн соёлын элемент

хадгалагдаж байгаатай холбоотой. Мөн анд нөхдийн холбоогоор дамжсан хууль бус хувийн ашиг хонжооны хэлбэрүүд нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд улс төр, бизнест нөлөөлөх дүрэм журмыг албан ёсоор гаргаж хувийн ашиг хонжоогоор ашигладаг. “Кронизм”⁷⁷-ын энгийн нэг хэлбэр нь “хуучин хүүгийн сүлжээ”⁷⁸ байдаг бөгөөд тэр нь албан тушаалын томилогоог хаалттай хэлбэрээр сонгон шалгаруулдаг. Энэ нь таньдаг, мэддэг, итгэлтэй хүнээ ойрын хүрээллээс олж тодруулах үйл явц юм. Албан тушаалын хаалттай томилгоо нь ихэвчлэн неопатримон шалгуурыг хаацайлсан хэрэг байдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь хувийн шалгуур, төрийн албаны стандарт шалгуур хоёрын зөрчлийг агуулж байдаг.

Неопатримониализмын бас нэг гол элемент бол патронеж буюу ивээн тэтгэх үзэгдэл юм. Энэ нь улс төрийн үйл ажиллагаа үзэл суртал болон хуулиар биш, харин хувийн эх оронч, ивээн тэтгэгчийн дүр төрхийг бий болгосон хэлбэрээр явагдахыг хэлнэ. Уг үзэгдэл улс төрийн шийдвэр, төрийн үйл ажиллагаанд ч нөлөөлөх бөгөөд макро түвшинд намууд сонгогчдод их хэмжээний мөнгө амлах, нэр дэвшигчид тухайн орон нутгийг болон нийгмийн эмзэг бүлгийг ивээн тэтгэх амлалт өгөх төдийгүй, микро түвшинд төрийн албан тушаалд томилох, төрийн үйлчилгээг зөвхөн тодорхой нэг хувь хүн, хэсэг бүлэгт үзүүлэх хэлбэрээр илэрдэг. Энэ бол нийгмийн баялагийг өгөөмрөөр тараан цацагчийн дүр төрх юм. Мэдээж үүний цаана засаглал дахь хувийн болон хэсэг бүлгийн ашиг хонжоо тооцоологдож байдаг. Үүний нөгөө талыг клиентелизм гэдэг бөгөөд хөгжиж буй бүс нутгийн улс орнуудын нийгмийн байгууллагын нийтлэг хэлбэр байдаг бөгөөд ивээн тэтгэгч болон үйлчлүүлэгч гэсэн харилцаагаар тодорхойлогдоно. Хүчтэй хөрөнгөтэй ивээн тэтгэгчид эрх мэдэлгүй, хөрөнгө чинээ муутай үйлчлүүлэгчдийг ажил, хамгаалалт, дэд бүтэц болон бусад ашигтай зүйлсээр хангана гэж саналынх нь төлөө ажилладаг. Макро түвшинд клиентүүд буюу сонгогчид ивээн тэтгэгчдийг патронежийг амлалтын “өрийн дарамт”-д оруулдаг бол, микро түвшинд ивээгч үйлчлүүлэгчээ “ач санах” ёс зүйн дарамтанд оруулдаг. Ивээгч-үйлчлүүлэгчийн харилцаа нь ихэвчлэн шудрага бус ёс суртахуунгүй байдаг аж. Патронежийн харилцааг тодорхой эрх мэдэлд хуульчилдаг. Жишээ нь: Ерөнхийлөгч, ерөнхий сайд тийм албан тушаалуудад томилоно гэх мэт. Төрийн бусад албан тушаалын томилогоог хуульчлах болон байгууллагын дүрэм журмаар шийдвэрлэх нь ивээгчийн сөрөг үр дагаварыг хязгаарладаг. Эрх мэдэл,

⁷⁷ **Кронизм** гэдэг нь урт удаан хугацааны харилцаатай өөрийн танил тал, анд нөхдийг, ялангуяа тэдний боловсрол, мэдлэгийг үл харгалзан эрх бүхий албан тушаалд томилох холбоо харилцааг хэлнэ. Крони гэдэг үг XVIII зуунд анх Лондонд бий болж хриовис *χρόνιος* (*chronios*), “long-term” удаан хугацааны гэсэн утгатай грек үгнээс Oxford English Dictionary-д дамжуулан орчуулсан байсан ч *crony* г 1811 онд Grose’s *Vulgar Tongue* ийн албан бус тодорхойлтонд cant of the underworld.^[2] буюу гэмт хэргийн ертөнц гэж бас тодорхойлсон байдаг. Ирланд хэлэнд энэхүү үгийн үндсийг Comh-Roghna (pron. ko-rohə) буюу “close pals” гэж орчуулсан бөгөөд энэ нь ойр дотны анд нөхөд гэсэн утгыг илэрхийлж байна. http://en.wikipedia.org/wiki/Cronyism#cite_note-1

⁷⁸ Төрийн албаны хүний нөөцийн шалгуур, томилогооны механизм суларсан нөхцөлд дарга нар доод тушаалын хүмүүсээ ойрын хүрээллээс хайхад хүрдэг. Өөрөөр хэлбэл, “танихгүй бурханаас, таньдаг лам дээр” гэгчээр.

албан тушаалын ивээн тэтгэх үйлдэл нь нийгмийн харилцаанд байх ёстой үзэгдэл бөгөөд ажлын амжилт, ур чадварын өсөлтийг хэмжих үзүүлэлт юм. Гэхдээ хэн нэгэнд хувийн болон байгууллагын шагнал урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэх, давуу эрх эдлүүлэх, санхүүгийн тусламж үзүүлэх нь ил тод нээлттэй байсан нөхцөлд элдэв хардлага, неопатримон хэлбэрийн үзэгдлүүдээс хамгаалагддаг. Неопатримониализмын мөн чанар нь удирдах үүрэг хүлээсэн хүмүүсийн хувьд өмчийн болон нийгмийн харилцаан дахь итгэлцэл нь амин хувиа бодох сэтгэлгээний үндсэн дээр тэдний хамгийн ойрын хүрээнд илүү үйлчлэж байдгаар тайлбарлагдана. Төрийн удирдлагын тогтолцоон дахь неопатримон хэлбэрийн харилцааны сөрөг үр дагаварыг хязгаарласан механизм, түүний нээлттэй байдлыг хуульчлахгүйгээр засаглалын энэ төрлийн хэлбэрийг бууруулж чадахгүй. Хэрэв засаглалын неопатримон төрлийн харилцааг хязгаарлаагүй нөхцөлд орчин үеийн дэлхийн дэг журам, өнөөгийн глобальчлалын нөхцөлд тухайн улс орны газар нутаг, эдийн засаг, байгаль экологи гээд хувь хүний явцуу ашиг сонирхолд нийцсэн бүгд худалдагдаж, улс орны эрх ашиг, аюулгүй байдалд аюул учрах болно. Нөгөө талаар уг сэдэв нь шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажилд танин мэдэхүйн ач холбогдолтой бөгөөд дараах жишээ үүний тод илрэл болно. Жишээ нь: хоёр жилийн өмнө нэгэн судалгааны байгууллага судалж буй зүйлийнхээ объект, субъектыг бүрэн таньж, мэдэж, тодорхойлоогүйн улмаас нийгэмд шуугиан тарьсан худал судалгааны дүн гаргаж байсан билээ. Уг судалгаа нь авлига, хахууль, бэлэг гурвыг тодорхойлж чадаагүйн улмаас эмч, багш нар хамгийн их авлига авдаг гэсэн дүгнэлт гаргасан байдаг. Өөрөөр хэлбэл, авлига, бэлэг хоёр маш их ялгаатай. Зарим бэлэг хүний чанар, ёс зүйг илэрхийлдэг. Тухайлбал, маш бага цалинтай мөртлөө өргөсөн тангарагтаа үнэнч зүтгэж, нойр, хоолгүй шахуу ажиллаж, хүний амь нас аварсан ачлалт эмчид өчүүхэн бэлгээр сэтгэлээ илэрхийлэх нь хүний ёс ажгуу.

Resume

In this article has taken concerning the patrimonial bureaucratic of traditional social relations and neopatrimonial patterns in nowadays state administration. Main reason that concerning issues, it will reduce some negative effectives of social relations of nowadays public administration. Main purpose to take consideration of social scientists and researchers for those issues.

Ашигласан ном, зохиол:

Kamenka E. Bureaucracy. Oxford, 1989.

Roth G. Introduction // Weber M. Economy and society. Berkeley, 1978.

Webster's Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994. dilithium Press Ltd.

- Weber M. *Wirtschaft und Gesellschaft*. Tubingen, 1976. Пер М.В.Масловского. *Хозяйство и общество / Царский патримониализм*.
Oxford. *Advanced learner's dictionary*. London., 1994.
- Bendix R. *Max Weber: An intellectual portrait*. L., 1966.
- Вебер М. Улс төр бол шинжлэх ухаан мөн. Улс төр бол мэргэшил мөн. УБ., Орч Ү.Нямдорж. УБ., 2000. Suna group.
- Ф.Фукуяама. Төрийг бэхжүүлэх нь. УБ., 2005.
- Э.Н.Ожиганов. *Политическая теория Макса Вебера, Критический анализ*. Рига., 1986.
- Гайдено П.П., Давыдов Ю.Н. *История и рациональность: Социология Макса Вебера и веберовский ренессанс*. М., 1991.
- М.В.Масловский. *Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология /Полис/*. М., 1997.
- Christopher Clapham. *of The Nature of the Third World State*.
<http://www.borders.co.uk/ebook/third-world-politics/3119062/>
- R.Fatton. *State and Civil Society in Africa*. Boulder, CO:Lynne Rienner Press.
<http://www.worlded.org/docs/Publications/idr/pdf/11-6.pdf>

НОМЫН ОРЧУУЛГА, СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

УЛС ТӨРИЙН УХАМСРЫН СОЦИОЛОГИ ⁷⁹

Г.Цэнд-Аюуш

ахлах багш

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Улс төрийн харилцааны социологийн нэгэн бие даасан хэсэг бол улс төрийн ухамсрын социологи бөгөөд Ё.Вятр түүнийг судлахдаа улс төрийн байр суурь, олон нийтийн санаа бодол ба үзэл суртлын асуудлын хүрээнд авч үзсэн байх юм.

1. Улс төрийн байр суурь

“Улс төрийн байр суурь” гэдэг ойлголтонд улс төрийн өвөрмөц онцлог бүхий, эсвэл байнгын, тогтвортой үйл байдалд чиглэж хандсан, өөрөөр хэлбэл, улс төрийн засаглалын төлөө, засаглалыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцлийн үйл байдалд чиглэж хандсан бодьгалын бие хүнийх нь шинж төрхүүдийг ойлгодог гэсэн утгаар авч үзжээ. Тийнхүү улс төрийн байр суурь гэсэн ойлголтонд:

а / Улс төрийн үзэгдлүүдэд хамааралтай тодорхой, эсвэл байнгын тогтвортой сэтгэл хөдлөлийн төлөв байдлыг

б/ Улс төрийн үзэгдэлүүдэд хамааралтай итгэл үнэмшлийг

в/ Улс төрийн хүрээн дэх үйл ажиллагаанд эв дүйтэй хандах явдлыг багтаан оруулж байна.

Ингэж үзэж ойлгосон улс төрийн байр суурийн хүрээ нь улс төрийн үнэлгээний хүрээнээс өргөн болно. Улс төрийн үнэлгээ нь улс төрийн байр суурийн зөвхөн бүрдэл хэсэг нь болох бөгөөд улс төрийн байр суурь нь сэтгэл хөдлөлийн ба удирдамж бүхий бусад элементүүдтэй холбоотойгоор илрэн гардаг байна.

Улс төрийн байр суурийг бодьгаллаг үзэгдэл гэж үзэх үндэстэй бөгөөд хувь хүний үйл байлын сэдлийг ухааран ойлгох боломж өгдөг хэмээн ойлгож болно. Байр суурийг шууд ажиглан харах, илрүүлэх боломжгүй. Бидний ажиглан харах, илрүүлж болох зүйл гэвэл зөвхөн гадны илрэл бүхий цуглаан, тунхаглал, илэрхийлэл төдий зүйлс бөгөөд тэдгээр нь байр суурийг нэг бол үгээр, эсвэл бусад үйлдлээр илэрхийлсэн илэрхийлэлт л байдаг. Өөрөөр хэлбэл хүмүүс хэлж ярьж байгаа (ам,хэлээр илэрхийлсэн илрэл), эсвэл тэд үйлдэж байгаа (аман биш илрэл) явдлыг иш үндэс болгож хүмүүсийн байр суурь илэрч байна гэсэн дүгнэлтийг хийдэг. Ингэхэд хүмүүс улс төрийн янз бүрийн үзэгдэлд

⁷⁹ Ёжи Вятрын “Улс төрийн харилцааны социологи” бүтээлээс багш Г.Цэнд-Аюушийн орчуулснаар толилуулж байна.

хандах хандлагынхаа талаар ярьж буй яриа нь тэд өөрсдийн жинхэнэ бодит байр сууриа үнэн мөнөөр нь илэрхийлэхийг хүсэхгүй байгаа тэр нь ухамсартай, зориудын санаа бодлоор гуйвуулагдсан, гажуудсан байж болохыг үгүйсгэхгүй. Тийм учраас улс төрийн байр суурийг эмпирик байдлаар судлахдаа (ер нь байр суурийг ерөнхийд нь судлахдаа ч гэсэн) улс төрийн аль нэг үзэгдэлд хандах хандлагын талаархи энгийн жирийн, шууд асуултуудыг илүү нарийн бодож боловсруулсан, жинхэнэ байр суурийн талаар дүгнэлт хийж болохоор асуултуудаар орлуулахыг хичээдэг. Жишээлбэл: хэн нэг хүнээс тэрбээр ямар нэг мөрийн хөтөлбөрийг талархан дэмжигч мөн үү? гэж шууд асуухын оронд эл мөрийн хөтөлбөртэй холбоотой дам, шууд бус хэд хэдэн асуулт тавьж, тухайн хүнээс түүнд өгсөн хариултуудаар дамжуулан тэр хүн уг мөрийн хөтөлбөрт хэрэг дээрээ чухам хэрхэн ханддагийг нь илэрүүлэн гаргаж болдог.

АНУ-ын Энн-Арбора дахь Нийгмийн судалгааны хүрээлэн улс төрийн байр суурийг судлахдаа АНУ-д голдуу хэрэглэгддэг хүрд бүхий хэмжээс, үзүүлтүүдийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн материалыг хэвлүүлжээ. Тэдгээр шкал бүхий хэмжүүрүүдийг 1. либерализм ба консерватизмын шкал, 2. ардчилсан зарчмуудад хандах хандлагын шкал, 3. төрийн дотоод бодлогод холбогдолтой шкал, 4. арьс өнгө, угсаатны байр суурийн шкал, 5. бусад угсаатан, үндэстэнд дайсагнасан байр суурийн шкал, 6. нийгмийн бүлгүүдийн түвшин дэх улс төрийн асуудалд холбогдох байр суурийн шкал, 7. улс төрийн мэдээллийн шкал, 8. улс төрд оролцох оролцооны шкал, 9. улс төрийн үйл явцад хандах байр суурийн шкал гэсэн бүлэгт хуваан ангилжээ. Эндээс тухайн шкал бүхий үзүүлэлт, хэмжүүрүүд өөр хоорондоо хэлхээ холбоотой байгааг хялбархан олж харж болохоор байгаа юм. Орон нутгийн засаг захиргааг харьцуулан судлах олон улсын судалгааг Польш, Югослав, Энэтхэг ба АНУ-д хийхдээ үнэт зүйлсийн арван шкал бүхий хэмжээсийг хэрэглэсэн бөгөөд "үнэт зүйлс" гэсэн нэр томъёог улс төрийн онцгой байр суурь хэмээн онцолсон ба өөрөөр хэлбэл үнэт зүйлс нь үйлдэл, үйл ажиллагааны ямар нэгэн чиглэлийг хүмүүсийн зүгээс зөвтгөх, эсвэл буруушааж үгүйсгэхдээ хэрэглэдэг стандарт, эсвэл зарчим хэмээн ойлгосон юм). Эдгээр шкал бүхий хэмжээс нь дараах үнэт зүйлсийг хөндсөн байна. Үүнд: 1) эдийн засгийн хөгжил, 2) мөргөлдөөн, сөргөлдөөнийг гаргахгүй байх, 3) улс төрийн шийдвэр гаргах үйл хэрэгт иргэдийн оролцоо, 4) ашиг завшааныг үл бодох, 5) орон нутгийн, эсвэл нийт улс орны хэмжээний улс төрийн зорилгод чиглэсэн хандлага, 6) үйл ажиллагаанд бэлэн байгаа байдал, 7) үнэнч шударга байдал, 8) өөрчлөлтөд хандах хандлага, 9) тэгш байдал, 10) улс төрийн зүтгэлтний хариуцлага эдгээр болно. Энэхүү судалгаанд шкал буюу хэмжээсүүдийг зохион бүтээх аргыг анх удаа хэрэглэсэн бөгөөд түүндээ судлагдсан дөрвөн орны хувьд нийтлэг, ижил хийгээд нөгөөтэйгүүр орон тус бүрт өвөрмөц онцлогтой элементүүдийг багтаан оруулжээ. Тэгснээрээ үндэсний хөгжлийн онцлогуудыг тусгасан хүчин зүйлсийг тооцон анхаарах боломжийг бий болгож чадсан байна. Эл судалгаанд улс төрийн байр суурийг илрүүлэх хэмжээс, үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох чиглэлд олсон

мэдэгдэхүйц ахиц дэвшил, ололт нь энэхүү аргыг ихээхэн найдвар, итгэлтэйгээр хэрэглэх боломжийг өгч байгаа юм. Гэвч энэ нь бидний дээр дурдсан бэрхшээлүүдийг хараахан арилгахгүй билээ.

Тэдгээр бэрхшээл нь байр суурийг шууд ажиглан илрүүлэх боломжгүй байдагт, тэгэхлээр үйл байдал нь байр сууринд үнэхээр нийцэн тохирч байна уу, түүгээр ч үл барам тухайн байр суурь (байр суурийг үйл байдалд дуршилтай байх явдал хэмээн ойлгосон утгаараа) үнэхээр бодитойгоор байна уу үгүй юү гэдгийг батлан нотлох боломжгүй байдагт оршино. Хэрэв хүмүүсийн үйл байдал нь өөрсдийнхөө байр суурь болгож илэрхийлэн харуулж буй зүйлтэй (шууд, ил тод хэлж ярьсан зүйл, эсвэл байр суурийн шкалд оруулсан асуултанд өгсөн хариу зэрэг нь) нийцэн тохирохгүй байвал энэхүү үл тохироог янз бүрийн аргаар тайлбарлаж болдог. Ийм тохиолдолд байр суурийг үг хэлээр илэрхийлсэн байдлыг задлан шинжилсэн бидний судалгааны арга боловсронгуй биш, эсвэл хүмүүсийн үйл байдал нь байр сууринд үл нийцэхэд гадны ямар нэг нөхцөл байдал нөлөөлж хүргэсэн байж болох тухай ярих хэрэгтэй болно. (жишээлбэл: гадны ямар нэгэн хүчтэй шахалт, дарамт нөлөөлсөн байж болно). Эл асуудал нарийн ээдрээтэй, төвөг бэрхшээлтэй болж хувирахад өөр хүчин зүйлс ч нэмэлт байдлаар нөлөөлж болох юм. Жишээлбэл: хүмүүсийн үйл байдлыг тодорхойлох практик сонголт хийх тохиолдолд байр сууриуд нь хоорондоо сөргөлдөн зөрчилдөхөд хүрдэг, тэр нь гаднах илрэлээрээ зөрчилтэй арга хэлбэрүүдээр дамжин үйл байдалд нөлөөлдөг. Эдгээр учир шалтгаануудын улмаас байр суурь ба түүний гадаад илрэл, үйл байдлын хоорондын харьцааг тодорхойлон гаргах явдал нь социологи хийгээд нийгмийн сэтгэл судлалын хамгийн бэрхшээлтэй, нарийн асуудлын тоонд багтан орно. Эдгээр бэрхшээл, нарийн асуудал нь улс төрийн харилцааны хүрээнд улс төрийн олон янзын үзэгдэл, улс төрийн байр суурь нь өөр төрлийн байр сууриудтай, бас нийгмийн нөхцөл байдлын онцлогуудтай олон янзаар холбогдсон байдагтай уялдаж бүүр ч нарийн ээдрээтэй болдог байна.

Гэвч асуудал хэдийгээр ийм ээдрээтэй байх тусам улс төрийн байр суурийг танин мэдэх явдал нь улс төрийн харилцааны социологт туйлын чухал байдаг юм. Улс төрийн үзэгдэлүүдийг тодруулан гаргахаар судлаж буй онолч эрдэмтэн ухамсартай холбоотой асуудлууд, түүний бүрдэл хэсгүүдээс хийсвэрлэн хөндийрч чадахгүй, харин улс төрч хүмүүс улс төрийн үйл явдлын тухай юу боддог, өөрсдөө оролцогчид, бүр объект нь болж байдаг, улс төрийн үзэгдлүүдийг хэрхэн хүлээн авч төсөөлөн ойлгодгийг ямагт тооцон анхаарч байвал зохино. Тиймээс улс төрийн практикийн чухал бүрдэл хэсэг бол улс төрийн хүмүүжил олгох, өөрөөр хэлбэл иргэдийн улс төрийн байр сууринд тодорхой чиглэлээр нөлөөлөх явдал байдаг.

2. Олон нийтийн санаа бодол

Эрдэм шинжилгээний ном зохиолд олон нийтийн санаа бодлыг олон янзаар тодорхойлсон байдаг. Тэдгээрийн нэг нь "социаль асуудалд" хамааралтай зүйлийг тэргүүн байранд дэвшүүлэн тавьдаг. Зарим нь санаа бодлыг нийтэд ил хэлж илэрхийлэх явдлыг чухал шалгуур үзүүлэлт болгон үздэг. Гурав дахь нь санаа бодлыг олон тооны хувь хүмүүс хуваалцан баримтлахын тулд санаа бодлыг хүрэлцээтэй хэмжээгээр өргөн дэлгэрүүлэх нь чухал хэмээн шаарддаг. Эцэст нь хэлэхэд зарим судлаачид олон нийтийн санаа бодол бол ард олны санал бодол засаг төрийн эрхийг барьж буй анги, бүлгийн үзэл бодлоос ялгаатай, засгийн эрх мэдлийг бариагүй хүмүүсийн үзэл бодол мөн гэсэн санал хэлдэг. Тэдгээрт олон нийтийн санаа бодлыг төр ба ангийн ноёрхлын онолын агуулгаас ангид авч үздэг бөгөөд тэгснээрээ олон нийтийн санаа бодлын гүйцэтгэх үүрэг ба ач холбогдлыг улс төрийн амьдралын бүхий л цогцолбор дотор, ялангуяа ардчиллын тогтолцооны хүрээн дотор багтаан авч үзэх боломжийг олгодог.

Граммши бичихдээ: "олон нийтийн санаа бодол" хэмээн нэрлэж буй тэрхүү зүйл нь улс төрийн манлайлалтай холбоотой бөгөөд "иргэний нийгэм" ба "улс төрийн нийгэм" хоёрын уулзварын цэг мөн юм" гэжээ. Төр нь ямар нэгэн онцгой гойд, нийтлэг биш үйлдэл хийхээр завдахдаа түүнд нийгмийн санал бодлыг урьдчилан бэлтгэж иргэний нийгмийн тодорхой бүрдэл хэсгүүдийг зохион байгуулж төвлөрүүлдэг байна. Нийгмийн санал бодлын түүхэнд олон нийтийн санаа бодлын бүрдэл хэсгүүд аль ч үед ямагт байсаар байсан нь ойлгомжтой ба түүгээр ч үл барам азийн эзэрхэг дэглэмтэй орнуудад ч байсан, гэхдээ нийгмийн санал бодол нь бидний өнөөгийн ойлгон үзэж буй байдлаараа хэмжээгүй эрхт хаант засгууд нурж унахын өмнөх үед бүрэлдэн бий болжээ, өөрөөр хэлбэл хөрөнгөтний шинэ анги засгийн эрхийг байлдан авахын төлөө тэмцэх үед бий болжээ. Нийгмийн санал бодол нь улс төрийн хамтын хүсэл зоригийн улс төрийн агуулга мөн болно. Тийм ч учраас хэвлэл, нам, парламент зэрэг нийгмийн санал бодлын байгууллага, дуу хоолойг монополдон дангаар эзлэхийн төлөө тэмцэл хийгддэг байна. Үүний зорилго бол аль ч хүчнийхэн үндэстний санал бодол, улс төрийн хүсэл зоригийг нэгтгэн төлөвшүүлэх явдлыг эрмэлздэг бөгөөд энэ нь тэрхүү нэгдмэл хүсэл зоригийг төлөвшүүлэхэд саад тотгор болж буй бүх зүйлийг тоосон товрог болгож хийсгэх зорилготой байдаг.

Нийгмийн санал бодол нь нийгмийг бүрдүүлдэг хүмүүс, эсвэл бүлгүүдийн хэлж илэрхийлдэг санал бодлын жирийн нийлбэр биш. Улс төрийн системийн цогцолбор нэгдлээс харьцангуй тусгаарлагдсан нийгмийн жижиг бүлгүүдийн хүрээнд (жишээлбэл гэр бүл, айл хөршүүд, хамтарч тоглоом тоглодог бүлгүүдийн хүрээнд) аль эсвэл хувь хүмүүсийн хүрээнд илэрч гардаг хувийн санал бодол нь тодорхой нөхцөлд нийгмийн санал бодол үүсэн бүрэлдэж болох материал бүхий нөөцийн томоохон ач

холбогдолтой болж чадах ажээ. Гэвч энэ нь нийгмийн санал бодол ч бас хараахан биш юм. Энд өгүүлсэнд дараах зүйлийг нэмж болох талтай бөгөөд тэр нь юу вэ гэвэл "олон нийтийн санал бодлын судалгаа" гэдэг тодорхойлолтыг хэрэглэх үндэслэл болгож аль нэг хамтлагийн гишүүдийн ямар нэгэн сэдвийн талаархи үзэл бодлыг илрүүлж тодорхой болгох зорилгоор янз бүрийн тандалт судалгаа хийхдээ тийм төрлийн судалгаа нь тодорхой хэмжээгээр хувийн санал бодлыг нийгмийн санал бодол болгож хувиргасан байдаг явдал гарах болно. Ийм өөрчлөн хувиргах явдал яагаад явагддаг вэ? гэвэл тэрхүү тандалт судалгааны нэгтгэн дүгнэсэн, задлан шинжилсэн үр дүн нь нийгмийн санал бодлын тодорхой хэмжээний хэлбэр болж хувирсан, тэгснээрээ улс төрийн системийн бүрдэл хэсэг болж тогтсон байдагт хамаг учир шалтгаан байгаа юм. Гэлээ гэхдээ судалгаанд хамрагдагсадын зүгээс асуултанд өгсөн хариултууд нь хүмүүсийн хувийн үзэл бодол, саналын зөвхөн нийлбэр л байдаг гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино. Тэдгээр хувийн санал бодлууд нь нийгэмд өргөн дэлгэрч тархсан тохиолдолд л олон нийтийн санаа бодол болж чадна.

Нийгмийн санал бодол гэдэг бол хүмүүсийн томоохон бүлгүүдийн нийгмийн ухамсрын түүхэн ёсоор нөхцөлдсөн хийгээд өөрчлөгдөн буй төлөв байдал мөн бөгөөд тэрбээр улс төрийн системийн ил тод илэрхийлэл юм. Нийгмийн санал бодол нь улс төрийн системийн оршин тогтнолын бүрдэл хэсэг бүхий элемент болж хувирдаг. Улс төрийн систем нь улс төрийн байр суурийг ямар нэгэн байдлаар илэрхийлэхийг зөвшөөрдөггүй тийм газарт нийгмийн санал бодол байдаггүй бөгөөд улс төрийн байр суурийн илэрхийлэлт нь улс төрийн оршин тогтнолд нөлөөлөх зорилготой байдаг.

Олон түмний санаа бодолд бүрэн хэмжээгээр монополь тогтоон, нэг гарт төвлөрүүлж барих нь нийгмийн санал бодлыг байгаа байдлаар нь устгасантай адил хэрэг болно. Гэвч энэ нь нийгмийг тийм байдлаар удирдаж буй хүмүүс төрийн асуудлаар ерөөсөө санал бодолгүй байдаг гэсэн үг бас хараахан биш юм. Нийгэмд янз бүрийн үзэл бодол нийтэд ил тод байдлаар илэрхийлэгдэж, тэдгээрийг янз бүрийн байр суурийн төлөөлөлтөй болгож харьцуулах замаар хооронд нь уялдуулан зохицуулсан үед л нийгмийн санал бодол бодитойгоор орших болно. Нийгмийн санал бодлын хүрээн дэх тэмцэл янз бүрийн үзэл бодлыг илэрхийлэн төлөөлсөн хүмүүсийн хоорондын маргаан төдий байдлаар хэзээ ч хэрэгждэггүй. Энэхүү тэмцэлд эдийн засгийн ба улс төрийн хүчнүүд татагдан ордог бөгөөд учир нь үзэл бодлын төлөвшил нийгмийн санал бодол болж хувирдаг зүйлийг илэрхийлэх явдал нь тодорхой хэмжээний эдийн засгийн урьдач нөхцлийн (санал бодол, үзлийг томъёолох, дэлгэрүүлж тараах материал, хэрэгсэлүүд) оршин буй байдлаас, түүнчлэн улс төрийн урьдач нөхцлийг (нийгмийн санал бодлын хил хязгаар, заагийг ямар нэг аргаар тодорхойлж тогтоох боломж өгөхүйц албадлагын хэрэгсэл) бий болгох зэргээс шалтгаалдаг.

Тийнхүү нийгмийн санал бодол нь нийгмийн гишүүдийн үзэл бодлын жирийн, энгийн нийлбэр юм уу эсвэл ямар нэгэн завсар дундын хир хэмжээ биш байдаг. Нийгмийн санал бодол бол улс төрийн үзэгдэл байдаг бөгөөд түүний мөн чанар нь нийгэмд бодитойгоор оршиж үйл ажиллагаа явуулж буй хүчнүүдийн харилцааг тодорхойлоход оршино. Хувь хүмүүс, бодьгалуудын үзэл бодол нь энэхүү нарийн нийлмэл тэгшитгэлийн бүрдэл хэсгийг бүрэлдүүлэн бий болгодог, гэхдээ нийгмийн санал бодлын шинжийг зөвхөн тэдгээр нь тодорхойлдоггүй юм. Хувь хүмүүсээс илэрхийлж гаргасан, тарамдаж бутарсан үзэл бодлуудыг өөрчлөн хувиргаснаар сая нийгмийн санал бодол бий болно.

Энэхүү өөрчлөлт хувиралтын механизм бол улс төрийн бодлогын онолын гол асуудлуудын нэг мөн.

Тухайн нийгэмд хэдэн янзын, хэдий хэрийн тооны нийгмийн санал бодол зэрэгцэн оршиж болох вэ? гэсэн асуулт гардаг. Энэ тохиолдолд хэл ярианы дадал зуршил нь ганц тоог хэрэглэхийг тулгадаг, нэг л тооны нийгмийн санал бодол оршихыг урьдчилан шаарддаг. "Дотроо зөрчилтэй байж чадахуйц улс төрийн хамтын хүсэл зоригийн" тухай Грамшигийн үгийг чухамдаа тийнхүү ойлгож болох магадлалтай. Гэвч нийгэмд зөвхөн ганцхан тооны нийгмийн санал бодол оршино хэмээн үзэх нь сайндаа загварыг тодорхойлоход л хэрэгтэй болно. Грамшигийн онож ажиглан харснаар улс төрийн тэмүүлэл нь янз бүрийн, ихэнхдээ эсрэг тэсрэг урсгалд хуваагдсан ухамсарыг нэг төрлийн санал бодол, наандаж тодорхой утгаар нийгмийн санал бодол болгож хувиргахад чиглэгдсэн байдаг. Гэвч тийм нийгмийн санал бодол нь яг эмпирик утгаараа ямагт хуурмаг зохиомол зүйл байдаг. Ангийн ялгаа эсвэл нийгмийн бусад ялгаанаас ургаж гарсан бодит зөрчилтэй, улс төрийн идэвх нь өндөр биш түвшинтэй нийгэм нь, түүний гишүүд нь улс төрийн бодит байдлын тухай юу бодож байгаагаараа цул нэгдэлтэй байдаггүй, байж ч чадахгүй. Бодьгалуудын хувийн үзэл бодлыг жигдлэн нэг төрлийн болгох явдал нь хор уршигтай болохын зэрэгцээ бодит биш шаардлага болно. Учир нь тийм оролдлого нь дэвшилттэй өөрчлөлт, шинэчлэлт хийх замыг засаж тавьдаг шинэ үзэл бодлуудын эсрэг чиглэсэн байдаг юм.

Нийгмийн санал бодлын нарийн нийлмэл бүтэц нь юунд үндэслэгддэг вэ? гэвэл бодит байдал дээр хүмүүс янз бүрийн санал бодлыг ил тод, нийтэд хэлж илэрхийлдэг, тэдгээр нь хоорондоо тулгарч сөргөлдөх явцад нийгмийн санал бодлын зонхилогч, давамгайллагч урсгал ихэнх тохиолдолд энгийнээр нийгмийн санал бодол гэж нэрлэдэг тэрхүү санал бодлын урсгал бүрэлдэж бий болдогт үндэслэгддэг байна. Нийгмийн санал бодлын олон ургальч байдал нь (плюрализм) олон янзын хүчин зүйлсээс, тухайлбал ангиудын болон бусад төрлийн зөрчлүүдийн хүчнээс, тэдгээр нь гаднах илрэлээрээ нэг нь нөгөөгөөсөө ялгаа онцлогтой санал бодлууд төлөвшихөд хүргэдэг байдлаас, түүнчлэн нийгмийн аль нэг тусгай бүлэг өөрийн үзэл бодлоо нийтэд илэрхийлж гаргах бололцооны хүрээ хязгаараас, үзэл бодол нь нийгмийн

санал бодлын эцсийн хэлбэрт нөлөөлж чаддаг, түүнийг нь тооцдог, эсвэл үл хайхардаг олон нийтийн идэвхжилтийн түвшинээс шалтгаална. Нийгмийн санал бодол нь хэр зэрэг олон ургальч байна вэ?, энэхүү олон ургальч байдал нь өөрөө ямар төрөлтэй вэ? гэсэн асуултанд хариу өгөх нь нийгмийн санал бодол төлөвшдөг нийгмийн ба улс төрийн нөхцөл байдлыг иж бүрэн задлан шинжлэхийг шаардана.

Би дээр нийгмийн санал бодолд тодорхойлолт өгөхдөө нийгмийн санал бодол нь улс төрийн системийн оршин тогтнолын бүрдэл хэсэг болдгийг тухайлан дурьдсан билээ. Улс төрийн систем нь өөрийнхөө оршин тогтнолд хүмүүс, хэсэг бүлгүүд боломжит хэлбэрээр оролцох явдлыг бүрэн хааж боосон тийм газарт нийгмийн санал бодол бодитойгоор оршин байдаггүй юм. Фашист дэглэмүүдэд нийгмийн санал бодол гэж байдаггүй бөгөөд яагаад вэ гэвэл тэдгээр дэглэм нь нийгмийн санал бодлыг улс төрийн системд багтаан оруулах явдлыг ядаж боломжит хэлбэрээр ч гэсэн хүлээн зөвшөөрдөггүй юм. Фашист номлол ёсоор нийгмийн санал бодол гэж байдаггүй бөгөөд тэр нь ямар ч зорилтгүй зүйл ажээ. Зөвхөн удирдагч жолоодогчийн хүсэл зориг гэдэг зүйл л бодитой оршдог бөгөөд түүнийг хүлээн авах нь нийгмийн гишүүдийн ухамсар болдог ажээ. Удирдагчын хүсэл зоригоос ангид, чөлөөтэй орших нийгмийн санал бодол фашист системд оршин тогтнох эрхгүй байдаг.

Ардчиллыг ойлгох хөрөнгөтний ба социалист үзэл баримтлалууд нь хоорондоо ихээхэн ялгаатай боловч тэдгээр хоёр үзэл баримтлал хоёулаа нийгмийн санал бодол бодитойгоор байдаг бөгөөд тэр нь улс төрийн системийн оршин тогтнолд баталгаатайгаар нөлөөлөх ёстой гэдэгтэй санал нийлдэг юм. Улс төрийн системийн нэгэн хэсэг нь нийгмийн санал бодлыг төлөвшүүлэн илэрхийлэх институт бүхий байгууллагууд мөн, түүнчлэн нийгмийн санал бодол нь улс төрийн шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөн хэрэгжих дамжилга бүхий байгууллагууд ч мөн болно. Энэ үйл ажиллагааны тодорхой хэлбэрүүд нь маш олон янз байдаг бөгөөд тэгэхдээ тэрхүү ялгаа онцлогууд зөвхөн социалист ба капиталист нийгэм, орнуудын хооронд төдийгүй нийгэм улс төрийн нэг төрлийн байгуулалтай орнуудын хооронд ч ажиглагддаг юм. Гэвч эдгээр системүүдийн нийтлэг элементийг, тэдгээр системүүд нь нийгмийн санал бодлыг өөрсдийнхөө байгууллагууд болон улс төрийн амьдралын хэм хэмжээний нийт цогцод багтаан оруулдаг ба тэр нь нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөх боломж олгох явдлыг бүрдүүлдэг. Нийгмийн улс төрийн системд нийгмийн санал бодлын гүйцэтгэх үүргийн тухай хөрөнгөтний либерал ба социалист үзэл баримтлалын хоорондын зарчмын ялгаа юунд орших вэ гэвэл тэдгээрийн нэг дэх нь нийгэм эдийн засгийн хүрээнд хэрэг дээрээ тэгш бус байдал бодитой оршдог байхад улс төрийн хүрээнд тэгш байдал бодитойгоор оршдог хэмээн үздэг.

Либераль номлол нь хүмүүсийн бололцоо, гараа нь улс төрийн ба хууль эрх зүйн хувьд тэгш байдалтай байх зарчмыг иш үндэс болгож нийгмийн санал бодол төлөвших

хийгээд илэрч гарах хүрээнд улс төрийн хүчнүүдийн тоглоом нь эрх чөлөөтэй байдаг тухай нотолгоог гаргаж тавьдаг юм. Гэвч энэхүү номлолын байр сууринаас их бага хэмжээгээр олон удаа ухарч татгалзах, ялангуяа хувьсгалт хүчнүүдийн талаар, мөн түүнчлэн хөрөнгөтний либерал систем хэт барууны хүчнийхний дарамт шахалтанд өртсөн тохиолдолд дээрхи номлолоосоо татгалзах явдал цөөнгүй гардаг. Гэвч эл ухралт, татгалзал нь тухайн номлолд хамаарахгүй ажээ. Учир нь эл номлолоос дараах үзэл санаа¹дүгнэлт урган гардаг бөгөөд тэдгээрийн үздэгээр нийгмийн санал бодлыг төлөвшүүлэн бий болгодог, илэрхийлдэг нийгмийн субъект бүхий хүчнүүдийн гараа ба бололцоо нь албан ёсоор, эрх зүйн хувьд тэгш, тоглоомын дүрэм нь эрх чөлөөтэй байгаа тохиолдолд эдийн засгийн хувьд зүйрлэшгүй хүчирхэг хүч нөөцтэй, түүнээс гадна уламжлалын ихээхэн хүч нөлөөг өөртөө эзэмшдэг онцгой эрх дархтай анги нь давуу байдалтай байж нийгмийн санал бодлын зонхилох чиглэлийг өөрийнхөө эрх ашигт нийцүүлж төлөвшүүлэн тогтоодог билээ. Чухам үүгээр ангийн ноёрхлын үзэл сурталтай аспект илрэн гардаг ажээ.

Гэтэл социализмын нөхцөлд хэрэг явдал үүнээс өөр байдаг юм. Ажилчны хөдөлгөөн үг хэлэх эрх чөлөөг эсэргүүцэхгүй, гэхдээ энэхүү эрх чөлөөг өмч хөрөнгөтэй ангийн эрх ашгийн төлөө ашиглахыг гаргахгүй байхын төлөө тэмцэнэ. Ажилчны хөдөлгөөн нь нийгмийн санал бодлыг төлөвшүүлэх, илэрхийлж гаргах хүрээнд өөртөө давуу байдал бий болгож хангахдаа зэрэгцэж хэрэгжих, бас бие биеэ харилцан нөхөж байдаг дараах арга хэмжээнүүдийн тусламжаар хэрэгжүүлнэ. Тэдгээр нь: нийгмийн ухамсарт нөлөөлөх материаллаг үндсэн хэрэгсэлүүдийг (хэвлэх үйлдвэр, хэвлэл мэдээлэл, радиостанц) нийгэмчлэх, нийгэмд дэлгэрүүлэн түгээж буй мэдээллийн агуулгад олон түмний зүгээс төрийн хяналт тавих явдал юм. Нийгэмд дэлгэрүүлэн түгээж буй мэдээллийн агуулгад тавих хяналтын хэлбэр нь социалист бүх оронд адил биш, бас нэг төрлийн биш бөгөөд, гэхдээ тэдгээр хэлбэрүүдийн аль нь ч нийгмийн санал бодлыг төлөвшүүлэх, илэрхийлж гаргах хүрээнд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг юм.

Энэ нь нийгмийн санал бодлын онолын үүднээс үзвэл дараах асуудлыг төрүүлэн гаргаж байна: улс төрийн системд нийгмийн санал бодлын эзлэх байр суурийг тодорхойлдог улс төрийн социалист бодлогын дээр дурдсан зарчмуудыг хэрэгжүүлэхэд нийгмийн санал бодол бодитой оршин байна гэж хэлэх хэр зэрэг үндэслэлтэй байна вэ? гэсэн асуулт гарна. Зарим эрдэмтэд либерал номлолын зарчмыг иш үндэс болгож социализмын үед нийгмийн санал бодол байдаггүй, харин засгийн газрын санал бодол л бий гэж шууд батлан хэлж байгаа юм.

Асуудлын мөн чанар юунд оршиж байна вэ? гэвэл социализмын үеийн нийгмийн санал бодол нь чанарын хувьд цоо шинэ шинжтэй байгаа бөгөөд тэр нь хөрөнгөтний либерал ардчилсан системийнхээс ялгаатай юм. Социализмын үеийн нийгмийн санал бодол нь юуны өмнө социалист шинж агуулгатай бөгөөд учир нь эл нийгэмд нийгмийн

асуудлуудын талаархи үзэл бодлын бүрэлдэн тогтох, нийтэд ил тод илэрхийлэгдэх үйл явц нь социалист байгууллын үндсүүдийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр хэрэгждэг. Социализмын үед нийгмийн гишүүдийн дунд социалист биш, түүгээр ч үл барам социализмын эсрэг үзэл бодол ба байр суурь хичнээн өргөн дэлгэрсэн байлаа ч гэсэн түүнээс шалтгаалахгүйгээр нийгмийн санал бодол болж төлөвшиж буй үзэл бодол социалист шинж чанартай байдаг юм. Намын удирдан чиглүүлэгч үүрэг хийгээд социалист шинжтэй улс төрийн зохион байгуулалттай хүчнүүдийн идэвхтэй хамтын оролцоо нь нийгмийн санал бодол социалист санал бодол болж төлөвшин тогтоход хүргэдэг. Социализмын үед коммунист нам өөрийнхөө удирдан чиглүүлэгч үүргээ түр зуур алдсан нөхцөлд л нийгмийн санал бодлын социалист шинж гажууддаг бөгөөд эл гажуудал нь төрийн байгууллагуудад гажуудал үүсэхээс түрүүлж нийгмийн санал бодлын хүрээнд үүсдэг байна.

Нийгмийн санал бодол социалист шинжтэй байх нь эл санал бодол бүх тохиолдолд аль нэг асуудлаар явагдаж буй тодорхой бодлоготой нийцэж тохирохыг урьдчиланшаарддаггүй юм. Нийгмийн санал бодол ба хэрэгжин буй бодлого хоёрын хооронд зөрчил гарах магадлал байдаг. Нийгмийн санал бодол ба хэрэгжүүлэн явуулж буй бодлогын хоорондын зөрчлийг арилгах ёстой бөгөөд нэг бол хэрэгжүүлэн буй бодлогыг өөрчлөх замаар, аль эсвэл нийгмийн санал бодол ба бодлогын хоорондын зөв харьцааг сэргээн тогтоох зорилгоор уг санал бодолд оновчтой байдлаар нөлөөлөх замаар арилгана.

Эцэст нь тэмдэглэхэд нийгмийн социалист санал бодлын өөр нэг шинж чанар бол улс төрийн удирдлагын үзэл бодол ба нийгмийн гишүүдээс аяндаа үүсэн гарч бүрэлдсэн үзэл бодол хоёр нийгмийн тухайн санал бодолд цаг тухайд нь тусаж зохицуулагддаг явдал мөн болно. Энэхүү уялдаа зохицуулалт нь зарим хүрээ салбарт ямар нэгэн асуудал, бэрхшээлгүйгээр хэрэгжин биелдэг, үүний учир нь аяндаа үүсэн гарч төлөвшдөг санал бодлын зонхилох хэсэг нь улс төрийн удирдлагаас дэвшүүлэн гаргадаг үзэл бодолтой адил, нийцэмжтэй байдаг явдал юм. Ихэнх тохиолдолд нийгмийн санал бодлын төлөвшлийн үйл явц нь нарийн ээдрээтэй байх нь зайлшгүй зүйл бөгөөд түүнийг шийдвэр гаргахдаа тооцон анхаарах хэрэгтэй байдаг. Энэхүү үйл явц нарийн төвөгтэй, ээдрээтэй болохыг үл тоох, хайхрахгүй байх явдал нь ардчиллыг гажуудуулах, хязгаарлан хумихад хүргэнэ, үүний үр дагавар болж улс төрийн хямрал ч үүсч гардаг. Нийгмийн санал бодлын хүрээн дэх ардчилалын зарчимд тохирсон улс төрийн бодлого юунд орших вэ? гэвэл олон түмний ухамсарт идэвхтэй нөлөөлөхдөө нийгэмд ямар шийдвэр гарч байна вэ?, түүнийг нийгэмд хэрхэн яаж сурталчилан таниулж байна вэ? гэдгийг тооцон анхаарахад оршино.

3. Улс төрийн үзэл суртал

Улс төрийн ухамсрыг задлан шинжлэх гурав дахь хүрээ бол үзэл суртал бөгөөд түүний улс төрийн амьдралд гүйцэтгэх үүргийг судлан шинжлэх явдал чухал. Үзэл суртал бол харьцангуйгаар өндөр түвшинд системчлэгдсэн үзэл бодлуудын цогц бөгөөд түүний ялгагдах гол шинж нь нийгмийн бүлгүүдийн эрх ашиг ба тэмүүлэлтэй функционал буюу үүргийн хэлхээ холбоотой байдаг явдал болохын дээр үзэл суртлын бүрэлдэхүүнд тухайн бүлгийн түүхэн туршлага хийгээд амьдралынх нь нөхцлийн үндсэн дээр үүсэж гардаг үзэл санаа багтаж орох ба тэр нь бодит байдлыг тусгаж, үнэлж цэгнэдэг, эдгээр үзэл санаанд үндэслэгдсэн үйл ажиллагааны удирдамж ч мөн багтаж ордог хэмээн тодорхойлж болно. Үзэл суртал нь нийгмийн ухамсрын хэлбэрүүдийн нэг мөн. Бид нийгмийн ухамсрыг К.Маркс "Улс төрийн эдийн засгийн ухааны шүүмжлэлд" бүтээлийнхээ өмнөх үгт илэрхийлж томъёолсон нийгмийн ахуйгаар тодорхойлогддог оюун санааны амьдралын хэлбэрүүдийн цогц хэмээн ойлгож байна. Үзэл суртал дараах шинжийг агуулдаг.

а) Үзэл суртал нь нийгмийн бүлгийн (тухайлбал анги, үндэстний) эрх ашиг ба үйл ажиллагаанаас хараат байдалтайгаар шалтгаалж оршино, өөрөөр хэлбэл үзэл суртал нь нийт нийгмийн эрх ашгийг биш харин зарим хэсэг, бүлгийн эрх ашгийг хамгаалахад үйлчилдэг

б) Харьцангуй өндөр түвшинд системчлэгдсэнээрээ ялгаатай болно.

Үзэл суртлын нэгдүгээрт заасан онцлог нь нийгмийн танин мэдэхүйн үйл явц хоёрдмол шинжтэй байдгийг тусгана. Хүн төрөлхтөн бодит байдлыг нийгмийн амьдралын явцдаа танин мэдэх бөгөөд ингэхдээ тэрхүү танин мэдэхүйн үйл явц нь хүмүүсийн практик үйл ажиллагааны явцтай нягт холбоотойгоор хэрэгжинэ. Түүгээр ч үл барам танин мэдэхүй бол өөрөө ер нь хүмүүсийн практик үйл ажиллагааны үйл явцын нэг хэсэг, онцгой тал байдаг хэмээн хэлж болох юм. Хамгийн ерөнхий хэлбэрээр хэлэхэд хүн төрөлхтний практик нь хоёр төрөл зүйлд хуваагдна.

Нэгдүгээрт, хүн байгалтай идэвхтэй байдлаар дасан зохицох, түүнийг өөртөө захируулахыг хичээн зүтгэж түүнд нөлөөлдөг. Хүн төрөлхтөн эдгээр үйл ажиллагааныхаа явцад нэгэн нэгдмэл, цул, бүхэл субъект болж үйлдэнэ (энд хэрэв улс төрийн ба эдийн засгийн өрсөлдөөний үр дүнд үүсэн гардаг зарим учрал, тохиолдол, нөхцөлийг үл тооцвол шүү дээ). Тиймээс ч энэхүү практикийн танин мэдэхүйн тал нь нийт хүн төрөлхтөний нийтлэг, ижил эрх ашгийг илэрхийлдэг. Хэрвээ байгалийг танин мэдэхэд үзэл суртлын тал дээр асуудал үүсч гардаг бол (жишээлбэл: Коперник, эсвэл Дарвины нээлтэнд) түүний шалтгаан нь тухайн нээлтийн өөрийнх нь байгаль шинжлэлийн мөн чанар биш, харин нийгмийн шалтгаан, тухайлбал, энэхүү нээлт нь нийгмийн ямар нэг бүлэг, эсвэл байгууллагын эрх ашигтай зөрчилдөх явдал мөн болно. Бидний дээр дурдсан жишээнүүдэд католик шашны сүм хийдийн нэр хүнд,

давуу талд аюул занал учирсан нь католик сүм нь дурдсан нээлтүүдэд эсрэг чиглэсэн үзэл санаа, дүгнэлтүүдийг хамгаалан баримталж байсан билээ.

Хүний танин мэдэхүйн үйл ажиллагааны өөр нэг хэлбэрийн хувьд, тухайлбал хүмүүсийн өөрсдийнх нь хоорондын харилцааг өөрчлөн хувиргахад чиглэгдсэн практикийн оюун ухааны эквивалент бүхий төлөөлөл болох салбарт асуудал дээр дурдсанаас өөр байдалтай байдаг юм. Практикийн энэхүү хоёр дахь төрлийн хүрээн дотор хүн төрөлхтөн танин мэдэхүйн хуваагдаж салбарласан, объектив эрх ашгийнхаа дагуу хэсэг бүлэг болсон субъект болж үйлддэг байна. Эдгээр эрх ашиг нь эдийн засгийн, улс төрийн гэх зэргээр янз бүр байдаг. Ангит нийгэмд эрх ашгуудын эсрэг тэсрэг байдал тэргүүн эгнээнд гарч ирж тавигддаг бөгөөд тэр нь ангиудын эрх ашгийн объектив, бодит сөргөлдөөн, мөргөлдөөнөөс ургаж гардаг. Гэхдээ эрх ашгуудын дифференциаци буюу ялгарал, салбарлан гарах явдал нь зөвхөн ангийн үндэс шалтгаантай байдаггүй юм. Үндэстэн, төр улсын хоорондын ялгаа, түүнчлэн газар зүйн бүс нутаг, ажил мэргэжлийн бүлгүүдийн ялгаа гэх зэрэг ялгаанууд нь нийгмийн бодит байдлын дүр төрх, зургийг нийгмийн бүлгүүдийн үзэл бодлын үүднээс бүрдүүлэн бий болгоход түлхэц өгдөг бөгөөд тэдгээр бүлгүүдийн эрх ашиг ба үйлдэл нь онолч буюу үзэл санааг түгээн дэлгэрүүлэгч, оюун ухааны удирдагч, жолоодогчийн оюун санааны үйл ажиллагааны үндэс суурь болж өгдөг. Чухам энэхүү тохиолдолд бид үзэл бодлуудын тодорхой нэг цогц нь нийгмийн бүлгийн эрх ашиг ба эрмэлзэл тэмүүлэлтэй функционал холбоотой, өөрөөр хэлбэл "бүлгийн коррелят" мөн гэж хэлж болно.

Тэгэхлээр үзэл суртал бол нийгмийн ухамсрыг бүхэлд нь төлөөлөн илэрхийлэхгүй, учир нь үзэл сурталын хүрээнд нийгмийн ухамсрын зөвхөн зарим хэлбэрүүд, тухайлбал өөр өөр эрх ашигтай бүлгүүдийн үйл ажиллагаа нь оюун ухааны илэрхийллээ олсон ухамсрын хэлбэрүүд л багтаж орно.

Гэвч үзэл сурталыг тодорхойлж томъёолоход энэ зүйл бас хангалттай биш. Учир нь бид нийгмийн бүлгүүдийн эрх ашгийн ялгааг тусган илэрхийлж буй үзэл бодол, төсөөлөл болгоныг үзэл сурталд багтаан оруулахгүй. Үзэл суртал бол системчлэгдсэн үзэл бодлуудын цогц нийлбэр юм. Оскар Ланге бичихдээ: "Хүмүүс нийгмийн харилцааг ухааран ойлгож байдаг тэрхүү хязгаар дотор, тэдний ухаан бодол дотор үзэл санаа үүсэж бий болдог бөгөөд хүмүүс түүгээр дамжуулж (үзэл санаагаар) тэдгээр харилцааг ухааран ойлгодог, түүнчлэн тэдний ухаан санаанд нь эрх зүй, улс төр, ёс суртахуун, шашин, философи, шинжлэх ухаан, уран сайхны үзэл санаанууд үүсэн бий болдог, тэдгээрийн үндсэн дээр хүмүүс нийгмийн харилцааг үнэлэн цэгнэж, дүгнэж байдаг юм. Бид эдгээр үзэл санааг нийгмийн үзэл санаа хэмээн нэрлэж байгаа бөгөөд харин тэдгээр үзэл санааны системчлэгдсэн нэгдлийг үзэл суртал хэмээн нэрлэж байгаа юм" гэж бичжээ.

Бид үзэд суртал бол нийгмийн бүлгүүдийн эрх ашиг ба эрмэлзлэл тэмүүлэлтэй функционал, үүргийн харилцаатай үзэл бодлуудын харьцангуй системчлэгдсэн цогц юм хэмээн тодорхойлохдоо энэхүү ойлголтыг “ертөнцийг үзэх үзэл”, “номлол” гэсэн өөр хоёр ойлголтоос ялган салгаж ойлгож байгаа юм. Эдгээр хоёр ойлголт хоёулаа үзэл суртал хэмээх ойлголтонд багтаж орно.

Ертөнцийг үзэх үзэл гэдэг бол үзэл суртлын тодорхой бөгөөд онцгой төрөл зүйл бөгөөд түүний дагуу ертөнц, хүн, нийгмийн дүр зураг системчлэгднэ, түүнчлэн хүний амьдралын утга учир ба ёс суртахууны үүргийн тухай ойлголтонд хариу өгөгднө. Өөрөөр хэлбэл ертөнцийг үзэх үзэл нь ертөнцийн тухай нэгтгэн дүгнэсэн философийн дүр зураг, төсөөлөл юм. Дотроо талцаж хуваагдсан нийгэмд ертөнцийг үзэх үзэл нь нийгмийн бүлгүүдийн онцгой байр суурь, эрх ашгийг тусган илэрхийлдэг бөгөөд энэ утгаараа үзэл суртал болдог. Гэвч үзэл суртал бүхэн ертөнцийг үзэх үзлийг давхар агуулдаггүй. Чухам ийм учир шалтгаанаар үзэл суртал нь ертөнцийг үзэх үзлээс агуулга багтаамжаараа өргөн, том ойлголт байдаг. "Номлол" гэсэн ойлголтын тухайд гэвэл байдал мөн үүнтэй ижил юм (жишээлбэл: эрх зүй, улс төрийн ба эдийн засгийн номлол). Номлол гэдэг бол маш өндөр түвшинд системчлэгдсэн үзэл суртал мөн бөгөөд тэрбээр ер нь ямагт онолын үүднээс нэгтгэн дүгнэгдсэн байдлаар илэрхийлэгддэг. Бид энд ийм маягийн номлолыг үзэл суртал хэмээн тодорхойлж байгаа ч гэсэн үзэл суртал бүхнийг бас номлол мөн гэж нэрлэж чадахгүй. Тэдгээрийн ялгаа заагийг энд тогтоон гаргахад хэцүү, бэрхшээлтэй ч гэсэн тэрхүү ялгаа нь хэлний мэдрэмж болон судлан шинжилж буй үзэл бодлуудыг үнэлэх явдлаас ихээхэн хэмжээгээр шалтгаална.

Улс төрийн харилцааны социологийн чухал зорилтуудын нэг бол үзэл суртлын янз бүрийн хэв маягууд ба тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг харьцуулан судлах явдал мөн болно. Бид үзэл суртлын янз бүрийн хэв маягийг харьцуулан судлах явдлыг дараах үндсэн шалгууруудыг удирдамж болгож хэд хэдэн хүрээ салбарт зэрэгцүүлэн явуулах болно. Тэдгээр шалгуур бол: а) үзэл суртлын үүрэг, б) үзэл суртлын нийгмийн бааз суурь, в) үзэл суртлын дотоод бүтэц, г) үзэл суртлын тогтвортой байдал хийгээд үйлчлэлийн хүрээ салбар юм.

Бид үзэл суртлын үүргийг задлан шинжлэхдээ тэр нь хэнд, юунд үйлчилдэг вэ? гэсэн асуулт тавьж юуны өмнө үзэл суртлын үүрэг нь нийгмийн ангиуд ба хүмүүсийн бусад томоохон бүлгүүдэд хандсан байдлыг зааж үзүүлнэ. Жишээлбэл: фашизм нь монополист хөрөнгөтний ангийн үзэл суртал мөн, учир нь тэрбээр империализмын нөхцөл дэх монополист капиталын эрх ашиг ба эрмэлзлэл тэмүүллийг үзэл суртлаар үндэслэсэн нэг хувилбар юм. Бид үзэл суртлын үүргийг зөвхөн тодорхой бүлгүүдийн эрх ашигтай холбох төдийгүй мөн нийт нийгмийн эрх ашигтай ч холбоотойгоор тодорхойлж болно. Ингэхдээ тэрхүү эрх ашиг нь нийгмийн дэвшилт хөгжлийн үйл явцтай нийцэн

тохирдог болохыг хамтад нь ойлгож байгаа юм. Үзэл суртал нь дэвшилттэй, консерватив, бас харгис шинжтэй байж болно.

Үзэл суртал нь нийгмийн бааз суурийнхаа үүднээс ангийн (өөрөөр хэлбэл нийгмийн аль нэг ангитай ил тод холбоотой), үндэстний үзэл суртал гэх зэргээр хуваан ангилагдана. Бид ямар нэгэн үзэл суртлыг ажилчин ангийн үзэл суртал хэмээн нэрлэхдээ түүний дэлгэрэлт, нөлөөний хил хязгаар ба нийгмийн бааз суурийнх нь шинж байдлыг тооцон анхаарч байгаа юм. Функционал буюу үүргийн хамаарлынх нь үүднээс авч үзвэл пролетарчуудын ангийн үзэл суртал бол марксизм-ленинизм мөн бөгөөд гэхдээ ажилчин ангийн дээд давхрааны үзэл суртлын нийгмийн бааз суурь нь ямар нэгэн өөр үзэл суртал байж болно (жишээлбэл британы лейборизм).

Бид үзэл суртлын дотоод бүтцэд шашны ба шашны бус, иргэний үзэл суртал, рационал ба иррационал үзэл суртал, түгээмэл, нийтлэг ба хэсэг бүлгийн үзэл суртал гэсэн эсрэг тэсрэг гурван хос үзэл суртлыг ялган авч үзэж болно. Эдгээрийн ялгааны үндэс нь голлох үнэт зүйлс, эсвэл үндэслэлүүдийн зонхилогч хэв маягууд мөн болно. Шашны ба шашны бус, иргэний үзэл суртлын ялгаа нь "загалмайтны" элемент буюу "ариун нандин" хэмээн ойлгосон элемент байгаа эсэх явдал мөн болно. Дашрамд хэлэхэд энэхүү ялгаа нь бүрэн гүйцэд судлагдаагүй байгаа бөгөөд учир нь "загалмайтны" буюу "ариун нандин" хэмээгдэх элемент нь янз бүрийн (гэхдээ бүгдэд нь биш) үзэл суртлуудад янз бүрийн байдлаар илэрдэг юм.

Рационал ба рационал биш (иррационал) үзэл суртлуудын ялгаа зааг нь тухайн үзэл суртал өөрийнхөө дүгнэлт, нотолгоонуудыг логик болон рационал хяналтанд оруулж шалгахад ямар хэмжээгээр бэлэн байна уу гэдэгт үндэслэгдэнэ. Иррационал буюу рационал биш үзэл суртал нь (жишээлбэл удирдагч, жолоодогчийг шүтэх фашист үзэл суртал) удирдагчийн зөн билиг, "цусны дуу хоолой" ба тэдгээртэй төсөөтөй иррационал шалгууруудад хандаж чиглэсэн байдаг. Эцэст нь хэлэхэд түгээмэл, нийтлэг ба тусгай үзэл суртлуудын хоорондын ялгаа нь тухайн үзэл суртлын уриа лоозон нь хэнд зориулагдаж чиглэгдсэн байна вэ? гэдэгт үндэслэгдэнэ. Жишээлбэл: христос шашин нь бүх шүтлэгтэн сүсэгтэнд хандаж чиглэгдсэн байдаг тул тэрбээр түгээмэл, нийтлэг үзэл суртал мөн болно, харин расизм буюу арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь өөрийнхөө тодорхойлолтоороо бүлгийн, тусгай үзэл суртал мөн болно. Учир нь тэрбээр онцгой эрх дарх, давуу байдалтай арьстанд хандсан байдаг юм.

Энэхүү үзлийн үүднээс авч үзвэл марксизм нь дээр дурьдсан ангиллын явцуу хүрээг сэтэлж тэлсэн онцгой үзэл суртал мөн болно. Тэрбээр юуны өмнө ажилчин ангид зориулагдаж хандсан үзэл суртал мөн болохын хамт хөдөлмөрчдийн алс хэтийн, ирээдүйн эрх ашиг нь нийт хүн төрөлхтний, түгээмэл шинж чанартайн улмаас нийт хүн төрөлхтнийг чөлөөлөхийг эрхэмлэсэн үзэл суртал мөн.

Үзэл суртлуудыг хооронд нь ялгах сүүлчийн шалгуур бол үзэл суртлын тогтвортой байдал хийгээд чиглэлийн хүрээ юм. Эл шалгуурын дагуу үзэл суртлыг урт удаан хугацаанд (заримдаа хэдэн зууны туршид үйлчлэх) оршин үйлчилдэг, мөн түүнчлэн амархан, хурдан замхарч алга болдог, эсвэл өөрийнхөө нөлөөгөөрөө нийт дэлхий ертөнцийг, эсвэл аль нэг тусгай улс орныг хамарсан, бас бүс нутгийн, явцуу орон зайн үзэл суртал гэх мэтээр ялган ангилж болно. Эдгээр ялгаа зааг эмпирик судалгаанд чухал байдаг бөгөөд бас үзэл суртлын онолын чанар чансаанд ч мэдэгдэхүйц хэмжээгээр илэрдэг юм.

Үзэл суртлын дэлгэрэлт, тархалтын хил хязгаар хийгээд оршин байх хугацааны үргэлжлэлийг судлан шинжлэхдээ "аж үйлдвэржсэн" нийгэмд хүн ардын амьдралын сайн сайхан байдал өсөн нэмэгдэхийн хир хэмжээгээр үзэл суртлын үүрэг өөрийн эрхгүй багасдаг гэсэн үзэл бодол агуулагдсан өрнөдийн шинжлэх ухааны үзэл баримтлалуудыг шүүмжлэн авч үзэх явдал чухал ач холбогдолтой болно. Энэхүү онол нь сүүлийн жилүүдэд коммунизмыг эсэргүүцэх үзлийн хамгийн их моодтой чиглэл болоод байна. Эл онол тавиад оны дунд үед (гэхдээ үүнтэй төстөй санал бодол өмнө нь ч гэсэн гарч байсан билээ) тухайн үедээ баруунд өргөн дэлгэрсэн "конвергенцийн онолын" өвөрмөц хувилбар болж үүсэн гарчээ. Түүнийг Р.Арон, Д.Белл, С.Липсет, Р.Лейн зэрэг философчид, социологчид сурталчилж байлаа. Эл онолыг барууны нэртэй том эрдэмтэд эхнээсээ шүүмжилж байсан хэдий ч тэрбээр мэдэгдэхүйц хэмжээгээр дэлгэрч танил болсон ба түүнийг социалист орнуудын эсрэг суртал ухуулгад өргөн ашиглаж байв.

"Үзэл суртлын эриний төгсгөлийн" онолчид дараах хоёр сэдэв бүхий санааг хамгаалан баримталж байв. Нэгдүгээрт, амьдралын сайн сайхан байдал өсөн нэмэгдсэнээр үзэл суртлыг сонирхох сонирхол, үзэл суртлыг талархан баримтлах явдал зайлшгүй буурна, харин улс төр, улс төрийн бодлого нь үзэл суртал ба түүнтэй холбоотой фанатизм, хэт шүтлэгээс ангид чөлөөтэй, прагматик, тоглоомын шинжтэй болж хувирна. Хоёрдугаарт, улс төр дэх үзэл суртлыг, тодруулж хэлбэл туйлширсан хэт үзэл суртлыг арилгах явдлыг аль болох дэмжиж, амьдралд хурдан түргэн нэвтрүүлбэл зохих ая таатай үзэгдэл мөн ажээ.

Гэвч үзэл суртал ба улс төр хоёрын хоорондын харилцааны асуудал нээлттэй хэвээр үлдэж байна. Бид хамгийн ерөнхий, нэгтгэн дүгнэсэн байдлаар үзэл суртал бол улс төрийн үйл ажиллагааны оюун ухаан, сэтгэлгээний үндэс мөн бөгөөд тэгэхлээр үзэл суртал ба улс төр хоёрын хоорондын харилцаа бол онол ба практик, ухамсар ба үйл ажиллагааны хоорондын харилцааны онцгой илрэл бодит жишээ баримт мөн гэж хэлж болно.

Тэгэхлээр үзэл суртал ба улс төр хоёрын харилцан нөлөөлөл, харилцаа холбоог дараах байдлаар тодорхойлж болно:

а). Үзэл суртал нь улс төрд оролцон үйлдэж буй хүчнүүдэд тэдний үйл ажиллагааны үндэс суурь болж буй үнэт зүйлс ба ертөнцийн ерөнхий дүр зургийг тайлбарлан таниулж өгнө, эдгээр үнэт зүйлсийг хэрэгжүүлэх явдлыг хангах хэрэгсэлийг заана, аль үед биш юмаа гэхэд наандаж ихэнх тохиолдолд тэдний үйлдэлийн удирдамжийг өгч чадна. Чухам энэ утгаараа үзэл суртал нь үйлдэл, үйл ажиллагааны оюун ухаан, сэтгэлгээний үндэс мөн болно. Улс төрийн янз бүрийн хөдөлгөөнүүд тов тодорхой болж томъёологдсон хийгээд тууштай хэрэгжин биелэгдэх үзэл суртлыг янз бүрээр хэрэглэдэг байна. Гитлеризм нь үзэл санааны байнгын тогтвортой бөгөөд өөрчлөгдөшгүй зарчмуудыг зарчмын хувьд үгүйсгэж, тэдгээрийг удирдагч, жолоодогчийн хүсэл зоригоор сольж байлаа. Жижиг хөрөнгөтний реформист олонхи намууд, түүнчлэн ажилчны намуудад прагматик байдлаар ойлгосон зүйд нийцэх зохистой зүйл нь үзэл санааны зарчмуудыг таглаж халхлах явдал гардаг. Гэхдээ улс төрийн хөдөлгөөн тус бүр их, бага ямар нэг хэмжээгээр тодорхой болж тогтсон, байнгын тогтвортой үзэл суртлын зарчмуудыг баримталдаг бөгөөд тэдгээр нь тухайн хөдөлгөөнүүдийн үйл ажиллагааны чиглэл ба шинж чанарыг тодорхойлж байдаг ажээ.

б). Үзэл суртал нь улс төрийн хөдөлгөөнийг нэгтгэн нягтруулж байдаг нь баримт (факт) мөн. Адилхан, ижил байдлаар сэтгэн боддог хамтлагт багтан орж байгаа гэдэгтээ итгэж үнэмшсэн хүмүүсийн итгэл үнэмшил нь улс төрийн томоохон хөдөлгөөн бүхнийг хэлхэн холбогч хэсэг мөн байдаг

в). Үзэл суртал нь бодьгалууд ба бүлгүүдийн үйл хөдлөлийг эрчимжүүлэхэд тус дөхөм болдог сэтгэл хөдлөлийн утга агуулгатай бэлэгдлүүдийн цогц нийлбэр мөн болно. Жишээлбэл XIII, XIX, XX зуунд үндэсний үзэл сурталчдаас онцгойлон зааж, цохон тэмдэглэж байсан эх орон, үндэстний үзэл санаа нь амь биеэ хайрлалгүй тэмцэж зүтгэсэн илүү их баатарлаг үйлсийг бий болгох, төрүүлж гаргах хүчин чадалтай болох нь харагдсан бөгөөд тэдгээрийн хүч нөлөө нь эзэн хааны өмнө үүрэг хүлээх, нэр төрөө бодох, жирийн мэдрэмж үзлээс хавьгүй илүү хүчтэй байсан билээ.

Үзэл суртал нь тийнхүү улс төрийн үйлдэл хөдлөлийн бүрдэл хэсэг болохын хувьд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд харин үзэл суртлын үйл ажиллагааны хүрээ салбар нь улс төрийн тэмцлийн хэлбэрүүдийн нэг мөн хэмээн зүй ёсоор хүлээн зөвшөөрөгджээ. Утга зохиол, философи, нийтлэл, урлагын түүхэнд дэвшилт хүчнүүдийн үзэл сурталчид улс төрийн үйл явдал, хөдөлгөөнд татагдан орж байсан жишээ баримтууд олон байдаг нь санамсаргүй зүйл биш юм.

Тиймээс улс төр нь үзэл суртлаас хараат байх явдал нь харьцангуй шинжтэй бөгөөд тэр нь үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд ба үйл байдлын үндсэн аргуудыг сонгох явдлыг хөндөж байгаа ба харин тодорхой асуудлыг прагматик байдлаар шийдвэрлэх, улс төрийн үйл ажиллагааны тактикийг үгүйсгэхгүй билээ. Бодит байдлыг эрүүл саруулаар, байгаагаар нь үнэлэн дүгнэдэг реалист улс төрч нь үзэл санааны зарчмуудад үнэнч байх явдлыг тусгай асуудлуудыг шийдвэрлэхдээ уян хатан, тодорхой хандах, тэр нь улс төрийн аливаа үйл ажиллагаанд нийтлэг, зуршмал байдаг явдалтай хослуулж, холбож чаддагаараа фанатик буюу хэт улайран итгэгч, бишрэгчээс ялгаатай байдаг.

ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ: ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Ц.Ганболд

доктор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

1. Судалгааны зорилго, зорилт:

Судалгааны үндсэн зорилго нь Монгол улсын дээд боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэх ялангуяа оюутны сургалтын тэтгэлэгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход оршино.

Дээрх үндсэн зорилгоо хангах хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Үүнд:

1. Оюутны ахуй, орчинтой холбоотой мэдээллийг авах. Тухайлбал: ам бүлийн тоо, өрхийн орлого түүний эх үүсвэр, их дээд сургуульд нэг өрхөөс хэдэн хүн сурдаг болох, хаана амьдардаг, сурдаг сургуулийнх нь өмчлөл гэх мэт
2. Судалгаанд хамрагдаж байгаа оюутнууд сургалтынхаа төлбөрийг яаж төлдөг, сургалтын тэтгэлэгт хамрагддаг эсэхийг тодорхойлох
3. Сургалтын тэтгэлэг хэрэгтэй эсэх, хэрэв хэрэгтэй бол ямар хувь хэмжээтэй байвал зохистой байх, сургалтын тэтгэлэгийг олгохдоо ямар шалгуур үзүүлэлтийг харгалзаж үзэх зэрэг асуудлаар оюутнууд иргэд, эцэг эх ямар бодолтой байгааг тандах
4. Өнөөгийн их дээд сургуулиудын чанар, дээд боловсролын үнэ цэнэ, сургалтын тэтгэлэг, дээд боловсролтой холбоотой шийдвэрлэвэл зохих ямар асуудал байгааг тодруулах зэрэг болно.

2. Судалгааны арга зүй, арга:

Судалгааны үндсэн мэдээллийг тоон судалгааны үндсэн арга болох анкет, /асуулга/-ын аргаар цуглуулсан болно.

Өргөн цар хүрээтэй, олныг хамарсан мэдээллийг анкетын аргаар авах нь тохиромжтой төдийгүй нийгмийн үзэгдлийн ерөнхий төлөв байдал, хандлагыг илрүүлэхэд түгээмэл хэрэглэгддэг. Судалгааны үндсэн мэдээллийг нийгмийн судалгааны мэдээлэл боловсруулах программуудаар боловсруулсан. Үүнд тоон судалгааны мэдээллийг **Excel**

программын тусламжтайгаар компьютерт оруулж мэдээллийн бааз үүсгээд, мэдээлэл боловсруулалт, статистик шинжилгээнд **SPSS-16** программыг ашигласан.

Судалгааны мэдээлэл цуглуулах газруудаа доорх шалгуураар сонгосон. **Үүнд:**

1. Энэхүү судалгааг захиалагчийн санал
2. Бүсчилсэн ангиллын төлөөлөл
3. Их дээд сургуулиудын төвлөрөл, төлөөлөл

Судалгааны анхдагч мэдээллийг Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Ховд, Завхан, Дорнод, Хэнтий аймгуудын нийт 500 оюутан, 1000 иргэдээс санамсаргүй түүврийн аргаар цуглуулсан болно. Судалгааг явуулахаас өмнө асуулгад орсон ерөнхий болон гол шалгах асуултуудаар тест хийж анкетаа шалгаж захиалагч байгууллагатай зөвшилцөж тохирсон.

Судалгааны түүврийн бүтцийг оновчтой байлгахын тулд дараахь шалгууруудыг харгалзсан. Үүнд:

- Нас
- Хүйс
- Боловсролын түвшин
- Ажил эрхлэлт ба амьжиргааны түвшин

Насны хувьд ангилал, хувь хэмжээг урьдчилан тогтоогүй. Гэхдээ 18-аас дээш насны хүн амыг дотор нь залуу үе, дунд үе, ахмад үе гэж ангилвал эдгээр үеүүдийн тэгш төлөөллийг судалгаанд хамруулахыг зорьсон.

Боловсролын түвшингийн бүх төлөөлөл судалгаанд хамрагдсан. Гэхдээ энд нэг тайлбар хийх нь зүйтэй. Манай иргэдийн дунд дээд боловсролтой хүмүүсийн тоо санал асуулгаар нилээд өндөр хувьтай гардаг нь анхаарал татаж байгаа юм. Үүнийг чанарын судалгааны аргаар тодруулж үзэхэд их, дээд сургууль төгссөн хүмүүсээс гадна 1990-ээд оноос өмнө техникум төгссөн хүмүүс мөн одоо их, дээд сургуульд суралцаж байгаа зарим оюутнууд өөрсдийгөө дээд боловсролтой гэж хариулж байсан нь ажиглагдсан.


Анкетын асуултанд нэгэн зүйлийн хязгаарлалт хийсэн. Энэ нь “мэдэхгүй” буюу “хариулахад хэцүү байна” гэсэн сонголтыг бараг оруулаагүй бөгөөд энэ нь респондентууд идэвхигүй хариулт өгөх явдлыг хязгаарласан хэрэг болно. Өөрөөр хэлбэл иргэдийг заавал тодорхой хариулт өгөхийг шахах зорилт тавьсан. Гэхдээ зарим иргэд тодорхой асуултуудад хариулахгүй байх боломж олгосон бөгөөд үүнийг SPSS-16 –д задгай орхисон нь Missing System-д тэмдэглэгдсэн. Энэ нь тухайн асуултанд хариулаагүй гэсэн утгыг илэрхийлж байгаа юм.

Энэхүү судалгааны мэдээллийг цаг хугацааны хувьд 2009 оны 10-р сарын 07-ноос 10-р сарын 12-ны өдрүүдэд багтаан цуглуулсан болно. Судалгааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Монголын оюутны холбоо, Үндэсний хөгжлийн хүрээлэн хамтран хийсэн болно.


Судалгааны үр дүн

1. Оюутны ахуй, орчин

Нийт 500 оюутны өрхийн ам бүлийн тоог тодруулахад судалгаанд хамрагдагсдын 112 оюутан буюу 22,4 хувь нь 1-3 ам бүлд, 310 оюутан буюу 62,0 хувь нь 4-6 ам бүлд, 65 оюутан буюу 13 хувь нь 7-9 ам бүлд, 13 оюутан буюу 2,6 хувь нь 10-аас дээш ам бүлд тус тус амьдарч байна.



Судалгаанд хамрагдсан нийт 1000 иргэдийн 289 буюу 28,4 хувь нь 1-3 ам бүлтэй, 617 нь буюу 61,7 хувь нь 4-6 ам бүлтэй, 81 нь буюу 8,1 хувь нь 7-9 ам бүлтэй, 13 нь буюу 1,3 хувь нь 10-аас дээш ам бүлтэй байна.





Судалгаанд оролцсон нийт иргэдийн 62% нь буюу олонхи нь 4-6 ам бүлтэй гэж хариулсан нь албан ёсны статистиктай үндсэндээ таарч байгаа юм. Өнөөдөр Монгол улс 2'729.757 хүн амтай 634827 өрх айлтай⁸⁰ байгаа бөгөөд дунджаар нэг өрх айл 4.3 ам бүлтэй байна. Энэ нь манай судалгаа магадлал сайтай байгаагийн нэг илэрхийлэл гэж үзэж болох юм.


Оюутан амьдардаг өрхийн сарын орлогын талаар тодруулахад, судалгаанд оролцогчдын:

- 209 оюутан буюу 41,8 хувь нь 0-100,0 мян.төг
- 191 оюутан буюу 38,2 хувь нь 100,1-300,0 мян.төг
- 73 оюутан буюу 14,6 хувь нь 300,1-500,0 мян.төг
- 21 оюутан буюу 4,2 хувь нь 500,1-800,0 мян.төг
- 6 оюутан буюу 1,2 хувь нь 800,1 мян.төгрөгөөс дээш орлоготой өрхөд амьдарч байна.

⁸⁰ www.nso.mn- 2009.11.21




Судалгаанаас үзэхэд оюутнуудын олонхи нь 4-6 ам бүлтэй өрхөөс суралцаж байна. Өрхийн сарын орлогын хувьд оюутантай айл өрхийн 80 орчим хувь нь 0-300000 төгрөгийн орлоготой үүнээс 41.8 хувь нь амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур буюу 0-100000 төгрөгийн орлоготой өрхөөс суралцаж байна. Энэ нь оюутанд сургалтын тэтгэлэг дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байгааг илэрхийлнэ.



Оюутан бүхий өрхийн орлогын эх үүсвэрийн 63.9 хувь нь цалин тэтгэвэр тэтгэмж, 29.6 хувь нь МАН, газар тариалангаас орлогын эх үүсвэрээ олдог. Нийтдээ 93 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж, МАН газар тариалангаас орлогынхоо гол эх үүсвэрийг олдог

байна.



Судалгаанд хамрагдсан 1000 иргэдээс “Танайх хэдэн оюутантай вэ?” гэж асуухад 34.5 хувь нь оюутан байхгүй, 65.5 хувь нь 1-3 оюутантай гэж хариулжээ. Энэ нь манай улсын нийт айл өрхийн олонхи нь оюутантай, оюутны ахуй орчны асуудал бол төр


засгийн бодлогын анхааралд байх ёстойг харуулж байна. Энэхүү нөхцөл байдлыг иш үндэс болговол оюутанд сургалтын тэтгэлэг дэмжлэг үзүүлэх нь нийт айл өрх, иргэдийн амьжиргааг дэмжих, санхүүгийн ачааллыг хөнгөлөхөд бодитой нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл бидний судалгаагаар 634827 өрхийн 400000 орчим өрхөд энэ асуудал хамаарч байгаа юм. Нөгөө талаар оюутанд сургалтын тэтгэлэгээс гадна амьдрах орчин, оюутны дотуур байр, цагийн ажил, ажлын байр гэх мэт шийдвэрлэвэл зохих олон асуудал хуримтлагдсаныг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан 500 оюутнаас “Та одоо хаана амьдарч байна вэ?” гэсэн асуултанд 143 оюутан буюу 28,6 хувь нь гэртээ, 111 оюутан буюу 22,2 хувь нь хамаатныдаа, 121 оюутан буюу 24,2 хувь нь дотуур байранд, 96 оюутан буюу 19,2 хувь нь өрөө хөлсөлж, 29 оюутан буюу 5,8 хувь бусад гэсэн хариултыг тус тус өгчээ. Бусад гэдэгт ямар оюутнууд хамаарагдаж байгааг чанарын судалгааны аргаар тодруулж үзэхэд гэр хөлслөх, хашаа байшинг хэд хэдээрээ нийлж түрээслэх, найзындаа, тодорхой амьдрах газаргүй дамжиж явдаг оюутнууд цөөн биш байгаа нь ажиглагдсан.



2. Сургалтын төлбөр ба тэтгэлэгт хамрагддаг байдал

Оюутны сургалтын төлбөрийн хэлбэрийг санал асуулгаар тандаж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна.





Дээрх зурагт үзүүлсэн хувь хэмжээ буюу төрөөс санхүүгийн дэмжлэгтэй суралцдаг оюутны эзлэх хувь БСШУЯ-ны 2008-2009 оны хичээлийн жилийн тайланд дурьдсан тоотой үндсэндээ адилхан байгаа юм. (уг тайланд нийт оюутны 24.7 хувь нь төрөөс санхүүгийн дэмжлэгтэй суралцаж байна гэжээ.) Энэ нь бидний судалгаа албан ёсны статистиктай таарч байгаа нь магадлал өндөртэй байгаагийн илэрхийлэл мөн.

	2006/07 х.ж.		2007/08 х.ж.		2008/09 х.ж.	
Дээд боловсролын нийт суралцагчид	142,411		150,326		161,111	
үүнээс хувийн зардлаар суралцдаг	92,882	65.2%	104,026	69.2%	115,077	71.4%
сургуулийн зардлаар суралцдаг	1,444	1.0%	1,121	0.7%	988	0.6%
Төрийн албаны тухай хуулиар	18,523	13.0%	17,259	11.5%	16,875	10.5%
СТС-гийн буцалтгүй тусламжаар	17,416	12.2%	14,417	9.6%	13,313	8.3%
СТС-гийн зээлээр	11,021	7.7%	10,380	6.9%	9,457	5.9%
төрөөс санхүүгийн	46,960	33.0%	42,056	28.0	39,645	24.6%


дэмжлэгтэй бүгд %				%		
бусад задлаар	1,125	0.8%	3,123	2.1%	5,401	3.4%
төлбөрөө төлсөн бүгд	54,998	39%	62,614	42%	80,988	50%
хувиасаа төлбөрөө төлсөн	37,968	41%	43,562	42%	57,769	50%
Төрийн албаны тухай хуулиар	6,529	35%	7,264	42%	9,592	57%
СТС-гийн буцалтгүй тусламжаар	5,796	33%	6,430	45%	7,434	56%
СТС-гийн зээлээр	4,127	37%	4,538	44%	5,386	57%
бусад задлаар	578	51%	820	26%	807	15%

Дээрх хүснэгтээс харахад хувийн зардлаар суралцдаг оюутны тоо жилээс жилд байнга өсөх хандлагатай байна. Жишээ нь, 2006-2007 оны хичээлийн жилд нийт оюутны 65.2 хувь нь хувийн зардлаар суралцдаг байсан бол 2007-2008 оны хичээлийн жилд 69.2 хувь, 2008-2009 оны хичээлийн жилд 71.4 хувь болж өсчээ.

Оюутнууд тэтгэлэгт хэрхэн хамрагдаж байгааг санал асуулгаас үзвэл дараах байдлаар хариулсан байна.




Их дээд сургуулийн оюутанд төрөөс сургалтын тэтгэлэг олгох нь шаардлагатай эсэх талаар иргэд болон оюутнуудаас санал асуухад иргэдийн 82,6 хувь нь, оюутнуудын 90,2 хувь нь шаардлагатай гэж хариулжээ. Энэ нь өнгөцхөн харахад эцэг эхчүүд, оюутнууд төрөөс дэмжлэг хүсч байгаа нь өндөр хувьтай харагдаж байгаа боловч, тэтгэлэгийн хэмжээ, тэтгэлэг үзүүлэх гол шалгуур үзүүлэлт зэргийг авч үзвэл нилээд бодитой санал хэлж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.



Эдгээр үзүүлэлтээс харахад оюутнууд ч, иргэд, эцэг эхчүүд ч бидэнд төрөөс санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байна гэхдээ бид сургалтын төлбөрийнхөө тодорхой хэсгийг өөрсдөө буюу бусад эх үүсвэрээс олно гэж 65.5 хувь нь хариулжээ.




Судалгаанд хамрагдсан 500 оюутнаас “**Оюутанд тэтгэлэг олгох хамгийн чухал үзүүлэлт юу вэ**” гэсэн асуултанд 187 оюутан буюу 37,4 хувь нь сурлагын үзүүлэлт, 186 оюутан буюу 37,2 хувь нь амьжиргааны түвшин, 81 оюутан буюу 16,2 хувь нь улсад хэрэгтэй мэргэжил, 26 оюутан буюу 5,2 хувь нь төгсөөд хөдөө ажиллах, 20 оюутан буюу 4,0 хувь нь бусад гэсэн хариултуудыг өгчээ. Харин судалгаанд хамрагдсан 1000 иргэдээс 420 буюу 42,0 хувь нь сурлагын үзүүлэлт, 355 иргэн буюу 35,5 хувь нь амьжиргааны түвшин, 162 иргэн буюу 16,2 хувь нь улсад хэрэгтэй мэргэжил, 42 иргэн буюу 4,2 хувь нь төгсөөд хөдөө ажиллах, 22 иргэн буюу 2,2 хувь нь бусад гэсэн хариултуудыг өгчээ.




Манай дээд боловсролын чанарын талаар иргэдийн өгсөн үнэлэлт


■ Их сайн ■ Боломжийн ■ Муу



Дээд боловсрол эзэмших талаар оюутны бодол

■ тоо ■ хувь





Иргэд болон оюутнуудаас авсан судалгааны анкетын төгсгөлд танд бусад санал, зөвлөмж, хүсэлт байна уу? Хэрэв байгаа бол саналаа бичнэ үү? гэсэн нээлттэй асуулт оруулсан. Энэхүү нээлттэй задгай асуултанд судалгаанд оролцогчдын тус бүр 35 орчим хувь нь саналаа бичсэн бөгөөд тэдгээрийг хувь, процентоор илэрхийлэх буюу эрэмбэлэх нь арга зүйн хувьд учир дутагдалтай хэмээн үзэж нилээд олон давтагдсан зарим онцлог саналуудыг тэмдэглэв.

НИЙТЛЭЛИЙН ШААРДЛАГА, СТАНДАРТ

Эрдэмтэд, судлаачид Та бүхнийг **ПОЛИТОЛОГИ** сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, илтгэл, шүүмж өгүүлэл зэргээ нийтлүүлэхийг урьж байна.

Сэтгүүлийн зөвлөл нь тухайн бүтээлийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлийн дагуу албан ёсоор хүлээн авсны дагуу сэтгүүлийн агуулга, зорилгод нийцүүлэн сонгон шалгаруулж нийтлэнэ.

Бүтээлээ ирүүлэхдээ хэвлэмэл 1 хувийг сэтгүүлийн хаягаар, түүнчлэн электрон файлаар ccpr@num.edu.mn хаяг руу хавсаргах шаардлагатай.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Сэтгүүлд ирүүлэх бүтээл нь урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Бүтээлийн хураангуй нь 150-иас ихгүй үгтэй байх ба монгол, орос, англи хэлний аль нэг дээр байх
- Бусдын бүтээлээс текст, зураг, график зэргийг ашигласан бол эх сурвалжийг тодорхой дурьдах
- Бүтээлийн өмнө зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, ажлын газар, бүтээлийн гарчиг зэргийг бичих

Сэтгүүлд нийтлэгдэх бүтээлтэй холбоотой аливаа асуудлыг зохиогч өөрөө хариуцна.

Сэтгүүлийн зөвлөл